



ДОТООД ХЭРГИЙН
ИХ СУРГУУЙ



МОНГОЛЫН КРИМИНОЛОГИЧДЫН
ХОЛБОО

ГЭМТ ЯВДАЛТАЙ ТЭМЦЭХ АСУУДАЛ

ОНОЛ, АРГА ЗҮЙН
УЛИРАЛ ТУТМЫН СЭТГҮҮЛ

2019 №3 (69) 17 дахь жилдээ



СЭТГҮҮЛИЙН ЗӨВЛӨЛ

ЭРХЛЭГЧ

Дорждамба ЗҮМБЭРЭЛЛХАМ
ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР

ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮД

Батбуян БАТ-ЭРДЭНЭ
ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР

Бөхчулуун Бат-Эрдэнэ
ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР

Бадам БАТЗОРИГ
ДОКТОР (Ph.D), ДЭД ПРОФЕССОР

Баатар БОЛДБААТАР
ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР

Насанжаргал ГАНБАДРАЛ
ДОКТОР (Ph.D), ДЭД ПРОФЕССОР

Жамсран ДОЛГОРСҮРЭН
ДОКТОР (Sc.D), ПРОФЕССОР

Наваанпэрэнлэй ЖАНЦАН
МОНГОЛ УЛСЫН ГАВЬЯАТ ХУУЛЬЧ, ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР

Авирмэд ЛХАГВА
МОНГОЛ УЛСЫН ГАВЬЯАТ ХУУЛЬЧ, ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР

Ганбат ЭРДЭНЭБАТ
ДОКТОРАНТ

Батзэвэг ЭНХБОЛД
ДОКТОР (Ph.D)

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Сэнгээ ГАНТУЛГА
ДОКТОР (Ph.D), ДЭД ПРОФЕССОР

ДУГААРЫГ ЭРХЛЭН ГАРГАСАН

Сэнгээ ГАНТУЛГА
ДОКТОР (Ph.D), ДЭД ПРОФЕССОР

ХЭВЛЭЛИЙН ЭХ БЭЛТГЭСЭН

Бэгзсүрэн Жамсран



ГАРЧИГ

КРИМИНОЛОГИЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН ТУЛГАМДСАН АСУУДАЛ	
Мансууруулах бодистой холбоотой гэмт хэрэгт холбогдогсдын хэрэглэсэн мансууруулах бодисын төрөл, архи, тамхины хэрэглээний түвшинг судалсан нь.....С.Байгалмаа, Д.Дэжидмаа, Л.Насанцэнгэл	4
ЭРҮҮГИЙН ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН ТУЛГАМДСАН АСУУДАЛ	
Эрүүгийн эрх зүйн шинжлэх ухаан: Сургалт, эрдэм шинжилгээний ажил, хөгжлийн чиг хандлага.....Б.Энхболд, С.Гантулга, А.Амарсайхан, Б.Батцэрэн, Б.Мөнхзул	9
Гэм буруу, гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг тогтоосон хэм хэмжээг хэрэгжүүлэхэд тулгамдаж буй асуудал.....О.Амарсайхан	20
Хүн барьцаанд авахын эсрэг олон улсын эрх зүйн зохицуулалт.....Д.Сундуйсүрэн	26
Өсвөр насны хүнд хүлээлгэж буй эрүүгийн хариуцлагын онцлог, өнөөгийн байдал.....А.Амарсайхан	34
ЭРҮҮГИЙН ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН ТУЛГАМДСАН АСУУДАЛ	
Гэрч, хохирогчийн аюулгүй байдлыг хамгаалах олон улсын эрх зүйн механизм.....П.Батбаатар	44
ЦАГДААГИЙН ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН ТУЛГАМДСАН АСУУДАЛ	
Гадаадын зарим орны цагдаагийн байгууллагаас объектын судалгаа хийж байдал, харьцуулсан судалгаа.....Г.Бямбадорж	54
ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН ТУЛГАМДСАН АСУУДАЛ	
Эмэгтэй хоригдолд үзүүлэх нийгмийн ажлын үйлчилгээ, анхаарах зарим асуудал.....О.Баяржаргал	64
ЭРДЭМТЭН, СУДЛААЧДЫН БАЙР СУУРЬ	
Монгол Улс дахь эрх зүйн шинэчлэлийн бодлого, хэрэгжилт, үр дүн, анхаарах асуудал.....Б.Болдбаатар	73
Хот дахин төлөвлөлт дэх иргэдийн оролцоо, анхаарах асуудал.....О.Хишигмөнх	82
Хилийн боомтын үйл ажиллагаа, аюулгүй байдалд тулгамдаж буй асуудлууд.....Я.Цэлмэн	90



КРИМИНОЛОГИЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН ТУЛГАМДСАН АСУУДАЛ

МАНСУУРУУЛАХ БОДИСТОЙ ХОЛБООТОЙ ГЭМТ ХЭРЭГТ ХОЛБОГДОГСДЫН ХЭРЭГЛЭСЭН МАНСУУРУУЛАХ БОДИСЫН ТӨРӨЛ, АРХИ, ТАМХИНЫ ХЭРЭГЛЭЭНИЙ ТҮВШИНГ СУДАЛСАН НЬ

*С.Байгальмаа¹ /СЭМҮТ-ийн ШСЭСК-ийн эрхлэгч, магистрант/
Д.Дэжидмаа² /СЭМҮТ-ийн Поликлиникийн эрхлэгч, тэргүүлэх зэргийн эмч/
Д.Лянхуа³ /СЭМҮТ-ийн зөвлөх эмч, анагаах ухааны магистр/
Л.Насанцэнгэл⁴ /СЭМҮТ-ийн Ерөнхий захирал, анагаах ухааны доктор,
дэд профессор/*

Товч агуулга: Мансууруулах бодисын хууль бус эргэлттэй холбоотой гэмт хэрэгт холбогдогсдын хэрэглэсэн мансууруулах бодисын төрөл болон архи, тамхины хэрэглээний түвшинг судалсан болно.

Түлхүүр үг: Мансууруулах бодис, архи, тамхи, гэмт хэрэг.

Судалгааны үндэслэл:

Төв мэдрэлийн системийн үйл ажиллагааг цочроож сэтгэцийн хөөрөл, сэтгэлийн баясал, хий үзэгдэл буюу бусад солио үүсгэх, эсвэл төв мэдрэлийн системийн үйл ажиллагааг саатуулж булчин сулруулах, нойр хүргэх, тайвшруулах зэрэг үйлчлэлийг үзүүлэх чадвартай, эмнэлгийн бус зориулалтаар тогтмол хэрэглэвэл эмгэг хэрэгцээг бий болгох чадавхитай эм бодисуудыг сэтгэц идэвхит бодис гэж нэрлэдэг.¹ Мансууруулах бодис мөн эсэхийг эмнэлгийн, нийгмийн, хуулийн хэмжүүрээр тогтоодог.² Мансууруулах, сэтгэц идэвхит эм бодисуудыг наркотикууд, сэтгэц идэвхит чадвартай сэтгэц нөлөөт бодисууд, олон улсын хяналтанд ороогүй сэтгэц идэвхит бодисууд гэж гурван бүлэгт ангилан үздэг.³ Харин өвчний олон улсын 10 дугаар ангилалд мансууруулах, сэтгэц идэвхит эм бодисын төрлийг нь харгалзан 10 дэд бүлэг эмгэг болгон хуваажээ.⁴

НҮБ-ын Мансууруулах бодис болон гэмт хэрэгтэй тэмцэх хэлтсээс 2014 оны байдлаар дэлхий дахинд 15-64 насны 250 сая хүн мансууруулах бодис хэрэглэж байна⁵ гэж мэдээлсэн бол 2016 онд 275 сая болсон тухай дурджээ. Дэлхий даяар хамгийн өргөн хэрэглэгддэг мансууруулах бодисын тоонд каннабис (192 сая хэрэглэгч), амфетамины болон опиоидын төрлийн мансууруулах бодисууд (34 сая хэрэглэгч), экстази (21 сая хэрэглэгч), кокаин (18 сая хэрэглэгч) оржээ.⁶

Мансууруулах, сэтгэц идэвхит эм бодис ба донтолтын Европын хяналтын төвийн 2015 оны тайланд мансууруулах, сэтгэц идэвхит эм бодисын тоо төрөл жилээс жилд нэмэгдэж байгаа бөгөөд НҮБ-ын 1961, 1971 оны конвенцийн жагсаалтанд орсон мансууруулах, сэтгэц идэвхит эм бодисуудыг оролцуулаад нийт 560 гаруй төрлийн мансууруулах, сэтгэц идэвхит эм бодис байна гэж дурджээ.⁶

2013 оны байдлаар дэлхийн нийт гэмт хэргийн 1/5 орчмыг мансууруулах, сэтгэц идэвхит эм бодисын шалтгаант гэмт хэрэг эзэлж байсан байна.⁷ Монгол улсад 2014 онд энэ төрлийн 62 хэрэгт 144 хүн холбогдон шалгагдаж байсан бол 2018 оны 12 дугаар сарын байдлаар 197 хэрэгт 402 хүн холбогдсон байна.⁸

2011 онд мансууруулах, сэтгэц идэвхит эм бодистой холбоотой гэмт хэрэгт шүүх сэтгэц эмгэг судлалын магадлан шинжилгээ хийлгэгсдийн тоо 11 байсан бол 2018 онд 252 болж өссөн байна.⁹

2002-2003 онд Тайвань улсад мансууруулах, сэтгэц идэвхит эм бодис хэрэглэдэг гэх өгүүлэмжтэй, гэмт хэрэгт холбогдсон өсвөр насныхны дунд хийгдсэн судалгаагаар судалгаанд оролцогсдын эцгүүдийн 10,3%, эхчүүдийн 1,7 %, төрсөн ах, эгч, дүү нарынх нь 1,5% нь тус тус мансууруулах бодис хэрэглэдэг гэж хариулсан байна.¹⁰

2010 онд Хятадын метамфетамин хэрэглэгчдийн дунд тамхи татах зан үйл болон никотины хамаарлыг үнэлэх судалгаагаар метамфетамин хэрэглэгчдийн 55,4% нь никотины бага ба дунд зэргийн хамааралтай гэсэн үр дүн гарчээ.¹¹

Монгол Улсад мансууруулах бодисын хууль бус хэрэглээ жилээс жилд нэмэгдэж байгаатай уялдан уг төрлийн гэмт хэрэгт холбогдогсдын тоо өсч байгаа тул мансууруулах,



сэтгэц идэвхит эм бодисын хэрэглээний түвшин, түүнд нөлөөлөх эрсдэлт хүчин зүйлсийг судлах нь нэн чухал хэрэгцээтэй байгаа тул бид энэхүү судалгааг хийх үндэслэл болж байна.

Судалгааны зорилго:

Мансууруулах бодистой холбоотой гэмт хэрэгт холбогдогсдын хэрэглэсэн мансууруулах бодисын төрөл ба архи, тамхины хэрэглээний түвшинг судлах

Судалгааны зорилт:

- Мансууруулах бодистой холбоотой гэмт хэрэгт холбогдогсдын хэрэглэсэн мансууруулах бодисын төрлийг тогтоох;
- Мансууруулах бодистой холбоотой гэмт хэрэгт холбогдогсдын архи, согтууруулах ундааны хэрэглээний түвшинг тодорхойлох;
- Мансууруулах бодистой холбоотой гэмт хэрэгт холбогдогсдын тамхины хэрэглээний түвшинг тодорхойлох.

Судалгааны ажлын ёс зүй:

АШУҮИС-ийн Судалгааны ёс зүйн хяналтын хорооны 2017 оны 05 дугаар сарын 19-ний өдөр хурлын шийдвэрээр судалгааг хийх ёс зүйн зөвшөөрөл авсан /Дугаар № 2017/3-07/. СЭМҮТ-ийн Шүүх сэтгэц эмгэг судлалын кабинетэд мансууруулах, сэтгэц идэвхит эм бодистой холбоотой шүүх сэтгэц эмгэг судлалын магадлан шинжилгээ хийлгэгсдэд судалгааны ажлын зорилго, судалгааны ажлын талаарх мэдээллийг танилцуулж судалгаанд оролцохыг зөвшөөрсөн оролцогчоос судалгааг авсан.

Судалгааны ажлын хэрэглэгдэхүүн ба арга зүй:

Судалгааны загвар:

Уг судалгааг дескриптив судалгааны загвараар чанарын судалгааны аргаар (асуумж, эмнэлзүйн үзлэг, тусгай сорил, ярилцлага болон баримтын судалгаа) тусгайлан боловсруулсан карт ашиглаж судалгааны мэдээлэл болон баримтыг цуглуулсан.


Судалгааны хамрах хүрээ:

Судалгаанд 2017 оны 08 дугаар сарын 01-ний өдрөөс 2018 оны 02 дугаар сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд буюу 6 сарын хугацаанд СЭМҮТ-ийн Шүүх сэтгэц эмгэг судлалын кабинетэд мансууруулах, сэтгэц идэвхит эм бодистой холбоотой шүүх сэтгэц эмгэг судлалын магадлан шинжилгээ хийлгэгсдийг хамруулсан бөгөөд судалгааны шалгуурыг хангасан 106 оролцогчоос судалгааг авсан.

Судалгааны ажлын зарим үр дүн:

Бидний судалгаанд 18-41 насны, эрэгтэй 94, эмэгтэй 12, нийт **106** оролцогч хамрагдсаны **99,1%** нь Улаанбаатар хотын харъяалалтай, дундаж нас нь **24,5±6,1** байлаа.

График.1




Судалгаанд хамрагдагсдын 88 буюу 83%-д нь шээсний шинжилгээгээр мансууруулах бодис хэрэглэсэн нь тогтоогдсон. Үүнээс 59 буюу **67%** нь дан ТНС




(тетрагидроканнабинол) хэрэглэсэн байсан бол 10 буюу 11.4 % нь ТНС (тетрагидроканнабинол) болон амфетамины төрлийн мансууруулах бодисыг хавсран хэрэглэсэн байв.

График.2




Уг судалгаанд нийт 106 хүн хамрагдагсан бөгөөд 96 нь мансууруулах бодис хэрэглэж үзсэн гэж хариулжээ. Үүнээс 80 нь Монгол улсад, БНХАУ-д 6 нь анх мансууруулах бодис хэрэглэсэн гэжээ.

График.3



Судалгаанд хамрагдагсдын 102 буюу 96.2% нь “Согтууруулах ундаа хэрэглэдэггүй буюу эрсдэл багатай”, 4 буюу 3.8% нь “Архи хэтрүүлэн хэрэглэгч” гэж оношлогдсон байна.

График.4



Судалгаанд хамрагдагсдын 76 буюу 71.7 % нь никитоны маш бага хамааралтай, 13 буюу 12,3 % нь никитоны бага зэргийн хамааралтай, 13 буюу 12,3 % нь никитоны дунд зэргийн хамааралтай, 1 буюу 0.9% нь маш өндөр хамааралтай, 3 буюу 2.8% нь гэсэн үр дүн гарсан.

Дүгнэлт

- Шээсний шинжилгээгээр мансууруулах бодис хэрэглэсэн болох нь тогтоогдсон 88 оролцогчийн 59 буюу **67 %** -д нь **ТНС** (тетрагидроканнабинол), 17 буюу **19,3%**-д нь **АМР, МЕТ** (амфетамин, метамфетамин), 10 буюу **11,4 %** -д нь **ТНС** (тетрагидроканнабинол), **АМР, МЕТ** (амфетамин, метамфетамин) илэрсэн нь манай улсын хүн амын дунд каннабиноид болон амфетамины төрлийн сэргээгч бодисыг хэрэглэх тохиолдол илүү их байгааг илтгэж байна.
- Архи, согтууруулах ундааны хэрэглээг үнэлэх (AUDIT) сорилоор судалгаанд хамрагдагсдын 102 буюу **96.2%** нь “Согтууруулах ундаа хэрэглэдэггүй буюу эрсдэл багатай”, 4 буюу 3.8% нь “Архи хэтрүүлэн хэрэглэгч” гэж оношлогдсноос үзэхэд мансууруулах бодис (каннабиноид, амфетамин, метамфетамин) хэрэглэгчдийн дунд архи, согтууруулах ундааны хэрэглээний түвшин бага байна.
- Никитоны хамаарлын түвшинг үнэлэх сорилоор судалгаанд хамрагдагсдын 76 буюу **71.7 %** нь никитоны маш бага хамааралтай, 13 буюу 12,3 % нь никитоны бага зэргийн хамааралтай, 13 буюу 12,3 % нь никитоны дунд зэргийн хамааралтай гэж оношлогдсон. Үүнээс үзвэл мансууруулах бодис (каннабиноид, амфетамин, метамфетамин) хэрэглэгчид нь тамхи (никитон)-ны маш бага, бага, дунд зэргийн хамааралтай байгааг харуулж байна.

Санал, зөвлөмж

- ЭМЯ, ХЗДХЯ болон БСШУСЯ салбар хоорондын хамтын ажиллагааг сайжруулж, мансууруулах бодисын хэрэглээнээс урьдчилан сэргийлэх чиглэлээр гарц шийдлийг тодорхойлох, холбогдох хуулийн хэрэгжилтийг сайжруулж хяналт тавих, гэр бүл, ерөнхий боловсролын болон их дээд сургууль, албан байгууллагад чиглэсэн үйл ажиллагаа явуулах,
- Ерөнхий боловсролын сургуулийн эрүүл мэндийн хичээлийн стандарт, чанарт анхаарах, багш нарыг чадавхижуулах,
- Хэвлэл мэдээллийн хэрэгсэлээр цацах мансууруулах бодистой холбоотой мэдээ, мэдээлэлд тодорхой шалгуурыг тавьж байх.

Ном зүй

- С.Бямбасүрэн.Сэтгэцийн эмгэг судлал. УБ 2013 он. х 469



- ЭМЯ, НЭМХ, СЭМҮТ, ДЭМБ. Мансууруулах эм бодис ба нийгмийн эрүүл мэнд. УБ 2016. х 11
- С.Бямбасүрэн. Мансуурал судлал. Нэгдүгээр хэсэг. УБ 1999 он. х 4-5
- Л.Эрдэнэбаяр. Архидалт ба мансуурал. УБ 2015 он. х 123
- United Nations Office on Drugs and Crime. <World Drug Report 2016-web.pdf>. New York 2016
- United Nations Office on Drugs and Crime. <World Drug Report 2016-web.pdf>. New York 2018
- EMCDDA-Europol 2015 Annual Report on the implementation of Council Decision 2005/387/JHA
- Цагдаагийн ерөнхий газар, Хар тамхитай тэмцэх газрын дүн мэдээ 2018 он.
- СЭМҮТ, Сэтгэцийн эрүүл мэндийн статистик үзүүлэлтүүд. УБ 2018 он
- Hsueh-Ling Chang, MD; Sue-Huei Chen, PhD; Chien Huang, MS. Temperament of Juvenile Delinquents with History of Substance Abuse/Original article/. Chang Gung Med J 2007;30:47-52
- Ziyun Wang, Bao, Shiyan Yan, Zhi Lian, Zhenjun Jia. An Investigation of Cigarettes Smoking Behavior and Nicotine Dependence among Chinese Methamphetamine Users Two Provinces /Research Article/. Biomed Research International Volume 2014, Article ID 175205, 9 pages



ЭРҮҮГИЙН ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН ТУЛГАМДСАН АСУУДАЛ

ЭРҮҮГИЙН ЭРХ ЗҮЙН ШИНЖЛЭХ УХААН: СУРГАЛТ, ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ АЖИЛ, ХӨГЖЛИЙН ЧИГ ХАНДЛАГА

*Б.Энхболд, С.Гантулга, А.Амарсайхан, Б.Батцэрэн, Б.Мөнхзүл
Дотоод хэргийн их сургуулийн Цагдаагийн сургуулийн
Эрүүгийн эрх зүй, криминологийн тэнхим*

Товч агуулга: Энэхүү илтгэлийн зорилго нь эрүүгийн эрх зүйн сургалт, эрдэм шинжилгээний ажлын өнөөгийн байдалд дүн шинжилгээ хийж, хөгжлийн чиг хандлагыг тодорхойлохыг зорьсон. Судалгааны ажлын хүрээнд а)Эрх зүйч мэргэжил ба эрүүгийн эрх зүйн сургалтын харилцан хамаарал, б)Дотоод хэргийн их сургуульд эрүүгийн эрх зүйн сургалт явуулж ирсэн уламжлал, хүний нөөцийн асуудал, в)Эрүүгийн эрх зүйн сургалт, эрдэм шинжилгээний ажлын өнөөгийн байдал, г)Эрүүгийн эрх зүйн сургалт, эрдэм шинжилгээний ажлын хөгжлийн чиг хандлагын талаар судалж, дүгнэлт хийсэн болно.

Судалгаанд түүхчлэх, харьцуулах, статистик болон баримт бичигт дүн шинжилгээ хийх аргыг ашигласан. Судалгааны мэдээллийн сан нь Дотоод хэргийн их сургуулийн 684 орчим суралцагчийн санал асуулгын дүнд үндэслэсэн болно.

Түлхүүр үг: Эрүүгийн эрх зүй, сургалтын хөтөлбөр, багц цаг, үнэлгээ, суралцагч, судалгаа, хөгжил, профессор.

Удиртгал

Хууль зүйн шинжлэх ухаан нь эрх зүйн үзэгдлийн мөн чанар, зүй тогтол, чиг хандлагыг судалдаг нийгмийн шинжлэх ухааны нэг төрөл юм. Хууль зүйн шинжлэх ухааны тогтолцоог 1) хууль зүйн тулгуур шинжлэх ухаан, 2) хууль зүйн салбар шинжлэх ухаан, 3) хууль зүйн хавсарга шинжлэх ухаан, 4) хууль зүйн харьцуулсан шинжлэх ухаан гэж ангилдаг.¹ Эрх зүйн тодорхой салбар бүрэлдэн тогтох, хөгжих, хэрэгжих зүй тогтлыг судалдаг хууль зүйн цогц шинжлэх ухааныг хууль зүйн салбар шинжлэх ухаан гэж тодорхойлж болно. Дээрх тодорхойлолтоос авч үзвэл, эрүүгийн эрх зүйн шинжлэх ухаан нь хууль зүйн салбар шинжлэх ухаан гэж үзэж болно. Эрүүгийн эрх зүйн шинжлэх ухааны үндсэн зорилт нь эрүүгийн хууль тогтоомжийг боловсронгуй болгох замаар хүн, төр, нийгмийн аюулгүй байдлыг хангах явдал юм.

Эрүүгийн хууль тогтоомжийг боловсронгуй болгох, хүний эрх, эрх чөлөөг хангах, эрүүгийн хуулийн зорилтыг хэрэгжүүлэхэд эрдэмтэн, судлаач, шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах байгууллагын мэргэшсэн албан хаагчдын эрүүгийн эрх зүйн онолын суурь мэдлэг онцгой ач холбогдолтой.

Энэхүү илтгэлийн зорилго нь эрүүгийн эрх зүйн сургалт, эрдэм шинжилгээний ажлын өнөөгийн байдал, хөгжлийн чиг хандлагад дүн шинжилгээ хийхийг зорьсон.

Судалгааны ажлын хүрээнд а)Эрх зүйч мэргэжил ба эрүүгийн эрх зүйн сургалтын харилцан хамаарал, б)Дотоод хэргийн их сургуульд эрүүгийн эрх зүйн сургалт явуулж ирсэн уламжлал, в)Эрүүгийн эрх зүйн сургалт, эрдэм шинжилгээний ажлын өнөөгийн байдал, г)Эрүүгийн эрх зүйн сургалт, эрдэм шинжилгээний ажлын хөгжлийн чиг хандлагын талаар судалж, дүгнэлт хийх болно.

Судалгааны арга зүй: Судалгааны хүрээнд түүхчлэх, харьцуулах, статистик болон баримт бичигт дүн шинжилгээ хийх арга зүйг ашигласан. Дотоод хэргийн их сургуулийн Цагдаагийн сургуулийн Эрүүгийн эрх зүй, криминологийн тэнхимийн сургалтын үйл ажиллагааны тайлан, тус тэнхимийн багш нарын өөрийн үнэлгээний судалгаанд оролцсон 684 орчим суралцагчдын санал асуулгын дүн, МУИС-ийн Хууль зүйн сургууль, Хүмүүнлэгийн Ухааны Их сургуулийн харьяа “Билиг” сургууль, Монголын Үндэсний Их сургуулийн Хууль зүйн сургууль, Отгонтэнгэр их сургуулийн Хууль зүйн сургуулийн эрх зүйч хөтөлбөрт тус тус дүн шинжилгээ хийсэн болно.

¹ Ч.Нямсүрэн. Эрх зүйн ерөнхий онол. УБ., 2010. 33 дахь тал



Энэхүү судалгааны ажлын хүрээ зөвхөн Дотоод хэргийн сургуулийн орчинд хийгдсэн болно.

1. Монгол Улс дахь хууль зүйн их, дээд сургуулиудад эрүүгийн эрх зүйн сургалт явуулж буй байдал:

Монгол Улсын Үндэсний статистикийн хорооны судалгааны дүнгээс үзэхэд, 2019 оны 6 дугаар сарын 18-ны өдрийн байдлаар Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй дээд боловсролын сургалтын байгууллага 94 байгаагаас 26 хувь нь бизнес, удирдлага, эрх зүй мэргэжлийн чиглэлд хамаарч байна.²

Монгол Улсын Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2015 оны 3 дугаар сарын 13-ны өдрийн А/78 дугаар тушаалаар “Дээд боловсролын байгууллагад мөрдөх бакалаврын мэргэжлийн чиглэл, индекс”-ийг баталсан.³ Энэ шийдвэрийг хэрэгжүүлэх хүрээнд “Эрх зүй” хөтөлбөрөөр сургалтын үйл ажиллагаа явуулж байгаа их, дээд сургуулийн сургалтын хөтөлбөрт дүн шинжилгээ хийж үзэхэд, “Эрүүгийн эрх зүй ерөнхий анги”, “Эрүүгийн эрх зүй тусгай анги” хичээлийг заавал судлах хичээлийн багцад хамааруулан тусгасан нь тухайн хичээлийн ач холбогдлыг тодорхойлж байна.

Хууль зүйн их, дээд сургуулиудын мэргэшүүлэх чиглэл, үйл ажиллагааны онцлогоос хамаарч хууль зүйн салбарыг дараах 4 чиглэлд хувааж сургалтын үйл ажиллагаа явуулж байна. Үүнд: 1) Үндсэн хууль, захиргааны эрх зүй, 2) Эрүүгийн эрх зүй болон эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх эрх зүй, 3) Иргэний болон бизнесийн эрх зүй, 4) Олон улсын эрх зүй зэрэг болно. Судалгаанаас үзэхэд, аль салбар эрх зүйгээр мэргэшүүлж байгаагаас үл хамааран эрүүгийн эрх зүй хичээлийг заавал судлах хичээлд хамааруулсан байна. Хүснэгт №1 Хууль зүйн их, дээд сургуулийн төлөөлөл 7 сургуулийн “Эрүүгийн эрх зүй” хичээлийн багц цаг, заах улирал, судлах хэлбэрийг харуулав.

Хүснэгт №1. Хууль зүйн их, дээд сургуулиудын “Эрүүгийн эрх зүй” хичээлийн багц цагийн мэдээлэл

№	Сургууль	Хичээл	Багц цаг	Заах улирал	Судлах хэлбэр
1	ХУИС-ийн харьяа Билиг сургууль	Эрүүгийн эрх зүй /ерөнхий анги/	2	III	Заавал судлах
		Эрүүгийн эрх зүй /тусгай анги/	2	IV	
2	МУИС	Эрүүгийн эрх зүй /ерөнхий анги/	3	I	Заавал судлах
		Эрүүгийн эрх зүй /тусгай анги/	3	V	
3	Отгонтэнгэр их сургууль	Эрүүгийн эрх зүй /ерөнхий анги/	2	III	Заавал судлах
		Эрүүгийн эрх зүй /тусгай анги/	2	IV	
4	МУИС	Эрүүгийн эрх зүй /ерөнхий анги/	3	III	Заавал судлах
		Эрүүгийн эрх зүй /тусгай анги/	3	IV	

² Монгол Улсын Үндэсний статистикийн хороо. *Монгол Улсын нийгэм, эдийн засгийн байдлын илтгэл*. УБ., 2019

³ Монгол Улсын Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2015 оны 3 дугаар сарын 13-ны өдрийн А/78 дугаар тушаалын хавсралт



Их засаг олон улсын их сургууль	Эрүүгийн эрх зүй /ерөнхий анги/	2	III	Заавал судлах
	Эрүүгийн эрх зүй /тусгай анги/	2.5	IV	
Шихихутуг	Эрүүгийн эрх зүй /ерөнхий анги/	3	III	Заавал судлах
	Эрүүгийн эрх зүй /тусгай анги/	3	IV	
ДХИС	Эрүүгийн эрх зүй /ерөнхий анги/	3	VI	Заавал судлах
	Эрүүгийн эрх зүй /тусгай анги/	3	V	

Дээрх судалгаанаас харахад, Отгонтэнгэр их сургуулийн Хууль зүйн сургууль, Хүмүүнлэгийн Ухааны Их сургуулийн харьяа Билиг сургууль “Эрүүгийн эрх зүй: ерөнхий анги”, “Эрүүгийн эрх зүй: тусгай анги” хичээлийг тус бүр 2 багц цаг, нийт 4 багц цаг судалж байгаа бол Их засаг олон улсын их сургуулийн Хууль зүйн сургуульд нийт 4.5 багц цаг, бусад сургуулийн хувьд нийт 6 багц цагийн багтаамжтайгаар судалж байна. Монгол Улсын Их сургуулийн Хууль зүйн сургуульд “Эрүүгийн эрх зүй: ерөнхий анги” хичээл I улиралд заагдаж, “Эрүүгийн эрх зүй, тусгай анги” хичээл V дугаар улиралд заагдаж байгаа нь сонирхол татаж байна.

“Эрүүгийн эрх зүй” хичээлийг гүнзгийрүүлэн судлах хичээлийн хүрээнд Монгол Улсын Их сургуулийн Хууль зүйн сургуульд “Эрүүгийн хууль тогтоомжийн хэрэглээ”, Дотоод хэргийн их сургуульд “Гэмт хэргийн зүйлчлэлийн онол” хичээлийн хүрээнд 3 багц цагийн сургалт явагдаж байна.

Дотоод хэргийн их сургуульд Эрүүгийн эрх зүйн сургалт явуулж ирсэн уламжлал, хүний нөөцийн асуудал:

Эрүүгийн эрх зүйн сургалтын үйл ажиллагаа нь эрүүгийн хууль тогтоомжийн түүхэн хөгжилттэй салшгүй холбоотой. Монгол Улсын эрүүгийн хууль тогтоомж 1921 оны Ардын хувьсгалаас өнөөг хүртэл 90 гаруй жилийн турш хөгжлийн адармаатай түүхэн замналыг туулж энэ хугацаанд 1926, 1929, 1934, 1942, 1961 онд шинээр, 1986 онд шинэчлэн найруулагдан батлагдсан байна. Шинэ Үндсэн хуулийн үзэл баримтлал, агуулгад нийцүүлэн эрүүгийн хууль тогтоомжийг шинэчлэх зайлшгүй шаардлагаар 1993, 2002, 2015 онд Эрүүгийн хуулийг шинэчлэн найруулж, 2017 оны 5 дугаар сарын 11-ний өдөр нэмэлт, өөрчлөлт оруулж, 2017 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс хүчин төгөлдөр үйлчилж эхлээд байна.

Дээрх түүхэн цаг хугацаанд одоогийн Дотоод хэргийн их сургуулийн бүтцэд эрүүгийн эрх зүйн сургалт явуулах чиг үүрэг бүхий нэгж ажиллаж, тус сургуулийн эрдэмтэн багш, судлаачид эрүүгийн хууль тогтоомжийг боловсруулах, сургалт явуулах арга хэмжээг тасралтгүй явуулж ирсэн.

Дотоод хэргийн их сургуулийн Цагдаагийн сургуулийн Эрүүгийн эрх зүй, криминологийн тэнхимийн анхны суурь 1974 онд Цэргийн тусгай дунд сургуулийг хорооны эрхтэйгээр байгуулагдахад Хуулийн кафедр⁴ ажиллах болсноор тавигдсан. Хуулийн кафедрин даргаар 1974 оноос эрүүгийн эрх зүйн мэргэжилтэн Т.Батсүх, 1980 оноос Л.Гарамжил нар томилогдон ажилласан байна.⁵ Тус тэнхимд багшаар С.Бадарчи, Д.Цэрэнсодном, 1975 оноос Б.Дашзэвэг, Ц.Итгэл, С.Дашцэдэн, Н.Авирмэд, 1976 оноос Л.Гарамжил, Б.Балдан-Ёндон, С.Цэдэн, 1977 оноос С.Жанцан, Ц.Донров, 1979 оноос

⁴ Д.Дашдэмбэрэл. Манай сургуулийнхан. УБ., 2000. 41 дэх тал

⁵ С.Бадарч. Нийгмийг аюулаас хамгаалах яамны Цэргийн тусгай дунд сургууль (1974-1983) УБ., 1999. 18 дахь тал



С.Халидолда, И.Төмөрбаатар, Д.Цолмон, 1980 оноос Д.Энхбат, 1981 оноос Б.Бат-Эрдэнэ, лаборантаар Д.Цэрэнжав, Дорж нар, нууц номын санчаар Цуу, Туул нар ажиллаж байв.⁶

1982 онд НАХЯ-ны Цэргийн дээд сургууль болгон өргөтгөхөд “Тусгай албаны тэнхим”-ийг байгуулжээ.⁷ Цэргийн тусгай дунд сургуулийн Хуулийн кафедр нь эрүүгийн эрх зүй, эрүүгийн байцаан шийтгэх эрх зүй, засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн эрх зүй, криминалистик, криминологи, шуурхай эрэн сурвалжлах ажиллагаа зэрэг мэргэжлийн хичээлийн сургалтыг 12-48 цагийн багтаамжтайгаар явуулж иржээ. Тэнхимийн даргаар Д.Тархаашин, багшаар Со.Бадарч, О.Нямдаваа, Ж.Долгорсүрэн С.Жанцан, С.Дуламдорж, Д.Цолмон, Б.Дашзэвэг, Мөрөндэлгэр, Д.Дамдин, Н.Баянбат нар томилогдон ажилласан байна.

Эрүүгийн ба эрүүгийн байцаан шийтгэх эрх зүйн тэнхимд харьяалагдах эрүүгийн эрх зүйн хичээлийг Кафедрын эрхлэгч Т.Батсүх, эрүүгийн байцаан шийтгэх эрх зүйн хичээлийг Ц.Итгэл, Д.Энхбат, криминологи хичээлийг С.Жанцан, И.Төмөрбаатар, С.Халидолда нар зааж байжээ.

1985 оноос тус тэнхимийн даргаар криминологийн сэдвээр ЗХУ-д дэд эрдэмтний зэрэг хамгаалсан Р.Ёндондэмбэрэл ажиллаж эхэлсэн байна. Энэ үед тус тэнхимд багшаар хууль зүйн ухааны дэд эрдэмтэн Д.Цогт-Очир, А.Лхагва, О.Энхбат, Б.Ганчулуун, Ц.Амгаланбаяр, Ч.Даваа, Ж.Болдбаатар нар томилогдон ажиллажээ.

НАХЯ-ны дээд сургуульд эрдмийн цол, зэрэгтэй багш нар ихээр шаардагдаж байсныг харгалзан ЗСБНХУ-ын Дотоод явдлын яам, манай НАХЯ-ны хооронд байгуулсан гэрээний дагуу хэрэгжих адьонктурын эчнээ сургалтад багш Со.Бадарч, Б.Дашзэвэг, өдрийн сургалтад багш С.Жанцан нар тус тус хамрагдан суралцаж байсан нь тэнхимийн эрдэм шинжилгээ, судалгааны ажлын эхлэл болсон гэж үзэх бүрэн үндэстэй.⁸

Со.Бадарч адьонктурт эчнээгээр амжилттай суралцан 1984 онд, С.Жанцан 1985 онд хууль зүйн ухааны дэд эрдэмтний зэргийг ЗХУ-ын ДЯЯ-ны Академийн эрдмийн зөвлөлд хамгаалсан юм. Тус тэнхимийн багш О.Нямдаваа, Ж.Долгорсүрэн, А.Лхагва нар 1984 оноос ЗХУ-ын ДЯЯ-ны Академийн адьонктурт эчнээгээр, төр, эрх зүйн тэнхимийн багш Б.Бат-Эрдэнэ, 1986 оноос өдрөөр суралцаж эхэлсэн нь тус дээд сургуулийг эрдэмжүүлэх талаар НАХЯ-ны удирдлагаас явуулж байсан эхэлсэн бодлогын бодит биелэл байлаа.

1990 онд БНМАУ-ын НАХЯ татан буугдсантай холбогдуулан БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн шийдвэрээр ЦСЕГазар болгон өөрчлөн зохион байгуулсан ба 1990 оны 1 дүгээр сарын 19-ний өдрийн 192 дугаар тогтоолоор УЦСЕГ-ын зохион байгуулалтын бүтцийг шинээр батлахад түүний харьяа байгууллагад Цагдан сэргийлэхийн дээд сургууль багтсан байдаг. Хожим 1992 онд ЦЕГ-ын харьяа Цагдаагийн дээд сургууль болон өөрчлөгдсөн бөгөөд одоогийн тэнхимийн харьяалан зааж буй хичээлүүд болох эрүүгийн эрх зүй, криминологи, гэмт хэргийн зүйлчлэлийн онол хичээлийг дэд доктор, хурандаа Р.Ёндондэмбэрэл эрхлэгчтэй Хуулийн тусгай тэнхимийн багш нар зааж байжээ.

1992 оны нэгдүгээр сараас тус тэнхимийн эрхлэгчээр дэд хурандаа Х.Доржпалам томилогдон ажилласан ба Монгол Улсын эрүүгийн эрх зүй хичээлийг ахлах багш, дэд доктор, дэд хурандаа С.Жанцан, багш ахлах, дэслэгч Г.Гантөмөр, криминологи хичээлийг хошууч Б.Ганчулуун, хошууч Ц.Амгаланбаяр, ахмад Б.Болд, эрүүгийн байцаан шийтгэх эрх зүй хичээлийг дэд хурандаа О.Нямдаваа, ахмад Д.Зүмбэрэллхам нар зааж байлаа.

ЦЕГ-ын даргын 1994 оны 45 дугаар тушаалаар Цагдаагийн дээд сургуульд “Эрүүгийн цагдаагийн албаны тэнхим”, “Мөрдөн байцаах албаны тэнхим”-ийг байгуулж, Эрүүгийн эрх зүй, криминологийн хичээл нь Эрүүгийн цагдаагийн албаны, Эрүүгийн байцаан шийтгэх эрх зүй хичээл нь Мөрдөн байцаах албаны тэнхимд харьяалагдаж байв.

Эрүүгийн цагдаагийн албаны тэнхимийн эрхлэгчээр дэд хурандаа Х.Доржпалам, ахлах багшаар дэд доктор, дэд хурандаа А.Лхагва, дэд хурандаа Ю.Сэрсэнжав, багшаар ахмад Г.Гантөмөр, М.Мөнхбаяр, Д.Бямбадолгор, ахлах дэслэгч Б.Баяраа, Д.Адъяабазар, туслах ажилтнаар Д.Нямаа, С.Туяа, Д.Ягаанцэцэг, Х.Тунгалаг нар ажиллаж байлаа.

Эрүүгийн цагдаагийн албаны болон Мөрдөн байцаах албаны тэнхим нь 1994 оноос практик байгууллагад ажиллаж байсан болон шинэ залуу багш, боловсон хүчнээр бэхжиж,

⁶ Д.Дашдэмбэрэл. Манай сургуулийнхан. УБ., 2000. 45 дахь тал

⁷ Д.Дашдэмбэрэл. Манай сургуулийнхан. УБ., 2000. 45 дахь тал

⁸ Д.Дашдэмбэрэл. Манай сургуулийнхан УБ., 2000. 60 дахь тал



1994 онд Хан-Уул дүүргийн Мөрдөн байцаах тасгийн даргаар ажиллаж байсан ахмад Д.Нямдорж, 1995 онд УМБГ-ын мөрдөн байцаагч, ахмад Б.Цоодол, 1995 онд ЦДС-ийг онцсайн дүнтэй төгссөн, ахлах дэслэгч Д.Адъяабазар, 1996 онд ХУД-ийн Цагдаагийн хэлтсийн ахлах мөрдөн байцаагчаар ажиллаж байсан, ахмад Т.Оюунчимэг нар томилогдон эрүүгийн ба эрүүгийн байцаан шийтгэх эрх зүйн хичээлийг зааж байсан эрүүгийн эрх зүй, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх эрх зүйн хичээлийн хөгжилд чухал алхам болсон.

1997 оны ЦЕГ-ын даргын 274 дугаар тушаалаар Эрүүгийн ба эрүүгийн байцаан шийтгэх эрх зүйн тэнхимийг шинээр байгуулснаар өөр тэнхимүүдэд харъяалагдаж байсан хичээлүүд болон багш нар нэг тэнхимд харъяалагдсан. 1997-1998 онд хошууч Д.Нямдорж тус тэнхимийн эрхлэгчийн үүрэг гүйцэтгэгчээр, 1998-2001 онд дэд хурандаа С.Халидолда тэнхимийн эрхлэгчээр ажилласан ба ахлах багш, дэд хурандаа Ж.Болдбаатар, хошууч Б.Цоодол, Д.Нямдорж, Т.Оюунчимэг, Г.Гантөмөр, Ц.Болдбаатар, ахмад Д.Адъяабазар нар ажиллаж байв. 1997 онд УМБГазарт мөрдөн байцаагчаар ажиллаж байсан ахлах дэслэгч Б.Батзориг тус тэнхимд багшаар томилогдон ажилласан байна.

Монгол Улсын Засгийн газрын 2000 оны 2 дугаар сарын 2-ны өдрийн 17 дугаар тогтоолоор Цагдаагийн академи байгуулагдахад “Эрүүгийн эрх зүй ба эрүүгийн байцаан шийтгэх эрх зүйн тэнхим”-ийг байгуулж, 2000 оны 4 дүгээр сараас 2001 оны 2 сар хүртэл дэд хурандаа С.Халидолда, дэд хурандаа Т.Оюунчимэг нар Эрүүгийн эрх зүйн тэнхим, ЭБШЭЗүйн тэнхимийн эрхлэгч, эрхлэгчийн үүрэг гүйцэтгэгчээр, 2001 оны 2 дугаар сарын 1-ний өдрөөс хошууч Г.Гантөмөр Эрүүгийн эрх зүйн тэнхимийн, дэд хурандаа Ч.Даваа ЭБШЭЗүйн тэнхимийн эрхлэгчээр тус тус томилогдон ажиллаж байв. Энэ хугацаанд Эрүүгийн эрх зүйн тэнхим нь ахлах багш, дэд хурандаа С.Халидолда, Ж.Болдбаатар, хошууч Д.Адъяабазар, ахмад Б.Батзориг, туслах ажилтан Г.Бадмаараг, Д.Оюунгэрэл нарын, ЭБШЭЗүйн тэнхим нь ахлах багш, дэд хурандаа Т.Оюунчимэг, Д.Нямдорж, Ц.Болдбаатар, багш, ахмад Б.Болд, туслах ажилтан Б.Ууганбаяр нарын бүрэлдэхүүнтэй ажиллаж байлаа. 2002 оны 10 дугаар сард Орхон аймгийн Цагдаагийн газрын эрүүгийн төлөөлөгч, ахлах дэслэгч О.Амарсайхан, 2003 оны 4 дүгээр сард УМБГ-ын III хэлтсийн мөрдөн байцаагч, ахлах дэслэгч Б.Эрдэнэбилэг нар Эрүүгийн эрх зүй, ЭБШЭЗүйн тэнхимд багшаар томилогдон ажиллаж эхэлжээ.

ЦЕГ-ын даргын 2003 оны 4 дүгээр сарын 5-ны өдрийн тушаалаар “Эрүүгийн ба эрүүгийн байцаан шийтгэх эрх зүйн тэнхим”-ийг байгуулж, мөн оны 6 дугаар сарын 1-ний өдрөөс хууль зүйн шинжлэх ухааны доктор, профессор, цагдаагийн хурандаа С.Жанцан тэнхимийн эрхлэгчээр томилогдсон ба тус тэнхим нь ахлах багш, дэд хурандаа Т.Оюунчимэг, дэд хурандаа Г.Гантөмөр, хошууч А.Отгонбаатар, ахмад Б.Батзориг, багш, ахмад О.Амарсайхан, ахлах дэслэгч Б.Эрдэнэбилэг, ахмад И.Чимэдбадам, туслах ажилтан Б.Ууганбаяр, М.Март, Ц.Эрдэнэдолгор нар тус тус ажиллаж байлаа.⁹ Тус тэнхим нь “Эрүүгийн эрх зүй: ерөнхий анги”, “Эрүүгийн эрх зүй: тусгай анги”, “Гэмт хэргийн зүйлчлэлийн онол”, “Криминологи” хичээлийг тус бүр 4 багц цагийн агуулгатайгаар зааж ирсэн нь эрүүгийн эрх зүй чиглэлээр мэргэшсэн албан хаагчдыг бэлтгэхэд чухал алхам болсон. Мөн дээрх хичээлүүдээс гадна эрүүгийн байцаан шийтгэх эрх зүй, мөрдөх арга зүйн чиглэлийн 15 орчим хичээлийг зааж байсан бөгөөд засан хүмүүжлүүлэх хөдөлмөрийн эрх зүй, гүйцэтгэх ажлын холбогдох хичээлүүдийг мэргэжлийн бусад тэнхимүүдэд шилжүүлсэн байна.

ЦЕГ-ын даргын 2007 оны 1 дүгээр сарын 17-ны өдрийн 20 дугаар тушаалаар¹⁰ “Эрүүгийн ба эрүүгийн байцаан шийтгэх эрх зүйн тэнхим”-ийг салгаж, “Эрүүгийн эрх зүйн тэнхим”-ийг анх удаа бие даасан нэгж болгон байгуулсан нь эрүүгийн эрх зүйн шинжлэх ухааныг хөгжүүлэх, тус тэнхимийн харьяалан заадаг хичээлийг өргөжүүлэх, мэргэшсэн судлаач, багш, албан хаагчдыг бэлтгэх, магистр, докторын шатны сургалтад эрүүгийн эрх зүйн чиглэлийн сургалтыг дагнан явуулахад ач холбогдолтой ажил болсон.

ЦЕГ-ын даргын 2008 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн 568 дугаар тушаалаар “Эрүүгийн эрх зүй, криминологийн тэнхим”, Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 7

⁹ С.Жанцан. Эрүүгийн эрх зүйн шинжлэх ухааны хөгжил, цаашдын чиг хандлага. Гэмт явдалтай тэмцэх айболоонол арга зүйн улирал тутмын сэтгүүл, УБ., 2004. 12.

¹⁰ Цагдаагийн сургуулийн Эрүүгийн эрх зүй, криминологийн тэнхимийн архивын материал, хавтас № 13, 2008 он



дугаар сарын 6-ны өдрийн 229 дүгээр тогтоолоор Дотоод хэргийн их сургуулийн “Эрүүгийн эрх зүйн тэнхим”, 2014 оны 10 дугаар сард Хууль зүйн сайдын тушаалаар Хууль сахиулахын их сургуулийн Цагдаагийн сургуулийн “Эрүүгийн эрх зүй, криминологийн тэнхим”-ийг бие даасан хэлбэрээр ажиллуулж байсан нь өмнөх бодлогыг үргэлжлүүлсэн гэж үзэх үндэстэй. Харин 2008, 2014 онд тэнхимийн нэрийг “Эрүүгийн эрх зүй, криминологийн тэнхим” гэж нэрлэсэн нь эрүүгийн эрх зүйн сургалтаас гадна гэмт явдлын шалтгаан, нөхцөлийг судлах чиглэлд анхаарал хандуулж байсныг илэрхийлж байна.

2003-2008 онд тус тэнхимийн эрхлэгчээр **хууль зүйн шинжлэх ухааны доктор, профессор, цагдаагийн хурандаа С.Жанцан**, 2008 оны 7 дугаар сараас тэнхимийн эрхлэгчээр хууль зүйн ухааны доктор, цагдаагийн хурандаа Г.Гантөмөр ажилласан байна. Энэ үед ахлах багшаар цагдаагийн хошууч О.Амарсайхан, цагдаагийн дэд хурандаа Т.Мөнхдалай, А.Отгонбаатар, багшаар цагдаагийн дэслэгч Б.Энхболд, Л.Бат-Очир, туслах ажилтнаар Ц.Эрдэнэдолгор нар ажиллаж байсан.

2011 оны 7 дугаар сард Цагдаагийн академи нь Дотоод хэргийн их сургууль болон өргөжиж, тус тэнхим нь Цагдаагийн сургуулийн Эрүүгийн эрх зүйн тэнхим болж, тэнхимийн эрхлэгчээр ажиллаж байсан хууль зүйн доктор, цагдаагийн хурандаа Г.Гантөмөр 2011 оны 12 дугаар сарын 12-ны өдөр Дотоод хэргийн их сургуулийн дэд захирал бөгөөд сургалтын бодлогын газрын даргаар томилогдсонтой холбоотойгоор тэнхимийн эрхлэгчийн үүрэг гүйцэтгэгчээр цагдаагийн дэд хурандаа Т.Мөнхдалай ажиллаж, ахлах багшаар цагдаагийн дэд хурандаа А.Отгонбаатар, цагдаагийн ахлах дэслэгч Б.Энхболд, дэслэгч Л.Бат-Очир, туслах ажилтнаар Э.Хишигбайгаль нар ажиллаж байв.

2012 оны 2 дугаар сарын 19-ний өдрөөс 2014 оны 11 дүгээр сарын 26-ны өдөр хүртэл хууль зүйн доктор, дэд профессор, цагдаагийн дэд хурандаа Д.Мягмарцэрэн тэнхимийн эрхлэгчээр, дэд профессороор цагдаагийн дэд хурандаа О.Амарсайхан, цагдаагийн ахлах дэслэгч Л.Бат-Очир, цагдаагийн ахмад С.Гантулга, багшаар цагдаагийн ахмад Э.Болорчимэг, туслах ажилтан, цагдаагийн дэд ахлагч Э.Хандармаа нар тус тус ажилласан байна.

2013 онын 2 дугаар сард ахлах багшаар ажиллаж байсан цагдаагийн ахлах дэслэгч Б.Энхболд БНСУ-д докторантурт суралцах болсон, багш, цагдаагийн ахмад Э.Болорчимэг өөр ажилд шилжин томилогдсон, ахлах багш, цагдаагийн дэд хурандаа А.Отгонбаатар, Т.Мөнхдалай нар цэргийн байнгын тэтгэвэрт гарсантай холбоотойгоор ахлах багшаар доктор, цагдаагийн ахмад Ж.Нямдулам, багшаар Б.Мөнхзул, Э.Золбоо нарыг тус тус томилон ажиллуулсан байна.

Тэнхимийн эрхлэгчээр ажиллаж байсан доктор, цагдаагийн дэд хурандаа Д.Мягмарцэрэн Цагдаагийн сургуулийн Гүйцэтгэх ажлын тэнхимийн эрхлэгчээр томилогдсонтой холбоотойгоор 2014 оны 11 сард цагдаагийн дэд хурандаа О.Амарсайханыг тэнхимийн эрхлэгчээр, хошууч Ж.Нямдуламыг дэд профессороор тус тус дэвшүүлэн томилж, 2015 оны 10 дугаар сард ахлах багш, цагдаагийн хошууч С.Гантулга Их сургуулийн Хэвлэл, редакцийн хэлтсийн даргаар тус тус дэвшин ажилласан байна.

2012 оноос эхэлсэн хууль сахиулах салбарын шинэтгэлийн хүрээнд “Зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр дагнан ажиллах чадамж бүхий Мөрдөх албыг бий болгоно” гэсэн Монгол Улсын Засгийн газрын мөрийн хөтөлбөр¹¹, түүнд нийцүүлэн гаргасан Мөрдөх албаны сургууль байгуулна гэсэн төлөвлөгөөний хүрээнд Хууль сахиулахын их сургуулийн захирлын 2016 оны 5 дугаар сарын 10-ны өдрийн Б/224 дугаар тушаалаар Эрүүгийн эрх зүй, криминологийн тэнхим, Мөрдөх ажиллагааны онол, тактикийн тэнхимүүдийг нэгтгэн Цагдаагийн сургуулийн бүтцэд “Мөрдөх албаны тэнхим”-ийг байгуулсан. Тус тэнхим нь Эрүүгийн эрх зүй, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх эрх зүй, криминологи, мөрдөн шалгах ажиллагааны тактик, сэтгэл зүйн чиглэлийн 20 гаруй хичээлийг сургалтын төлөвлөгөөний дагуу зааж байсан. Тус тэнхимийн эрхлэгчээр цагдаагийн хурандаа Б.Эрдэнэбат, дэд профессороор цагдаагийн дэд хурандаа О.Амарсайхан, ахмад Н.Манлайбаатар, Г.Амаржаргал, ахлах багшаар цагдаагийн дэд хурандаа Б.Хишигтогтох, Ө.Болдбаатар, хошууч Д.Энхбаяр, Ж.Нямдулам, Я.Цэлмэн, Л.Бат-Очир, багшаар цагдаагийн дэд хурандаа Л.Эрдэнэбаатар, ахмад Ц.Шийтэрчулуун, Ж.Мөнхжаргал, цагдаагийн дэслэгч Б.Мөнхзул, Э.Золбоо, туслах ажилтнаар ахлагч Я.Долгорсүрэн нар ажиллаж байв.

¹¹ Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр



2017 оны 11 дүгээр сард Хууль сахиулахын их сургуулийн бүтэц орон тооны өөрчлөлтөөр Мөрдөх албаны тэнхимийг Эрүүгийн эрх зүй, криминологийн тэнхим, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх эрх зүйн тэнхим болгон болгон өөрчлөн зохион байгуулж, Эрүүгийн эрх зүй, криминологийн тэнхимийн эрхлэгчээр доктор, цагдаагийн хошууч Б.Энхболд, дэд профессороор доктор, цагдаагийн хошууч С.Гантулга, ахлах багшаар цагдаагийн дэд хурандаа О.Амарсайхан, А.Амарсайхан, цагдаагийн хошууч Л.Бат-Очир, багшаар цагдаагийн ахлах дэслэгч Б.Мөнхзул туслах ажилтнаар дэд ахлагч Д.Биндэръяа нар томилогдож 2018 оны 01 сараас багшаар цагдаагийн ахмад Б.Батцэрэн, дадлагажих ажилтнаар А.Мөнхцэцэг 2018 оны 10 сараас томилогдон ажиллаж байна.

1965-2018 онд эрүүгийн эрх зүйн салбарын судлаач, багш нараас эрүүгийн эрх зүйн сэдвээр 28 хүн хууль зүйн болон хууль зүйн шинжлэх ухааны докторын зэрэг хамгаалж, нийт 65 орчим сурах бичиг, гарын авлага, нэг сэдэвт бүтээл гаргасан нь энэ салбарын хөгжлийг илэрхийлэх бөгөөд цөөнгүй хувь нь өнөөгийн Дотоод хэргийн их сургуулийн төгсөгчид байна.

3. Эрүүгийн эрх зүйн сургалт, эрдэм шинжилгээний ажлын өнөөгийн байдал:

2018-2019 оны хичээлийн жилд Цагдаагийн сургуулийн Эрүүгийн эрх зүй, криминологийн тэнхим нь “Цагдаа-хууль сахиулах ажил”, “Эрх зүйч”, “Шүүхийн шийдвэр-хууль сахиулах ажил”, “Шинжээч”, “Онцгой байдал- гамшгаас хамгаалах алба”, “Хилийн алба” бакалаврын, “Гэмт явдал судлал-эрх зүй” магистр, докторын хөтөлбөрийн 67 дамжаанд “Эрүүгийн эрх зүй: ерөнхий анги”, “Эрүүгийн эрх зүй: тусгай анги”, “Гэмт хэргийн зүйлчлэлийн онол”, “Криминологи”, “Криминологийн онол” хичээлээр 94.8 багц цагийн сургалт явуулахаар төлөвлөснөөс 112.32 багц цагийн гүйцэтгэлтэй байна. Багш тус бүрийн ачааллыг хүснэгтээр үзүүлбэл:

Хүснэгт.2

Албан тушаал	Улирал	Нийт багц цаг	Гүйцэтгэсэн багц цаг	Гүйцэтгэвэл зохих багц цаг	Илүү гүйцэтгэсэн багц цаг
Тэнхимийн эрхлэгч	I	9.47	16.76	12	4.76
	II	7.29			
Дэд профессор	I	10.17	19.06	12	7.06
	II	8.89			
Ахлах багш	I	10	10	6.4	3.6
Ахлах багш	I	12.51	17.16	16	1.16
	II	4.65			
Ахлах багш	I	11.53	16.18	16	0.18
	II	4.65			
Багш	I	12.74	18.58	18	0.58
	II	5.84			
Багш	I	5.51	14.61	14.4	0.21
	II	8.8			
	Нийт	112.35	112.35	94.8	17.55

Дээрх судалгаанаас үзвэл, тэнхимийн профессор багш нар 17.55 багц цаг, нэг багш дунджаар 2.5 багц цагийн илүү гүйцэтгэлтэй ажилласан байна.

2019-2020 оны хичээлийн жилд Цагдаагийн сургууль, Хилийн сургууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн сургууль, Онцгой байдлын сургууль, Эрх зүй, нийгмийн ухааны сургууль, Шинжлэн магадлахуйн институтын 2 дугаар дамжаанд “Эрүүгийн эрх зүй: ерөнхий анги”, “Эрүүгийн эрх зүй: тусгай анги”, “Гэмт хэргийн зүйлчлэлийн онол”, “Криминологи” хичээлийг тус тэнхимээс заахаар төлөвлөсөн. Мөн “Гэмт хэргийн зүйлчлэлийн онол” хичээлийн багц цагийг 3 болгон нэмэгдүүлж байгаа, Ахисан шатны боловсролын сургуулийн “Гэмт явдал судлал-эрх зүй” магистрын хөтөлбөрийн сургалтад “Криминологийн онол”, “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга зүй”, “Гэмт хэргийн зүйлчлэлийн онол, арга зүй”, “Эрүүгийн эрх зүйн шинжлэх ухааны орчин үеийн асуудал” гэсэн 4 хичээлийн 11 багц цаг, 2019-2020 оны хичээлийн жилд “Цагдаа-хууль сахиулах ажил” хөтөлбөрөөр 430 орчим суралцагч элсүүлэн авахтай холбогдсон нэмэлт багц цаг,



“Цагдаа-гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил” хөтөлбөр хэрэгжүүлэх ажлын хүрээнд нэмэгдэх 11 багц цагийг тооцон үзвэл, одоогийн ачаалал 25 орчим багц цагаар нэмэгдэхээр байна. Иймд Эрүүгийн эрх зүй, криминологийн тэнхимийн сул байгаа ахлах багшийн орон тоонд нөхөн томилгоо хийх, цаашид үүсэх ачааллыг тооцон 1 ахлах багшийн орон тоо нэмэгдүүлэх шаардлагатай байгаа нь судалгаанаас харагдаж байна.

Багшлах бүрэлдэхүүний 2 буюу 28.5 хувь нь доктор, 5 буюу 71.4 хувь магистрын зэрэгтэй, их, дээд сургууль, практик байгууллагад 5-15 жил ажилласан албан хаагчид байна. Эрүүгийн эрх зүйн сургалтын чанар, үр нөлөө, багшлах бүрэлдэхүүний ур чадвар тодорхойлох шалгуур үзүүлэлт нь багшийн үйл ажиллагаанд өгсөн суралцагчдын сэтгэл ханамжийн үнэлгээ юм. Тиймээс дээрх асуудлыг тодруулах зорилгоор сургалтын үйл ажиллагааны талаарх “Багшийн өөрийн үнэлгээний хуудас”¹²-аар санал асуулга авч, үнэлгээг 1-5 оноогоор¹³ дүгнэж, асуулт тус бүрээр нэгтгэв.

33 дамжааны 750 сонсогч “Гэмт хэргийн зүйлчлэлийн онол”, “Эрүүгийн эрх зүйн: ерөнхий анги”, “Эрүүгийн эрх зүй: тусгай анги” хичээлийг судалж, 684 сонсогч санал асуулгад оролцсон.

Санал асуулгын дүнг Хүснэгт №2-т үзүүлэв.

Хүснэгт. 3

Санал асуулгын дүн											
		1		2		3		4		5	
№	Асуулт	Тоо	(%)	Тоо	(%)	Тоо	(%)	Тоо	(%)	Тоо	(%)
1.	Тухайн хичээлийн цаг сэдвийн төлөвлөгөөний дагуу бэлтгэсэн байдал	3	0.4	-	-	6	0.8	131	19.1	544	79.5
2.	Тухайн хичээлийн агуулгыг багш бүрэн эзэмшсэн байдал	1	0.1	2	0.2	3	0.4	116	16.9	562	82.1
3.	Сэдэвтэй холбоотой асуудлуудыг оновчтой хүргэж тайлбарлах ур чадвар	1	0.1			5	0.7	136	19.8	542	79.2
4.	Семинар дасгалын хичээлийг тодорхой тохиолдол шинжлэх, шүүхийн практиктай холбож заасан эсэх	-	-	3	0.4	7	0.9	163	23.8	511	74.7
5.	Суралцагч бүрийн оролцоог хангах, санал бодлыг хүлээж авах зэрэг сургалтын идэвхтэй арга ашигласан эсэх	-	-	2	0.2	6	0.8	176	25.7	500	73.0
6	Сургалтын төгсгөлд хичээлийн агуулгатай холбоотойгоор таны мэдлэг, чадвар, хандлагад	-	-	-	-	8	1.1	150	21.9	526	76.9

¹² Багшийн өөрийн үнэлгээний хуудсыг материалд хавсаргав.

¹³ 1-Маш муу, 2- Муу, 3-Дунд зэрэг, 4-Сайн, 5 Маш сайн гэсэн утга илэрхийлнэ.



гарсан өөрчлөлт										
-----------------	--	--	--	--	--	--	--	--	--	--

Судалгаанд оролцогчдын 73-аас дээш хувь нь 5 гэсэн үнэлгээ өгсөн байгаа нь эрүүгийн эрх зүйн хичээл зааж буй багшийн ур чадварыг бүхэлд нь сайн гэж үнэлсэн үзүүлэлт юм. Судалгаанд оролцогчдын цөөн хувь нь тухайн хичээлийн цаг сэдвийн төлөвлөгөөний дагуу бэлтгэсэн байдал, тухайн хичээлийн агуулгыг багш бүрэн эзэмшсэн байдал, сэдэвтэй холбоотой асуудлыг оновчтой хүргэж, тайлбарлах чадвар гэсэн асуултад “Сэтгэл ханамжгүй” байгаагаа илэрхийлсэн нь анхаарал татаж байна.

Дээрх судалгаанд оролцогчдоос тухайн ангид хичээл орсон багш судалгааг авсан нь судалгааны үнэн байдлыг алдагдуулахад хүрсэн байж болзошгүй гэж үзэж, 160 суралцагчийн дунд дээрх асуултаар чанарын судалгааг давтан хийж, дүнг нэгтгэсэн болно. Чанарын судалгааны дүн, эхний асуулгын дүнтэй зарим талаараа зөрүүтэй гарсныг анхаарах зүйтэй. Чанарын судалгаанд оролцсон суралцагчдын 32.6 хувь нь “Суралцагч бүрийн оролцоог хангах, санал бодлыг хүлээж авах зэрэг сургалтын идэвхтэй арга ашигласан эсэх” гэсэн асуултад сэтгэл ханамж дунд зэрэг, 27.9 хувь нь “Сэдэвтэй холбоотой асуудлуудыг оновчтой хүргэж, тайлбарлах ур чадвар” гэсэн асуултад сэтгэл ханамж дунд зэрэг, 10.3 хувь нь “Семинар, дасгалын хичээлийг тодорхой тохиолдол шинжлэх, шүүхийн практиктай холбож заасан эсэх” гэсэн асуултад сэтгэл ханамж дунд зэрэг байсан бол 4.6 хувь нь дээрх асуултад сэтгэл ханамжгүй гэж хариулсан байна.

Цаашид багш нарын сурган заах арга зүй, хичээлд тодорхой жишээ, судалгаа ашиглах, семинарын хичээлд суралцагчдын оролцоог хангах зэрэг асуудалд анхаарал хандуулах шаардлагатай байна.

Эрдэм шинжилгээ, судалгааны ажлын талаар:

Эрүүгийн эрх зүй, криминологийн тэнхимийн хамт олон Их сургуулийн эрдэм шинжилгээ, судалгааны ажлын нэгдсэн бодлого, стратеги хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор эрүүгийн эрх зүйн шинжлэх ухааны хөгжилд хувь нэмэр оруулахуйц цөөнгүй онолын болон хавсарга судалгааг хийж, эрүүгийн хууль тогтоомж боловсруулж, батлуулах ажлын хэсэгт ажиллаж, эрүүгийн эрх зүйн чиглэлийн үндэсний хэмжээний сурах бичиг, гарын авлага боловсруулж, эрдэм шинжилгээний өгүүллийг гадаадын өндөр хянан магадлагаа бүхий мэргэжлийн сэтгүүлд нийтлүүлсэн бахдам амжилтыг гаргасан. Тухайлбал,

- Доктор Б.Энхболд, цагдаагийн дэслэгч Б.Батцэрэн нар “Гэмт хэрэгтэй тэмцэх төрийн бодлого”, доктор, дэд профессор С.Гантулга, цагдаагийн ахмад Л.Бат-Очир нар “Төрийн эрүүгийн бодлого” боловсруулах ажлын хэсэгт гишүүнээр ажилласан.

- Доктор Б.Энхболд, доктор, дэд профессор С.Гантулга нар Хууль зүй, дотоод хэргийн сайдын тушаалаар байгуулагдсан Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн шинэчилсэн найруулга, нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулах Монгол Улсын Засгийн газрын болон УИХ-ын Хууль зүйн байнгын хорооны ажлын хэсэг, ажлын дэд хэсэгт гишүүнээр ажилласан.

- Их сургуулийн захиалгаар доктор Б.Энхболд, доктор, дэд профессор С.Гантулга нар “Эрүүгийн эрх зүй: тусгай анги” сурах бичиг, Хууль зүй, дотоод хэргийн яамны захиалгаар доктор, дэд профессор С.Гантулга төрийн захиргаа, шүүх, прокурорын байгууллагын албан хаагчидтай хамтран “Эрүүгийн хууль /шинэчилсэн найруулга/”, “Зөрчлийн тухай хууль /шинэчилсэн найруулга/” сургагч багшийн гарын авлага, доктор Б.Энхболд “Шүүхийн сургалтын чадавхийг бэхжүүлэх нь” төслийн үндэсний зөвлөхөөр ажиллаж, “Эдийн засгийн гэмт хэрэг” сургагч багшийн гарын авлага, Доктор Б.Энхболд, С.Гантулга нар Монголын криминологичдын холбооноос эрхлэн гаргасан “Монгол Улс дахь гэмт хэргийн цагаан ном-2016”, “Монгол Улс дахь гэмт хэргийн цагаан ном-2017” бүтээлийн хамтран зохиогчоор цагдаагийн ахмад Л.Бат-Очир “Гэмт этгээдийг баривчлах, гэмт хэргийн шинжтэй үйлдлийг таслан зогсоох хэм хэмжээ” нэг сэдэвт бүтээлийг тус тус туурвисан.

- Доктор Б.Энхболд ЦЕГ-ын захиалгаар Нээлттэй нийгэм хүрээлэнгийн санхүүжилтээр “Цагдаагийн байгууллага: хэрэглэгчийн үнэлгээ-2017” судалгааны удирдагчаар ажиллаж, 21 аймгийн 1000 орчим иргэд, 220 гаруй байгууллагын төлөөллөөс судалгааг авч, үр дүнг нэгтгэн, судалгааны тайланг хүлээлгэн өгч, зохиогчийн эрхийн гэрчилгээ авсан байна.



- Доктор Б.Энхболд “Confidence in the Police among Mongolian Immigrants in Korean and Native Mongolians in the home country: A Comparative Test of Conceptual” эрдэм шинжилгээний өгүүллийг олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн, нийгмийн шинжлэх ухааны салбарт ишлэл авах эрх бүхий импакт, фактор бүхий “International journal of law, Crime and Justice” сэтгүүлийн 2017 оны №2 дугаарт нийтлүүлсэн. Энэхүү өгүүллийг нийтлүүлснээр цагдаа судлалын чиглэлээр Зүүн болон Зүүн өмнөд Азийн орнуудаас өндөр хянан магадлагаа бүхий сэтгүүлд өгүүлэл нийтлүүлсэн 6 дахь улс, Монгол Улсаас хууль зүйн салбарыг төлөөлөх анхны бүтээл болсон.

- Эрүүгийн эрх зүй, криминологийн тэнхим нь бусад сургалт, эрдэм шинжилгээний байгууллагатай хамтран Монгол Улсын Гавьяат хуульч, доктор (Sc.D), профессор, цагдаагийн хурандаа С.Жанцан агсаны нэрэмжит эрдэм шинжилгээний олон талт арга хэмжээг жил бүр уламжлал болгон зохион байгуулж ирсэн.

- Л.Бат-Очир “Гэмт этгээдийн баривчлах, саатуулах үед гэм хор учруулах үйлдэл: онол, эрх зүйн зохицуулалтын зарим асуудал” сэдэвт хууль зүйн докторын зэрэг горилсон бүтээл бичиж, хамгаалуулах зөвлөлөөр хэлэлцүүлэхэд бэлэн болоод байна.

- Хууль зүй, дотоод хэргийн яам, Дотоод хэргийн их сургууль, Азийн сан хамтран “Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч төвтэй хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа: Албан хаагчдыг чадавхжуулах нь” төсөл амжилттай хэрэгжүүлж, төслийн хүрээнд сургагч багшийн болон суралцагчийн гарын авлага, сургалтын хөтөлбөр боловсруулж, шүүх, прокурор, цагдаа, хил хамгаалах, гадаадын иргэн, харьяатын албаны 600 гаруй албан хаагч, Дотоод хэргийн их сургуулийн 2000 орчим сонсогчийг сургалтад хамруулж, Цагдаагийн сургуульд “Хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга зүйн танхим”-ийг байгуулсан.

- Тус тэнхимээс “Гэмт явдалтай тэмцэх асуудал” онол, арга зүйн сэтгүүлийг 17 дахь жилдээ тасралтгүй эрхлэн гаргаж байна.

4. Эрүүгийн эрх зүйн сургалт, эрдэм шинжилгээний ажлын хөгжлийн чиг хандлага:

1. Эрүүгийн эрх зүйн сургалтын шаталсан тогтолцоонд шилжих.

Өнөөгийн байдлаар Дотоод хэргийн их сургуулийн Цагдаагийн сургуулийн “Цагдаагийн ажил-эрх зүй”, Ахисан шатны боловсролын сургуулийн “Гэмт явдал судлал-эрх зүй” магистр, докторын сургалтын хөтөлбөрийн уялдаа холбоог сайжруулах, тэнхим, төвтэй сургалт, эрдэм шинжилгээний тогтолцоонд шилжиж, багшлах бүрэлдэхүүний орон тоог нэмэгдүүлэх. Тухайлбал, “Гэмт явдал судлал-эрх зүй” магистр, докторын сургалтын хөтөлбөрийн “Эрүүгийн эрх зүйн философи”, “Эрүүгийн эрх зүйн шинжлэх ухааны орчин үеийн асуудал”, “Эрүүгийн эрх зүйн уламжлал судлал”, “Эрүүгийн эрх зүйн харьцуулсан судлал”, “Гэмт хэргийн зүйлчлэлийн онол, арга зүй”, “Эрүүгийн хариуцлагын орчин үеийн асуудал” зэрэг хичээлийг Эрүүгийн эрх зүй, криминологийн тэнхимд төвлөрүүлж, Эрүүгийн эрх зүйн шинжлэх ухаанд баримтлах Дотоод хэргийн их сургуулийн номлолыг бий болгох.

2. Хөтөлбөрийн шинэчлэл-хөгжүүлэлт.

Эрүүгийн эрх зүй, криминологийн тэнхимээс “Цагдаа-гэмт хэргээс урьдчилан ажил”, “Олон улсын Эрүүгийн эрх зүй” бакалаврын сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх. “Цагдаа-гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил” хөтөлбөрийн хүрээнд гэмт явдлын шалтгаан, нөхцөл, хууль тогтоомжийн бодлогын судалгаа хийх чадвар олгоход чиглэгдсэн мэргэшүүлэх тоог нэмэгдүүлэх.

Олон улсын Эрүүгийн эрх зүй хөтөлбөрийн хүрээнд хөрвөх чадвар бүхий мэргэжилтэнг бэлтгэхэд чиглэгдэнэ. Дээрх хөтөлбөрүүдэд их, дээд сургуулийг социологич, биологич, улс төр судлаач, философи, гадаад хэл, гадаад харилцааны чиглэлээр бакалаврын боловсрол эзэмшсэн элсэгч байхаар төлөвлөх.

3. Багшийн хөгжил.

Эрүүгийн эрх зүй, криминологийн тэнхимийн орон тоог хэрэгжүүлж байгаа сургалтын хөтөлбөр, багц цагийн ачаалалд тулгуурлан нэмэгдүүлэх. Багшлах бүрэлдэхүүнийг эрдмийн зэрэгтэй профессор, судлаачдаас бүрдүүлэх бөгөөд багш судалгааны болон заах арга зүйн чадвараа тогтмол хөгжүүлэх бололцоогоор хангах, магистрын зэрэг хамгаалуулах зөвлөлийг тэнхимийн профессор багш нар түшиглэн явуулдаг болох.

4. Сурган заах арга зүйн хөгжил.



Дүрст зөвлөгөөн, ухаалаг самбар, нийтийн сүлжээ зэрэг хамтын ажиллагааны хэрэглүүрүүд нь суралцагчдыг хооронд нь холбохоос гадна багш нарыг ч мөн хичээлд оролцох боломжийг олгож байна. Мөн хэд хэдэн ур чадвар бүхий багш нар тухайлбал, онолын болон ур чадварын багш нар нэгдэн нэг хичээлийг заах боломж бүрдүүлэх, хүн бүрийн зан чанарт тохирсон заах арга зүйг хэрэглэх, технологийн дэвшлийг ашиглан багш нарт, өгөгдлийг удирдах, бүтэцлэх, шүүх болон мэдлэгийг тараах, оюутан бүрийн онцлогт тохирсон сургалтын агуулгыг хөгжүүлэх, суралцагчийн сурах явцыг тогтмол, бодит хугацаанд нь үнэлэх, үнэлгээнд тулгуурлан сайжруулах.

5. Тэнхимийн эрдэм шинжилгээний төсөв бий болгох

Профессор багш бүр судалгааны сэдэвтэй байх бөгөөд өөрийн сэдвийн хүрээнд эсвэл тэнхимийн судалгааны тэргүүлэх чиглэлээр жил бүр тэтгэлэг зарлах, тэтгэлгийн үр дүнг дотоодын болон гадаадын хянан магадлагаа бүхий сэтгүүлд нийтлэгдсэн, эшлэгдсэн эрдэм шинжилгээний бүтээлээр тооцдог тогтолцоог бүрдүүлэх.

Ном зүй

1. Д. Дашдэмбэрэл. Манай сургуулийнхан. УБ., 2000 он.
2. Ч. Нямсүрэн. Эрх зүйн ерөнхий онол. УБ., 2010 он.
3. Монгол Улсын Үндэсний статистикийн хороо. *Монгол Улсын* нийгэм, эдийн засгийн байдлын илтгэл. УБ., 2019 он.
4. Монгол Улсын Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2015 оны 3 дугаар сарын 13-ны өдрийн А/78 дугаар тушаалын хавсралт
5. С. Жанцан. Эрүүгийн эрх зүйн шинжлэх ухааны хөгжил, цаашдын чиг хандлага. Гэмт явдалтай тэмцэх асуудал онол арга зүйн улирал тутмын сэтгүүл, УБ., 2004 он. №2.
6. С. Жанцан. Монгол Улсын эрүүгийн эрх зүйн онол /гэмт хэргийн сургааль/. I боть. УБ., 2011.
7. Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр
8. Цагдаагийн сургуулийн Эрүүгийн эрх зүй, криминологийн тэнхимийн архивын материал, хавтас №13, 2008 он
9. 2018-2019 оны Цагдаагийн сургуулийн Эрүүгийн эрх зүй, криминологийн тэнхимийн багш нарын өөрийн үнэлгээний тайлан.



**ГЭМ БУРУУ, ГЭМТ ХЭРГИЙН ХӨӨН ХЭЛЭЛЦЭХ ХУГАЦААГ ТОГТООСОН
ХЭМ ХЭМЖЭЭГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД ТУЛГАМДАЖ БҮЙ АСУУДАЛ**

О.Амарсайхан

*Дотоод хэргийн их сургуулийн Удирдлагын академийн Цагдаагийн удирдлага,
стратегийн профессорын багийн дэд профессор, цагдаагийн хурандаа*

Эрүүгийн хууль тогтоомжийн шинэчлэлийн хүрээнд Монгол Улсын Их Хурал 2015 оны 12 дугаар сарын 03-ны өдөр 2002 оны Эрүүгийн хуулийг шинэчлэн найруулж улмаар уг хуульд 2017 онд нийт 4 удаа нэмэлт өөрчлөлт оруулан мөн оны 7 дугаар сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөж байгаа билээ.¹⁴

Энэхүү Эрүүгийн хууль нь уламжлалт хорих, торгох ялаас гадна нийтэд тустай ажил хийлгэх, зорчих эрхийг хязгаарлах, эрх хасах ялыг шинээр нэмсэн, цаазаар авах ялыг халсан, өсвөр насны хүнд ял оногдуулах тусгай журмыг тогтоосон зэрэг олон талаараа дэвшилттэй болсон боловч тус хуулийн ерөнхий ангид заасан гэм буруу, гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаатай холбоотой зарим хэм хэмжээ ойлгомжгүй, хоорондоо уялдаа холбоогүй, түүнийг амьдрал практикт нэг мөр ойлгож зөв хэрэглэхэд хүндрэл учруулж байгаа зэрэг нь Эрүүгийн хуулийн эдгээр хэм хэмжээг шинжлэн үзэж боловсронгуй болгох арга замыг эрэлхийлэхийг зүй ёсоор шаардаж байна.

Нэг. Гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааны талаар

Нийгэмд аюултай гэмт хэрэг үйлдсэн хүнд хуульд заасан хугацааны дотор хариуцлага хүлээлгээгүй өнгөрсний дараа дахин тэр хэрэгт нь хариуцлага хүлээлгэх нь ашиггүй байдаг. Энэ нь юуны урьд тэр өнгөрсөн хугацаанд тухайн хүний үйлдсэн хэрэг нь цаг хугацааны хувьд хууль зүйн үр дагавраа алдаж, гэмт хэрэг үйлдсэн хүн засарч хүмүүжсэн байж болох талтайгаас гадна үйлдэгдсэнээс хойш удаан хугацаа өнгөрсөн хэрэгт хариуцлага хүлээлгэх нь эрүүгийн хариуцлагын /ял/ урьдчилан сэргийлэх, цээрлүүлэх, гэмт хэрэг үйлдсэн хүнийг нийгэмшүүлэх болон бусад зорилгыг бууруулахад хүргэдэг, мөн үйлдэгдсэнээс хойш удаан хугацаа өнгөрсний дараа илэрч байгаа гэмт хэргийн нотлох баримтууд зарим талаар баларч бодит үнэнийг тогтооход бэрхшээл учруулдаг тул шүүгдэгчийн эрх ашигт муугаар нөлөөлөх тал гарч болзошгүй зэрэг байдлыг харгалзан гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг дэлхийн улс орнууд Эрүүгийн хуульдаа хуульчлан тогтоодог.

Гэмт хэрэг үйлдсэн хүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэлгүй хуульд заасан хугацаа өнгөрсөн бол түүнд нэхэн эрүүгийн хариуцлага хүлээлгэдэггүй бөгөөд энэ нь нэг талаас гэмт хэргийг илрүүлэх ажиллагаанд хойрго хандсанаас болж эрүүгийн хариуцлага гарцаагүй байх зарчимд харшилдаг сөрөг талтай хэдий ч нөгөө талаас эрүүгийн хариуцлагын зорилгоос үндэслэн хэдийгээр гэмт хэрэг үйлдсэн боловч түүнээс хойш тодорхой хугацаанд засарч хүмүүжсэнээс зан төлөв, үйл ажиллагаагаараа харуулсан этгээдийг хариуцлагаас чөлөөлж байгаа энэрэнгүй ёсны зарчмыг хэрэгжүүлэх эерэг талтай эрүүгийн эрх зүйн онолын болон практикийн чухал асуудал юм.

Гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа нь эрүүгийн хариуцлагын зорилгоос урган гардаг материаллаг шинжтэй ойлголт тул эрүүгийн хариуцлагын мөн чанараас үндэслэн гэмт хэрэг үйлдсэнээс хойш эрүүгийн хариуцлага хүлээлгэх /ял оногдуулах/ хүртэлх хоорондын хугацаа нь хэдий чинээ богино байх тусам эрүүгийн хариуцлагын /ялын/ үр нөлөө төдий чинээ ашигтай байх ба гэмт хэрэг үйлдсэнээс хойш өнгөрсөн хугацаанд гэмт хэрэг үйлдсэн хүн хүмүүжсэн байдал нь түүнд ял оногдуулах /хэрэглэх/ шаардлагагүй болохыг харуулна.

Иймд гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг тогтоох гол шалгуур үндэслэл бол:

Нэгдүгээрт: Тухайн хүн хуульд зааснаар ял оногдуулж болох гэмт хэрэг үйлдсэнээс хойш тодорхой хугацаа өнгөрсөн байх, энэ хугацаанд гэмт хэрэг шинээр үйлдээгүй байх

Хоёрдугаарт: Энэ хугацааны дотор тухайн этгээд болон урьд үйлдсэн гэмт хэрэг нь нийгмийн хор аюулгүй болсон

Гуравдугаарт: Дээрх нөхцөл байдлуудын улмаас түүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэх /ял оногдуулах/ бодит шаардлагагүй болсон байх явдал мөн.

¹⁴ Эрүүгийн хууль /шинэчилсэн найруулга/. “Төрийн мэдээлэл”. 2016 он. №7



Эдгээрээс үндэслэн гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааны эхлэл, төгсгөлийг, өөрөөр хэлбэл энэ хугацааг ямар үеэс эхлэн хэдий хүртэл тоолох вэ гэдэг асуудлыг оновчтой зөв хуульчлах нь онолын болон практик чухал ач холбогдолтой бөгөөд энэ нь хөөн хэлэлцэх хугацааны мөн чанарыг шууд тодорхойлж байдаг.

Шинэчлэн найруулсан Эрүүгийн хуульд гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг урьд үйлчилж байсан Эрүүгийн хуулиудад зааж байсантай адилаар гэмт хэрэг үйлдсэн үеэс эхлэн тоолохоор хуульчилсан боловч харин энэхүү хугацааны төгсгөлийг хуулийн 1.10 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Гэмт хэрэг үйлдсэнээс хойш дараах хугацаа өнгөрсөн нь тогтоогдвол яллагдагчаар татаж болохгүй”, мөн зүйлийн 2 дахь хэсэгт “Гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг гэмт хэрэг үйлдсэн өдрөөс эхлэн анхан шатны шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болох хүртэл тоолно” гэж хуульчилсан¹⁵ нь энэ хугацааны төгсгөл буюу үргэлжлэх үеийг зөв тодорхойлоход хүндрэл учруулж байгаа юм.

Эндээс яллагдагчаар татах, анхан шатны шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болох нь адил ойлголт уу, эсхүл өөр өөр ойлголт уу гэдэг асуудал гарах бөгөөд үүнийг зөв тайлбарлах нь гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааны төгсгөлийг тодорхойлоход чухал ач холбогдолтой болно.

Эрүүгийн эрх зүйн үүднээс яллагдагчаар татах /эрүүгийн хариуцлагад татах/, анхан шатны шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болох нь эрүүгийн хариуцлагыг хэрэгжүүлэх бие даасан үе шатууд бөгөөд энэ тухай манай улсын эрүүгийн эрх зүйн эрдэмтэн судлаачид зохиол бүтээлдээ тэмдэглэсээр ирсэн байна. Тухайлбал, доктор /Sc.D/, профессор Г.Совд “Эрүүгийн хариуцлагад татаж байгаа явдал бол эрүүгийн хариуцлагыг хэрэгжүүлэх анхан шатны үе юм. Эрүүгийн ял оногдуулах нь эрүүгийн хариуцлагыг биелүүлэх нэг чухал үе юм. Шүүхээс шийтгүүлсэн этгээдэд ялыг эдлүүлж байгаа нь эрүүгийн хариуцлагыг биелүүлэх эцсийн буюу төгсгөлийн шатыг бий болгоно”¹⁶ гэж үзсэн бол доктор /Sc.D/ Ж.Болдбаатар “Эрүүгийн хариуцлага нь эрүүгийн хариуцлага үүсэх, эрүүгийн хариуцлагад татах, эрүүгийн хариуцлага хүлээлгэх, эрүүгийн хариуцлагыг биелүүлэх, эрүүгийн хариуцлага дуусгавар болох гэсэн үе шатуудыг дамжин хэрэгжинэ”¹⁷ гэжээ.

Эрүүгийн процессын эрх зүйн хувьд яллагдагчаар татах, анхан шатны шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болох нь уг ажиллагааг хэрэгжүүлэх үндэслэл, журам, субъектээрээ хоорондоо ялгаатай эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны бие даасан үе шатууд бөгөөд энэ тухай Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 30.15 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Хэрэг бүртгэлтийн явцад энэ хуулийн 1.5 дугаар зүйлд заасан тохиолдол үүсээгүй, тухайн хүн, хуулийн этгээд гэмт хэрэг үйлдсэн гэж үзэх нөхцөл байдал тогтоогдсон, яллагдагчаар татах хүн, хуулийн этгээд хаана байгаа нь тодорхой бол мөрдөгч эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах саналыг прокурорт хүргүүлнэ”, мөн зүйлийн 2 дахь хэсэгт “прокурор эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах тогтоол үйлдэнэ”, 31.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах тогтоол үйлдсэнээс хэргийг шүүхэд шилжүүлэх хүртэл хэргийн талаар нотлогдвол зохих байдлыг тогтоох зорилгоор явуулж байгаа энэ хуульд заасан ажиллагааг мөрдөн байцаалт гэнэ”, 36.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсын нэрийн өмнөөс гаргах шүүхийн шийдвэр нь шийтгэх, эсхүл цагаатгах хэлбэртэй байна”, 37.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт Анхан шатны шүүхийн шийдвэр нь талууд, оролцогч энэ хуулийн 38.2 дугаар зүйлд заасан хугацаанд давж заалдах гомдол, эсэргүүцэл гаргаагүй бол гомдол, эсэргүүцэл бичих хугацаа дуусмагц; давж заалдах шатны шүүх гомдол, эсэргүүцлийг хянаад анхан шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээсэн, эсхүл өөрчлөлт оруулсан бол хуулийн хүчин төгөлдөр болно” гэж тус тус заажээ.¹⁸

Эдгээрээс үндэслэн яллагдагчаар татах, анхан шатны шүүхийн шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болох нь эрүүгийн болон эрүүгийн процессын эрх зүйн аль алинд нь бие даасан өөр өөр ойлголт болох нь нотлогдох бөгөөд энэхүү нөхцөл байдлаас гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг яллагдагчаар татах /эрүүгийн хариуцлагад татах/ хүртэл тоолох уу,

¹⁵ Эрүүгийн хууль /шинэчилсэн найруулга/. “Төрийн мэдээлэл”. 2016 он. №7

¹⁶ Г.Совд “БНМАУ-ын эрүүгийн эрхийн курс”. УБ. 1973 он. 168 дахь тал

¹⁷ Ж.Болдбаатар “Эрүүгийн эрх зүйн тулгуур ойлголтууд”. УБ. 2002 он. 14 дэх тал

¹⁸ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль /шинэчилсэн найруулга/. “Төрийн мэдээлэл”. 2017 он. №23



анхан шатны шүүхийн шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болох хүртэл тоолох уу гэдэг асуудал урган гарна.

Бидний үзэж байгаагаар хэрэв хөөн хэлэлцэх хугацааны төгсгөлийг яллагдагчаар татах хүртэл тоолвол энэ үеэс хойш хөөн хэлэлцэх хугацааны асуудал яригдахгүй учир гэмт этгээд оргон зайлсан, эсхүл дахин гэмт хэрэг үйлдсэн тохиолдолд хөөн хэлэлцэх хугацааг зогсоох, таслах замаар тоолох тухай асуудал яригдахгүй, нөгөө талаас яллагдагчаар татсан л бол хэдэн жилийн дараа ч хамаагүй /магадгүй 40, 50, 60 жилийн дараа/ тухайн гэмт хэрэг, гэмт хэрэг үйлдсэн этгээд нь нийгэмд аюулгүй болж ял оногдуулах шаардлагагүй болсон үед эрүүгийн хариуцлага хүлээлгэх боломжтой болох бөгөөд энэ нь хөөн хэлэлцэх хугацааны мөн чанарт харшилсан, эрүүгийн хариуцлага /ял/-ын зорилготой зөрчилдсөн, түүний эрүүгийн эрх зүйн болон процессын ач холбогдлыг бууруулсан явдал болно.

Иймд гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг тогтоох гол үндэслэл нь хуульд заасан хугацааны дотор гэмт хэрэг үйлдсэн хүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэж эрүүгийн хариуцлагын зорилгыг хангах явдал тул гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг гэмт хэрэг үйлдсэн үеэс анхан шатны шүүхийн шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болох хүртэл тоолох нь зүйтэй бөгөөд үүнийг нэг мөр шийдвэрлэхийн тулд Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан “яллагдагчаар татаж болохгүй” гэсэн нэр томъёог “эрүүгийн хариуцлага хүлээлгэх болохгүй” гэж өөрчлөх, мөн зүйлийн 2 дахь хэсэгт заасан “Гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг гэмт хэрэг үйлдсэн өдрөөс эхлэн анхан шатны шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болох хүртэл тоолно” гэсэн заалтыг өөрчлөхгүй байх шаардлагатай байна.

Хоёр. Гэм буруугийн талаар

Гэм буруугийн тухай асуудал эрүүгийн эрх зүйн шинжлэх ухааны амин чухал, тулгуур, хамгийн нарийн ээдрээ түвэгтэй, маргаантай асуудлын нэг бөгөөд энэ нь зөвхөн гэмт хэрэг дээр төдийгүй хүний аливаа ухамсартай үйлдэл, эс үйлдэхүй дээр илэрдэг субъектив шинжтэй ухагдахуун мөн. Учир нь хүний ухамсартай үйл ажиллагаанд л гэм буруугийн тухай асуудал байдаг. Гэхдээ гэм буруугийн тухай асуудал нь эрүүгийн эрх зүйд, тухайлбал гэмт хэрэг дээр хүний үйл ажиллагаанд түүний илрэх нийтлэг шинжээс өөр агуулга, онцлог, хууль цаазын шинж, үр дагаврыг бий болгоно.

Эрүүгийн хуулийн 2.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Энэ хуулийн тусгай ангид заасан нийгэмд аюултай гэм буруутай үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэгт тооцно” гэж гэм бурууг гэмт хэргийн үндсэн шинжид оруулан хуульчилсанаас гадна 1.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Энэ хуульд заасан гэмт хэрэг үйлдсэн нь шүүхээр тогтоогдсон гэм буруутай хүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ”, 2 дахь хэсэгт “Гэм буруугийгээр энэ хуульд заасан хохирол, хор уршиг учруулсан бол эрүүгийн хариуцлага хүлээлгэхгүй” 3 дахь хэсэгт “Гэмт хэрэг үйлдсэн этгээд өөрийн үйлдэл, эс үйлдэхүйн нийгмийн аюулын шинж чанарыг ухамсарлаагүй, хэргийн нөхцөл байдлын улмаас ухамсарлах боломжгүй байсан, учирч болох нийгэмд аюултай хор уршигийг урьдчилан мэдэх боломжгүй, мэдэх ёсгүй байсан бол хор уршиг гэм буруугийгээр учруулсан гэж үзнэ”, 4 дэх хэсэгт “Хүний үзэл бодол, итгэл үнэмшлийн төлөө эрүүгийн хариуцлага хүлээлгэхгүй” гэж гэм буруугийн зарчмыг тус тус хуульчилсан юм.¹⁹

Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан нийгэмд аюултай үйлдэл, эс үйлдэхүйг гагцхүү гэм буруутайгаар үйлдсэн тохиолдолд л эрүүгийн хариуцлага хүлээлгэх бөгөөд гэм буруутай байх нь эрүүгийн хариуцлага хүлээлгэх субъектив үндэслэл болдог.

Иймд гэм буруугийн ойлголт, хэлбэр, төрлийг Эрүүгийн хуульд оновчтой зөв тодорхойлох нь гэм буруугийн зарчмыг хэрэгжүүлэх, гэмт хэргийг зүйлчлэх, эрүүгийн хариуцлага хүлээлгэх субъектив үндэслэлийг тогтооход онцгой ач холбогдолтой юм.

Шинэчлэн найруулсан Эрүүгийн хуулийн 2.3 дугаар зүйлд “Гэм буруу нь санаатай, эсхүл болгоомжгүй хэлбэртэй байна”, “Өөрийн үйлдэл, эс үйлдэхүйг хууль бус шинжтэй болохыг ухамсарлаж түүнийг хүсч үйлдсэн, хохирол, хор уршигт зориуд хүргэсэн бол санаатай гэмт хэрэгт тооцно”, “Өөрийн үйлдэл, эс үйлдэхүйг хууль бус шинжтэй болохыг ухамсарлаж түүний улмаас хохирол, хор уршиг учрах боломжтойг урьдчилан мэдэж түүнийг гаргахгүй байж чадна гэж тооцсон боловч хохирол, хор уршиг учирсан, эсхүл хохирол, хор уршиг учрах боломжтойг урьдчилан мэдэх ёстой, мэдэх боломжтой байсан

¹⁹ Эрүүгийн хууль /шинэчилсэн найруулга/. “Төрийн мэдээлэл”. 2016 он. №7



боловч мэдэлгүй үйлдсэний улмаас хохирол, хор уршиг учирсан бол болгоомжгүй гэмт хэрэгт тооцно” гэж заажээ.²⁰

Дээрх хэм хэмжээг 2002 оны Эрүүгийн хуулийн²¹ хэм хэмжээтэй харьцуулан судалж үзэхэд гэм буруугийн хэлбэр, төрлийг өөрчлөлгүй хэвээр хадгалан үлдсэн ба харин гэм буруугийн оюун санааны шинжийг хуульчлахдаа өөрийн үйлдэл, эс үйлдэхгүйг хууль бус шинжтэй болохыг ухамсарласан байх ёстой гэж өөрчлөн заасан байна.

Эрүүгийн эрх зүйн онолын үүднээс гэмт хэргийг гэм буруутайгаар үйлдэх нь гэмт этгээд өөрийн гэмт үйл ажиллагааг ухамсарласны илрэл болох ба гэм буруу буюу гэмт үйлдэл, эс үйлдэхүй, түүний улмаас учирсан хор уршигт хэрхэн хандсан сэтгэхүйн харьцаа нь оюун санаа болон хүсэл зоригийн шинж /элемент/-ийг агуулдаг.²²

Гэм буруугийн элемент нь оюун санаа, хүсэл зориг бөгөөд эдгээр нь нийлж гэм буруугийн агуулгыг бүрдүүлнэ.

Гэм буруугийн оюун санааны элемент нь гэмт этгээд өөрийн үйлдэл, эс үйлдэхүй, түүний үр дагаврыг оюун санаандаа хэрхэн ойлгож ухамсарласныг илэрхийлэх бөгөөд нэгдүгээрт, гэмт этгээд өөрийн үйлдлийн шинж чанарыг хэрхэн ойлгож ухамсарласан, хоёрдугаарт, өөрийн үйлдэл, эс үйлдэхүйн эцэст бий болох үр дагаврыг /хор уршигийг/ хэрхэн ухамсарлаж хандсан гэсэн 2 шинжийг өөртөө агуулна.

Харин гэм буруугийн хүсэл зоригийн элемент нь гэмт этгээд өөрийн үйлдлийг хэрхэн удирдан жолоодож, бодит үйл ажиллагаа болгон, тодорхой үр дүнд хүргэснийг харуулдаг.

Гэм буруугийн элемент болох оюун санааны болон хүсэл зоригийн шинжүүд гэмт этгээдийн үйл ажиллагаанд хэрхэн илэрч байгаа байдал, тэдгээрийн янз бүрийн хослол нь гэм буруугийн хэлбэр, төрлийг тодорхойлно. Өөрөөр хэлбэл гэм буруугийн хэлбэр бүр оюун санаа, хүсэл зоригийн үйл явцын харилцан үйлчлэлээс хамаарч өөр өөрийн өвөрмөц агуулгатай байдаг.²³

Мөн гэм буруу нь хэрэг хариуцах чадвартай шууд холбоотойгоор тайлбарлагдах бөгөөд Эрүүгийн хуулийн 6.3 дугаар зүйлд “Гэмт хэрэг үйлдсэн хэрэг хариуцах чадвартай хүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ. Сэтгэцийн эмгэг, оюун ухааны хомсдлын улмаас өөрийн үйлдлийн бодит шинж чанар, аюултай байдлыг ухамсарлах, удирдан жолоодох чадваргүй болсныг хэрэг хариуцах чадваргүйд тооцно”²⁴ гэж заасан байна.

Эдгээрээс үндэслэн гэм буруугийн оюун санааны шинж нь өөрийн үйлдэл, эс үйлдэхгүйг хууль бус шинжтэй болохыг ухамсарлах явдал биш, харин өөрийн үйлдэл, эс үйлдэхүйн бодит шинж чанарыг ухамсарлах явдал юм гэсэн дүгнэлтэд хүрнэ. Жишээлбэл, гэмт этгээд хурц иртэй хутга барьж байна, тэр хутгаар хүний цээж рүү дүрвэл амь нас, эрүүл мэндэд нь хохирол учруулна гэдгийг ойлгож ухамсарласан байх явдал болохоос энэ нь хууль бус үйлдэл юм гэдгийг ухамсарлаж ойлгосон байх тухай асуудал биш гэсэн үг.

Өөрийн үйлдэл, эс үйлдэхгүйг хууль бус шинжтэй болохыг ухамсарлана гэдэг нь тэр үйлдэл, эс үйлдэхгүйг хуулиар хориглосон бөгөөд түүнийг зөрчиж байгаагаа ойлгож ухамсарласан байхыг хэлнэ.

Тэгвэл тухайн хүн өөрийн үйлдэл, эс үйлдэхгүйг хууль бус болохыг мэдээгүй, түүнийгээ хууль ёсны үйл ажиллагаа гэж ойлгож хэрэгжүүлсэн бол гэм буруутай гэж үзэх үү гэсэн асуулт урган гарна.

Эрүүгийн эрх зүйн онолоор энэ тохиолдлыг гэм буруугийн андуурал /хууль зүйн андуурал/ гэсэн ухагдахууны хүрээнд авч үзэж шийдвэрлэдэг ба гэмт хэргийн бүрэлдэхүүнийг тогтоох, гэмт хэргийг зүйлчлэх, эрүүгийн хариуцлага хүлээлгэхэд хууль зүйн андуурал нь ямар нэгэн учир холбогдолгүй байдаг тул эрүүгийн хариуцлага хүлээлгэх ёстой гэж үздэг.

Харин одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа Эрүүгийн хуулийн дагуу дээрх тохиолдлыг шийдвэрлэх бол Эрүүгийн хуульд гэм буруугийн оюун санааны шинжийг заахдаа өөрийн үйлдэл, эс үйлдэхгүйг хууль бус шинжтэй болохыг ухамсарласан байх ёстой гэж хуульчилсан учраас шууд утгаараа тухайн хүнийг гэм буруугүй гэж үзэх ёстой болж байгаа юм. Гэхдээ энд зарим хэрэг дээр гэмт этгээд өөрийн өөрийн үйлдэл, эс

²⁰ Эрүүгийн хууль /шинэчилсэн найруулга/. “Төрийн мэдээлэл”. 2016 он. №7

²¹ Эрүүгийн хууль. “Төрийн мэдээлэл”. 2002 он. №5

²² Г.Гантөмөр “Гэмт хэргийн бүрэлдэхүүний ерөнхий онол”. УБ. 2011 он. 202 дахь тал

²³ С.Жанцан “Монгол Улсын эрүүгийн эрх зүйн онол”. УБ. 2009 он. 478 дахь тал

²⁴ Эрүүгийн хууль /шинэчилсэн найруулга/. “Төрийн мэдээлэл”. 2016 он. №7



үйлдэхүйг хууль бус шинжтэй болохыг ухамсарласан байхыг заавал шаарддаг гэдгийг анхаарах ёстой. Тухайлбал, Худал мэдүүлэг өгөх /ЭХ-ийн 21.2.1/

Гэм буруугийн тухай асуудлыг Эрүүгийн хуульд ингэж алдаатай хуульчилсан явдал нь гэм бурууг нотлоход багагүй бэрхшээл учруулна. Тухайлбал, гэмт хэрэг үйлдсэн хүн бүр өөрийн хийсэн үйлдэл, эс үйлдэхүйг зөвтгөж түүнийгээ хууль ёсны гэж ойлгож байсан, би хууль бус үйл ажиллагаа гэж бодоогүй гэсэн тайлбар, мэдүүлэг өгнө. Энэ тохиолдолд хэрэг явдлыг хэрхэн шийдвэрлэх вэ гэдэг мөн л эргэлзээтэй болох юм.

Иймд гэм буруугийн оюун санааны шинж нь өөрийн үйлдэл, эс үйлдэхүйг хууль бус шинжтэй болохыг ухамсарлах явдал биш, харин өөрийн үйлдэл, эс үйлдэхүйн бодит шинж чанарыг ухамсарлах явдал мөн тул Эрүүгийн хуулийн “Гэм буруу” гэсэн 2.3 дугаар зүйлийн 2, 3 дахь хэсэгт байгаа “өөрийн үйлдэл, эс үйлдэхүйг хууль бус шинжтэй болохыг ухамсарлаж” гэсэн нэр томъёог “өөрийн үйлдэл, эс үйлдэхүйн бодит шинж чанарыг ухамсарлаж” гэж өөрчлөх нь зүйтэй гэж үзэж байна.

Гурав. Гэм буруугийн холимог хэлбэрээр үйлдэгддэг гэмт хэргийн зүйлчлэлийн талаар

Эрүүгийн хуулийн 2.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Санаатай үйлдэл, эс үйлдэхүйн улмаас болгоомжгүйгээр хохирол, хор уршигт хүргэснийг гэм буруугийн холимог хэлбэр гэнэ” гэж гэм буруугийн холимог хэлбэрийг хуульчлаад уг зүйлийн 2 дахь хэсэгт “Энэ хуулийн тусгай ангид гэм буруугийн холимог хэлбэрээр үйлдсэн гэмт хэргийн шинж, оногдуулах ялын төрөл хэмжээг тусгайлан заана” гэсэн атлаа Эрүүгийн хуулийн тусгай ангид нэг ч гэмт хэрэг дээр ингэж тусгайлан заагаагүй байгаа нь ийм хэлбэрээр үйлдэгддэг гэмт хэргийг зүйлчлэхэд хүндрэл учруулж байна.

Уг нь хууль тогтоогч гэм буруугийн давхардсан хэлбэрээр үйлдэгддэг гэмт хэргийг тусгайлан заах байсан. Жишээлбэл: 27.10 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг “... Авто тээврийн хэрэгслийн жолооч хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, түүнд нийцүүлэн гаргасан захиргааны хэм хэмжээний актыг санаатай, эсхүл болгоомжгүйгээр зөрчсөний улмаас хүний эрүүл мэндэд хүндэвтэр хохирол болгоомжгүй учруулсан бол ...” гэх мэт.

Гэтэл хууль тогтоогч ингэж заагаагүй учраас энэ гэмт хэргийг Хүний эрүүл мэндэд хүндэвтэр хохирол санаатай учруулах гэмт хэргээс ялган зүйлчлэхэд хүндрэлтэй. Өөрөөр хэлбэл авто тээврийн хэрэгслийн жолооч хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, түүнд нийцүүлэн гаргасан захиргааны хэм хэмжээний актыг санаатай зөрчиж хүний эрүүл мэндэд хүндэвтэр хохирол санаатай учруулсан бол Эрүүгийн хуулийн тусгай ангийн 27.10.1-ээр зүйлчлэх үү, 11.4.1-ээр зүйлчлэх үү гэдэг нь ойлгомжгүй болж байна.

Өөр нэг жишээ авч үзье. Хүний эрүүл мэндэд хүнд хохирол санаатай учруулсны улмаас хохирогч нас барсан /ЭХ-ийн 11.1.2.5/ хэрэг гэм буруугийн холимог хэлбэрээр үйлдэгдэнэ. Өөрөөр хэлбэл, хүний эрүүл мэндэд хүнд хохирол учруулахад санаатай, амь хохирсон хохиролд болгоомжгүй ханддаг. Гэтэл Эрүүгийн хуулийн тусгай ангийн 11.1 дүгээр зүйлийн диспозицид энэхүү гэм буруугийн холимог хэлбэрийг тодорхой заагаагүй учраас энэ гэмт хэргийг хүнийг алах /санаатай/ гэмт хэргээс ялгах боломжгүй байна. Гагцхүү тэр дороо нас барсан бол Эрүүгийн хуулийн 10.1 дүгээр зүйлээр, хожуу нас барсан бол Эрүүгийн хуулийн 11.2.5-аар зүйлчлэхээс өөр аргагүй олж болох юм.

Иймд гэм буруугийн холимог хэлбэрээр үйлдэгддэг гэмт хэргийн субъектив талын шинжүүдийг тодорхой хуульчлах шаардлагатай бөгөөд ингэснээр гэм буруугийн холимог хэлбэрээр үйлдэгддэг гэмт хэргийг бусад төсөөтэй гэмт хэргээс ялган зүйлчлэх боломж бүрдэнэ.

Эцэст нь тэмдэглэхэд дээрх тодорхой асуудлуудыг хуулийг шүүмжлэх бус харин шинэчлэн найруулсан Эрүүгийн хуулийн хэм хэмжээг нэг мөр ойлгож зөв хэрэгжүүлэх зорилтын үүднээс тавьсан бөгөөд тэдгээрийг судалсаны үндсэн дээр тодорхой шийдэлд хүрэх нь хуулийн хэрэгжилт, үр нөлөөг дээшлүүлэхэд тус дөхөм болно гэдэгт найдаж байна.

Ном зүй

Нэг.Монгол Улсын хууль тогтоомж

- Эрүүгийн хууль. “Төрийн мэдээлэл”. 2002 он. №5
- Эрүүгийн хууль /шинэчилсэн найруулга/. “Төрийн мэдээлэл”. 2016 он. №7
- Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль /шинэчилсэн найруулга/. “Төрийн мэдээлэл”. 2017 он. №23



Хоёр.Ном, сурах бичиг, гарын авлага

- Ж.Болдбаатар “Эрүүгийн эрх зүйн тулгуур ойлголтууд”. УБ. 2002 он.
- Г.Гантөмөр, О.Амарсайхан “Монгол улсын эрүүгийн эрх зүй дэх цаг хугацаа”. УБ. 2004 он.
- Г.Гантөмөр “Гэмт хэргийн бүрэлдэхүүний ерөнхий онол”. УБ. 2011 он.
- С.Жанцан “Монгол Улсын эрүүгийн эрх зүйн онол”. УБ. 2009 он.
- Г.Совд “БНМАУ-ын эрүүгийн эрхийн курс”. УБ. 1973 он.



ХҮН БАРЬЦААНД АВАХЫН ЭСРЭГ ОЛОН УЛСЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

Д.Сундуйсүрэн

*Дотоод хэргийн их сургуулийн Удирдлагын академийн профессор,
цагдаагийн хурандаа*

Товч агуулга: Түүхэн цаг хугацааны туршид дэлхийн хамтын нийгэмлэг, улс орнууд хүн барьцаалах гэмт явдалтай олон улсын эрх зүйн хэм хэмжээ, зохицуулалтаар тэмцэж ирсэн бөгөөд нэгдсэн үндэстний улс түмний хамтын ажиллагаа, хэвийн харилцаа, аюулгүй байдлыг хангах, хүн барьцаалахын эсрэг гэрээ хэлэлцээрийг харьцуулан судлахыг зорьсон болно.

Түлхүүр үг: Эх сурвалж, терроризм, боолын худалдаа, ёс заншил, барьцаа, хүн барьцаалах гэмт явдал, гэрээ /конвенц/

Удиртгал

Сүүлийн үед дэлхий нийтийн анхаарлыг татаж, ихээхэн айдас түгшүүрийг төрүүлж буй сөрөг үзэгдэл бол олон улсын шинжтэй гэмт хэрэг, тухайлбал алан хядах үйлдлийн илрэл болсон терроризм, хүн барьцаалах, агаарын тээврийн онгоц барьцаалах явдал өсч байгаатай холбогдуулан түүнтэй тэмцэхийн тулд олон улсын гэрээ, хэлэлцээр (конвенц) байгуулах шаардлагатай болсон байна.

Хүн барьцаалах гэмт явдалтай тэмцэх олон улсын гэрээ, хэлэлцээр (конвенц)

Орчин үеийн гэмт хэрэгтэй тэмцэх олон улсын хамтын ажиллагаа нь эрүүгийн гэмт хэрэг болон олон улсын шинжтэй гэмт хэрэгтэй тэмцэх тэмцлээс бүрдэж байна.

Урьд нь хууль зүйн шинжлэх ухаан болон практикт “Олон улсын шинжтэй гэмт хэрэг”-ийн тухай бүрэн гүйцэд тодорхойлолт байгаагүй. Энэ тухай оновчтой тодорхойлолтыг профессор И.И.Карпец өгчээ. Үүнд: “Олон улсын шинжтэй гэмт хэрэг гэдэг нь олон улсын гэрээ хэлэлцээрт заасан, хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэгт хамаарахгүй гэвч улс хоорондын хэвийн харилцаанд халдаж, дэлхий нийтийн хамтын ажиллагаа, салбар дундын харилцаа /эдийн засаг, нийгэм, соёл, хөрөнгө гэх мэт/ ... нд хохирол учруулж буй, тогтоосон хэм хэмжээний дагуу шийтгэлтэй, гэрээ хэлэлцээр ёсоор үндэсний эрүүгийн хууль тогтоомжидоо хуульчлан тогтоосон байх явдал юм.”²⁵

И.И.Карпедын үзэж байгаагаар, дээрх гэмт хэргийн олон улсын шинж чанар нь олон улсын хэлэлцээрт заасан, олон улсын харилцааны салбарт хохирол учруулж байгаагаар тодорхойлогдох бөгөөд үндэсний эрүүгийн хууль тогтоомждоо заавал тусгаж, шийтгэлийг ногдуулдаг байна.

Энэ гэмт хэргийн олон улсын шинж чанарыг олон улсын харилцааны салбарт хохирол учруулдаг гэхээсээ илүү “гадаадын элемент”-тэй холбоотой үүсдэг, нарийн төвөгтэй эрүүгийн эрх зүйн харилцаа, өөрөөр хэлбэл, гэмт хэргийн субъект нь “гадаадын”, гэмт хэргийн субъект объект нь гадаад орны нутаг дэвсгэр дээр, үйлдэл нь хэд хэдэн хууль эрх зүйг /хоёр ба түүнээс дээш үндэсний болон олон улсын/ зөрчсөн байдгаар тодорхойлогддог байна.

Дээр дурдсанаас үзэхэд олон улсын шинжтэй гэмт хэрэг нь олон улсын ба улс үндэстний эрх зүйн журамд халдаж байгаа, төр, олон улсын байгууллага, албан тушаалтан, бие хүн хуулийн этгээд тэдгээрийн өмч хөрөнгө, амьдралын сайн сайхан, хүний үнэт зүйл, эрх, эрх чөлөөнд нь хор хохирол учруулж байгаа төрийн /улсын/ хууль тогтоомжид заасан, эрх зүй зөрчсөн, ээдрээ төвөгтэй, нийгэмд аюултай үйл ажиллагаа /үйлдэл/ гэж үзэж болох юм.

НҮБ-ын Ерөнхий ассамблейн 1979 оны 12 дугаар сарын 17-нд батлагдсан “Хүн барьцаалахын эсрэг” олон улсын Конвенцид хүн барьцаалах нь олон улсын гэмт хэргийн бие даасан төрөл болохыг анх удаа заажээ.

Урьд нь баталсан олон улсын гэрээ, конвенциудад боолчлол, алан хядах ажиллагаа, агаарын хөлөг барьцаалах, бусад олон улсын шинжтэй гэмт хэргийг

²⁵ Карпец И.И.Преступления международного характера. М., 1979. С. 40.



хамааруулсан байна. Тухайлбал; 1926 оны 9 сарын 25-ны өдөр Женев хотод боолчлолтой холбоотой Конвенцид гарын үсэг зурсан бөгөөд хожим нь нэмэлт оруулжээ. Энэхүү конвенцийн эх сурвалж нь дараахь олон улсын актууд:

- 1889-90 оны Брюсселийн бага хурлын ерөнхий акт, энэхүү актанд гарын үсэг зурсан улс орнууд Африкт хийгддэг боолын наймааг эцэс төгсгөл болгохыг хатуу мэдэгджээ.
- 1919 оны Сен Жерменийн конвенц, энэхүү конвенцид гарын үсэг зурсан улс орнууд хуурай газар болон далай тэнгист бүх хэлбэрийн боолчлол, боолын наймааг бүрэн устгахаа илэрхийлжээ.
- 1924 оны 6 дугаар сарын 12-ний өдөр Үндэстнүүдийн Холбооны Зөвлөлөөр томилсон Боолчлолын түр хорооны илтгэл

Сен-Жерменийн конвенцид гарын үсэг зурсан улсуудаас боолчлол, боолын худалдааны талаар гаргасан зорилтуудыг дэлхий даяар хэрэгжүүлэх үүднээс Брюсселийн актын дагуу хэрэгжүүлэх ажлыг дуусгавар болгон хэрэгжүүлэхийг эрмэлзэн, энэхүү конвенцид тусгагдсан заалтуудаас илүү нарийвчилсан заалт бүхий хэлэлцээр байгуулах шаардлагатай байгааг хүлээн зөвшөөрч, 1926 оны 09 дүгээр сарын 25-ны өдөр “Боолчлол, боолын худалдааг хориглох тухай” Женевийн конвенци батлагдсан байна.

Энэхүү Конвенцид “Боолчлол гэж өмчлөх эрхэд хамаарах бүх, эсхүл зарим эрх мэдлийг хүн дээр хэрэгжүүлсэн байдал буюу нөхцлийг ойлгоно”, “боолын худалдаа гэж хүнийг боол болгох зорилгоор олзлох, олж авах буюу эрхэндээ оруулах бүх үйлдэл, боолыг худалдах буюу солих зорилгоор түүнийг олж авахтай холбогдсон бүх үйлдэл, худалдах буюу солих зорилгоор олж авсан боолыг худалдах буюу солих замаар эрхэндээ оруулах бүх үйлдэл, бүхэлдээ боолыг тээвэрлэх, эсхүл худалдах бүх үйлдэл хамаарна”²⁶ гэж боолчлол, боолын худалдаа гэдгийг анх удаа тодорхойлжээ.

Конвенцийг хүлээн зөвшөөрч хэлэлцэн баталсан талуудын хүлээсэн гол үүрэг бол: Боолын худалдааг хориглох түүнээс урьдчилан сэргийлэх, боолчлолын бүх хэлбэрийг богино хугацаанд бүрмөсөн устгахыг чармайх, боолын худалдаа болон боолчлолыг устгахын тулд харилцан бие биедээ дэмжлэг үзүүлэх явдал гэж үзжээ. 1956

оны 09 дүгээр сарын 07-ны өдөр “Боолчлол, боолын худалдаа болон боолчлолтой адилтгах ёс, заншлыг устгах тухай” нэмэлт конвенц батлагдаж, 1957 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр хүчин төгөлдөр болжээ.²⁷

Энэхүү конвенцид оролцогч улс бүр, эрх чөлөө бол хүн бүрийн төрөлхийн заяагдмал эрх мөн гэж үзээд, /Нэгдсэн Үндэстний улс түмэн дүрэмдээ хүн төрөлхтний үнэ цэнэ, нэр төрд итгэх итгэлийг бататгасныг дурдаж/ Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейгаас зарлан тунхагласан Хүний эрхийн түгээмэл тунхаглалд боолчлол буюу эрх мэдэлгүй байдалд хэн ч нэрвэгдэх ёсгүй бөгөөд боолчлол, боолын худалдааг бүх хэлбэрээр нь хориглоно гэж заасныг анхааралдаа авч, Энэхүү Конвенциор 1926 оны “Боолчлол, боолын худалдааг хориглох тухай” Женевийн конвенцид заасан боолчлол, боолын худалдаа гэсэн тодорхойлолтыг хөндөхгүйгээр зарим ойлголтыг өргөжүүлэн нэмэлт болгож, дараах ёс болон заншлыг бүрэн халах буюу устгах шаардлагатай арга хэмжээ авахыг тусгасан байна.

а/Өрөнд баригдаж боолчлогдсон, өөрөөр хэлбэл өртэй хүн өөрийнхөө, эсхүл өөрөөсөө хараат хүний үйлчилгээгээр өрөө төлөх үүргээ биелүүлэхтэй холбоотойгоор үүссэн барьцааны байдал буюу нөхцөл, хэрэв тэрхүү үйлчилгээг зохих ёсоор үнэлсэн үнэлгээ нь уг өрийн төлөөсөнд тооцогдохгүй, эсхүл тэрхүү хөдөлмөрийн шинж чанар, үргэлжлэх хугацаа нь тодорхой бус бол, ...

с/ Дараахь үйлдлийг зөвшөөрсөн аливаа ёс, заншил:

а)эмэгтэй хүнийг мөнгө болон биет эд зүйлийн оронд төлөх болзолтойгоор өөрийнх нь зүгээс татгалзах эрхгүйгээр түүний эцэг, эх асран хамгаалагч, гэр бүл, эсхүл бусад хүн, эсхүл бүлэг хүмүүсээс эхнэр болгож өгөхийг амласан эсхүл өгсөн.

б) эмэгтэйн нөхөр, түүний гэр бүл, эсхүл овгийнхон нь тухайн эмэгтэйд өөр хүнд үнэтэй эд зүйлсийн оронд буюу бусад хэлбэрээр шилжүүлэн өгөх эрх эдэлдэг байх.

²⁶ СССР и международное сотрудничество в области прав человека. Документы и материалы МИД СССР. М., 1989. С. 105-106.

²⁷ Международное сотрудничество государств по борьбе с преступностью: Учебно-методическое пособие. М., 1982. С. 124.



с) нөхрийг нь нас барахад бэлбэсэн эхнэрийг бусдад өвлүүлэн өгөх.

д) 18 нас хүрээгүй болон бага насны хүүхдүүдийг ашиглах буюу тэдний хөдөлмөрийг мөлжих зорилгоор эцэг эхийнх нь аль нэг, эсхүл хоёул, эсхүл асран хамгаалагч нь тэднийг шан харамжтай буюу харамжгүйгээр бусдад өгдөг аливаа ёс буюу заншил.²⁸

Анхны эрх зүйн баримт болох 1937 оны “Терроризмаас урьдчилан сэргийлэх болон ял оногдуулах тухай” Женевийн Конвенцид “хүн барьцаалах” гэсэн нэр томъёог анх эхлэн нэрлэн заажээ. Энэ Конвенци оршил болон 29 зүйлтэй, терроризмын үйлдлийн объектыг бүрэн дүүрэн, өргөн хүрээтэй тодорхойлжээ. Конвенцид олон улсын алан хядах явдал /терроризм/-ын ойлголтыг томъёолсон, терроризмтай тэмцэх механизмыг боловсруулсан, үндэсний болон олон улсын түвшинд хэрэглэгдэх журам, үйл ажиллагаа Конвенцид элсэн орох процедурыг тогтоосон юм. Харин улс төр ба хууль зүйн шалтгаанаар хүчин төгөлдөр болоогүй гэвч олон улсын эрх зүйн эсрэг шинжтэй гэмт хэрэг ба олон улсын алан хядах ажиллагааг буруушааж байсан нь одоо ч ач холбогдлоо алдаагүй байна.

Энэ нь сүүлдээ хүн төрөлхтний аюулгүй байдал, дэлхий нийтийн эсрэг гэмт хэргийн тухай хууль, эрх зүйн баримт бичгийн төсөл боловсруулахад ашиглах суурь нь болсон гэж үзэх үндэстэй юм. Түүнчлэн агаарын хөлгийг барьцаалахын зэрэгцээ хүн барьцаалах, олон улсын хамгаалалтанд байдаг хүн, дипломат төлөөлөгчийн халдашгүй байдал, харилцаанд хүч хэрэглэн халдах явдал терроризмын төрлүүдийн нэг юм.²⁹

Иргэний нисэх хүчин, олон улсын харилцааны эсрэг агаарын хөлгийн бүхээгт үйлдэгдэж буй гэмт хэргийн тоо өсч байгаатай холбогдуулан улс орнууд 1963 онд “Агаарын хөлгийн бүхээгт үйлдсэн гэмт хэрэг болон тодорхой бусад үйлдлийн тухай” Конвенцийг Токио батлан гаргасан байна.

Энэ конвенциор агаарын хөлөг, түүний дотор байгаа хүмүүс, эд хөрөнгө, түүнчлэн агаарын хөлгийн дотоод сахилга, дэг журамд аюул учруулсан, учруулж болзошгүй үйлдэл, агаарын хөлгийг хууль бусаар булаан авах үйлдлийг тодорхойлжээ.

Энэ гэмт хэргийг үйлдэхээр завдсан, үйлдсэн гэх үндэслэл байвал агаарын хөлгийн дарга, агаарын хөлөг, түүнд байгаа хүмүүсийн аюулгүй байдлыг хамгаалах, нисэх багийн гишүүд болон зоригчдийн дэмжлэгийг авах, гэмт этгээдийн эрх чөлөөг нь хязгаарлах, саатуулах, агаарын хөлгөөс буулгах, эрх бүхий байгууллагад шилжүүлэх, зэрэг бололцоотой бүхий л арга хэмжээг авахыг тусгажээ.

Конвенцийн 11 зүйлийн 1 дэх хэсэгт: “Агаарын хөлгийн бүхээгт байгаа этгээд хүч хэрэглэн, эсхүл хүч хэрэглэхээр заналхийлэн нислэгт буй агаарын хөлгийн удирдлагад хууль бусаар саад учруулах, удирдлагыг булаан авах буюу хууль бус бусад үйлдэл үйлдсэн буюу үйлдэхийг завдсан тохиолдолд хэлэлцэн тохирогч улсууд агаарын хөлгийн удирдлагыг түүний хууль ёсны даргад эгүүлэн өгөх буюу түүний хяналтанд байлгахад шаардлагатай бүхий л арга хэмжээ авна”³⁰ гэжээ. Харилцан тохирогч улс орнууд дээрх арга хэмжээг авахын зэрэгцээ сэжигтэн этгээдийг шилжүүлэн авч, албадан саатуулан, цагдан хорьж, эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа явуулахаар тодорхой зохицуулсан байна.

1970 онд Гаагийн “Агаарын хөлгийг хууль бусаар булаан авах үйлдлийг хориглох тухай” конвенци батлагдсан. Хэлэлцэн тохирогч улс бүр “агаарын хөлгийг хууль бусаар булаах” үйлдэл гаргасан тухайн этгээдэд хүнд ял оногдуулах үүрэг хүлээсэн.

Мөн 1971 онд Монреалийн “Иргэний нисэхийн аюулгүй байдлын эсрэг хууль бус үйлдлийг хориглох тухай” конвенци батлагдсан.

Конвенцийн 7 дугаар зүйлд: Нутаг дэвсгэр дээр нь сэжигтэн этгээд илэрч тогтоогдсон хэлэлцэн тохирогч улс түүнийг шилжүүлэн өгөхгүй байвал гэмт хэрэг түүний нутаг дэвсгэр дээр гарсан эсэхээс үл хамааран яллуулахаар өөрийн эрх бүхий байгууллагад шилжүүлнэ. Тэрхүү эрх бүхий байгууллага нь тухайн улсын хуульд заасны дагуу ноцтой шинж агуулсан ердийн хэрэгтэй адил журмаар шийдвэрлэнэ” гэж заажээ.

Ийм байдлаар хэлэлцэн батлагдсан олон улсын конвенци нь иргэний нисэх хүчний эсрэг үйлдэж буй гэмт хэргийн ангилалд хамаарч буй нөхцөл байдлыг арилгахын тулд бие биендээ дэмжлэг үзүүлэх, зохих ёсны хариуцлагын зарчим бусад арга хэмжээг

²⁸ Олон улсын гэрээ, хэлэлцээрийн эмхтгэл.Уб., 1998. 313 дахь тал.

²⁹ Советский Ежегодник международного право. М., 1989. С. 124.

³⁰ Олон улсын гэрээ, хэлэлцээрийн эмхтгэл.Уб., 1998. 306 дахь тал.



хэрэгжүүлэх, олон улсын терроризмын аюултай төрөл буюу хамгийн түгээмэл энэ гэмт хэрэгтэй тэмцэхэд улс орны хамтын ажиллагааны эрх зүйн үндсийг бүрдүүлжээ.

Гэвч олон улсын иргэний нисэхэд үйлчилдэг, нисэх буудалд үйлдэгдэж буй хүч хэрэглэсэн явдлыг таслан зогсоох асуудал олон улсын эрх зүйн зохицуулалтгүй үлдсэн байна. Тиймээс “Иргэний нисэхийн аюулгүй байдлын эсрэг хууль бус үйлдлийг хориглох тухай” Монреаль хотноо 1971 оны 9 дүгээр сарын 23-ны өдөр үйлдсэн Конвенцийн олон улсын иргэний нисэхэд үйлчилдэг нисэх буудал дахь хүч хэрэглэсэн хууль бус үйлдлийг хориглох тухай нэмэлт протокол 1988 оны 2 дугаар сарын 24-ний өдөр баталж, 1989 оны 8 дугаар сарын 6-ны өдөр хүчин төгөлдөр болсон.

Энэхүү нэмэлт протоколд “Оролцогч улсууд олон улсын иргэний нисэхэд үйлчилдэг нисэх буудал дахь хүмүүсийн аюулгүй байдалд аюул занал учруулж буй, учруулж болзошгүй, эсхүл эдгээр нисэх буудлын аюулгүй ажиллагаанд саад учруулж буй хүч хэрэглэсэн хууль бус үйлдлүүд нь эдгээр нисэх буудлын аюулгүй ажиллагаанд итгэх дэлхийн ард түмний итгэлийг бууруулж, бүх улсын хувьд иргэний нисэхийг аюулгүй, журамтай удирдахад саад болж байгаа гэж үзэж, ийм гэмт хэрэг үйлдэх нь олон улсын хамтын нийгэмлэгийг ноцтой түгшээж байгаа гэж үзэн, энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх болон шийтгэхийн тулд тууштай арга хэмжээ авах шаардлагатай болсныг хэлэлцэн тохирсон тухай” заажээ.

Олон улсын хамгаалалтад байдаг хүмүүс түүний дотор дипломат төлөөлөгчдийн эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх болон шийтгэх тухай конвенцийг НҮБ-ын Ерөнхий ассамблей 1973 оны 12 дугаар сарын 14-ны өдөр баталж, 1977 оны 2 дугаар сарын 20-ний өдөр хүчин төгөлдөр болсон.

Энэ конвенцид “тусгай хамгаалалт”, “сэжигтэн этгээд” /тухайн гэмт этгээд/ гэсэн ойлголтыг гарган тавьж, олон улсын хамгаалалтанд буй хүн гэдгийг тодорхойлсон. Конвенцийн 4-11 дүгээр зүйлд тогтоосон хэм хэмжээ, үндсэн зарчмын хүрээнд олон улсын алан хядах ажиллагаа үйлдэж буй этгээдэд ял шийтгэл оногдуулж байх зарчмыг хангах, тэдгээртэй холбоотой зүйлүүд хамаарсан байна.

1973 оны Конвенцийг нэгтгэн дүгнэж үзвэл 1937, 1971 оны конвенцийн олон зүйл заалтыг ашигласан байна.

1976 оны арван нэгдүгээр сарын 10 өдөр Европын Холбооны Сайд нарын зөвлөл терроризмтай тэмцэх тухай Европын конвенцийн баримтыг хүлээн авч, 1977 оны нэгдүгээр сард батласнаар уг баримт 1978 оны наймдугаар сарын 4 өдөр хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн. 16 зүйл бүхий энэ баримт бичиг нь олон улсын терроризмтай тэмцэх үйл ажиллагаанд улс хоорондын хамтын ажиллагааны талаар байгуулсан бусад гэрээ хэлэлцээрийн дунд онцгой байр суурь эзэлдэг.

Террорист хүчирхийлэл, үйлдлийн өргөн хүрээг тодорхойлсон нь Конвенцийн онцлог юм. Тэдгээрт иргэний агаарын эсрэг, нисэх хөлгийн бүхээгт үйлдсэн гэмт хэргүүд, олон улсын хэмжээнд хамгаалуулах эрхтэй этгээдийн эрүүл мэнд, эрх чөлөөнд халдсан явдал, хүн барьцаалах эсхүл санаандгүй байдлаар хүний эрх, эрх чөлөөнд халдах түүнчлэн бусдад аюул учруулах тэсэрч дэлбэрэх зэвсэг хэрэгсэл ашиглах явдал хамаарахаар зохицуулагдсан.

Уг Конвенци *aut dedere, aut judicare* гэх зарчимд тулгуурласан, түүнчлэн хэрэгтнийг шилжүүлэн өгөх үйл ажиллагаа нь террорист акт үйлдсэн этгээдүүд ял шийтгэлээс зайлсхийхээс урьдчилан сэргийлж чадсан үр дүнтэй хэрэгсэл болсон байна.

Хүн барьцаалах явдалтай тэмцэх тухай дээр дурьдагдсан конвенциудаас гадна дайны үед эдгээр гэмт хэрэг үйлдэхийг хориглосон конвенциуд байжээ.

1949 онд Женевт олон улсын 4 конвенц батлагдсан. Үүнд: “Дайны талбарт байгаа зэвсэгт хүчний шархтан, өвчтөний нөхцөл байдлыг сайжруулах тухай” Конвенци, “Зэвсэгт хүчний бүрэлдэхүүнээс сүйрсэн хөлөг онгоцноос хохирсон этгээд, өвчтөн, шархтаны нөхцөл байдлыг сайжруулах тухай” Конвенц, “Олзлогдсон цэргийг харж хандах тухай” Конвенц, “Дайны үед иргэний хүн амыг хамгаалах тухай” Конвенциуд³¹ юм. 1977 онд эдгээр конвенциудад нэмэлт протокол батлагдсан.

Тухайн цаг үед хүнийг газар сайгүй барьж, хорьж, алахаар эрүү шүүлт тулгах, ташуурдаж яллах, гэмтэл бэртэл учруулах, хүний эрхэм чанарыг доромжлох, хүнийг барьцаанд авах, зохих ёсны шийдвэргүйгээр хоморголон яллаж байсан, эдгээр гэмт

³¹ Женевские конвенции о защите жертв войны. М., 1954. С. 12.



үйлдлийн бүх төрлүүд нь харгис хэрцгий, бусдыг басамжлан доромжилсон хандлагатай байв.

1949 оны Женевын конвенциуд болон 1977 онд баталсан Нэмэлт протокол баримтууд байлдаж буй талууд олзлогдсон, далайд онгоцны сүйрэлд нэрвэгдсэн, шархадсан, өвчтөн зэргийн хүмүүст хандах хүмүүнлэг ёсны хэм хэмжээг тусгасан байна. Дээрх олон улсын акт баримтад тусгаж зааснаар хүн барьцаалах хүнд ноцтой гэмт хэрэг үйлдэхийг хориглосон байгаа нь чухал ач холбогдолтой юм. Хүн барьцаанд олзлон авах үйлдэл олон улсын зарим эрх зүйн баримт бичигт³² олон улсын гэмт хэрэгт тооцогдож байгаа боловч практик дээр энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх арга хэмжээнүүд хангалтгүй байгаа нь илт харагддаг.

Олон улсын төвшинд хүн барьцаалах үйлдлийг бие даасан гэмт хэрэгт тооцох, түүнтэй тэмцэхэд чиглэсэн нэн яаралтай арга хэмжээг боловсруулан батлахад хүргэсэн эмгэнэлтэй явдал бол 1972 оны есдүгээр сарын 5-ны өдөр Мюнхены XX Олимпийн наадмын үед гарсан “Хар есдүгээр сар” гэх, экстремист бүлгийн гишүүд тамирчдыг барьцаалсан хэрэг юм.

“Террористууд барьцааны хүмүүстэй хамт арабын аль нэг улс руу хамт нисэх онгоц гаргаж өгөхийг шаардсан. Террористууд, ХБНГУ-ын цагдаагийн байгууллага нар зөвшилцөлд хүрсэний дараа террористууд болон барьцааны хүмүүсийг Мюнхен хотоос 25 км байрших Фюрстенфельдруке дэх нисэх буудал руу хоёр вертолёт онгоцоор хүргэсэн, тэдгээрийг тэнд “Боинг” онгоц хүлээж байв. Вертолёт онгоц газардахад отолтод байсан цагдаагийн мэргэн буучид террористуудын зүг гал нээв. Буудалцааны үед террористууд барьцааны хүмүүс, вертолётын нэг нисгэгч мөн цагдааг бөмбөг дэлбэлэн амийг нь хөнөөжээ. Энэ ажиллагааны дүнд 16 хүн амиа алдсан ба тэднээс 11 нь олимпийн тэмцээнд оролцож байсан тамирчид байв. Бавари мужийн Дотоод хэргийн сайд отолт зохион байгуулсан шалтгаанаа тайлбарлахдаа нисэх буудалд ирэнгүүт нь барьцааны хүмүүсийг алж болзошгүй гэж Германы албаны хүмүүс болгоомжилж байсан учир тэдгээрийг онгоцонд суухаас нь өмнө цагдаа нар аврахыг оролдсон гэжээ”³³.

Энэ гэмт хэрэг гарсантай холбогдуулан НҮБ-ийн гишүүн орны хувьд ХБНГУ Хүн барьцаалах үйлдэлтэй тэмцэх Конвенци санаачлан боловсруулсан. НҮБ-аас ХБНГУ-ын энэхүү санаачилгыг дэмжсэн бөгөөд Ерөнхий Ассамблейн 31\103 баримт бичгийн дагуу 1976 оны арванхоёрдугаар сарын 15 өдөр Хүн барьцаалах үйлдэлтэй тэмцэх олон улсын конвенци боловсруулах Тусгай хороог байгуулсан юм.

Улс төрийн зорилгоор хүн барьцаалах гэмт үйлдэл ямар ч гэм буруугүй хүмүүсийн амь насанд заналхийлж, олон нийтийн амгалан тайван байдлыг алдагдуулан, төр засгийн хүчийг сулруулж буй үйлдлийн эсрэг тухайн улс орны зүгээс хүмүүнлэг ёсыг дагаж хууль зөрчин арга хэмжээ авахад хүргэж байна. Хүн барьцаалах явдлыг “Мексик болон өөр бусад улс орны хууль тогтоомжид хүн барьцаалах үйлдлийг эрх чөлөөг хууль бусаар хязгаарлах” гэж тодорхойлдог болохыг хуралдаан дээр Мексикийн төлөөлөгч Исака мэдэгдсэн³⁴ байна.

Аль ч орны дотоодын хууль тогтоомжоор хүний амь хөнөөх, агаарын хөлгийг эзлэн авч барьцаалах, хүүхэд хулгайлах, хүний эрх чөлөөг хууль бусаар хасах, дээрэмдэх зэрэг хэргүүд нь хүнд ноцтойд тооцогддог, хатуу шийтгэлтэй гэмт хэрэг юм. Хүн барьцаалах нь мөн адил олон улсын эрх зүйгээр байж болшгүй гэмт хэрэг, ихэнх тохиолдолд үндэсний эрүүгийн эрх зүйгээр хангалтгүй зохицуулагдсан байдаг, ялангуяа нэг улс оронд хүн барьцаалж, амийг нь хороосон этгээд өөр улс орноос орогнол олдог явдлыг таслан зогсоох шаардлагатай байгааг Канадын төлөөлөгч Вонг онцлон тэмдэглэжээ.³⁵

Хүн бүр Хүний эрхийн түгээмэл тунхаглалд заасан амьд явах, эрх чөлөөтэй байх, хувийн аюулгүй байдлаа хамгаалах эрхтэй гэсэн зарчмыг баримтлах шаардлагатай. Хүн барьцаалах явдал нь гэм буруугүй хүмүүсийн амь насанд заналхийлсэн гэмт үйлдэл тул түүнтэй тэмцэхгүй нэг ч улс орон байх боломжгүй юм.

³² Женевские конвенции 1949 года и Дополнительные протоколы к ним 1977 года; Европейская конвенция 1976 года.

³³ Советский спорт. 1972. 7 сент.

³⁴ ООН.Генеральная Ассамблея. 5-е заседание. Специальный комитет. 5 августа 1977 г. A/AC. 188/5. С. 4.

³⁵ ООН.Генеральная Ассамблея. 5-е заседание. Специальный комитет. 5 августа 1977 г. A/AC. 188/5. С. 6.



Тусгай хороо гурван удаа чуулган хийж /1977, 1978, 1979 он/ ажлын явцад 35 орны төлөөлөгчид конвенцийн үндсэн зүйл заалтуудыг хэлэлцсэн байна.

1979 оны 12 сарын 17-ны өдөр Нью-Йорк хотод НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 34-р чуулганаар 34/146 тоот тогтоолыг баталж, Хүн барьцаалахын эсрэг олон улсын конвенцид гарын үсэг зурснаар, хэрэгжүүлэх нөхцөл боломжийг нээж өгсөн.

Конвенц нь удиртгал ба 20 зүйлээс бүрдсэн. Удиртгалд конвенцид оролцогч улс орнууд Нэгдсэн үндэстний ард түмнүүд хоорондын хамтын ажиллагаа, найрсаг харилцаа, аюулгүй байдал, олон улсын энх тайвныг хангахад чиглэгдсэн НҮБ-ын дүрмийн зорилго, зарчмыг дэмжихийг онцлон дурьдсан. НҮБ-ын дүрэм болон олон улсын эрх зүйн зарчмын тухай тунхаглалд ард түмнүүдийн тэгш эрх, тусгаар тогтнох зарчмыг бататгасан.

Удиртгалд мөн энэхүү конвенцид оролцогч орнууд хүний эрхийн түгээмэл тунхаглал, иргэний болон улс төрийн эрхийн олон улсын пактад заасан хүн бүр амьд явах, эрх чөлөөтэй байх, аюулгүй байх эрхтэй гэдгийг хүлээн зөвшөөрсөн, мөн хүн барьцаанд авах нь олон улсын хамтын нийгэмлэгийн санааг ихээхэн түгшээсэн гэмт хэрэг гэж үзэж байгаа тул нэг бол эрүүгийн журмаар яллах эсхүл шилжүүлэн өгвөл зохихыг заасан. Хүн барьцаанд авах бүх үйлдлийг олон улсын терроризмын илрэл гэж үзэн тэдгээрээс урьдчилан сэргийлэх, тэдгээрийг яллах болон шийтгэх талаар үр нөлөөтэй арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг хэлэлцэн тохирсон байна.

Хүн барьцаалахын эсрэг Олон улсын Конвенцийн 1 дүгээр зүйлд энэ гэмт хэргийн шинжийг тодорхойлсон байна.

1. Гурван дахь этгээдээр, тухайлбал улс, засгийн газар хоорондын олон улсын байгууллага, хувь хүн, хуулийн этгээд, эсхүл бүлэг этгээдээр аливаа үйлдэл гүйцэтгүүлэх буюу гүйцэтгэхээс татгалзуулах зорилгоор өөр нэг хүн (цаашид “барьцааны хүн” гэх)-ийг суллах шууд буюу шууд бус болзол болгон тавьж түүнийг олзлох буюу саатуулах, амийг нь хөнөөх, бие махбодид нь гэмтэл учруулах, эсхүл үргэлжлүүлэн саатуулахаар заналхийлж буй аливаа этгээдийг энэхүү конвенцийн хүрээнд хүн барьцаалах гэмт хэрэг үйлдсэн гэж үзнэ.

2. Аливаа этгээд:

а) хүн барьцаалах үйлдэл хийхийг завдсан

б) хүн барьцаалах үйлдэл хийсэн буюу чингэхийг завдсан этгээдийн гэмт хэрэгт хамтран оролцсон бол, конвенцийн зорилгод гэмт хэрэг үйлдсэн гэж үзэхээр заасан.

2 дугаар зүйл: оролцогч улс бүр 1 дүгээр зүйлд заасан гэмт хэргүүд тэдгээрийн ноцтой шинжийг харгалзан зохих шийтгэл ногдуулна.

3 дугаар зүйл:

1. Гэмт хэрэгтэн нутаг дэвсгэрт нь хүн барьцаалсан бол оролцогч тухайн улс барьцааны хүний байдлыг хөнгөвчлөх, тухайлбал, түүнийг суллах, сулласны дараа шаардлагатай тохиолдолд уг улсаас гарахад нь тусламж дэмжлэг үзүүлэх талаар зохистой гэж үзсэн бүх арга хэмжээг авна.

2. Гэмт этгээдийн хүн барьцаалж байж олж авсан аливаа зүйл оролцогч улсын мэдэлд орсон бол тухайн оролцогч улс түүнийг аль болох түргэн хугацаанд барьцааны хүн буюу тухайн тохиолдлоос хамаарч 1 дүгээр зүйлд заасан 3 дахь этгээдэд, эсхүл тэдгээрийн эрх бүхий холбогдох байгууллагад буцааж өгнө.

8 дугаар зүйл

1. Оролцогч улс нь нутаг дэвсгэрт нь олж тогтоосон сэжигтэнг шилжүүлээгүй бол гэмт хэрэг нутаг дэвсгэрт нь үйлдэгдсэн эсэхээс үл хамаарч уг хэрэгт тухайн улсын хууль тогтоомжийн дагуу байцаан шийтгэх ажиллагаа явуулж өөрийн эрх бүхий байгууллагад яллуулахаар шилжүүлэх үүргийг аливаа нөхцөлгүйгээр хүлээнэ. Эдгээр байгууллага шийдвэрээ тухайн улсын хууль тогтоомжийн дагуу ноцтой шинж бүхий ердийн гэмт хэргийг шийдвэрлэдгийн адилаар гаргана.

2. 1 дүгээр зүйлд заасан гэмт хэрэгт холбогдуулан байцаан шийтгэх ажиллагаа явуулж буй аливаа этгээдэд байцаан шийтгэх ажиллагааны бүх үе шатанд шударга хандаж, түүнийг байгаа улсынх нь хууль тогтоомжид заасан бүх эрх, баталгаагаар бүрэн хангана.

12 дугаар зүйл

Дайнд хэлмэгдэгсдийг хамгаалах тухай 1949 оны Женевийн конвенциуд буюу тэдгээрийн нэмэлт протоколуудыг хүн барьцаалах тодорхой үйлдлийн хувьд хэрэглэдэг бөгөөд энэхүү конвенцид оролцогч улсууд дээрх конвенцуудын дагуу хүн барьцаалсан



этгээдийг яллах буюу шилжүүлэн өгөх үүрэг хүлээсний хэрээр 1977 оны 1 протоколын 1 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт заасан Нэгдсэн Үндэстний Байгууллагын дүрэм болон Нэгдсэн Үндэстний Байгууллагын дүрмийн дагуу улсууд найрсагаар харилцах, хамтран ажиллах талаархи олон улсын эрх зүйн зарчмын тухай тунхаглалд дурдсан өөртөө засан тохиноо эрхээ хэрэгжүүлэх үүднээс колонийн дарлал, харийн эзлэн түрэмгийлэл, арьсны үзэлт дэглэмийн эсрэг хийж буй ард түмнүүдийн тэмцлээс үүдсэн зэвсэгт мөргөлдөөн зэрэг 1949 оны Женевийн конвенциуд болон тэдгээрийн протоколуудад заасан зэвсэгт мөргөлдөөний үед хүн барьцаалах үйлдлийн хувьд энэхүү конвенцийг хэрэглэхгүй байхаар заасан.

13 дугаар зүйл

Гэмт хэргийг нэг улсын нутаг дэвсгэрт үйлдсэн бөгөөд барьцаанд байгаа хүн болон сэжигтэй этгээд хоёул тухайн улсын харьяат, түүнчлэн сэжигтэн этгээдийг тухайн улсын нутаг дэвсгэрт олж тогтоосон тохиолдолд энэхүү конвенцийг хэрэглэхгүй байхаар тогтсон байна.

Уг хэлэлцээрийн дутагдал бол гэмт хэргийн субъектыг тодорхойлох асуудалд зөвхөн хувь хүн (этгээдүүд) гэж тодорхойлсон, зарим тохиолдолд хүн барьцаанд авах актыг зохион байгуулан гүйцэтгэгчээр оролцож буй улс, засгийн үүрэг ролийг тодорхойлоогүй явдал юм.

Гишүүн орнууд Хүн барьцаалахтай тэмцэх Олон улсын конвенцид гарын үсэг зурсан явдал түүх, улс төр болон хууль эрх зүйн чухал ач холбогдолтойг тэмдэглэх нь зүйтэй.

Монгол улс Хүн барьцаалахын эсрэг олон улсын Конвенцид 1992 оны 06 дугаар сарын 09-нд нэгдэн орсон байна.

Дүгнэлт

Хүн барьцаалах гэмт хэрэг нь олон улсын терроризмын нэг хэлбэр, мөн дэлхийн хамтын нийгэмлэг, улс орнуудын хоорондох харилцаанд (олон улсын харилцааг тогтворгүй болгодог) хохирол учруулдаг олон улсын бие даасан гэмт хэрэг гэж үзэхээр байна.

Түүхэн цаг хугацаанд олон улсын гэрээ, конвенциудад боолчлол, алан хядах ажиллагаа, агаарын хөлөг барьцаалах, бусад олон улсын шинжтэй гэмт хэргийг хамааруулан зохицуулсан байна. Хүн барьцаалах гэмт хэргийн нэн эртний хэлбэрийг боолчлолтой холбоотой гэж үндэстэй юм.

1926, 1956 оны конвенциор боолын худалдааг хориглох түүнээс урьдчилан сэргийлэх, боолчлолын бүх хэлбэр, боолын худалдаа болон боолчлолыг устгахын тулд улс, орнууд харилцан бие биедээ дэмжлэг үзүүлэх тухай тусгажээ.

1963 оны “Агаарын хөлгийн бүхээгт үйлдсэн гэмт хэрэг болон тодорхой бусад үйлдлийн тухай” Конвенциор агаарын хөлөг, түүний дотор байгаа хүмүүс, эд хөрөнгө, түүнчлэн агаарын хөлгийн дотоод сахилга, дэг журамд аюул учруулсан, учруулж болзошгүй үйлдэл, агаарын хөлгийг хууль бусаар булаан авах үйлдлийг тодорхойлсон байна.

1970 оны Гаагийн “Агаарын хөлгийг хууль бусаар булаан авах үйлдлийг хориглох тухай” конвенциор “агаарын хөлгийг хууль бусаар булаах” үйлдэл гаргасан тухайн этгээдэд хүнд ял шийтгэл оногдуулах үүрэг хүлээсэн байна.

1971 оны Монреалийн “Иргэний нисэхийн аюулгүй байдлын эсрэг хууль бус үйлдлийг хориглох тухай” Конвенциор иргэний нисэх хүчний эсрэг үйлдэж буй гэмт хэргийн нөхцөл байдлыг арилгахын тулд терроризмын аюултай төрлийн нэг болох, энэ гэмт хэрэгтэй тэмцэхэд улс орны хамтын ажиллагааны эрх зүйн үндсийг бүрдүүлсэн, энэ конвенцийн нэмэлт протокол 1989 онд батлагдаж олон улсын иргэний нисэхэд үйлчилдэг, нисэх буудалд үйлдэгдэж буй хүч хэрэглэсэн явдлыг таслан зогсоох асуудлыг нарийвчлан зохицуулсан байна.

1949 оны Женевын конвенциуд болон 1977 онд баталсан Нэмэлт протоколд байлдаж буй талууд олзлогдсон, далайд онгоцны сүйрэлд нэрвэгдсэн, шархадсан, өвчтөн зэрэг хүмүүст хандах хүмүүнлэг ёсны хэм хэмжээг тусгаж, хүн барьцаалах гэмт хэрэг үйлдэхийг хориглосон байгаа нь чухал ач холбогдолтой юм.

1979 оны 12 сарын 17-ны өдрийн Хүн барьцаалахын эсрэг олон улсын Конвенцид хүн барьцаалах үйлдлийг анх удаа олон улсын төвшинд бие даасан гэмт хэрэг гэж үзэхээр зааж, энэ гэмт хэргийн шинжийг тодорхойлсон, улс орнууд үндэсний болон эрүүгийн хууль тогтоомжидоо хүн барьцаалах явдлыг гэмт хэрэгт тооцож хуульчлах, сэжигтэн этгээдийг



шилжүүлэх, мөрдөн байцаах, энэ хэргийн ноцтой шинжийг харгалзан зохих ёсны ял шийтгэл ногдуулах үүрэг хүлээсэн байгаа нь онцлог юм.

Ном зүй

1. Карпец И.И. Преступления международного характера. М., 1979.
2. СССР и международное сотрудничество в области прав человека. Документы и материалы МИД СССР. М., 1989.
3. Международное сотрудничество государств по борьбе с преступностью: Учебно-методическое пособие. М., 1982.
4. Олон улсын гэрээ, хэлэлцээрийн эмхтгэл. УБ., 1998.
5. Советский Ежегодник международного право. М., 1989.
6. Женевские конвенций о защите жертв войны. М., 1954.
7. Женевские конвенций 1949 года и Дополнительные протоколы к ним 1977 года; Европейская конвенция 1976 года.
8. Советский спорт. 1972.
9. ООН. Генеральная Ассамблея. 5-е заседание. Специальный комитет. 5 августа 1977.



ӨСВӨР НАСНЫ ХҮНД ХҮЛЭЭЛГЭЖ БУЙ ЭРҮҮГИЙН ХАРИУЦЛАГЫН ОНЦЛОГ, ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

А.Амарсайхан

*Дотоод хэргийн их сургуулийн Цагдаагийн сургуулийн Эрүүгийн эрх зүй,
криминологийн тэнхимийн ахлах багш, цагдаагийн дэд хурандаа*

Өсвөр нас нь аливаа хүний хувийн амьдралын мөчлөгийн чухал хүчин зүйл төдийгүй, эрх зүйн харилцаанд оролцох субъектын чадварыг тодорхойлоход шийдвэрлэх ач холбогдолтой, эрүүгийн хариуцлага хүлээлгэх шалгуур нөхцөл болдог онцлогтой. Өсвөр насны хүний үйлдсэн гэмт хэргийг мөрдөх болон шүүхээр хянан хэлэлцэхэд “Насанд хүрээгүй этгээд өөрийн үйлдэл, эс үйлдэхүйн бодит мөн чанар болон нийгэмд учруулах аюулыг ухамсарлах, эсхүл жолоодох боломжтой байсан уу” гэсэн асуудлыг авч үзэх ёстой юм.

Эрүүгийн хуулийн 8 дугаар бүлэгт “Өсвөр насны хүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэх” талаар заасан байна. Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгад гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүнд ял оногдуулах бодлогыг тусгайлан тодорхойлсон, хорих ялын бодлогыг уян хатан тодорхойлж хорихоос өөр төрлийн ялыг нэмж тусгасан бөгөөд уг бүлгийн онцлон авч эрэл хайгуул хийж, тоон судалгаа, цахим болон ном сурах бичгээс онолын болон практикт хэрхэн хэрэглэгдэж байгаа талаар судалж үзэв.

Хүний нас нь өргөн утгаараа хувь хүний онцлогийг тодорхойлох нэг гол шинж болохын хувьд өөртөө биологи, физиологи, сэтгэл судлал, нийгэм, эрх зүйн учир холбогдолтой олон хүчин зүйлийг багтаасан төрөх үеэс эхлэлтэй амьдрах, амьдарсан хугацаа юм. Хүнийг ухамсарт үйл ажиллагааны онцлог, сэтгэцийн түвшинг тодорхойлогч хүчин зүйл бол түүний нас юм. Учир нь хүний нас ахиж, физиологийн хөгжлийн тодорхой өндөрлөгт хүрэх тусам хувь хүний оюун ухаан, сэтгэх үйл явцын цар хүрээ улам сайжирч, энэ хэрээр амьдрал үйл ажиллагааны туршлага баяжин төлөвшиж, өөрийн үйл ажиллагааны мөн чанар, утга учир, гарах үр дагаврыг ухамсарлан ойлгох, тайлбарлах, түүнчлэн үйл ажиллагаагаа удирдан залах, захиран хариуцах чадвар улам нэмэгддэг зүй тогтолтой.

Монгол хэлний их тайлбар тольд “өсвөр нас” гэдгийг ид өсөн торниж буй хүүхэд үеийг хэлнэ хэмээн тайлбарласан байдаг³⁶ бол өдгөө Монгол Улсад хүчин төгөлдөр үйлчилж байгаа Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль болон бусад хууль тогтоомжуудад өсвөр насны хүн /насанд хүрээгүй хүн/-ий ойлголтын талаар тодотгон тогтоосон нэр томъёо хэллэг нь нэг утга агуулга бүхий ойлголтыг өөр өөр байдлаар илэрхийлсэн байх нь харагддаг.

Эрүүгийн хуулиар гэмт хэргийн субъектийг тодорхой насанд хүрсэн байхыг шаарддаг. Энэ нь хүүхдийн үйл ажиллагааныхаа учир холбогдлыг ойлгон ухамсарлах сэтгэхүйн хөгжлийн чадамжид үндэслэдэг. Учир нь гэмт хэрэг нийгмийн харилцааны энгийнээс нарийн төвөгтэйг хүртэл хамардаг учир хэрэг бүрийн нийгмийн учир холбогдол, хор уршгийг бага насны хүүхэд тэр бүр ойлгон ухамсарлах чадваргүй байдаг тул 16 наснаас эхлэн эрүүгийн хариуцага хүлээлгэж эхэлдэг. Харин хүүхэд нийгмийн учир холбогдол, хор уршигийг нь ойлгоход төвөггүй, нийгэмд аюултай болохыг нь ухамсарлах боломжтой зарим гэмт хэргийн хувьд субъектийн насыг 14 наснаас эхлэхээр тогтоосон. Харин зарим төрлийн гэмт хэрэгт шууд заагаагүй боловч 18 насанд хүрсэн этгээдийг субъектээр тооцох шаардлага тавигдана.³⁷

Өсвөр насны хүнийг насны ангиллын хувьд дараах байдлаар хуваан үзэж болох юм. Тухалбал:

- Арван дөрөв хүртэлх насны хүүхдийг бага насны хүүхэд гэх ба бага насны хүүхэд нь өөрийн үйлдсэн гэмт хэргийн нийгмийн хор аюул, учир холбогдлыг бүрэн ухаарах чадваргүй, үйлдсэн хэргийн хариуцлага, үр дагаврыг мэдэх боломжгүй, оюун ухааны хөгжил гүйцээгүй байх тул бага насны хүүхдийг хариуцлага хүлээх чадваргүй гэж үздэг.

³⁶ Я.Цэвэл “Монгол хэлний товч тайлбар толь” УБ хот, 1966 он, 156 дахь талд

³⁷ Г.Эрдэнэбат “Эрүүгийн эрх зүйн” гарын авлага, УБ хот, 2007 он, 91 дэх талд



- 14-18 хүртэлх насны хүүхдийг насанд хүрээгүй буюу өсвөр насны хүн гэж үзэх ба тэд хэдийгээр өөрийн үйлдлийн учир холбогдлыг ухаарах боловч бүрэн ухаарах чадваргүй, өөрийгөө удирдан жолоодох, үйлдлээ хянах, үр дагаврыг ойлгох чадвар, насанд хүрсэн хүнтэй харьцуулахад харьцангуй сул тул тэдний үйлдсэн хэргийг тусгайлан авч үздэг.

Эрүүгийн хариуцлага гэдэг нь гэмт хэрэг үйлдэж гэм буруутай нь шүүхээр тогтоогдсон этгээдийн эрх, эрх чөлөөнд шүүхийн шийтгэх тогтоолоор хязгаарлалт тогтоосон төрийн албадлагын арга хэмжээ юм.³⁸ Эрүүгийн хариуцлага нь өргөн утгаараа а/ гэмт хэрэг үйлдэгдсэн фактаас шууд үүдэлтэй, эрүүгийн хуулийн хэм хэмжээнд үндэслэгдсэн гэмт хэргийн субъект болох этгээдийн хийсэн хэргийнхээ төлөө төр түүнийг төлөөлсөн байгууллагын өмнө хүлээх хариуцлага, б/ үйлдэгдсэн гэмт хэрэг, гэмт хэрэг үйлдсэн этгээдэд төрийн нэрийн өмнөөс шүүхийн тогтоолоор өгч буй сөрөг үнэлгээ, в/ гэм буруутай нь нотлогдсон шүүгдэгчид оногдуулах эрүүгийн хуульд заасан төрийн албадлагын арга хэмжээ, г/ шүүхээр хорих ял шийтгэсэнтэй холбогдож үүсгэх ялтай байдал гэсэн дөрвөн үндсэн шинжийг өөртөө агуулж байдаг гэмт хэрэг үйлдэгдсэн хууль зүйн фактын нийгэм эрх зүйн шууд үр дагавар юм.³⁹

Эрүүгийн хариуцлага нь иргэн, нийгмийг гэмт халдлагаас хамгаалах, гэмт хэргийн улмаас зөрчигдсөн эрхийг сэргээх, гэмт хэрэг үйлдсэн этгээдийг цээрлүүлэх, хүмүүжүүлэх, гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх зорилгыг хангадаг.⁴⁰ Шүүх гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүний хувийн байдал, гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдлыг харгалзан эрүүгийн хуулийн 8 дугаар бүлэгт заасан журмын дагуу ял оногдуулж, оногдуулсан ял дээр нэмж, эсхүл ял оногдуулахгүйгээр хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээг хэрэглэж болно. Харин хүнд гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүнд ял оногдуулахгүйгээр хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээг дангаар хэрэглэж болохгүй.⁴¹

Эрүүгийн хариуцлагын үндэслэл нь Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан гэмт хэргийн бүрэлдэхүүний бүх шинжийг агуулсан нийгэмд аюултай, гэмт буруутай үйлдэл /эс үйлдэхүй/ хийсэн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэх үндэслэл болно. Үнэн хэрэг дээрээ гэмт хэрэг үйлдэгдсэн боловч тухайн этгээдийн үйлдэлд гэмт хэргийн бүрэлдэхүүний аль нэг шинж байхгүй бол гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй болно.⁴² Жишээ нь: субъект өсвөр насны хүн

Өсвөр насны хүнд хүлээлгэх эрүүгийн хариуцлага нь түүний нас, биед тохирсон, эрүүл мэнд, ёс суртахуун, сэтгэцийн онцлогийг харгалзан, нийгэмд өөрийн байр суурийг олоход туслах, боловсрол эзэмшүүлэх, үйлдсэн гэмт хэргийнх нь хор уршгийг ухамсарлуулах, гэмт хэрэг үйлдэхэд хүргэсэн орчин, хүмүүсийн нөлөөнөөс тусгаарлах, шаардлагатай тохиолдолд гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүнийг хорьж хүмүүжүүлэхэд чиглэсэн байна.⁴³

Монгол Улсын Эрүүгийн хуульд зааснаар 16 насанд хүрсэн хүнд Эрүүгийн хариуцлага хүлээлгэхийн хамт тусгай ангид заасан хүнд, хөнгөн гэмт хэрэг үйлдсэн /Эрүүгийн хуулийн 10.1, 11.1, 12.1 зэрэг/ насанд хүрээгүй хүнд 14 наснаас эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ. Насанд хүрээгүй байхдаа гэмт хэрэг үйлдсэн нь эрүүгийн хариуцлагыг хөнгөрүүлэх нөхцөл байдал бөгөөд насанд хүрээгүй байхдаа гэмт хэрэг үйлдсэн хүнд бүх наснаар нь хорих ял болон 15-аас дээш жилийн хугацааны хорих ял оногдуулахгүй.⁴⁴ Гэмт хэрэг үйлдэх үедээ арван дөрвөн насанд хүрсэн ба арван найман насанд хүрээгүй байсан хүнд эрүүгийн хуулийн 8 дугаар бүлэгт заасан үндэслэл журмын дагуу эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.⁴⁵

Эрүүгийн эрх зүйн хүний эрх, эрх чөлөө, нийгэм, төрийн ашиг сонирхолыг гэмт халдлагаас хамгаалах зорилтоос үүдэн эрүүгийн хариуцлага нь ихэвчлэн гэмт хэрэг үйлдсэн этгээдэд хэрэглэх албадлагын арга хэмжээ байдлаар илрэн гардаг. Энэхүү эрүүгийн эрх зүй дэх албадлагын арга хэмжээг ял гэнэ. Эрүүгийн эрх зүйд олон төрлийн

³⁸ С.Жанцан “ Монгол Улсын Эрүүгийн эрх зүй”/ерөнхий ба тусгай анги/, УБ хот, 2011 он, 32 дахь талд

³⁹ Мөн тэнд, 104 дэх талд

⁴⁰ Мөн тэнд, 208 дахь талд

⁴¹ Монгол Улсын Эрүүгийн хууль, Төрийн мэдээлэл 2016 он №7

⁴² С.Жанцан “ Монгол Улсын Эрүүгийн эрх зүй”, УБ хот, 2011 он, 208 дахь талд

⁴³ Монгол Улсын Эрүүгийн хууль, Төрийн мэдээлэл 2016 он №7

⁴⁴ С.Жанцан “ Монгол Улсын Эрүүгийн эрх зүй”/ерөнхий ба тусгай анги/, УБ хот, 2011 он, 91 дэх талд

⁴⁵ Монгол Улсын Эрүүгийн хууль, Төрийн мэдээлэл 2016 он №7



ялын бус (ял тэнсэх, ял хойшлуулах, эмнэлэгийн болон хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ г.м) хариуцлагын арга хэмжээ хэрэглэж хүн, нийгэм, төрийг гэмт халдлагаас хамгаалж байдаг. Үүнээс үндэслэн эрүүгийн хариуцлагыг дотор нь:

- Ялын буюу ял оногдуулсан
- Ялын бус буюу ял оногдуулаагүй гэсэн төрөлд хуваадаг.⁴⁶

Ял оногдуулсан эрүүгийн хариуцлага:

- ✓ Торгох ял
- ✓ Нийтэд тустай ажил хийлгэх ял
- ✓ Зорчих эрхийг хязгаарлах ял
- ✓ Хорих ял
- ✓ Эрх хасах ял⁴⁷

ял оногдуулаагүй эрүүгийн хариуцлага:

- ✓ Эмнэлэгийн чанартай албадлагын арга хэмжээ
- ✓ Хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ

Ял⁴⁸ нь хууль зүйн хариуцлагын анхны түүхэн хэлбэр төдийгүй гэмт явдалтай тэмцэх чухал хэрэглүүр бөгөөд эдүгээ онолын төдийгүй жишгийн шалгуураар авч үзэх боломжтой дэлхий нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн нэр томъёо болон төлөвшжээ.

Ял гэдэг нь гэмт хэрэг үйлдэж, гэмт буруутай нь шүүхээр тогтоогдсон ялтны эрх, эрх чөлөөнд Эрүүгийн хуульд заасны дагуу шүүхийн шийтгэх тогтоолоор эрхийн хязгаарлалт тогтоосон агуулга бүхий төрийн албадлагын онцгой арга хэмжээ юм.

Эрүүгийн хуульд эрүүгийн хариуцлага хүлээгэх насны доод хязгаарыг тогтооходоо гэмт хэрэг үйлдсэн хүүхдүүдэд ял хүлээлгэхгүйгээр хүмүүжлийн шинжтэй албадлагын арга хэмжээний тусламжтайгаар тэдний үйлддэг гэмт хэрэгтэй тэмцэх боломж, хэдийд тэдэнд эрх зүйн ухамсар төлөвшиж, эрүүгийн эрх зүйн хэм хэмжээний агуулга, утга учрыг бүрэн ухамсарлах чадвартай болох зэргийг харгалзан үзэх шаардлагатай. Эрүүгийн хариуцлага хүлээлгэх насны доод хязгаарыг тогтоох нь нийгэм-сэтгэл зүй, сурган хүмүүжүүлэх зүйн төдийгүй эрүүгийн бодлогын асуудал юм.⁴⁹

Монгол Улсын Эрүүгийн эрх зүй дэх ялын үндсэн ба хамгийн хатуу төрлийн нэг хорих ял юм. Хорих ялын үндсэн агуулга нь ялтныг олон нийтээс тусгаарлаж, харуул хамгаалалт, хяналт бүхий нөхцөлд хорих тусгай байгууллагад байлгахад оршино.⁵⁰ Эрүүгийн хуульд насанд хүрээгүй хүмүүст 15 жил хүртэл хугацааны хорих ял оногдуулахаар заасан. Гэмт хэрэг үйлдэх үедээ 14 насанд хүрсэн ба 18 насанд хүрээгүй байсан хүнд хуульд заасан үндэслэл, журмын дагуу ял оногдуулна. Гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүнд дараах ял оногдуулна.⁵¹ Үүнд:

1. Нийтэд тустай ажил хийлгэх
2. Зорчих эрхийг хязгаарлах
3. Сургалт- хүмүүжлийн тусгай байгууллагад хорих

Өсвөр насны хүнд хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан хугацаанд шүүхээс хүлээлгэсэн үүрэг, тогтоосон хязгаарлалтыг зөрчөөгүй бол прокурорын дүгнэлтийг үндэслэн шүүх ялаас чөлөөлнө.⁵²

- Өсвөр насны хүнд хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулах үндэслэл, журам:
- Анх удаа гэмт хэрэг үйлдэж хорих ял шийтгүүлсэн насанд хүрээгүй этгээдийн үйлдсэн гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээ, гэмт буруутай этгээдийн хувийн байдал, гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдлыг харгалзан түүнийг нийгмээс тусгаарлахгүйгээр хүмүүжүүлэх боломжтой гэж шүүх үзвэл хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг 6 сараас 2 жил хүртэл

⁴⁶ Г.Эрдэнэбат “Эрүүгийн эрх зүйн” гарын авлага, УБ хот, 2007 он, 121 дэх талд

⁴⁷ Монгол Улсын Эрүүгийн хууль, Төрийн мэдээлэл 2016 он №7

⁴⁸ Ял-латин “рета” “рипайз” - залхаалт, цээрлэл, төлөөс гэсэн утгатай

⁴⁹ С.Жанцан “ Монгол Улсын Эрүүгийн эрх зүй”/ерөнхий ба тусгай анги/, УБ хот, 2009 он, 406 дахь талд

⁵⁰ С.Нарангэрэл “Хууль зүйн эх толь бичиг”, УБ хот, 2008 он, 108 дахь талд

⁵¹ Монгол Улсын Эрүүгийн хууль, Төрийн мэдээлэл 2016 он №7

⁵² Монгол Улсын Эрүүгийн хууль, Төрийн мэдээлэл 2016 он №7



хугацаагаар хойшлуулж болно. Ийм тогтоол гарсан үед нэмэгдэл ял биелүүлэхийг нэгэн адил хойшуулна.

- Шүүх шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулахдаа тодорхой хугацаанд ажил, сургуульд орох, учруулсан хохирлоо нөхөн төлөх, гэм хорыг арилгах, ажлын газар сургуулиа өөрчилсөн тухайгаа оршин суугаа газрынхаа цагдаагийн байгууллагад мэдэгдэж байх зэрэг түүний засрал хүмүүжилд дөхөм үзүүлэх үүргийг даалгаж, түүнийг хараа хяналтдаа байлгаж, хүмүүжүүлэх үүргийг тодорхой хамт олон буюу төрийн бус байгууллага, эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, сурган хүмүүжүүлэгч, ойрын төрөл, садангийн хүн, тодорхой иргэнд тэдний хүссэнээр буюу зөвшөөрснөөр хариуцуулж болно.
- Шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан этгээд шүүхээс тогтоосон хугацаанд даалгасан үүрэг биелүүлээгүй буюу захиргааны шийтгэл хүлээсэн бол шүүгч цагдаагийн байгууллагын саналыг үндэслэн хорих ял оногдуулсан шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан шийдвэрийг хүчингүй болгож, хорих ялын биечлэн эдлүүлэх тухай захирамж гаргана.
- Хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан хугацаанд уг этгээд засарч хүмүүжсэнээ харуулсан бол цагдаагийн байгууллагын саналыг үндэслэн шүүх түүнийг ялаас чөлөөлж болно.
- Шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан хугацаанд уг этгээд гэмт хэрэг шинээр үйлдвэл шүүх эрүүгийн хуульд заасны дагуу ял оногдуулна.

Шүүхийн шийтгэх тогтоолыг хойшлуулах гэдэг нь Эрүүгийн хуульд заасан үндэслэл, журмаар шүүгдэгчид оногдуулсан хорих ялыг биечлэн эдлүүлэхгүйгээр хүмүүжүүлэх боломжтой гэж шүүх үзвэл тодорхой хугацаа зааж, үүрэг болгосон агуулгатай болзол тавьж, ялыг биечлэн эдлүүлэх явдлыг түдгэлзүүлж байгаа хэрэг юм.

Шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулахдаа насан хүрээгүй этгээдэд:

- Тодорхой хугацаанд ажил, сургуульд орох
- Учруулсан хохирлоо нөхөн төлөх
- Гэм хорыг арилгах
- Ажлын газар, сургуулиа өөрчилсөн тухайгаа оршин суугаа газрынхаа цагдаагийн байгууллагад мэдэгдэж байх үүргийг даалгаж байгаа нь хүмүүжил, засралд холбогдолтой болзол юм.

Шүүх насан хүрээгүй этгээдэд хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан бол тогтоолын хувийг ялтны оршин суугаа газрын цагдаагийн байгууллагад нэн даруй хүргүүлж, сум, дүүргийн Засаг дарга, ялтныг хараа хяналтандаа байлгаж хүмүүжүүлэхээр зөвшөөрсөн иргэн, хуулийн этгээдэд энэ тухай бичгээр мэдэгдэнэ.

Насанд хүрээгүй этгээдийг хянан харгалзах талаар цагдаагийн байгууллага:

- Тогтоолын хувийн хүлээн авсан өдрөөс хойш 7 хоногт багтаан хяналтын хувийн хэрэг нээж ялтан, түүний эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, түүнчлэн ялтныг хараа хяналтандаа байлгаж хүмүүжүүлэхээр зөвшөөрсөн иргэн, эсхүл хуулийн этгээдийн төлөөлөгчийг дуудан уулзаж тэдгээрийн эрх, үүрэг, ялтанд хууль, шүүхийн шийтгэх тогтоолоор тогтоосон хязгаарлалт, даалгасан үүргийг танилцуулах
- Ялтны эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, түүнчлэн ялтныг хараа хяналтандаа байлгаж хүмүүжүүлэхээр зөвшөөрсөн иргэн, хуулийн этгээд үүргээ биелүүлэх талаар шаардлага тавьж, биелэлтийг хангуулах
- Ялтны сахилга, засрал хүмүүжил, шүүхээс даалгасан үүргийн биелэлтийн талаар сар тутам хяналтын хувийн хэрэгт тэмдэглэл хийх
- Шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан хугацаа дуусмагц энэ тухай шүүх болон ял шийтгүүлсэн этгээдэд бичгээр мэдэгэх үүрэг хүлээнэ.⁵³

Хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ нь хэн нэгний хүсэлтээр бус шүүх насанд хүрээгүй этгээдийн үйлдсэн гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээ, хвийн байдал, гэр бүл, хамт олны дунд хүмүүжүүлэх боломж зэргийг харгалзан,

⁵³ С.Жанцан “Монгол Улсын Эрүүгийн эрх зүй онол” /Ялын тухай сургаал/, УБ хот, 2014 он, 315-317 дахь талд



эрх зүйн ухамсарыг удирдлага болгон шүүхээс хэрэглэдэг учир эрүүгийн хариуцлагын албадлагын шинж агуулсан өвөрмөц арга хэмжээ юм.⁵⁴

Эрүүгийн хуульд заасан эрүүгийн хариуцлагын бусад арга хэмжээний бие даасан нэг төрөл бол хүмүүжлийн албадлагын арга хэмжээ юм.

Өсвөр насны хүн хөнгөн болон хүнд гэмт хэрэг үйлдсэнээс үл хамааран ял тэнсэж хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ авч болно.

Энэ нь Эрүүгийн 7 дугаар бүлэгт заасан ял тэнсэх албадлагын арга хэмжээтэй зөрчилддөг. Зөвхөн хөнгөн гэмт хэрэг үйлдсэн хүн л ял тэнсэж 1-5 жил хүртэл хугацаанд хяналтанд байх хуулийн зохицуулалт бий.

Харин өсвөр насны хүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэх тухай Эрүүгийн хуулийн 8 дугаар бүлэгт заасан зарим, зүйл заалтууд нь Эрүүгийн хуулийн нийтлэг зохицуулалттай зөрчилддөг.

Эрүүгийн хуулийн 8.7 дахь хэсэгт “шүүх энэ хуульд зааснаар хорих ялын дээд хэмжээг 8 жил, түүнээс доош тогтоосон эсхүл хорихоос өөр төрлийн ял оногдуулахаар гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдлыг харгалзан үзэж шүүхээс оногдуулсан ял дээр нэмж эсвэл ял оногдуулахгүйгээр тэнсэж хянан хүмүүжүүлэхээр шийдвэрлэж болно.

Шүүхээс 1-3 жил хүртэлх хугацаагаар хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээг оногдуулж болдог” гэмт хэрэг анх удаа үйлдсэн насанд хүрээгүй этгээдэд шүүхээс хэрэглэдэг хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ юм. Энэ арга хэмжээг нийгмийн хор аюул багатай хөнгөн, хүнд гэмт хэргийг анх удаа үйлдсэн өсвөр насны хүнд ял оногдуулахгүйгээр засарч хүмүүжих боломж олгох, түүнийг хүмүүжүүлэх үйл хэрэгт эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, сурган хүмүүжүүлэгч, ойрын төрөл, садангийн хүмүүс, хамт олон, төрийн бус байгууллагыг өргөнөөр оролцуулах зорилгын үүднээс хэрэглэнэ.⁵⁵

Эрүүгийн хуулийн тусгай ангид 8 жил хүртэл хугацаагаар хорих ял оногдуулахаар заасан гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүний гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал, учруулсан хохирол, хор уршгийн шинж чанар, хувийн байдлыг харгалзан ял оногдуулахыг тэнсэж 1 жилээс 3 жил хүртэл хугацаагаар хянан хүмүүжүүлэхээр шийдвэрлэж болно. Хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээг хүүхдийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хэрэгжүүлнэ.

Гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүнийг хянан хүмүүжүүлэх хугацаанд хараа хяналтандаа байлгаж хүмүүжүүлэх үүргийг тодорхой хамт олон, төрийн бус байгууллага, эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, сурган хүмүүжүүлэгч, ойрын төрөл, садангийн хүн, тодорхой иргэний хүсэлтээр нь эсхүл зөвшөөрснөөр нь даалгаж болно.⁵⁶

Насанд хүрээгүй хүнд хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэх нь насанд хүрээгүй хүмүүсээс үйлдсэн гэмт хэрэг нь нийгэмд учруулж буй хор аюулаар их биш, заавал эрүүгийн ял хүлээлгэхгүйгээр түүнийг засаж хүмүүжүүлэх боломжтой нөхцөлд шүүх хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ авна. Хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ нь хүний эрхийг зарим талаар хязгаарладаг учир гагцхүү шүүх хэрэглэх ёстой.⁵⁷

Хамт олон буюу төрийн бус байгууллага, түүнчлэн тодорхой иргэний хяналтад байлгахгаар тэдний хүссэнээр буюу зөвшөөрснөөр шилжүүлэх, шаардлагатай гэж үзвэл хүмүүжүүлэгч томилж болно.

Энэ арга хэмжээг хэрэглэхэд зайлшгүй шаардагдах нөхцөлүүд:

- 14-18 насны хооронд нийгмийн хор аюул багатай гэмт хэрэг үйлдсэн байна.
- Хөнгөн буюу хүндэвтэр нэмт хэрэг анх удаа үйлдсэн байна.
- Насанд хүрээгүй этгээдийг хүмүүжлийн чанартай арга хэмжээний тусламжтайгаар засах боломжтой байна.

Хүмүүжлийн шинжтэй албадлагын арга хэмжээний төрөл:

⁵⁴ С.Жанцан “ Монгол Улсын Эрүүгийн эрх зүй онол” /Ялын тухай сургаал/, УБ хот, 2014 он, 337 дахь талд

⁵⁵ Монгол Улсын Эрүүгийн хуулийн тайлбар, УБ хот, 2013 он, 206 дахь талд

⁵⁶ <http://citycourtofcriminalappeals.mn/c/1499068149098173>

⁵⁷ С.Нарангэрэл “ Монгол Улсын Эрүүгийн эрх зүй” ерөнхий анги, УБ хот, 369-370 дахь талд



- 6 сараас нэг жил хүртэл хугацаагаар засарч хүмүүжихийг даалгах - Үйлдсэн гэмт хэргийн хор аюулыг ухамсарлуулэ ойлгуулах замаар хэрхэн, яаж хүмүүжил төлөвшил олох арга замыг зааж өгнө.
- 16 насанд хүрсэн этгээд бие даан орлого олдог бол хохирлыг өөрийн хөдөлмөрөөр арилгах үүрэг хүлээлгэх - 16 насанд хүрсэн этгээдийн эд хөрөнгийн байдал, хөдөлмөрлөх дадалыг харгалзан учруулсан хохирлоо төлсөн байх зайлшгүй шаардлагатай болохыг үүрэг болгоно.
- Эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, сурган хүмүүжүүлэгч, ойрын төрөл садангийн хүмүүсийн хяналтад өгөх - Эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, сурган хүмүүжүүлэгч, ойрын төрөл садангийн хүмүүс хуулийн дагуу гэмт хэрэг үйлдсэн хүүхдийг харж хандах, зан байдалд нь хяналт тавих, хүмүүжлийн эерэг нөлөөлөл үзүүлэх үүрэгтэй.⁵⁸

2018 оны 11 сарын байдлаар шүүхийн тогтоол биелүүлэхийг хойшлуулсан 57 өсвөр насны этгээд хяналтанд байсан. 2019 оны 03 дугаар сарын байдлаар Сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагад хорих ял эдэлж байгаа 6 эрэгтэй, 1 эмэгтэй өсвөр насны хоригдол анх удаа гэмт хэрэг үйлдэж шүүхээс оногдуулсан хорих ялыг хойшлуулсан хугацаандаа дахин гэмт хэрэг үйлдэж хорих ялыг биечлэн эдэлж байгаа нь анхаарал татах асуудал юм.

Монгол улсад гэмт хэрэг үйлдэж, ял шийтгэл авч байсан өсвөр насны хүүхдүүдийг судалж үзэхээр эцэг, эх, харгалзан дэмжигчдийн хараа хяналт муу байх, үл хайхрагдах хүчирхийлэлд өртөж байсан зэрэг нь нөлөөлсөн байдаг.

Өсвөр насны хүүхдүүд гэмт хэрэг үйлдэх нь түгээмэл бөгөөд шүүхээс хорих ялыг хойшлуулсан өсвөр насны хүмүүсийг дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэхэд энэ талаар хийгдсэн судалгааны ажил, түүнд тулгуурласан шинжлэх ухааны үндэслэлтэй саналуудыг боловсруулах, олон улсын жишиг дүрэм, журам, зөвлөмжийг ашиглах нь чухлыг тодорхойлж, Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, Хүүхэд, гэр бүл залуучуудын хөгжлийн газар⁵⁹, Залуучуудын хөгжлийн төв⁶⁰, Жендэрийн үндэсний хорооны уялдаа холбоог тодорхойлж энэ талаар баримталж буй бодлого, түүний хэрэгжилт болон олон улсын зарим туршлагыг судлан тодорхой санал дэвшүүлэхийг эрмэлзсэн.

Өсвөр насны хүнд хүлээлгэх эрүүгийн хариуцлага нь түүний нас, биед тохирсон, эрүүл мэнд, ёс суртахуун, сэтгэцийн онцлогийг харгалзсан, нийгэмд өөрийн байр суурийг олоход туслах, боловсрол эзэмшүүлэх, үйлдсэн гэмт хэргийнх нь хор уршгийг ухамсарлуулах, гэмт хэрэг үйлдэхэд хүргэсэн орчин, хүмүүсийн нөлөөнөөс тусгаарлах, шаардлагатай тохиолдолд гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүнийг хорьж хүмүүжүүлэхэд чиглэсэн байна⁶¹.

Эрүүгийн хуульд шүүх анх удаа “хөнгөн гэмт хэрэг”⁶² үйлдсэн өсвөр насны хүн, жирэмсэн эмэгтэй, гурав хүртэлх насны хүүхэдтэй эх, ганц бие эцэгт хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хоёр жил хүртэл хугацаагаар хойшлуулж болно⁶³. Энэ хугацаанд ялтанд шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага хяналт тавина.

Эрүүгийн хуулийн 8.6 дугаар зүйлийн 1 дахь хэсэгт “Шүүх анх удаа энэ хуулийн тусгай ангид хорих ялын дээд хэмжээг найман жил, түүнээс доош хугацаагаар тогтоосон, эсхүл энэ хуулийн тусгай ангид хорих ял оногдуулахаар заагаагүй гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүнд энэ хуулийн 7.6 дугаар зүйлд заасны дагуу шийтгэх тогтоол

⁵⁸ С.Жанцан “ Монгол Улсын Эрүүгийн эрх зүй”, УБ хот, 2011 он, 171 дэх талд

⁵⁹ Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн 20.6 дахь хэсэгт “...Залуучуудын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь орон нутаг дахь залуучуудын хөгжлийн төвийг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж ажиллана...” гэж заасан.

⁶⁰ Мөн хуулийн 20.7 дахь хэсэгт “...Залуучуудын хөгжлийн төв нь залуучуудын хөгжлийн салбар зөвлөлийн ажлын алба байна...” гэж заасан.

⁶¹ Монгол Улсын Эрүүгийн хууль.,УБ.,2015 он., 8.1 дүгээр зүйлийн 2 дахь заалт;

⁶² Монгол Улсын Эрүүгийн хууль.,УБ.,2015 он., 2.7 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Эрүүгийн хуулийн тусгай ангид зааснаар хорих ялын дээд хэмжээг 5 жил, түүнээс доош хугацаагаар оногдуулахаар тогтоосон, эсхүл хорих ял оногдуулахаар заагаагүй гэмт хэргийг хөнгөн гэмт хэрэг гэнэ” гэж заасан.

⁶³ Монгол Улсын Эрүүгийн хууль.,УБ.,2015 он., 7.6 дугаар зүйлийн 1 дэх заалт;



биелүүлэхийг хойшлуулахдаа 7.3 дугаар зүйлийн 2,3 дахь хэсэгт заасан үүрэг хүлээлгэж, хязгаарлалт тогтоож болно” гэж тус тус заасан байна⁶⁴.

ЭХ-ийн 7.6.1-т зааснаар хорих ял оногдуулсан шүүхийн тогтоол биелүүлэхийг хойшлуулахад өсвөр насны хүн анх удаа хөнгөн гэмт хэрэг /хорих ялын дээд хэмжээ 5 жил/ үйлдсэн байх ёстой. Харин ЭХ-ийн 8.6.1-т заахдаа анх удаа гэмт хэрэг үйлдэж хорих ялын дээд хэмжээг 8 жил эсхүл түүнээс доош хугацаагаар тогтоосон гэдэгтэй шууд утгаараа зөрчилдөж байна. Шүүхээс өсвөр насны хүн хөнгөн эсхүл хүнд гэмт хэрэг үйлдсэн байснаас үл хамааран хорих ялыг хойшлуулах боломжтой байгаа нь хуулийн хийдэл юм.

Мөн ЭХ-д зааснаар гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүнд оногдуулсан хорих ялыг хоёрны нэгээр бодож хорих ял оногдуулдаг. Хорих ялын дээд хэмжээг 8 жил хүртэл эсхүл түүнээс доош хугацаагаар тогтоосон гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүн шүүхээс хуулийн дагуу ялаа багасгуулж 4 жилийн хорих ялыг авч оногдуулсан хорих ялаа хойшлуулах боломжтой.

Сургалт-хүмүүжлийн байгууллагын нийгэм-сэтгэл зүйн албатай учир нийгмийн ажилтан, сэтгэл зүйч нар төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллаж гэмт хэргийн хор уршгийг арилгах талаар арга хэмжээ авч хохирлоо барагдуулахгүй бол хугацааны өмнө тэнсэн суллагад эрх үүсэхгүй гэдгийг ойлгуулахаас гадна зан үйлд нөлөөлөх, хөдөлмөрлөх дадал олгох сургалтанд өсвөр насны хоригдлуудыг бүрэн хамруулж, үр дүн нь ч сайн байдаг. Өсвөр насны хоригдол насанд хүрээгүй тул тодорхой ажил үүрэг гүйцэтгүүлэхгүй ерөнхий боловсролын сургалтанд хамруулж, сард 10 хүртэл шагналын хоног олгож, эдэлсэн ял дээр нэмж тооцдог. Мөн тодорхой хүнтэй харилцахыг хязгаарлах, галт зэвсэг өмчлөх, эзэмшихийг хориглох, согтууруулах ундаа, мансууруулах бодис хэрэглэхийг хориглож байнгын биечилсэн хяналтыг тавьж ар гэр рүү нь утсаар яриулах, зөвхөн хувийн хэрэгт бүртгэлтэй гэмт хэрэг үйлдэхэд хамааралгүй хүнтэй эргэлт, уулзалтаар уулзахыг зөвшөөрдөг.

ЭХ-ийн 6.12.1 дахь хэсэгт “Ялтан гэмт хэрэг үйлдэж учруулсан хохирлоо нөхөн төлж зан байдлаараа нийтэд аюулгүй болсноо нотлон харуулж ял эдлэх хугацаандаа ноцтой зөрчил гаргаагүй, оногдуулсан ялыг дараах хувийг эдэлсэн бол прокурорын саналыг харгалзан шүүх хугацаанаас өмнө суллаж, хяналт тогтоохоор шийдвэрлэж болно” гэж заагаад 6.12.1.1. таван жил хүртэл хорих ялын хоёрны нэгээс доошгүй хувийг эдэлсэн бол хугацаанаас өмнө суллаж болно.

Мөн хуулийн 6.12.2 Хорих ялаас хугацаанаас нь өмнө суллахдаа эдлээгүй үлдсэн ялын хугацаатай тэнцүү хяналтын хугацаа тогтооно гэж заасан. Дээрх заалтыг практикт зөвхөн хорих ял биечлэн эдэлж байгаа хоригдлуудад хэрэгжүүлээд хорих ялыг биечлэн эдлээгүй ч хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан ялтан хяналтын хугацаанд хорих ял эдэлсэнд тооцогддогийг харгалзан үзэж энэ заалтыг нэг мөр хэрэгжүүлэх шаардлагатай. Хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан өсвөр насны ялтан хяналтын хугацаанд сайн байж чадсан бол үлдсэн хорих ялаас хугацааны өмнө тэнсэн суллаж хяналт тогтоох асуудлыг бий болговол ял завшуулах асуудлыг цэгцлэх боломжтой гэж үзэж байна. хорих ялыг биечлэн эдлүүлээгүй ч хорихгүйгээр нийгэмд нэгтгэхэд өөрчлөлтүүдийг хийх хэрэгтэй.

Шүүхээс 2013-2017 онд 1443 насанд хүрээгүй этгээд ял шийтгүүлснээс 1273 хүүхдийн хорих ялыг хойшлуулж, 36 хүүхдэд тэнсэн харгалзсан байдаг.

Хүснэгт 1⁶⁵

НХХ-д шүүхээс хорих ял оногдуулсан байдлын судалгаа			Нийт
2013-2017 он	Хорих ялыг биечлэн эдэлсэн	Тэнсэн харгалзах	1443 /100 хувь/
		Хорих ялыг оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан	

⁶⁴ Монгол Улсын Эрүүгийн хууль, УБ., 2015 он., 8.6 дугаар зүйлд 2018 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн хуулиар нэмэлт өөрчлөлт оруулсан.

⁶⁵ “Монгол улсад насанд хүрээгүй хүмүүсээс болон хүүхдийн эсрэг үйлдэгдсэн гэмт хэргийн шалтгаан нөхцөл” сэдэвт судалгааны ажлын тайлан /2013-2017/, УБ., 2018 он., 22 дахь тал;



	134 буюу 9.3 хувь	36 буюу 2.5 хувь	1273 буюу 88 хувь	
--	------------------------------	-----------------------------	--------------------------	--

2019 оны 03 сарын байдлаар Сургалт хүмүүжлийн тусгай байгууллагад 30 гаруй өсвөр насны хоригдол хорих ял эдэлж байгаагаас 7 өсвөр насны хоригдол шүүхээс оногдуулсан хорих ялыг хойшлуулсан хугацаандаа дахин гэмт хэрэг үйлдэж хорих ял шийтгүүлсэн байна.

Мөн эмэгтэй өсвөр насны хоригдлын хувь д 2018 онд анх хулгайлах гэмт үйлдээд 2 жилийн хорих ял авч шүүхээс 1 жил хорих ял хойшлогдсон хугацаандаа дахин хулгайлах гэмт хэргийг бүлэглэн үйлдэж шүүхээс урьд оногдуулсан хорих ял дээр нэмж 2 жилийн хорих ял шийтгүүлэн 4 жилийн хорих ялыг багасгаж 2 жил болгон хорих ялыг сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагад биечлэн эдлүүлэх болсон. Хорих ял хойшлогдсон хугацаанд нь Залуучуудын хөгжлийн төв, төрийн бус байгууллагуудын оролцоон дор зоргоор нь орхилгүй батлан даалтанд авсан хойд эцэг, төрсөн эх нь анхаарал сайн тавьж, охиныхоо бусад уруу татагдах, гадуур тэнэх зэргээс урьдчилан сэргийлж чадсан бол бүлэглэн гэмт хэрэг үйлдэхгүй байх нөхцөл бүрдэх байсан. Сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагад ял эдэлж буй өсвөр насны хоригдлуудын ял шийтгэлийн байдал.

Хүснэгт 2

Эрүүгийн хуулийн зүйл, хэсэг	Гэмт хэргийн ангилал	
	Хөнгөн	Хүнд
10.1 Бусдын амь насыг санаатай хохироох	-	2016 онд 5 жил хорих ял авсан. 1 хоригдол. 17 настай Анх удаа ял шийтгэгдсэн
11.1 Бусдын бие махбодид хүнд гэмтэл санаатай учруулах	-	2018 оны 1 сард 2 жил хорих ял авсан. 1 хоригдол. 17 настай Анх удаа ял шийтгэгдсэн
12.1.2.1, 12.1.2.2 Бусдын бэлгийн эрх чөлөөнд халдах	7 хоригдол. 16-17 насны /1-2 жилийн хорих ялтай/ Анх удаа ял шийтгэгдсэн	-
12.1.4 бусдын бэлгийн эрх чөлөөнд халдах /хүндрүүлэх нөхцөлтэй/	-	7 хоригдол. 16-17 насны /6-9 жилийн хорих ялтай/ Анх удаа ял шийтгэгдсэн
17.1.2.1 Хулгайлах	9 хоригдол. 15-17 насны 1-2 жилийн хорих ялтай /Анх удаа ял авсан 6 нь, давтан шийтгэгдсэн 3/	-
17.2.2. Дээрэмдэх	-	3 хоригдол. 15-17 насны 1-2 жилийн хорих ялтай давтан үйлдэлтэй .
Бүгд	17 хоригдол.	12 хоригдол.

Энэ нь эцэг эхийн зүгээс тавих хараа, хяналт алдагдаж бүтэн буюу эцэг эх нь салж сарнисан хагас өнчрөлд орох нь өсвөр насны хүүхдүүдийг гэмт хэрэг үйлдэхэд дөхөм үзүүлсэн нэг нөхцөл болж байна. Одоогоос 40 гаруй жилийн өмнө 1971 онд Монголд гэр бүл салалтын улмаас өнчирсэн л хайхрагдсан хүүхдүүдийн 12.6 хувь нь гэмт хэрэг үйлдэж, 14.5 хувь нь зөрчилд холбогдсон байгааг⁶⁶ тогтоосон байдаг. Насанд хүрээгүй хүмүүсийн үйлдэж буй хэргийн 60 гаруй хувь нь хулгай, үлдсэн хувь нь дээрэм, хүчин, танхай, зодоон бусад хэргүүд зонхилон эзэлдэг⁶⁷.

⁶⁶Н.Жанцан, Ю.Цэвээннамжил, "Насанд хүрээгүй хүмүүсийг гэмт хэргээс урьдчилан сэргийлье", УБ., 1975 он., 26 дахь тал;

⁶⁷ Б.Наранзаяа. "Насанд хүрээгүй этгээдээс үйлдэгдэж буй хулгайн гэмт хэргийн эрүүгийн эрх зүйн ба криминологийн зарим асуудал" сэдэвт Цагдаагийн дээд сургуулийн дипломын ажил., УБ., 1999 он., 56 дахь тал;



Гэр бүл салалтыг аль болох гаргахгүй байх нь чухал гэдгийг эрдэмтэн Н.Жанцан 1984 онд өөрийн бүтээлдээ "...гэмт хэрэг үйлдсэн насанд хүрээгүй хүмүүсийн 400 хавтаст хэргийн материалд судалгаа хийж үзэхэд судалгаанд хамрагдагсдын 33.2 хувь бүрэн биш гэр бүлд хүмүүжсэн, 4.6 хувь нь эцэг эхгүй, 18.1 хувь эцэгтэйгээ, 9.2 хувь эхтэйгээ, 1.3 хувь нь төрөл садныхантайгаа хамт амьдарч байсан байна..." гэж тэмдэглэсэн байдаг⁶⁸. Энэ нь гэр бүлийн амьдралын нөхцөл үл хайхрагдах байдал нь хүүхдийн хүмүүжилд чухал нөлөө үзүүлдэг гэдгийг 25 жилийн өмнө баталсан бол 2013-2017 онд хорих ял авч хойшлогдсон 1273 хүүхэд, хорих ял биечлэн эдэлсэн 134 хүүхдийн ар гэрийн байдалд гэмт хэрэг үйлдэхэд нөлөөлсөн байсан. Мөн Сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагад ял эдэлж байгаа хүүхдүүдийн ар гэрийн байдал гэмт хэрэг үйлдэхэд нөлөөлсөн болох нь тогтоогдсон.

Насанд хүрээгүй этгээдэд хорих ял оногдуулахыг аль болохоор зайлсхийж, харин нээлттэй "шорон" буюу нийгмээс тусгаарлахгүйгээр эрх чөлөөг нь түр хязгаарлах замаар нийгэмшүүлэх чиглэлийн олон сонголттой ялын төрлийг хэрэглэж, энэ нь "төр, иргэний байгууллага, гэр бүл"⁶⁹ гэсэн гурвалсан субъектын хамтын хариуцлагын зарчмаар хэрэгжүүлэхээр зохицуулсан байдаг.

НҮБ-аас гаргасан жишиг дүрэмд⁷⁰ энэ талаар тодорхой тусгасан ба энэ нь шүүхээс хорихоос өөр төрлийн ялыг түлхүү хэрэглэх болсныг илэрхийлнэ. Хүүхдийн эрхийн конвенцэд хүүхэд бүр эрхээ эдлэхийн тулд шаардлагатай бүхий л олон улсын конвенц болон үндэсний хуулийг хэрэглэх эрхтэй.⁷¹ Насанд хүрээгүй этгээдийн хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаа нь тэдний насыг болон засарч хүмүүжихэд нь дэмжлэг үзүүлэхийг харгалзсан байна.⁷²

Хэргийн нөхцөл байдал шаардахгүй бол насанд хүрээгүй нэг ч хүнийг эцэг, эхийнх нь хараа хяналтаас бүрэн буюу зарим хэмжээгээр гаргаж болохгүйг заасан байдаг боловч энэ журам хэрэгжилт хангалтгүй байгааг дараах байдлаар тайлбарлаж болно.

Дүгнэлт

Гэмт хэрэгт холбогдсон өсвөр насны хүүхдийг шоронд явуулснаар хүмүүжүүлнэ гэж байхгүй, харин ч тэр хүүхэд ирээдүйд улам л эргэлзээтэй хүмүүжилтэй, ёс зүйтэй хүн болж төлөвшин тогтнох суурийг бий болгох аюултай.

2002 оны Эрүүгийн хуульд өсвөр насны хүн гэмт хэрэг үйлдсэн тохиолдолд ямар ял оногдуулах талаар зааж өгөөгүй.

Өсвөр насны хүн, том хүн хоёр нэг хуулиар яллуулдаг байсан бөгөөд шинэчилсэн найруулгаар хүүхдийн хорих ангийн хэлбэр өөрчлөгдөж сургалт-хүмүүжлийн тусгай байгууллага болсон.

Сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагад ял эдэлж байгаа өсвөр насны хүн ерөнхий, мэргэжлийн боловсрол, хөдөлмөрлөх, амьдрах ухааны дадал олгох сургалтад хамрагдаж байга юм. Гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүнд ял оногдуулахдаа хорих ялыг хамгийн эцсийн арга хэмжээ болгож хэрэглэж байгаа юм.

Өсвөр насны хүнд оногдуулах ялын төрөл, ял оногдуулах журам, түүнд хэрэглэх албадлагын арга хэмжээг тусгай бүлгээр 2017 оноос хэрэгжиж эхэлсэн Эрүүгийн хуулинд зохицуулж өгсөн. Ингэснээр өсвөр насны хүний бие, сэтгэл зүйн онцлогийг харгалзан насанд хүрэгчдээс ялгамжтай ял оногдуулах, аль болох хорих ял оногдуулахаас зайлсхийж, хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээг үр дүнтэй хэрэглэж, нийгэм, хамт олны дунд хүмүүжүүлэх боломж нээгдэх юм. Гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүнд нийтэд тусгай ажил хийлгэх, зорчих эрхийг хязгаарлах, сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагад хорих ял оногдуулахаар, шүүх хөнгөн гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүний гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал, учруулсан хохирол, хор уршгийн шинж чанар, хувийн байдлыг харгалзан ял оногдуулахыг тэнсэж, хуульд заасан хугацаагаар хүмүүжлийн

⁶⁸ Н.Жанцан., "Насанд хүрээгүй хүмүүсээс үйлдэж байгаа гэмт явдлын шалтгаан, нөхцөл, урьдчилан сэргийлэх арга зам", УБ., 1984 он., 85 дахь тал;

⁶⁹ "Дэлхийн эрүүгийн загвар хууль ба орчин үе", УБ., 2013 он., 34 дэх тал;

⁷⁰ НҮБ-ын хорихоос өөр төрлийн арга хэмжээнд холбогдах наад захын жишиг дүрэм./Токиогийн дүрэм/ Ерөнхий Ассемблейн 1990 оны 10-р сарын 14-ний өдрийн 45/110-р тогтоол.

⁷¹ "Хүүхдийн эрхийн конвенц", НУ., 1989 он., 37(Б);

⁷² "Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт", 1966 он., 14.4 дэх хэсэг;



чанартай албадлагын арга хэмжээ авах, өсвөр насны хүнд хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулж болохоор тусгасан байна.

Санал

1. Гадаад улс орнуудын Эрүүгийн хууль тогтоомжид “Насанд хүрээгүй хүн”-д ялыг хэрхэн оногдуулах, шийхийн шийдвэр биелүүлэлт үр нөлөөний чиглэлээр сургалт, эрдэм шинжилгээний хурал зөвөлгөөнийг үе шаттайгаар зохион байгуулах.
2. Гэмт хэрэгт холбогдсон өсвөр насны хүүхдийг хорих байгууллагад ял шийтгэгдсэнээр хүмүүжүүл төлөвшилд ахиц гарч байгаад судалгаа явуулж, тэдэнд зөв иргэн хүн болж төлөвшүүлэхийн тулд тухайн нутаг дэвсгэрийг хариуцаж ажиллаж байгаа нийгмийн ажилтан мөн хэрэгт холбогдож буй өсвөр насны хүүхдийн гэр бүлд энэ талаар сургалт зохиож үр дүнтэй ажлуудыг хийх хэрэгтэй.



ЭРҮҮГИЙН ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН ТУЛГАМДСАН АСУУДАЛ

ГЭРЧ, ХОХИРОГЧИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАМГААЛАХ ОЛОН УЛСЫН ЭРХ ЗҮЙН МЕХАНИЗМ

П.Батбаатар

*Дотоод хэргийн их сургуулийн Удирдлагын академийн захирал,
докторант, цагдаагийн хурандаа*

Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.2 дахь хэсэгт “Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө” гэж заасан бөгөөд Монгол Улсын хуулиар соёрхон баталсан, нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенц, эрх зүйн баримт бичгүүд нь гэрч, хохирогчийг хамгаалах үйл ажиллагаанд чухал ач холбогдолтой юм.

Гэрч, хохирогчийг хамгаалах үйл ажиллагааг зохицуулсан дараах олон улсын гэрээ, конвенц, эрх зүйн баримт бичгүүд батлагдан хүчин төгөлдөр мөрдөгдөж байна. Үүнд:

1. Хүний эрхийн түгээмэл тунхаглал⁷³

Энэхүү тунхаглал нь хүн бүр арьсны өнгө, үндэс, хүйс, хэл, шашин шүтлэг, нийгмийн гарал, эд хөрөнгө, язгуур угсаа болон бусад байдлыг үл харгалзан адил тэгш эрхтэй байхыг тунхаглан баталгаажуулж хүн төрөлхтөн нийтээрээ хүлээн зөвшөөрсөн хүний эрхийн тухай анхны баримт бичиг бөгөөд нийт 30 зүйлээс бүрдэнэ. Тунхаглал нь хэдийгээр заавал биелүүлэгдэх шинжгүй, санал зөвлөмжийн шинжтэй ч хүний эрхийг хамгаалах механизмын үүсэл хөгжилд гол үүрэг гүйцэтгэж, хүний эрхийг хамгаалах тогтолцоо бүрэлдэх үндэс суурь болсон билээ.

Уг Тунхаглалын 7 дугаар зүйлд “Хүн бүр хуулийн өмнө адил тэгш бөгөөд ямар ч алагчилалгүйгээр хуулиар адилхан хамгаалуулах эрхтэй. Хүн бүр энэхүү Тунхаглалд харшлах аливаа алагчилалаас болон тийнхүү алагчилахыг өдөөсөн турхиралтаас адилхан хамгаалуулах эрхтэй”, 12 дугаар зүйлд “Хэний ч хувийн болон гэр бүлийн амьдралд хөндлөнгөөс дур мэдэн оролцох, орон байрны халдашгүй байдал, захидал харилцааных нь нууц болон нэр төр, алдар хүндэд нь халдах ёсгүй. Тийм оролцоо халдлагын эсрэг хэн ч бай хуулиар хамгаалуулах эрхтэй”, 30 дугаар зүйлд “Энэхүү Тунхаглалын ямар ч зүйлийг аль нэг улс, бүлэг буюу бие хүний зүгээс энд тунхагласан эрх, эрх чөлөөг устгахад чиглэсэн аливаа үйл ажиллагаа явуулах буюу тийм үйлдэл хийх эрх олгож байгаа мэтээр мушгин тайлбарлаж болохгүй” гэж заасан нь гэрч, хохирогчийн аюулгүй байдлыг хамгаалах талаарх үндсэн суурь хэм хэмжээ болдог байна.

2. Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт⁷⁴

НҮБ-ын Дүрэмд тунхагласан зарчмын дагуу хүн төрөлхтөний ам бүлийн гишүүн бүхэнд угаас заяасан нэр төр болон тэдний адил тэгш, салшгүй эрхийг хүлээн зөвшөөрөх нь эрх чөлөө, шудрага ёс, бүх нийтийн энх тайвны үндэс мөн болохыг анхааралдаа авч, эдгээр эрх нь хүнд угаас заяасан нэр төрөөс үүдэн гарч байгааг болон Хүний эрхийн түгээмэл Тунхаглалд зааснаар хүн бүр эдийн засаг, нийгэм, соёлын эрхээ улс төр, иргэнийхээ эрхийн адил эдлэх нөхцөлөөр хангагдаж байж улс төр, иргэний эрх чөлөөгөө эдэлж, айх аюулгүй, гачигдах зовлонгүй байх чөлөөт бие хүний эрхэм зорилго биелэгдэхийг хүлээн зөвшөөрч, НҮБ-ын Дүрэм ёсоор улс гүрэн хүний эрх, эрх чөлөөг бүх нийтээр хүндэтгэн сахиж явдлыг хөхүүлэн дэмжих үүрэгтэйг, түүнчлэн хувь хүн бүр бусад хүн, хамт олныхоо өмнө үүрэг хүлээхийн сацуу энэхүү пактад хүлээн зөвшөөрсөн эрхийг хөхүүлэн дэмжих, сахиулах талаар чармайх ёстойг тунхаглах зорилгоор 1966 оны 12

⁷³ Энэхүү тунхаглал нь Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейн 217/A/III/ тогтоолоор 1946 оны 12 дугаар сарын 10-ны өдөр баталж, түүний бүх заалтыг дагаж мөрдөхийг гишүүн улсуудад уриалжээ. <https://www.legalinfo.mn/>

⁷⁴ Ерөнхий Ассамблейн 1966 оны 12 дугаар сарын 16-ны 2200A(XXI) тоот тогтоолоор баталж, 1976 оны 3 дугаар сарын 23-ны өдөр хүчин төгөлдөр болсон. <https://www.legalinfo.mn/>



дугаар сарын 16-ны өдөр НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаас 2200А(XXI) тоот тогтоол батлан гаргаж, тогтоолоор “Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт”-ыг баталжээ.

Энэхүү пакт нь хүний амьд явах, эрх чөлөөтэй байх, халдашгүй дархан байх, чөлөөтэй бодож сэтгэх, шашин шүтэх, эс шүтэх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, эвлэлдэн нэгдэх, улсаа удирдахад шууд буюу чөлөөтэй сонгосон төлөөлөгчөөрөө уламжлан оролцох, сайн дурын үндсэн дээр гэрлэх, өрх тусгаарлах, өмчтэй байх, хүн бүр хуулийн өмнө адил тэгш хамгаалуулах, улсынхаа дотор чөлөөтэй зорчих, амьдран суух газраа чөлөөтэй сонгох зэрэг хүний иргэний болон улс төрийн суурь эрхүүдийг багтаасан Хүний эрхийн баримт бичиг юм. Одоогийн байдлаар пактыг үзэглэсэн 74, соёрхон баталсан 167 улс байдаг ба манай улс 1968 оны 01 дүгээр сарын 05-ны өдөр энэхүү пактад гарын үсэг зурж, 1974 оны 11 дүгээр сарын 18-ны өдөр соёрхон баталсан байна. Нийт 6 хэсэг, 53 зүйл бүхий энэхүү пакт нь НҮБ-ын тогтолцоонд “Олон улсын эрхийн билл /Хүний эрхийн түгээмэл тунхаглал, Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт, Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пакт/” хэмээн нэрлэгдэх гурван үндсэн баримт бичгийн нэг бөгөөд пактад хувь хүний иргэний хувьд эдлэх бүхий л сонгодог эрх,эрх чөлөөг тусгасан байна.

Уг пактын 14 дүгээр зүйлд “Гэмт хэргийн хохирогчийг аюулгүй байдлыг нэн тохиромжтой нөхцөлөөр хангах, заналхийлэл буй тохиолдолд гэрчийг хамгаалах...” тухай заасан бөгөөд Пактын 2 дугаар зүйлийн 2.3 дахь хэсэгт:

- энэхүү Пактаар үүлээн зөвшөөрсөн эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн аливаа хүнийг, ийм зөрчлийг албан үүргээ гүйцэтгэж байсан этгээд үйлдсэн байсан ч үр нөлөөтэй эрх зүйн хамгаалалтаар хангах;

-эрх зүйн хамгаалалт хүссэн аливаа этгээдийн тийм эрхийг эрх бүхий шүүх, захиргаа, хууль тогтоох байгууллага, эсхүл тухайн улсын эрх зүйн тогтолцоонд заасан эрх бүхий бусад байгууллагаас тогтоож байх явдлыг хангах, түүнчлэн шүүхээр хамгаалуулах боломжийг нь хөгжүүлэх;

-эрх зүйн хамгаалалт олгож байгаа бол түүнийг эрх бүхий байгууллагаас хэрэгжүүлэх явдлыг хангахад Пактад оролцогч улс бүрт үүрэг болгосон байдаг.

Энэхүү Пактаар тогтоосон стандарт болон эдгээр стандартыг хэрэгжүүлэх журам нь гишүүн улсуудад заавал биелүүлэх хууль зүйн хүчин чадалтай байдгаараа онцлог юм.

3. Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенц⁷⁵

Энэхүү баримт бичгийг Нэгдсэн Үндэстний Байгууллагын дүрэмд тунхагласан зарчмын дагуу хүн төрөлхтөн хэмээх гэр бүлийн гишүүдийн тэгш, салшгүй эрхийг хүлээн зөвшөөрөх нь эрх чөлөө, шударга ёс, бүх нийтийн энх тайвны үндэс болохыг анхаарч, эдгээр эрх нь хүнд заяасан нэр төрөөс урган гардгийг хүлээн зөвшөөрч, Дүрмийн 55 дугаар зүйлийн дагуу хүний эрх, үндсэн эрх чөлөөг бүх нийтээр хүндэтгэн сахих үйлсэд хувь нэмрээ оруулах улс үүргээ анхаарч, хэнийг ч эрүүдэн шүүх, хэрцгий, хүнлэг бусаар буюу нэр төрийг нь доромжлон харьцаж шийтгэхгүй хэмээн Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 5 дугаар зүйл, Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 7 дугаар зүйлд заасныг харгалзан, Ерөнхий Ассамблейгаас 1975 оны 12 дугаар сарын 9-ний өдөр батласан Хүнийг эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу нэр төрийг нь доромжлон харьцаж шийтгэхээс хамгаалах тухай тунхаглалыг харгалзан, эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг тэмцлийн үр нөлөөг дэлхий нийтээр дээшлүүлэхийг эрмэлзэн батласан хүний эрхийн баримт бичиг юм.

Уг конвенцийн 13 дугаар зүйлд “Оролцогч улс түүний нутаг дэвсгэрт эрүүдэн шүүгдсэн хэмээн мэдүүлж буй этгээд эрх бүхий байгууллагад гомдол гаргах, хэргээ шуурхай, шударгаар хянан шалгуулах явдлыг хангана. Гомдол гаргасан этгээд болон гэрчүүдийг гомдол гаргасан болон нотлох баримт гаргаж өгсөнтэй холбогдуулан зүй бусаар харьцах, айлган сүрдүүлэхээс хамгаалах арга хэмжээ авна” гэж заажээ.

3. “Гэмт хэрэг болон эрх мэдлээ урвуулан ашигласны улмаас хохирсон хохирогчийн эрх зүйн хамгаалалтыг хангах үндсэн зарчмын тухай тунхаглал⁷⁶

⁷⁵ 1984 оны 12 дугаар сарын 10-ны өдөр Нью-Йорк хотноо баталж, 1987 оны оны 6 дугаар сарын 26-ны өдөр хүчин төгөлдөр болсон. <https://www.legalinfo.mn/>



НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 40/34 дугаар тогтоолоор 1985 онд “Гэмт хэрэг болон эрх мэдлээ урвуулан ашигласан үйлдлийн улмаас хохирсон хохирогчийн эрх зүйн хамгаалалтыг хангах үндсэн зарчмын тухай” тунхаглалыг батлан гаргасан нь олон улсын хэмжээнд хохирогчийн эрхийн талаар гаргасан үндсэн баримт бичиг болсон байна. Уг тунхаглалын 6 дугаар зүйлд “гэмт хэргийн хохирогчийн аюулгүй байдлын нэн тохиромжтой нөхцөлөөр хангах, мөн заналхийлэл буй тохиолдолд гэрчийг хамгаалах”-ыг улсуудад уриалсан юм.

НҮБ-аас олон улсын хамтын нийгэмлэг, засгийн газруудад гэмт хэргийн улмаас хохирсон хохирогчийн эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох боломжийг бүрдүүлэх, шударга ёсыг хангахад чиглэсэн хүчин чармайлт гаргахад нь туслах зорилгоор батлан гаргасан энэхүү зарчмыг хууль, олон улсын гэрээний хэм хэмжээний адил дагаж мөрдөх зайлшгүй шаардлагагүй боловч НҮБ-аас тогтоосон бусад норм, стандарттай адилтган үзэх боломжтой зэрэгцээ уг зарчим нь гэмт хэргийн улмаас хохирсон этгээдийн эрхийг хангахад баримтлах үндсэн стандарт болж байгаа юм.

Хохирогчид үзүүлэх тусламжийн тухайд шаардлагатай материаллаг, эмнэлгийн, сэтгэл зүйн болон нийгмийн халамжийн туслалцаа үзүүлэх, эх үүсвэрийг төрийн, сайн дурын, орон нутгийн эх үүсвэрээс олгохыг зөвлөсөн байна.

Уг тунхаглалд “Гэмт хэргийн хохирогчийн аюулгүй байдлыг нэн тохиромжтой нөхцөлөөр хангах, мөн заналхийлэл буй тохиолдолд гэрчийг хамгаалах”-ыг улсуудад уриалсан юм.

НҮБ-аас энэхүү зарчим, стандартыг тогтоохдоо “гэмт хэргийн улмаас хохирсон хохирогчтой шударга харьцах”, “гэмт хэргийн улмаас хохирсон хохирогчийг хамгаалалтын механизмд хамааруулах боломжоор хангах”, “мэдээлэл гаргаж өгөх эрхээр хангах”, “өшөө авалт, айлган сүрдүүлэлтээс хамгаалах”, “хохирогчийн эрхийг хамгаалах албан бус механизм ажиллуулах”, “хохирол арилгуулах, нөхөн төлбөр, нийгмийн халамжийн тусламж авах эрхээр хангах” зэргийг тулгуур үндэслэл болгожээ.

Тунхаглалын 6 дугаар зүйлийн “d” хэсэгт айлган сүрдүүлэх, өс хонзон авах зэргээс хамгаалагдах зарчмыг “хохирогчид учирч болох аюул заналхийллийг багасгах, шаардлагатай аливаа тохиолдолд амь насыг нь хамгаалах болон тэдгээрийн аюулгүй байдлыг хангах, мөн гэр бүлийн гишүүд, гэрчийн аюулгүй байдлыг хангах, айлган сүрдүүлэх, өшөө авалт зэргээс хамгаалах арга хэмжээ” хэмээн тайлбарлажээ.

Энэхүү баримт бичиг нь шүүх, хууль сахиулах байгууллагын ажилтанд хохирогчийн асуудлаарх зохих гарын авлага болохоос гадна энэ салбарын хууль тогтоомжийн үндэс болж гэрч, хохирогчийг хамгаалах механизмыг бүрдүүлэх, хөгжүүлэхэд ач холбогдол бүхий үүрэг гүйцэтгэх стандарт юм. Үүгээр тогтоосон стандартын дагуу өнөөдөр хохирогчийг хамгаалах асуудлаараа ямар улс аль түвшинд байгааг тодорхойлдог болсон байна.

НҮБ-ын Эдийн засаг, нийгмийн Зөвлөлийн 1989 оны 5 дугаар сарын 24-ний өдрийн 1989/57 дугаар тогтоолоор “Гэмт хэрэг болон албан тушаалын байдлаа урвуулан ашигласны улмаас хохирсон хохирогчийн талаарх хууль цаазын үндсэн зарчмын тухай тунхаглалыг хэрэгжүүлэх талаар зөвлөмж” баталсан байна. НҮБ-ын гишүүн улсуудад хандсан энэхүү баримт бичгийн 2 дугаар заалтад:

- Үндсэн хууль болон дотоодын практик /үүнийг эрх зүйн бүлээс хамааран гэж ойлгох/-т нийцүүлэн “Тунхаглалын” зүйл, заалтыг үндэсний шүүх эрх мэдлийн тогтолцоонд тусгах, түүнтэй холбоотой эрх зүйн баримт бичгийг батлан хэрэгжүүлэх

- Гэмт хэрэгтэй холбоотой аливаа эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа, бусад ажиллагааны явцад болон дараа нь гүтгэлэг, айлган сүрдүүлэх байдлаас хохирогчийг хамгаалах арга хэмжээг боловсруулах зэрэг арга хэлбэрээр тунхаглалыг хэрэгжүүлэхийг зөвлөсөн байна.

1989 оны 12 дугаар сарын 15-ны өдөр НҮБ-ын Ерөнхий Ассамблей энэхүү зөвлөмжийг дэмжин сайшааж 44/162 дугаар тогтоолоор гишүүн улсууд “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хүний эрхийг хангах талаар НҮБ-ын хэм хэмжээ, стандартыг хэрэгжүүлэх стратегийг боловсруулах”-даа энэ зөвлөмжийг харгалзан тооцохыг санал болгосон байна.

⁷⁶ Энэхүү тунхаглал НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 1985 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн A/KE5/40/34 тоот тогтоолоор батлагдсан. <http://www.un.org/russian/document/declarat/power.htm>



НҮБ-ын VIII Конгресс 1990 онд Гавана хотод “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ба эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны салбар дахь XXI зууны олон улсын хамтын ажиллагаа” сэдвээр хуралдахдаа гэрч, хохирогчийн асуудалд онцгой анхаарч “Хөгжлийн хүртээмж, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ба эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны салбар дахь олон улсын хамтын ажиллагаанд баримтлах Зөвлөмж” хэмээх чуулганы үр дүнд гарсан баримт бичгийн 18 дугаар зүйлийн “С” хэсэгт нийтээр анхаарал хандуулж, цаашид боловсруулах асуудлын нэг нь гэрч, хохирогчийн “зохистой хамгаалалт”-ыг хангах асуудал гэдгийг тэмдэглээд улс бүрт гэрч, хохирогчийг хамгаалах үндсэн зарчмыг боловсруулахыг үүрэг болгоод тодорхой гэмт хэргийн төрлөөс шалтгаалан гэрч, хохирогчийн аюулгүй байдлыг хангах шаардлагад чухал анхаарлаа хандуулсан байна. Тухайлбал, “Олон улсын терроризмтой тэмцэх арга хэмжээ” гэх тогтоолын “L” хэсгийн “Хохирогчийг хамгаалах” хэмээх хэсгийн 23-т “Улсуудын терроризмын хохирогчийг хамгаалах механизмыг бий болгох, холбогдох хууль тогтоомж гаргах, тэдгээрт туслалцаа үзүүлэх хангалттай хөрөнгийг гаргах шаардлагатай” гэсэн бол гэрчийн хувьд мөн тогтоолын “M” хэсгийн “Гэрчийг хамгаалах” хэмээх хэсгийн 25-д “Улс бүр террорист ажиллагааны гэрчийг үр дүнтэй хамгаалахад чиглэсэн арга хэмжээ, бодлогыг хэрэгжүүлэх шаардлагатай” гэж үзжээ.

Энэ тунхаглалыг хэрэгжүүлэхтэй холбогдуулан боловсруулан гаргасан “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хэрэгжүүлэгч эрх бүхий этгээдүүдэд зориулсан зааварчилгаа”-ны “B” хэсгийн “Хохирогч ба эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа” хэмээх хэсгийн 35-т “Хэрэв гэмт этгээдийн зүгээс сүрдүүлсний улмаас хохирогч нь айж, эмээж байгаа бол цагдаа болон бусад байгууллагаас тухайн хохирогчийг хамгаалах, түүнийг дэмжих бүх арга хэмжээг (тухайлбал: цагдаагийн хамгаалалт авах, оршин суух газрыг нь өөрчлөх г.м) авах ёстой. Ийм арга хэмжээ авах талаар талаараа хохирогчдод мэдэгдэх нь чухал болно”, мөн “B” хэсгийн 55-д “Хэрэв хохирогч гэрчийн мэдүүлэг өгөхөөсөө айж, эмээж байгаа бол видео дүрсээр, эсхүл видео хальсанд бичсэн гэрчийн мэдүүлгийг ашиглахыг зарим хууль тогтоомжоороо зөвшөөрсөн байх” гэсэн стандартыг тогтоож өгчээ.

4. Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг НҮБ-ын конвенц⁷⁷

Энэхүү конвенц нь үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн гэрч, хохирогчийн аюулгүй байдлыг хангахад чухал ач холбогдолтой баримт бичиг бөгөөд конвенцийн 24 дүгээр зүйлд /Ерөнхий Ассамблейн 55/25 шийдвэрийн нэгдүгээр хавсралт/ улс үндэстнүүд үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэгт гэрчийн мэдүүлэг өгч байгаа гэрчийн этгээдийг айлган сүрдүүлэх, дарамтлахаас үр дүнтэй хамгаалах зорилгоор тодорхой арга хэмжээг авч хэрэгжүүлэх үүрэгтэй болохыг заасан юм.

Дурьдсан арга хэмжээнд бодит биет хамгаалалт, өөр газарт оршин суух, хаяг, байршлаа солих, гэрчийн этгээдийн биеийн байцаалт, хувийн мэдээллийг нууцлах, хязгаарлах, гэрчийн этгээдийн аюулгүй байдлыг хангасан орчинд гэрчийн мэдүүлэг өгөхийг зөвшөөрөх зэрэг арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлж болно гэж заасан. Гишүүн улс орнууд гэрчийн этгээдэд зориулан өөр улс оронд түр болон урт хугацаагаар оршин суух зөвшөөрөл авах зорилгоор бусад улс орнуудтай гэрээ байгуулах, холбогдох зохион байгуулалтыг хийх үүрэгтэй, энэ нь хохирогчид болон түүний гэрчийн этгээдэд мөн адил хамаах тухай заажээ.

Мөн конвенцийн “Хохирогчийг хамгаалах болон түүнд туслэх” гэсэн 25 дугаар зүйлд “Оролцогч улс бүр энэхүү Конвенцид хамаарах гэмт хэргийн хохирогчийг тухайлбал, өшөө авах буюу сүрдүүлэх заналхийллээс хамгаалах болон түүнд туслалцаа үзүүлэх хүрээнд зохих арга хэмжээнүүдийг авна”, “Оролцогч улс бүр энэхүү Конвенцид хамаарах гэмт хэргийн хохирогчид нөхөн олговор олгох болон хохирлыг арилгах талаар зохих журмыг батална”, “Оролцогч улс бүр гэмт хэрэгтний эсрэг эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зохих шатанд хохирогч өөрийн үзэл санааг өмгөөлөх эрхэд нь хохирол учруулахгүй байх хэлбэрээр илэрхийлэх болон хэрэгжүүлэх боломжийг өөрийн дотоодын

⁷⁷ Ерөнхий Ассамблейн 2000 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр баталж, 2003 оны 12 дугаар сарын 25-ны өдөр хүчин төгөлдөр болсон. Монгол Улс 2008 оны 5 дугаар сарын 16 -ны өдөр соёрхон баталж, нэгдэн орж, 2008 оны 6 дугаар сарын 27-ны өдөр МУ-д хүчин төгөлдөр болсон.



хуулийн дагуу бүрдүүлнэ” гэж тус тус заажээ.

Манай улс энэхүү конвенцийн дагуу гэрчийн аюулгүй байдлыг хамгаалах чиглэлээр урьдчилан сануулах, тодорхой үйлдлийг хязгаарлах, биечилсэн хамгаалалт, мэдээллийн нууцлалыг хангах, хувийн хамгаалалтын хэрэгсэл болон аюулгүй байдлын техник хэрэгсэл, харилцаа холбооны хэрэгслээр хангах, аюулгүй газарт түр байрлуулах, нүүлгэн шилжүүлэх, баримт бичгийг солих, гадаад төрхийг өөрчлөх зэрэг арга хэмжээг Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд тусгасан юм.

5. “Авлигын эсрэг НҮБ-ын конвенц”⁷⁸

Энэхүү конвенцийн зорилго нь авилгалаас илүү үр ашигтай бөгөөд үр дүнтэйгээр урьдчилан сэргийлж, тэмцэх арга хэмжээг дэмжиж, бэхжүүлэх; авилгалаас урьдчилан сэргийлж, тэмцэх, тухайлбал хөрөнгө буцааж олгох талаар олон улсын хамтын ажиллагаа, техникийн туслалцааг хөгжүүлэх, хөнгөвчлөх, дэмжих; төрийн хэрэг, төрийн эд хөрөнгийн шударга, хариуцлагатай, зохистой удирдлагыг дэмжихэд оршино.

Уг конвенцийн 32 дугаар зүйлд “Оролцогч улс бүр энэхүү конвенцын дагуу тогтоосон гэмт хэргийн талаар мэдүүлэг өгч буй гэрч ба шинжээч, мөн зохих тохиолдолд тэдний хамаатан садан болон бусад ойрын хүнийг өс хонзон буюу айлган сүрдүүлгээс үр дүнтэйгээр хамгаалахаар заах талаар зохих арга хэмжээг өөрийн дотоодын эрх зүйн тогтолцоонд нийцүүлэн, өөрийн боломжийн хэмжээнд авна”⁷⁹ гэж заасан байна.

6. Хүн барьцаанд авахын эсрэг Нью-Йоркийн олон улсын конвенц”⁸⁰

Уг конвенцийн 3 дугаар зүйлд “Гэмт хэрэгтэн нутаг дэвсгэрт нь хүн барьцаалсан оролцогч тухайн улс барьцааны хүний байдлыг хөнгөвчлөх, тухайлбал, түүнийг суллах, сулласны дараа шаардлагатай тохиолдолд уг улсаас гарахад нь тусламж дэмжлэг үзүүлэх талаар зохистой гэж үзсэн бүх арга хэмжээг авна”, “Гэмт этгээдийн хүн барьцаалж байж олж авсан аливаа зүйл оролцогч улсын мэдэлд орсон бол тухайн оролцогч улс түүнийг аль болох түргэн хугацаанд барьцааны хүн буюу тухайн тохиолдлоос хамаарч 1 дүгээр зүйлд заасан гурав дахь этгээдэд, эсхүл тэдгээрийн эрх бүхий холбогдох байгууллагад буцааж өгнө” гэж заажээ.

7. Олон улсын эрүүгийн шүүхийн Ромын дүрэм”⁸¹

Уг дүрмийн 43 дугаар зүйлийн 43.6 дахь хэсэгт “Нарийн бичгийн дарга Нарийн бичгийн дарга нарын газрын бүтцэд хохирогч болон гэрчүүдэд туслалцаа үзүүлэх ажлын хэсгийг байгуулна. Энэ хэсэг нь Прокурорын газартай зөвлөлдөн Шүүхэд хандсан гэрчүүд, хохирогчид болон тухайн гэрчүүдийн мэдүүлгийн үр дүнд аюулд учраад байгаа бусад хүнд зориулсан хамгаалалтын арга хэмжээ авах болон аюулгүйн журам тогтоох, зөвлөлтөгөө өгөх болон холбогдох бусад туслалцаагаар хангана. Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд бэлгийн хүчирхийллийн гэмт хэрэгтэй холбогдсон гэмтлийг оролцуулан гэмтэлд хамаарах асуудлаар ажлын туршлага бүхий ажилтнууд орно”, “Хохирогч ба гэрчийн хамгаалалт болон шүүх хуралдаанд тэдгээрийн оролцоо” гэсэн 68 дугаар зүйлийн 68.1 дэх хэсэгт “Шүүх хохирогч болон гэрчүүдийн хувийн амьдралын аюулгүй байдал, бие махбодийн болон сэтгэл санааны сайн сайхан байдал, нэр төр болон хувийн халдашгүй байдлыг хамгаалахын тулд шаардлагатай арга хэмжээ авна. Ингэхдээ Шүүх 2 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт тодорхойлсон нас, хүйсийн хүчин зүйл болон эрүүл мэндийн байдал, түүнчлэн гэмт хэргийн шинж чанар болон зөвхөн үүгээр хязгаарлахгүйгээр гэмт хэрэг нь бэлгийн, хүйсийн буюу хүүхдийн хүчирхийллийг хамарсан нөхцөл байдал зэрэг

⁷⁸ НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 2003.10.31-ний өдрийн 58/4 тогтоолоор батлагдаж, 2005.12.14-ний өдөр хүчин төгөлдөр болсон. Монгол Улс 2005.10.27-ны өдөр нэгдэн орж 2006.01.11-ний өдөр соёрхон баталсан. Төрийн мэдээлэл эмхтгэл, 2005 он, № 43 (424) дахь дугаар, 855-888 дахь тал

⁷⁹ Авилгалын эсрэг НҮБ-ын конвенц. 32 дугаар зүйл. Төрийн мэдээлэл эмхтгэл. 2005.43. 855-888 дахь тал

⁸⁰ 1979.12.18-ны өдөр баталж, 1983.06.03-ны өдөр хүчин төгөлдөр болсон. Монгол Улс 1992.06.09-ний өдөр нэгдэн орж соёрхон баталж мөн өдрөө хүчин төгөлдөр болсон. Төрийн мэдээлэл эмхтгэл, Тусгай дугаар, IV боть, 904-910 дахь тал

⁸¹ 1998.07.18-ны өдөр баталж, 2002.07.01-ний өдөр хүчин төгөлдөр болсон. Монгол Улс 2000.04.05-ны өдөр нэгдэн орж соёрхон баталж 2002.04.11-ны өдрөөс хүчин төгөлдөр болсон.



холбогдох бүх хүчин зүйлийг харгалзан үзнэ. Прокурор тийм арга хэмжээг, ялангуяа эдгээр гэмт хэрэгт мөрдөн байцаалт явуулахдаа авч хэрэгжүүлнэ. Тийм арга хэмжээ нь яллагдагчийн эрхэд хохирол учруулах буюу түүнтэй зөрчилдөх ёсгүй, түүнчлэн шудрага болон нэг талыг бариагүй шүүх хуралдаан явуулахад хохирол учруулахгүй”, 68.2 дахь хэсэгт “67 дугаар зүйлд дурдсан нээлттэй сонсох зарчмыг үл хэрэглэн Шүүхийн танхим хохирогчид болон гэрчүүд буюу яллагдагчийг хамгаалах зорилгоор шүүх хуралдааны аливаа хэсгийг хаалттай (in Camera) явуулах буюу нотлох баримтыг цахилгаан буюу өөр тусгай хэрэгслийн тусламжтайгаар гаргаж тавихыг зөвшөөрч болно. Ялангуяа тийм арга хэмжээг бэлгийн хүчирхийллийн золиос болсон буюу хохирогч буюу гэрч нь хүүхэд байх тохиолдолд хэрэв Шүүх өөрөөр шийдээгүй бол бүх нөхцөл байдал, ялангуяа тухайн хохирогч буюу гэрчийн санаа бодлыг харгалзан авч хэрэгжүүлнэ”, 68.3 дахь хэсэгт “Шүүх зохимжтой гэж үзсэн шүүх хуралдааны шатанд хэрэв тэдгээрийн хувийн ашиг сонирхол нь хөндөгдсөн тохиолдолд хохирогчийн санаа бодол болон болгоомжлолыг гаргаж тавих буюу хянан хэлэлцэхийг зөвшөөрөх бөгөөд энэ нь яллагдагчийн эрх болон шудрага бөгөөд нэг талыг бариагүй шүүх хуралдаан хийхэд хохирол учруулахгүй байх тийм байдлаар хэрэгжинэ. Шүүх зөв гэж үзсэн тохиолдолд тийм санаа бодол болон болгоомжлолыг Дэгийн буюу нотолгооны журмын дагуу хохирогчийн хууль ёсны төлөөлөгч илэрхийлж болно”, 68.4 дэх хэсэгт “Хохирогч болон гэрчүүдэд тусламж үзүүлэх хэсэг 43 дугаар зүйлийн 6 дахь хэсэгт дурдсан хамгаалах, аюулгүй байдлыг хангах, зөвлөлгөө өгөх болон бусад тусламж үзүүлэх холбогдох арга хэмжээг Прокурор болон Шүүхэд зөвлөж болно”, 68.5 дахь хэсэгт “Энэ дүрмийн дагуу нотлох баримт буюу мэдээллийг задруулах нь аливаа гэрч буюу түүний гэр бүлийн гишүүдийн аюулгүй байдалд ночтой заналхийлэл учруулахаар бол Прокурор хэргийг сонсож эхлэхээс өмнө болсон аливаа байцаан шийтгэх ажиллагааг хэрэгжүүлэх зорилгоор тийм нотлох баримт буюу мэдээллийг задруулахгүй байж болох бөгөөд үүний оронд тэдгээрийн хураангуйг танилцуулж болно. Дурдсан арга хэмжээ нь яллагдагчийн эрх болон шудрага болон нэг талыг бариагүй шүүх хуралдаан явуулахад хохирол учруулахгүй бөгөөд үл нийцэх ёсгүй”, 68.6 дахь хэсэгт “Аливаа улс түүний албан хаагчид буюу төлөөлөгчдийг хамгаалах явдлыг хангах, түүнчлэн нууц буюу нарийн мэдээллийг хангахад зайлшгүй шаардлагатай арга хэмжээ авах хүсэлт гаргаж болно” гэж дэлгэрэнгүй заасан байна.

Эдгээр туслалцаа үзүүлэх бие даасан алба, хамгаалалтын хэлбэрүүд нь дийлэнхи улс орнуудын Эрүүгийн хэргийн гэрчийг хамгаалах тухай хуульд тусгалаа олсон байдаг байна.

8. Хүүхдийг худалдах, хүүхдийн биеийг үнэлэх, хүүхдийг садар самуунд сурталчлахын эсрэг хүүхдийн эрхийн тухай конвенцод оруулах нэмэлт протокол⁸²

Конвенцийн 3 дугаар зүйлд нийгмийн хамгааллын улсын, хувийн байгууллага, шүүх, захиргааны болон хууль тогтоох байгууллагаас хүүхдийн талаар явуулах аливаа үйл ажиллагаанд хүүхдийн дээд ашиг сонирхлыг хангах, хүүхдийг хамгаалах, халамжлах зорилгоор зохистой арга хэмжээ авахыг үүрэг болгосон төдийгүй хүүхдийг халамжлах, хамгаалах үүрэг бүхий газар, алба, байгууллагыг тухайн тодорхой салбарт аюулгүй байдал, хүүхдийн амьдрах, эсэн мэнд өсөж, хөгжих бололцоог хангах зорилгоор ажиллагсдын орон тоо, чадавхид хяналт тавих үүднээс эрх бүхий байгууллагаас жишигт нийцсэн нөхцөлөөр хангах шаардлагатай болохыг ч тогтоожээ. Мөн хүүхдийн ашиг сонирхлыг хамгаалах үүднээс хуулийн дагуу гаргасан шүүхийн шийдвэрээс бусад тохиолдолд хүүхдийг хүсэл зоригийнх нь эсрэг эцэг, эхээс нь салгахгүй байх үүрэг хүлээнэ гэж заажээ.

9. Венийн тунхаглал⁸³

Венийн тунхаглалаар олон улсын хамтын нийгэмлэгт дэлхий даяар хүний эрхийн чиглэлээр гараад байсан амжилтыг бэхжүүлэх, хийж байгаа ажлаа эрчимжүүлэх нийтлэг төлөвлөгөөг дэвшүүлсэн юм.

⁸² Төрийн мэдээлэл” эмхтгэл, Тусгай дугаар. I боть, 2004 он, 85-93 дахь тал

⁸³ 1993 оны 6-р сарын 25-ны өдөр Австрийн Вена хотод болсон Хүний эрхийн Дэлхийн Бага Хурлаар Венийн Тунхаглалыг баталсан.



Тунхаглалын оршилд НҮБ-ын Дүрэм, Хүний эрхийн түгээмэл тунхаглалд туссан хүний эрхийн зорилт, хүчин чармайлт, НҮБ-ын Дүрмийн үзэл санааг бататган цаашид олон улсын хэмжээнд анхаарвал зохих хүний эрхийн санаа зовоосон асуудал, хүний эрхийн ноцтой зөрчилд дэлхий нийтийн анхаарлыг хандуулан, хүний эрхийн салбарт хэрэгжүүлэвэл зохих үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийг гаргажээ

Уг тунхаглалд 2002 оныг "... бид улс гүрнүүдэд ... хохирогчид туслалцаа үзүүлэх албыг бэхжүүлэх, хохирогчийн эрхийг танилцуулах ажлыг зохион байгуулах, хохирогчид зориулсан тусгай сан байгуулах, гэрчийг хамгаалах төрийн бодлогыг боловсруулах, хэрэгжүүлэх жил болгон тодорхойлж байна" гэжээ.

НҮБ-ын Конгрессоос 2000 онд баталсан "Гэмт хэрэг ба шүүх эрх мэдэл: XXI зууны хариу" Венийн тунхаглалын 27-д "бид хэрэгцээтэй байгаа үндэсний, бүс нутгийн, олон улсын тэр түвшинд гэмт хэргийн хохирогчийг дэмжих үйл ажиллагааны, тухайлбал зуучлал болон нөхөн олговрын механизмыг бүрдүүлэх төлөвлөгөөг боловсруулан гаргах шийдвэрийг гаргалаа. Бид 2002 оныг улс гүрнүүдэд өөрийн практикийг дүгнэн үзэх, хохирогчдод туслалцаа үзүүлэх албыг бэхжүүлэх, хохирогчдын эрхтэй танилцуулах компани ажлыг зохион байгуулах, мөн түүнчлэн хохирогчдод зориулсан тусгай сан байгуулах, гэрчийг хамгаалах төрийн бодлогыг боловсруулах, хэрэгжүүлэх жил болгон тодорхойлж байна" гэжээ.

10. Хууль хэрэгжүүлэгч албан тушаалтны зан үйлийн кодекс⁸⁴, Хууль хэрэгжүүлэгч албан тушаалтны зан үйлийн кодексыг үр нөлөөтэй хэрэгжүүлэхэд баримтлах удирдлага болгох зарчим⁸⁵, Шүүхийн байгууллагын бие даасан байдлын үндсэн зарчим⁸⁶, Хуульчийн үүрэг Гүйцэтгэхтэй холбоотой үндсэн зарчим⁸⁷ гэсэн олон улсын баримт бичгүүдэд хууль сахиулах байгууллагын албан тушаалтны зүгээс хүний эрх, эрх чөлөө, нэр хүндийг хүндэтгэн дээдлэх, хамгаалах, зохистой харилцааны наад захын жишгийг тогтоож өгсөн байдаг.

11. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ба эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны салбар дахь НҮБ-ын хөтөлбөр⁸⁸-өөр НҮБ-ын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, гэмт этгээдтэй харьцах талаарх Конгресс болон НҮБ-ын бусад институтын үйл ажиллагааг зангидаж өгсөн ба гэмт хэргийн хохирогчийн эрхийг хамгаалах шаардлагыг дахин тэмдэглэсэн байна.

12. Неапольд 1994 онд "Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэг⁸⁹-ийн асуудлаар зохион байгуулсан олон улсын бага хурлаас гэрч, хохирогчийг хамгаалах "стратегий" арга хэмжээг авах шаардлагыг хүлээн зөвшөөрч эдгээр арга хэмжээ нь гэмт хэрэгтэй тэмцэхэд чухал үүрэг гүйцэтгэх бөгөөд улс орнуудын энэ талаарх бодлогын салшгүй хэсэг болох ёстойг, мөн гэрч, хохирогчийг хамгаалах тусгай хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлэхийг тэмдэглэсэн байна (17, 42 дахь заалт). Энэ хурлын баримт бичиг нь зөвлөмж хэлбэрээр НҮБ-ын Ерөнхий ассамблейн 49/159 дугаартай тогтоолоор батлагдсан.

13. 2010 оны 4 дүгээр сарын 12-19-ний өдрүүдэд Салвадор, Бразилд зохион байгуулагдсан "Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ба эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны талаарх" НҮБ-ын XXII Конгрессоос гаргасан тунхаглалын 5-д "хохирогчийг хамгаалах, тэдгээрт туслалцаа үзүүлэх, дахин хохирогч болохоос хамгаалах үндэсний хууль тогтоомжийг батлан гаргахын чухал"-ыг тэмдэглэж, хохирогч хүүхэд, эмэгтэйчүүдийн асуудлыг, мөн зохион байгуулалттай гэмт хэрэг, наймаа, терроризмын гэмт хэргийн хохирогчийн асуулалд анхаарахыг уриалсан

⁸⁴ 1979.12.17-ны өдрийн НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 34/169 дугаар тогтоолоор баталсан.

⁸⁵ 1979.12.17-ны өдрийн НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 34/169 дугаар тогтоолоор баталсан.

⁸⁶ НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 1985 оны 40/32 дугаартай тогтоолоор баталсан.

⁸⁷ НҮБ-ын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ба гэмт хэрэгтэнтэй харьцах асуудлаарх Конгрессын VIII чуулганаар баталсан.

⁸⁸ НҮБ-ын Ерөнхий ассамблей 1991 оны 46/152 дугаартай тогтоолоор баталсан.

⁸⁹ Неапольд 1994 онд зохион байгуулсан олон улсын бага хурал. Энэ хурлын баримт бичиг нь зөвлөмж хэлбэрээр НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 49/159 дугаартай тогтоолоор батлагдсан.



байна.

- Гэмт явдлыг урьдчилан сэргийлэх ба эрх зүй зөрчигчидтэй харилцах талаарх НҮБ-ын VII конгресс дээр олон улсын эдийн засгийн шинэ харилцаа, түүний хөгжлийн чиглэлээр гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ба эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны тулгуур зарчмуудыг баталсан юм. Тухайн баримт бичгийн үндэслэлд зааснаар НҮБ-ын гишүүн улс орнуудын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажиллагааг сайжруулах зорилгоор “гэмт хэргийн хохирогчдыг эрх зүйн хамгаалалтын үр нөлөөтэй арга хэрэгслээр хангахын тулд хууль зүйн болон бусад шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг” зөвлөмж болгосон билээ⁹⁰.

Барууны улс орнуудын виктимологийн хууль тогтоомжийн хөгжил нь гэмт хэргийн хохирогчтой харьцах ажлын зохион байгуулалт, гэмт хэргийн хохирогчийн эрхийг эрүүгийн хууль тогтоомжийн тогтолцооны хүрээнд хэрэгжүүлэх зарчмууд, нийтлэг үндэслэлүүдийг төлөвшүүлэх, бүрдүүлэх замаар явж байна.

14. “Эрүүгийн эрх зүй ба эрүүгийн процессын хүрээн дэх хохирогчийн харьцангуй байдлын тухай” Европын холбооны сайд нарын зөвлөлөөс баталсан Зөвлөмж

Гэмт хэргийн хохирогчийн эрхийн асуудлуудын хүрээнд 1985 оны “Эрүүгийн эрх зүй ба эрүүгийн процессын хүрээн дэх хохирогчийн харьцангуй байдлын тухай” Европын холбооны сайд нарын зөвлөлөөс баталсан Зөвлөмж илүү чухал ач холбогдолтой юм. Тухайн баримт бичгийн үндсэн үзэл баримтлал нь гэмт хэргийн хохирогчийг хууль цаазад итгэх итгэлийг бэхжүүлэх, тэднийг хуулийн байгууллагуудтай хамтран ажиллахад хандуулах зэргийг хангахад чиглэгджээ. Эрүүгийн хууль цаазын уламжлалт тогтолцооны зорилго нь төр ба эрх зүй зөрчигчийн хоорондын харилцааны хэм хэмжээг илүүтэй томъёолдог учраас хохирогчийн асуудлууд зөвхөн хүндрүүлэх талаас нь хандаж, үйлчилж байгааг тэмдэглэсэн байна. Үүнтэй холбогдуулан хохирогчид учирсан бие махбодийн, сэтгэл санааны, эд хөрөнгийн ба нийгмийн хохиролд илүү анхаарал хандуулах, эрүүгийн процессын бүхий л үе шатад тэдгээрийн хэрэгцээг хангах чиглэл зорилготой арга хэмжээг авч үзэх шаардлагын тухай санал дэвшүүлжээ. Тухайн арга хэмжээнүүд нь эрүүгийн эрх зүйн ба шүүн таслах ажиллагааны зорилгыг биелүүлэх, эцэст нь эрх зүй зөрчигч, хохирогчийн хоорондын эвлэрэлд үйлчлэх ёстой гэж үзсэн байна⁹¹.

Уг баримт бичиг нь улс орнуудын засгийн газарт үндэснийхээ хууль тогтоомж, албан тушаалаа урвуулан ашигласны болон гэмт хэргийн хохирогчтой харилцах практикаа эргэн харахыг зөвлөмж болгосон удирдамжийн шинжтэй зарчмуудыг боловсруулах үндэс болж байна⁹². Үүнд:

- Хохирогчтой энэрэнгүй халамжтай, идэвх санаачилгатай, тус дэмжлэг үзүүлэн харилцах чиглэлээр цагдаагийн мэргэшлийн түвшинг дээшлүүлэх;
- Хохирогч, хуулийн байгууллагын хамтын ажиллагаа, сэтгэл зүйн болон эрх зүйн туслалцаа авах, эрх зүй зөрчигч болон төрийн зүгээс нөхөн төлбөр авах боломжийн тухай, мөн цагдаагийн мөрдөн мөшгих үр дүнгийн тухай цагдаагийн ажилтнуудаас хохирогчид мэдээлэл өгөх;
- Хохирогчийг байцаахдаа түүний хувийн байдал, эрх, хууль ёсны ашиг сонирхол, хэрэгцээ, нэр төрийг хүндэтгэн харьцах;
- Зөвхөн хохирогчийн нөхөн төлбөрийн асуудлыг шийдвэрлэсний дараа эрх зүй зөрчигчийг эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх боломжийн тухай;
- Хохирогчид шүүн таслах ажиллагаа явагдах байр, хугацаа, эрүүгийн процессын явцад хохирол арилгуулах ба нөхөн төлбөр авах боломжийн тухай, хэргийг шийдвэрлэсэн үр дүнгийн тухай мэдэж болох эрх зүйн тусламж, арга хэрэгслийн тухай шүүхээс мэдээлэл өгөх;

⁹⁰ Руководящие принципы в области предупреждения преступности и уголовного правосудия в контексте развития и нового международного экономического порядка // Международные соглашения и рекомендации Организации Объединенных Наций в области защиты прав человека и борьбы с преступностью: Сб. междунар. документов. - М.: Академия МВД СССР, 1989. - С. 154.

⁹¹ Ч.Нямсүрэн “Гэмт хэргийн виктимологи”. УБ. 2006 он. 200 дахь тал

⁹² Ч.Нямсүрэн “Гэмт хэргийн виктимологи”. УБ. 2006 он. 210 дахь тал



- Үндэсний хууль тогтоомжид нөхөн төлбөрийг эрүүгийн санкц, эсхүл түүнийг орлох арга хэмжээний төрлөөр буюу эрүүгийн санкцад нэмэлт байдлаар ногдох хэлбэрээр тогтоох үндэслэлийг бэхжүүлэх;
- Хохирогчийн хувийн амьдралыг хөндсөн буюу нэр төрийг гутааж болох мэдээлэл баримт задрахаас хохирогчийг хамгаалах түвшинг дээшлүүлэх (хувийн мэдээллийг задруулахгүй байх, шүүхийн хуралдааныг хаалттай хийх гэх зэрэг);
- Гэмт этгээдийн зүгээс айлган сүрдүүлэх, өшөө авах боломжоос (зохион байгуулалттай гэмт хэргээс гэх зэрэг) хохирогчийн идэвхтэй хамгаалалтыг хангах зэрэг багтаж байгаа юм⁹³.

Дүгнэлт

Нэг. Дээрх олон улсын баримт бичигт заасан стандарт хэм хэмжээг нэгтгэн үзвэл гэрч, хохирогчийг хамгаалах, туслалцаа үзүүлэх талаар олон улсад дараах жишгийг тогтоосон байна. Үүнд:

- Гэрч, хохирогчийг хамгаалах төрийн бодлогыг боловсруулах;
- Гэрч, хохирогчийг хамгаалах үндсэн зарчмыг боловсруулах;
- Холбогдох хууль тогтоомж гаргах;
- Шүүх ажиллагааг шуурхай, шударга явуулах чадамжтай байхаас гадна оролцогчдын аюулгүй байдлыг хангах болон эрх, эрх чөлөөг нь хамгаалах чадамжтай шүүхийг бүрдүүлэх;
- Хохирогчтой харьцах шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэгч болон оролцогч байгууллагын ажилтны чадварыг сайжруулах, сургалт явуулах;
- Хууль сахиулах байгууллагын албан тушаалтны зүгээс гэрч, хохирогчтой харьцах дүрэм боловсруулж мөрдүүлэх;
- Хохирогчдод туслалцаа үзүүлэх албыг бэхжүүлэх;
- Гэрч, хохирогчид туслалцаа үзүүлэх хангалттай хөрөнгийг зарцуулдаг механизмыг бий болгох;
- Зуучлал болон нөхөн олговрын механизмыг бүрдүүлэх, тусгай зориулалтын сан байгуулах, бэхжүүлэх;
- Тодорхой гэмт хэргийн төрлөөс шалтгаалан гэрч, хохирогчийн аюулгүй байдлыг хангах. Тухайлбал, зохион байгуулалттай гэмт хэрэг, хүний наймаа, терроризмын гэмт хэргийн хохирогчийн асуудал;
- Хохирогч хүүхэд, эмэгтэйчүүдийн асуудлыг онцгой анхаарах;
- Гэмт хэрэгтэй холбоотой аливаа ЭХХША, бусад ажиллагааны явцад болон дараа нь гүтгэлэг, айлган сүрдүүлэх байдлаас хохирогчийг хамгаалах арга хэмжээг боловсруулах;
- Гэрч, хохирогчийн аюулгүй байдлын үүднээс шүүх хуралдааныг хаалттай явуулах боломж бүрдүүлэх;
- Шууд видео дүрсээр, эсхүл видео хальсанд бичсэн гэрчийн мэдүүлгийг ашиглах;
- Гэрч, хохирогчийн оршин суух газрыг өөрчлөх замаар аюулгүй байдлыг хангах;
- Гэмт хэргийн хохирогчдод хууль ёсны болон захиргааны хамгаалалтын механизмын хүртээмжтэй байдлыг хангах;
- Шаардлагатай мэдээллээр хангагдах эрхээр хангах. Тухайлбал, хохирогчийн авч болох эрх зүйн болон бусад туслалцаа, хохирлыг барагдуулах боломж (төрөөс болон гэм буруутай этгээдээс гаргуулах)-ийн талаарх мэдээлэл; /Хохирогч этгээд шүүх хурал хэзээ, хаана, яаж явагдах, хохирлыг барагдуулах, нөхөн олговор гаргуулах боломж, байцаан шийтгэх ажиллагааны үр дүнг мэдэх эрх зүйн туслалцаа болон бусад аргын талаар шүүхээс мэдээлдэг байх;
- Нөхөн олговор, нийгмийн халамжид хамруулах;
- Хохирогчоос мэдүүлэг авахдаа түүний хувийн байдал, нэр хүнд, эрхийг хүндэтгэдэг байх;
- Хохирогчийн хохирлыг барагдуулах асуудлыг шийдвэрлэсний дараа гэмт

⁹³ Ч.Нямсүрэн “Гэмт хэргийн виктимологи”. УБ. 2006 он. 215 дахь тал



этгээдийг эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх эсэхийг шийдвэрлэдэг байх;

- Хохирогчийн хувийн амьдрал, нэр хүнд хөндөгдөх аливаа баримт, мэдээллийг тараахаас хамгаалагдсан байх;

- Гэмт этгээдийн зүгээс хохирогчийг айлган сүрдүүлэх, өс хонзон авах зэргээс дээд хэмжээгээр хамгаалсан байх эдгээр болно.

Хоёр. Монгол Улс эрүүгийн эрх зүйн тогтолцоогоо өөрөө тодорхойлж, төлөвшүүлэх бүрэн эрхтэй ч хүний эрхийг дээдэлсэн ардчилсан зарчмыг нэгэнтээ сонгосон нь эдгээр олон улсын стандартад үндэсний хууль тогтоомжийг нийцүүлэх нь нэг талаасаа зүй ёсны нөгөө талаасаа зайлшгүй шаардлага юм.⁹⁴ Иймд манай улс нэгдэн орсон гэрч, хохирогчийг хамгаалах тухай олон улсын гэрээ, конвенцид заасны дагуу үндэсний хууль тогтоомжоороо гэрч, хохирогчийг хамгаалах арга хэмжээ авах үүрэг хүлээдэг.

Монгол Улсын Үндсэн хуулийн 10 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэг адил үйлчилнэ гэж заасан тул Үндсэн хуульд томъёологдоогүй боловч Монгол Улсын олон улсын гэрээнд тодорхойлсон хүний эрх, эрх чөлөөг /хэрэв Үндсэн хуульд зааснаар хязгаарлаагүй бол/ манай оронд байгаа бүх хүн нэгэн адил эдлэх боломжтой.

Монгол Улсын Үндсэн хуулийн Аравдугаар зүйлд заасны дагуу Монгол Улс олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ, зарчмыг баримталж энхийг эрхэмлэсэн гадаад бодлого явуулах бөгөөд Монгол Улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлэх ёстой. Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилдэг зарчимтай юм.

Гэрч, хохирогчийг хамгаалах олон улсын эрх зүйн зохицуулалтын асуудалд чиглэсэн суурь зарчмуудыг тунхаглан баталгаажуулсан олон улсын гэрээ, хэлэлцээр, конвенцүүдэд Монгол Улс нэгдэн орсон бөгөөд өнөөдрийг хүртэл олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ сахин биелүүлж байна. Гэсэн хэдий ч олон улсын гэрээний заалтуудыг үндэсний хууль тогтоомжид тусгах болон олон улсын гэрээг үндэсний хууль тогтоомжийн нэгэн адил мөрдөх асуудал тулгамдсан хэвээр байна.

⁹⁴ Гэрч, хохирогчийг хамгаалах үндэсний тогтолцоог бий болгох асуудал” судалгааны тайлан. УБ., 2010 он.



ЦАГДААГИЙН ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН ТУЛГАМДСАН АСУУДАЛ

ГАДААДЫН ЗАРИМ УЛСЫН ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГААС ОБЪЕКТЫН СУДАЛГАА ХИЙЖ БАЙДАЛ, ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА

Г.Бямбадорж

*Дотоод хэргийн их сургуулийн Цагдаагийн сургуулийн
ЦЭЗТ-ийн ахлах багш, докторант, цагдаагийн хошууч*

Цагдаагийн байгууллагаас гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиг үүргээ хэрэгжүүлэхдээ хариуцсан нутаг дэвсгэртээ объектын судалгаа хийж, түүнийг баяжуулах, боловсронгуй болгох, гэмт хэрэгтэй тэмцэхэд хэрхэн ашиглах арга, тушлага, эрх зүйн зохицуулалтыг гадаадын зарим орнуудын цагдаагийн байгууллага хэрхэн хэрэгжүүлж байгааг судлах нь онол, практикийн төдийгүй гадаадын зарим орны хууль тогтоомжийн онцлог ижил ба ялгаатай тал, онцлог зрэгийг танин мэдэхүйн ач холбогдолтой.

Энэ үүднээс бид судалгааны хүрээнд Оросын Холбооны Улс, Япон, Бүгд Найрамдах Солонгос Улс, Канад, АНУ-ын Калифорина мужуудын Цагдаагийн албаны тухай хууль болон Хууль сахиулах үйл ажиллганы тухай тогтоомж, дүрэм, журмыг харьцуулан судаллаа.

Оросын Холбооны Улс

ОХУ-ын Цагдаагийн хуулийн 2011 оны 2-р сарын 7-ны өдөр батлагдаж 2011 оны 3-р сарын 1-ний өдрөөс хүчин төгөлдөр болсон.

Цагдаагийн байгууллага нь цагдаагийн байгууллагад хүлээлгэсэн үүргээ биелүүлэхээр байгуулагдсан харъяа алба, нэгж, нутаг дэвсгэрийн нэгж байгууллагаас бүрдэнэ. Гэж заасан нь засаг захиргааны нэгдмэл төвлөрсөн удирдлагатай болох нь харагдаж байна.

Мөн Энхзүү хуулийн 11-р зүйлд: Гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиг үүрэгээ хэрэгжүүлэхдээ шинжлэх ухааны ололт амжилт, орчин үеийн техник технологи, мэдээллийн автоматжуулсан систем, нэгдсэн мэдээллийн сан үүсгэж ашиглана⁹⁵. хэмээн тусгасан нь хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэхдээ сэжигтэй хүн объектыг судлах шинжлэх ухааны ололт амжилт, орчин үеийн техник технологи, мэдээллийн автоматжуулсан систем ашиглах зарчмыг тусгасан нь цагдаагийн байгууллага алба хаагчаас хариуцсан нутаг дэвсгэрийнхээ хүн объектыг судлаж объект субъектын судалгаа явуулах эрх зүйн үндсийг хуульчилсан нь олзуурхуштай.

Мөн хуулийн 17-р зүйлд Цагдаагийн байгууллага дараах тоо бүртгэл хөтөлж, мэдээллийн сүлжээ, сан үүсгэн үйл ажиллагаандаа ашиглана хэмээн заажээ. Үүнд:

- 1) сэжигтэй буюу гэмт хэрэг үйлдсэн этгээдүүд;
- 2) ял шийтгэгдсэн хүмүүс;
- 3) шүүх эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ авагдсан этгээдүүд;
- 4) өршөөлөөр суллагдсан этгээдүүд;
- 5) эрүүгийн хариуцлагаас чөлөөлөгдсөн хорих ял хойгшилсон, хүүхдийн зан төлөвт сөргөөр нөлөөлж болзошгүй уруу татдаг этгээдүүдийн талаар;
- 6) хорихоос өөр төрлийн ялаар шийтгэгдсэн, хорихоос суллагдсан этгээдүүд;
- 7) гэмт хэрэг үйлдсэн этгээд;
- 8) захиргааны зөрчил үйлдсэн этгээдүүд;
- 9) эрэн сурвалжлагдаж байгаа хүмүүсийн талаар;
- 10) сураггүй алга болсон хүмүүсийн талаар;
- 11) хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаар;
- 12) тээврийн хэрэгсэл эзэмшигчийн;

⁹⁵ ОХУ-ын Цагдаагийн албаны тухай хууль



- 13) жолооны үнэмлэх авсан хүмүүсийн талаар;
- 14) гэрчилгээ, хувийн аюулгүй байдлын хамгаалалт авсан этгээд;
- 15) хувийн мөрдөгч (мөрдөгч) үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан этгээд;
- 16) захиргааны хяналтанд байгаа хүмүүсийн талаар;
- 17) о лицах, в отношении которых заведены дела оперативного учета;
- 18) о лицах, прошедших государственную дактилоскопическую регистрацию;
- 19) галт зэвсэгтэй этгээдүүдийн талаар;
- 20) хамгаалалтанд байдаг хүмүүсийн талаар;
- 21) захиргааны албадан гаргах тухай шийдвэрт тусгагдсан гадаадын иргэн, харьяалалгүй хүмүүсийн талаар;
- 22) ОХУ-ын нутаг дэвсгэрт оршин сууж байгаа болон оршин суух бүртгэлтэй хүмүүсийн талаар;
- 23) ОХУ-ын нутаг дэвсгэрээс гаргаж болохгүй насанд хүрээгүй иргэдийн талаар;
- 24) ОХУ-ын нутаг дэвсгэрээс гадна ОХУ-ын иргэдэд хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчдын талаар;
- 25) Гадаад улсад дүрвэсэн иргэн, эсхүл ийм статусын хүчинтэй байх хугацааг сунгасан хүмүүсийн талаар;
- 26) ОХУ-д гадаадад амьдарч байгаа эх орондоо сайн дураараа нүүлгэн шилжүүлэхэд дэмжлэг үзүүлэх хөтөлбөрт хамрагдсан хүмүүсийн талаар;
- 27) ОХУ-ын гадаадын иргэн, харьяалалгүй хүмүүсийн Холбооны Улсад нэвтрэх урилга өргөдөл гаргаж байгаа хүмүүст, мөн ийм урилгыг хүлээн авсан хүмүүсийн талаар;
- 28) мансууруулах бодис, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт эмийг эмчийн жоргүйгээр хэрэглэсэн, эсхүл сэтгэцэд нөлөөлөх бодисыг хэрэглэдэг, захиргааны шийтгэл хүлээлгэсэн этгээдүүд, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт эмийг эмчийн жоргүйгээр хэрэглэдэг хүмүүсийн талаар;

Тус тус бүртгэл судалгаа явуулах, мэдээллийн сан үүсгэж ашиглах талаар тусгасан бөгөөд уг зүйлд иргэний бүртгэл мэдээлэлтэй холбоотой тухайбал: Гадаад улсад оршин ОХУ-сад сууж байгаа иргэн, иргэншилээс гаргах, цагчаалах, ОХУ-д ажиллах эрх олгох тухай баримт хүлээн авсан эсвэл түүний хугацааг сунгасан гадаадын иргэн, харьяалалгүй хүмүүсийн талаар бүртгэл хөтлөж, сан үүсгэж ажилах талаар дэлгэрэнгүй заажээ.

Үүнээс гадна ОХУ-ын Дотоод хэргийн яамны сайдын 2012.12.31-ны өдрийн №1166 тушаалаар батлагдсан “Цагдаагийн хэсгийн төлөөлөгчийн үйл ажиллагааг зохион байгуулах ажлын заавар” юм. Энэхүү зааварын зорилго нь цагдаагийн хэсгийн төлөөлөгчийн үйл ажиллагааны зохион байгуулалт ба үндсэн чиглэлийг тодорхойлж, ОХУын нутаг дэвсгэрт иргэдийн амь нас, эрүүл мэнд эрх, эрх чөлөөг хамгаалах, гэмт явдалтай тэмцэх, нийтийн хэв журам, өмч хөрөнгийг хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үүрэг гүйцэтгэх зохион байгуулалтыг сайжруулах, объектын бүртгэл судалгаа явуулах, түүнийг гэмт хэрэгтэй тэмцэхэд ашиглах талаар үйл ажиллагааг нь журамлан тогтоожээ.

Мөн зааварт 36-р зүйлд Цагдаагийн хэсгийн төлөөлөгчийг ОХУ-ын ДЯЯ-ны нутаг дэвсгэрийн байгууллагын даргын тушаалаар албан тушаалд томилж, чөлөөлөх бөгөөд хариуцсан нутаг дэвсгэрийн хүн амын тоо, нягтаршил, арилжааны бус зориулалтаар ашигладаг цэцэрлэг, ногооны талбай, зуслан зэрэг улирлын чанартай ашигладаг нутаг дэвсгэр түүний хэмжээ, мөн түүнчлэн иргэд олноороо амарч, зугаалдаг газар гэх мэт нутаг дэвсгэрийн онцлог, засаг захиргааны нэгжид хуваасан байдал зэргийг харгалзан хэсгийн төлөөлөгчийг томилох бөгөөд алслагдсан, хүрч очиход бэрхшээлтэй газруудад цагдаагийн хэсгийн ахлах төлөөлөгч-1, хэсгийн төлөөлөгч-1, туслах ажилтан 1 нийт 3 алба хаагч ажиллахаар заасан бүртгэл, судалгаа явуулах ажлын ачаалалыг тэнцвэржүүлэх, бүртгэл судалгааг илүү бодиттой үр дүнтэй болгоход эерэг нөлөө үзүүлнэ.

ОХУ-ын “Цагдаагийн хэсгийн төлөөлөгчийн үйл ажиллагааг зохион байгуулах ажлын заавар”-ын 36-р зүйлд зааснаар Цагдаагийн хэсгийн байцаагч, төлөөлөгчийн объект субъектын бүртгэл, судалгаа явуулах талаар дараах заалтуудыг тусгажээ.

36-р зүйлийн 3 дахь хэсэгт: “Засаг захиргааны нэгжид нийтийн хэв журмыг хамгаалахад оролцсон ОХУ-ын ДЯЯ-ны нутаг дэвсгэрийн харьяалал байгууллага, туслах хүч хэрэгсэл, хувийн (төрйн бус) хамгаалалтын үйл ажиллагаа явуулдаг байгууллагын



ажилтнууд, хууль сахиулах чиглэлийн ажиллагаа явуулдаг олон нийтийн байгууллага тэдгээрийн төлөөлөгчдийн талаар...

36-р зүйлийн 4 дэхь хэсэгт: Засаг захиргааны хэсгийг харъяаллын газар нутаг, түүний онцлог, замын бүтэц өмчийн хэлбэрээс үл хамааран байгууллага үйлдвэр үйлчилгээний газруудын байрлал ба ажиллах цагийн хуваарь соёлын үнэт зүйлс хадгалагддаг объектууд иргэд нийтэр хамрагддаг агуулах савны байршил, бусад материаллаг үнэт зүйлс ба мөнгөн хэрэгсэл хадгалагддаг газрууд авто тээврийн хэрэгслийн зогсоолын байршил ба тэдгээрийн хамгаалалтын талаар;

36-р зүйлийн 5 дахь хэсэгт: Галт зэвсэг ба тэсэрч дэлбэрэх бодис эмийн сангийн байршил мансууруулах эм сэтгэгцэд нөлөөт бодис ба түүнтэй адилтгах эм бэлдмэлүүдийн хадгалагддаг эргэлддэг бусад газрууд, ОХУ-ын хууль тогтоомжийн дагуу хязгаарласан эд зүйл (бодис)-ийн буюу иргэдээс хураан авсан эд зүйл бодисын хадгалж буй бусад объектуудын тухай;

37-р зүйлийн 13 дахь хэсэгт: Эрх мэдлийнхээ хүрээнд тухайн засаг захиргааны хэсэгт гэмт хэрэг үйлдсэн буюу эсвэл сэжиглэгдэж буй этгээдүүд, гэмт хэрэг үйлдсэнд яллагдсан, хэрэг бүртгэх мөрдөн шалгах, шүүх байгууллагаас оргон зугтсан, сэтгэцийн өвчтэй холбоотойгоор шүүхээс оногдуулсан албан эмчилгээнээс зайлсхийсэн, шүүхээс оногдуулсан эмчилгээний ба хүмүүжлийн нөлөөллийн албадан арга хэмжээнээс зайлсхийсэн этгээдүүдийг эрэн сурвалжлах, түүнчлэн хулгайлагдсан эд зүйлсийг эрэн сурвалжлах, хэн болох нь тогтоогдоогүй цогцосыг таних ажиллагаа явуулах, тэдний талаар бүртгэл судалгаа хийх;

37-р зүйлийн 16 дахь хэсэгт: Хорих газраас суллагдсан этгээдүүдэд захиргааны хяналт тавих тухай 2011 оны 04 сарын 06 өдрийн №64-ФЗ Холбооны хууль, 38 хориглосон зүйл ба хязгаарлалтын дагуу шүүхээс тогтоосноор хорих газраас суллагдсан этгээдүүдэд хяналт тавих ажлыг эрх мэдлийнхээ хүрээнд хэрэгжүүлэх;

37-р зүйлийн 20 дахь хэсэгт: Биеэ үнэлэх, мансууруулах эм сэтгэгцэд нөлөөт бодис хууль бусаар хэрэглэхэд зориулагдсан байр сууцыг илрүүлэх, зохион байгуулагч ба эздийг нь тогтоох. Энэ үйл ажиллагааг таслан зогсоох арга хэмжээ авах, ялангуяа цагдаагийн харьяа хэлтэст энэхүү байр сууцанд явагдаж буй үйл ажиллагааг судлах;

46-р зүйл. Эмчийн зөвшөөрөлгүйгээр мансууруулах эм ба сэтгэгцэд нөлөөлөх бодис Зааварын 90-р зүйлд: Цагдаагийн хэсгийн төлөөлөгч албан үүргээ гүйцэтгэхдээ ОХУ-ын Цагдаагийн хуулийн 17-р зүйлд заасан бүртгэл судалгаа явуулж, хяналт тавьж ажиллана. Хэсгийн төлөөлөгч нь иргэдийн санал хүсэлтийн дэвтэрээс гадна, албан хөтлөлтийн дэвтэртэй байх ба ОХУ-ын ДЯЯ-ны эрх зүйн хэм хэмжээний актын тогтоогдсон журмын дагуу объект субъектын автомат систем ашиглана, хэсгийн цагдаагийн байранд төмөр сейфэнд албаны баримт бичгийг хадгална. Албаны нууц хадгалалт хамгаалалтыг тухайн алба хаагч хариуцана.

Канад Улс

Канадын цагдаагийн албаны тухай хуулийн 6.1-д хэсгийн байцаагч гэсэн нэр томъёог хуульчлаагүй бөгөөд манайхтай төстэй үйл ажиллагаа явуулдаг алба хаагчийг байцаагч, хэсгийн дарга гэсэн нэр томъёогоор тусгажээ. Тухайлбал: Канад улсын цагдаагийн албан тухай хуулийн 6.1-р зүйл “цагдаагийн офицерын алба хаагчид” гэсэн зүйлд дор дурьдснаар тусгажээ. Үүнд:

6. (1) Комиссараас гадна цагдаагийн офицерын бүрэлдэхүүнд дараах алба хаагчид багтана. Үүнд:

- (a) Орлогч Комиссар
- (b) Туслах Комиссар
- (c) Ахлах хэсгийн дарга
- (d) Хэсгийн дарга
- (e) Байцаагч

Дээрх хуулийн заалтад дурьдсан байцаагч, ахлах хэсгийн дарга нь Монгол Улсын цагдаагийн хэсгийн байцаагчтай ижил төстэй үүрэг гүйцэтгэдэг бөгөөд эдгээр алба хаагчид нь тайван байдлыг сахиулах буюу цагдаагийн хэв журмын албанд харьяалагдан үүрэг гүйцэтгэдэг бөгөөд тайван байдлыг сахиулах цагдаагийн алба хаагчийн үүргийг тус хуулийн 18-р зүйлд заажээ. Үүнд:



(а) Канад улсын холбооны болон мужийн хууль тогтоомжийг зөрчсөн, гэмт хэрэг үйлдсэн, нийгмийн хэв журмыг зөрчсөн үйлдлийг таслан зогсоож гэмт этгээдийг хуулийн дагуу саатуулах;

(b) Канад улсын холбооны болон мужийн хууль тогтоомж, энэ хуулийн дагуу тайван байдлыг сахиулах цагдаагийн алба хаагчийн гүйцэтгэж болох бүхий л шүүхийн шийдвэр, үүрэгт ажлыг биелүүлнэ;

(c) Тайван байдлыг сахиулах цагдаагийн алба хаагчийн гүйцэтгэж болох гэмт хэрэгтэн шилжүүлэх үйл ажиллагаанд оролцоно;

(d) Тайван байдлыг сахиулахад ашиглах санг бүрдүүлэх;

(e) Засгийн газар, Комиссарын тушаалын дагуу бусад үүргийг биелүүлнэ хэмээн заасан нь тайван байдлыг хамгаалах цагдаагийн гүйцэтгэх үүрэг, судалгаа хийх, сан бүрдүүлэх ажлын эрх зүйн үндсийг тогтоожээ.⁹⁶

Канадын Цагдаагийн хуулийн 68-зүйлд Мэдээллийн системийг ашиглах шаардлага хэмээх зүйлд цахим сан ашиглах талаар тусгажээ. Уг зүйлийн 1 дэхь хэсэгт зааснаар “Мэдээллийн менежментийн систем” гэж программ хангамж, техник хангамжийн бүрэлдэхүүн хэсэг, түүнтэй холбогдох технологийн системийг хэлнэ” гэж цахим санг тодорхойлжээ.

Мөн зүйлийн дор дурьдсан хэсгүүдэд мэдээллийн сангийн талаар дараах зохицуулалтыг тусгажээ. Үүнд:

(a) Цагдаа, хууль сахиулах байгууллагын хооронд мэдээлэл, өгөгдлийг хүлээн авах, үүсгэх, цуглуулах, бүртгэх, дүн шинжилгээ хийх, тайлагнах, дамжуулах, хадгалах, илгээх, хувилж ашиглаж болно.

(b) Энэхүү хэсгийг хэрэгжүүлэх зорилгоор сайдын тушаалаар хууль сахиулах алба, цагдаагийн нэгж хамтран ажиллана.

(c) Цагдаагийн асуудал хариуцсан сайд дээр дурьдсан нэг буюу хэд хэдэн мэдээллийн менежментийн системийг ашиглах талаар баталж болно.

(d) Хууль сахиулах алба нь батлагдсан мэдээллийн удирдлагын системийг бүрдүүлэх, хэрэгжүүлэх, ашиглах, засварлах, шинэчлэх ажлыг хэрэгжүүлнэ.⁹⁷

Мөн хуулийн 100-р зүйлд заасан Эрэн сурвалжлах ажил явуулах гэсэн зүйлийн 1 дэхь хэсэгт “Мөрдөн шалгах зорилгоор зорилгоор мөрдөн байцаагч ямар ч тохиолдолд зөвшөөрөлгүйгээр тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, бусад зүйлийн талаарх мэдээллийн санг ашиглана. Мөн зүйлийн 1.(b) хэсэгт дурдсан “аливаа сэжигтэй байр байгууламжийг бүртгэх, бичлэг хийх гэх мэт хуульд заасан бүх эрх мэдлийг хэрэгжүүлнэ”, 100-р зүйлийн 100.2 дахь хэсэгт Мөрдөн байцаагч мөрдөн байцаалтын зорилгоор дараах нэг буюу хэд хэдэн зүйлийг хийж болно. Үүнд:

(f) бүртгэлийн тэмдэглэл хөтлөх, бүртгэгдсэн мэдээллийг шалгах, хуулах;

(g) мөрдөн байцаагч мөрдөн байцаалтад хамааралтай гэж үзэх үндэслэлтэй бол аливаа өгөгдөл мэдээллийг хадгалах, боловсруулах, хадгалах төхөөрөмж системээс дурын бичлэг, өгөгдөл, мэдээлэлийг ашиглах⁹⁸. Гэж заасан нь Канад Улсын цагдаагийн хуулийн онцлог болжээ. Учир нь мөрдөн шалгах ажиллагааг хэрэгжүүлэгч мөрдөгч сэжигтэй байр байгууламж, хүний талаарх мэдээллийг бүртгэх, цахим сан бүрдүүлэх, халгалах, хуулах, ашиглах эрхтэй гэсэн нь мэдээллийн санг бүрдүүлэх субъектыг хязгаарлаагүйгээр зогсохгүй объект субьектын судалгааг дэлгэрүүлэх, баяжуулах, түүнийг хэрэглээг өрөгжүүлэх эерэг заалт болжээ.

Япон улс

Япон Улсын Үндэсний Цагдаагийн хууль 2007 оны 3-р сарын 31-ний өдөр батлагдсан бөгөөд уг хуулийн 2-р зүйлд Цагдаагийн байгууллагын үүргийг хүний амь нас, эрүүл мэнд, бие махбодь, өмч хөрөнгийг хамгаалах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, мөрдөн шалгах ажиллагаа явуулах, замын хөдөлгөөний хяналт болон олон нийтийн аюулгүй байдлыг хангах зэрэг үүргийг хэрэгжүүлнэ хэмээн тодорхойлжээ⁹⁹.

⁹⁶ <https://laws-lois.justice.gc.ca>

⁹⁷ <https://laws-lois.justice.gc.ca>

⁹⁸ <https://laws-lois.justice.gc.ca>

⁹⁹ laws and orders relevant to police issues. Police Policy Research Center. 2008., 13 дахь тал



Япон Улсын Үндэсний Цагдаагийн хуулинд Цагдаагийн байгууллагаас объект, субъектын судалгаа хийж ашиглах талаар тухайлсан заалт байхгүй боловч гүйцэтгэх чиг үүрэгтэй холбоотой хэд хэдэн үндэслэлийг тусгажээ. Тухайлбал:

Уг хуулийн 25-р зүйлд Мэдээлэл, харилцаа холбооны товчоо нь дараах судалгаа хийнэ. Тухайлбал: 25 дугаар зүйл. Мэдээлэл, харилцаа холбооны товчоо нь дараах ажлыг хариуцана. Үүнд:

- (1) Цагдаагийн харилцаатай холбоотой асуудал;
- (2) Мэдээлэл төлөвлөлт, техникийн судалгааны асуудал;
- (3) Гэмт хэрэгт холбогдолтой мэдээллийн технологийн шинжилгээтэй холбоотой асуудал;
- (4) Захиргааны үр ашгийг дээшлүүлэхтэй холбоотой асуудал;
- (5) Эрүүгийн статистикийн тоо бүртгэлтэй холбоотой асуудлыг тус тус хариуцана гэжээ.¹⁰⁰

Мөн хуулийн 28 дугаар зүйлд Цагдаагийн шинжлэх ухааны үндэсний судалгааны хүрээлэн дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. Үүнд:

- (1) Гэмт хэргийн мөрдөн байцаалтад зориулсан шинжлэх ухааны судалгаа, боловсруулалт, туршилт судалгаа хийж дүгнэлт гаргах;
- (2) Насанд хүрээгүй хүмүүсийн болон бусад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх судалгаа боловсруулалт, туршилт судалгаа хийж дүгнэлт гаргах;
- (3) Зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх талаар болон замын цагдаагийн бусад чиглэлээр судалгаа боловсруулалт, туршилт судалгаа хийж дүгнэлт гаргах гэж тус тус судалгааны төвийн ажиллах чиглэл, судалгаа туршилтын ажлыг хамрах хүрээ зэргийг нарийн тогтоож өгсөн бөгөөд нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн алба хаагчийн явуулах үйл ажиллагааг “Нийгмийн аюулгүй байдлын үндэсний зөвлөл”-ийн батласан “Цагдаагийн хууль сахиулах үйл ажиллагаа” хэмээх журамд тусгажээ.

Уг журамд цагдаагийн нэн тэргүүний үүрэг, хариуцлага нь хотын иргэдийн амар тайван, аюулгүй байдлыг хангах талаар хуулиар хориглоогүй үйл ажиллагаануудыг явуулж, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, түүнийг түргэн шуурхай илрүүлэх, таслан зогсоох зэргээр цагдаагийн үйлчилгээг шуурхай хүргэх үйл ажиллагаагааг хэрэгжүүлэхэд оршдог байна¹⁰¹.

Ингэхийн тулд Кобан болон Чузайшо-г олон нийтийн цагдаагийн ажилтнуудын төв буюу цагдаагийн газрын нэгж хэсэг болгон зохион байгуулжээ. Тэдний зохион байгуулалт, үйл ажиллагаа нь хүн ам, газар нутаг, тухайн нутаг дэвсгэрт гарч буй гэмт хэрэг, зам тээврийн осол хэргийн байлаас шалтгаалан тодорхойлогддог байна¹⁰².

Кобан буюу цагдаагийн хэсгийн алба хаагчид хууль тогтоомжид заасан эрхийнхээ хүрээнд ард иргэдийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн тэдэнд цагдаагийн ажил үйлчилгээг хүргэдэг бөгөөд эдгээр ажил үйлчилгээнээс дурьдвал:

- Иргэдтэй холбоотой байж, тэдний хэрэгцээг судлах;
- Мэдээлэл өгөх;
- Тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх;
- Иргэдтэй холбоотой байж тэдний хэрэгцээг судлах;
- Айл өрх, албан газруудын судалгаа хийх;
- Кобан ба Чузайшогогийн хамтарсан хурал зохион байгуулах;
- Оршин суугчдын уулзалт, цуглаанд оролцох;
- Үзлэг шалгалт хийх гэх мэт¹⁰³.

Дээр дурьдсан айл өрх, албан байгууллагын судалгаа хийх ажлыг ихэвчлэн өдрийн цагаар гүйцэтгэдэг бөгөөд энэ нь хариуцсан нутаг дэвсгэрт оршин суух хүн, объектоо судлаж буй хэлбэр нь юм.

Түүнээс гадна аливаа хэрэг зөрчил гарсан тохиолдолд гэмт хэрэгтний зураг авах, айж сандарсан, гэмтэж бэртсэн, хохирсон хүмүүст туслах, сэжигтний болон эрэн сурвалжлагдаж буй этгээдийн дүр төрх, онцлох шинж тэмдэгийг тодорхойлох, түүний

¹⁰⁰ laws and orders relevant to police issues. Police Policy Research Center. 2008., 13 дахь тал

¹⁰¹ laws and orders relevant to police issues. Police Policy Research Center. 2008., 14 дахь тал

¹⁰² Koban-Sho буюу Токиогийн цагдаагийн газар. 2011 он

¹⁰³ Губанов.А.В “Полиция зарубежных стран”, 1999, с.124.,



зугтсан чиглэл, авто машиныг тогтоох, төв рүү мэдээлэх, хэргийн газрыг хамгаалах, сэжигтнийг баривчилах зэрэг үүргийг гүйцэтгэдэг байна.¹⁰⁴

Ийнхүү гэмт хэрэгтний дүр төрх, онцлог содон шинж, айл өрх, байгууллагын байршил хаяг, тэдгээрийн үйл ажиллагаа онцлог байдал зэргийг судлан үзэх нь цагдаагийн алба хаагчид нь объект, субъектын судалгаа хийж ашиглаж буй нэг илэрэл юм.

АНУ-ын Калифорина мужын бодлого журам

Калифорина мужийн Цагдаа үйл ажиллагаагаа зохицуулж байгаа хууль тогтоомж, эрх зүйн актыг кодификаци хийсэн бодлого үйл ажиллганы нэгдсэн жагсаалт, журмыг албан ёсоор төрөлжүүлж, standart operating produce manual буюу бодлого хэрэгжүүлэх үйл ажиллганы стандарт хэмжээн нэрлэн хууль сахиулах бүхийл үйл ажиллагаандаа хэрэглэдэг ажээ¹⁰⁵.

Судлаач бид энэхүү бодлого журмыг шинжлэн судлаж Белмонтийн цагдаагийн байгууллагаас объект, субъектын судалгаа явуулах, судалгааны цахим мэдээллийн сан үүсгэж ашиглах, улмаар гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах зэрэг хууль сахиулах үйл ажиллагаа явуулахдаа хэрхэн ашиглаж байгаа талаар судлан авч үзлээ. Үүнд:

Бодлого 324. Насанд хүрээгүй хүнийг түр хугацаагаар саатуурах гэсэн журмын 324.48-т Хүнд гэмт хэрэг үйлдсэн эсвэл бэлэгсийн гэм хэрэг үйлдсэн 14 болон түүнээс насны насанд хүрээгүй хүнийг албан ёсны бүртгэлд заавал бүртгэж, гэрэл зураг, гарын мөрийн дардсыг нь авна.

Бодлого 356. Меганы хууль буюу бэлэгсийн гэм хэрэг үйлдсэн этгээдийн талаар олон нийтэд сэрэмжлүүлэг мэдээлэл тараах журмын 356.32-т Эрүүгийн төрөлжсөн хуулийн 290.46 дугаар зүйлийн (с) (2) болон (D) (2) хэсгүүдэд дурьдсан гэмт этгээдүүдийн талаар доорхи мэдээллийг цагдаагийн байгууллага вэб сайтаар дамжуулан тавьж болно. Үүнд:

- a) Гэмт этгээдийн бүтэн нэр
- b) Гэмт этгээдийн хэрэглэдэг нэрс \нэр хоч\
- c) Гэмт этгээдийн хүйс
- d) Гэмт этгээдийн арьсны өнгө
- e) Гэмт этгээдийн биеийн гадаад төрх, байдал
- f) Гэмт этгээдийн гэрэл зураг
- g) Гэмт этгээдийн төрсөн, он, сар, өдөр
- h) Эрүүгийн төрөлжсөн хуулийн 290 дугаар зүйлд заасан гэмт этгээдийн үйлдсэн хэргүүд
- i) Оршин суух хаяг, түр амьдарч байгаа хаяг
- j) Тухайн гэмт этгээдтэй холбоотой гэж цагдаагийн газрын үзэж байгаа бусад мэдээллүүд.

Бодлого 425. Хулгайлагдсан автомашиныг олж илрүүлэх

425.11-т хулгайлагдсан тээврийн хэрэгслийг олж тогтоох зорилгоор Сан Матеогийн нутаг дэвсэрийн хэмжээд үйл ажиллагаа явуулдаг бүх цагдаагийн газар Сан Матеогийн шерипийн албаны тээврийн хэрэгслийн болон түүний эзэмшигчийн талаар өргөн хүрээтэй мэдээллийн сан, GPS болон LoJack авто машинд суурилуулсан дамжуулагч төхөөрөмж зэргийг ашиглаж байгаа нь тээврийн хэрэгслийг хулгайлах гэмт хэргийг илрүүлэх боломжийг нэмэгдүүлж байна.

Алдагдсан тээврийн хэрэгслийн дараах мэдээллийг санд оруулж эрэн сурвалжлахад ашиглахаар заажээ. Үүнд:

- Тээврийн хэрэгсэл үйлдвэрлэсэн улс орон;
- Үйлдвэрлэсэн огноо, аралын дугаар;
- Экспорт, импортын талаар мэдээлэл;
- Тээврийн хэрэгслийн загвар, марк;
- Тээврийн хэрэгслийн өнгө;
- Тээврийн хэрэгслийн зориулалт;

¹⁰⁴ Япон болох хөрш орнууд дахь Кабон системийн талаарх Олон улсын семинарын илтгэлүүдийн эмхтгэл. 2004 он. 54 дахь тал

¹⁰⁵ Ж.Ганбаатар. Белмонтын цагдаагийн бодлого журам.,УБ хот 2009 он. 3 дахь тал



-Тээврийн хэрэгслийн эзэмшигчийн талаар хувийн мэдээлэл¹⁰⁶ гэх мэт.

Энэхүү журамд заасан дээрх мэдээллийн сан нь нэгдмэл бөгөөд цагдаагийн байгууллага болон тээврийн хэрэгслийн тоо бүртгэл хариуцсан байгууллага тус тусдаа сан бүрдүүлнэ гэж огт заагаагүй нь мэдээллийн сангийн нэгдмэл хүртээмжтэй байдлыг хангаж байна.

Иймд Цагдаагийн байгууллагын субъектын судалгааны төрөлд хамаарах автомашинтай иргэдийн бүртгэл судалгааны мэдээлэлийг дэлгэрүүлэн тусгаж уг судалгааг боловсронгуй болгох, цахимжуулах, тээврийн хэрэгслийн болон эзэмшигчийн талаарх мэдээллийн нэгдэл, хүтээмжтэй байдлыг шаардлага харагдаж байна.

Бодлого 442. Гудамжны гэмт бүлгүүдийг тодорхойлох

442.3-т Цагдаагийн алба хаагч гэмт бүлэглэл байж болзошгүй бүлэг бөөгнөрөл болон гудамжны гэмт бүлэглэлд оролцож байгаа гэсэн сэжигтэй этгээдүүдийн талаар мэдээлэл цуглуулах, тэднийг судлах ажлыг хариуцан гүйцэтгэнэ¹⁰⁷.

Дор дурьдсан гэмт хэрэг үйлдсэн, үйлдэхээр завдсан, үйлдэхээр үгсэн хуйвалдсан, ял шийтгэгдсэн хүмүүсийг судлана. Үүнд:

1. Эрүүгийн төрөлжсөн хуулийн 245-р зүйлд: Амь насанд аюул учруулж болзошгүй зэвсэг, хүнд гэмтэл учруулж болох хүч хэрэглэж гэмтэл учруулах;

2. Эрүүгийн төрөлжсөн хуулийн 211-р зүйл: Дээрэмдэх гэмт хэрэг;

3. Эрүүгийн төрөлжсөн хуулийн 187-р зүйл: Бусдыг алах гэмт хэрэг;

4. Эрүүгийн төрөлжсөн хуулийн 246-р зүйл: Явж байгаа тээврийн хэрэгсэлрүү буудах;

5. Эрүүгийн төрөлжсөн хуулийн 12034-р зүйл: авто машин дотороо буудах, буудахыг зөвшөөрөх;

6. Эрүүгийн төрөлжсөн хуулийн 450-р зүйл: Галдан шатаах;

7. Эрүүгийн төрөлжсөн хуулийн 136-р зүйл: Гэрч хохирогчийг сүрдүүлэх;

8. Эрүүгийн төрөлжсөн хуулийн 459-р зүйл: Хулгайлах;

9. Эрүүгийн төрөлжсөн хуулийн 261-р зүйл: Хүчиндэх;

10. Эрүүгийн төрөлжсөн хуулийн 463-р зүйл: Эд хөрөнгө булаах;

11. Эрүүгийн төрөлжсөн хуулийн 186.а-р зүйл: Мөнх угаах

12. Эрүүгийн төрөлжсөн хуулийн 207-р зүйл: бусдыг барьцаалах;

13. Эрүүгийн төрөлжсөн хуулийн 203, 205-р зүйл: Согтуурч танхайрах, хүндрүүлэх нөхцөл байдалтай танхайрах;

14. Эрүүгийн төрөлжсөн хуулийн 206-р зүйл: Гарчлаах;

15. Эрүүгийн төрөлжсөн хуулийн 518, 520-р зүйл: Заналхийлэх хүнд гэмт хэрэг;

16. Эрүүгийн төрөлжсөн хуулийн 594-р зүйл: Түүх соёлын дурсгалт үнэт зүйл утстгах гэмтээх;

17. Эрүүгийн төрөлжсөн хуулийн 215-р зүйл: Авто машин барьцаалах;

18. Эрүүгийн төрөлжсөн хуулийн 12072-р зүйл: Галт зэвсэг худалдах, бусдад өгөх, дамжуулах;

19. Эрүүгийн төрөлжсөн хуулийн 10851-р зүйл: Авто машин хулгайлах болон автомашиныг хууль бусаар жолоодох, эсхүл авч явах зэрэг болно.

Дээр дурьдсан субъектүүдын нутаг дэвсгэр хариуцсан алба хаагч нь гудамжны гэмт бүлэглэл байж болзошгүй бүлэг, түүнд оролцож байгаа гэсэн сэжигтэй этгээдүүдийн талаар мэдээлэл цуглуулах ажлыг хариуцан гүйцэтгэнэ¹⁰⁸.

Гэсэн нь цагдаагийн байгууллагаас дээрх субъектүүдыг гэмт хэрэг үйлдэж болзошгүй, гэмт хэрэг үйлдсэн субъектүүдын бүртгэл судалгаандаа авч субъектын бүртгэл судалгаа хөтөлөн гэмт хэрэгтэй тэмцэх үйл ажиллагаандаа ашигладагын нэг илрэл юм.

Мөн уг журмын 442.4-т дээр дурьдсан этгээдүүдийн талаар дараах мэдээллийг судлаж бүртгэл, судалгаа хөтлөнө хэмээн заажээ. Үүнд:

a. Овог нэр;

b. Ашигладаг нэр хоч;

c. Нас, хүйс;

d. Гэмт бүлэглэлийн нэр;

¹⁰⁶ Ж.Ганбаатар. Белмонтын цагдаагийн бодлого журам.,УБ хот 2009 он. 178 дахь тал

¹⁰⁷ Ж.Ганбаатар. Белмонтын цагдаагийн бодлого журам.,УБ хот 2009 он. 191 дахь тал

¹⁰⁸ Ж.Ганбаатар. Белмонтын цагдаагийн бодлого журам.,УБ хот 2009 он. 193 дахь тал



- e. Тухайн этгээдийг таних хувийн мэдээлэл, онцлог содон шинж;
- f. Түүний ашигладаг тээвийн хэрэгсэл, бусад тогтоогдсон бүлгүүдийн талаарх мэдээлэл;
- g. Гэрэл зураг зэрэг байна¹⁰⁹.

Гэмт этгээдүүдийн талаар ийнхүү судлах нь тухайн субъектын биеийн байцаалт онцлог содон шинж, ямар ямар субъектүүд хаана, хэд хэчнээн байгаа, тэдний зүгээр үйлдсэн гэмт хэрэг, холбогдон шалгагдсан үйлдэл, найз нөхөд, дотно харилцаатай хүмүүс, тэдгээрийн үйл ажиллагаа зэргийг олж илрүүлэн бүргэлд авч судалснаар тэднийг ямар төрлийн гэмт хэрэг үйлдэж болзошгүй талаар урьдчилан прогноз гаргаж, тэдгээр субъектүүдийг гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, үйлдсэн гэмт хэргийг илрүүлэхэд ач холбогдолтой ажээ.

БНСУ

БНСУ-ын Үндэсний Цагдаагийн Хууль нь 2017 оны 7-р сарын 26-ны өдөр шинэчлэн батлагдсан бөгөөд уг хуулийн 26-р зүйл. Олон нийтийн аюулгүй байдлыг хангахад шаардлагатай судалгаа, боловсруулалтыг дэмжих гэсэн зүйлийн 1 дэхь хэсэгт Үндэсний цагдаагийн газар нь судалгаа шинжилгээ, туршилт, шинжилгээ зэрэг нийгмийн аюулгүй байдлыг хангах салбарт шинжлэх ухаан, технологийг нэвтрүүлэх бодлого боловсруулж хэрэгжүүлнэ¹¹⁰.

Судалгаа, боловсруулалтын төслийг үр дүнтэй хэрэгжүүлэхийн тулд Үндэсний цагдаагийн газар нь дараахь байгууллагуудтай гэрээ байгуулж, судалгаа боловсруулалтын төслийг хэрэгжүүлнэ.¹¹¹ Үүнд:

1. Үндэсний болон олон нийтийн судалгааны хүрээлэн;
2. Тусгай судалгааны байгууллагуудыг дэмжих тухай хуулийн 2 дугаар зүйлд заасан тодорхой судалгааны байгууллага;
3. Засгийн газрын санхүүжилттэй шинжлэх ухаан, технологийн судалгааны хүрээлэн;
4. Дээд боловсролын тухай хуульд заасан их, дээд сургууль, коллеж, үйлдвэрлэлийн, бага сургууль, техникийн коллеж;
5. Иргэний хууль, бусад хууль тогтоомжид заасан корпораци болон корпорациудад хавсаргасан судалгааны байгууллага;
6. Судалгаа боловсруулалт, технологийг хөгжүүлэх тухай хуулийн 14-р зүйлийн 2-д заасан судалгаа боловсруулалтыг төрийн бус судалгааны сектор байгууллага;
7. Ерөнхийлөгчийн зарлигаар тогтоосон, нийтийн аюулгүй байдалтай холбоотой судалгаа, шинжилгээ, технологийн хөгжил, бусад чиглэлээр ажилладаг бусад байгууллагууд.

Мөн зүйлийн 3 дахь хэсэгт Үндэсний цагдаагийн газар нь судалгаа, боловсруулалтын төслийг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг бүрэн буюу хэсэгчлэн хариуцана¹¹².

Хэмээн заасан нь Бүгд Найрамдах Солонгос улсын Цагдаагийн байгууллага өөрийн үйл ажиллагааныхаа зорилтын хүрээнд судлах шаардлагатай зарим судалгаа боловсруулалтын ажил, шинжлэх ухаан технологийн төсөл хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлэх зэргээр судалгаа шинжилгээний ажилд ихээхэн ач холбогдол өгч, бага бус анхаарал хандуулж байгаа нь харагдаж байна.

Гэмт хэрэгтэй тэмцэж, хууль зөрчих явдлыг таслан зогсоох ур чадварыг нэмэгдүүлэхийн тулд эдгээр бүх дэд салбарт хөрөнгө оруулалт хийх шаардлагатай. Ялангуяа, шинэ технологи болон инноваци бий болгоход хөрөнгө оруулалт хийх хамгаас чухал.¹¹³ гэсэн нь бидний саналтай нийлж байна.

Шинжлэх ухаан болон технологийн давуу талыг ашиглан хууль сахиулагчид өөрсдийн дотоодын үйл ажиллагаагаа сайжруулж, гүйцэтгэлээ нэмэгдүүлэх боломжтой ба энэ нь эргээд ард иргэдэд илүү өндөр үйлчилгээ үзүүлэх ач холбогдолтой¹¹⁴.

¹⁰⁹ Ж.Ганбаатар. Белмонтын цагдаагийн бодлого журам., УБ хот 2009 он. 193 дахь тал

¹¹⁰. <http://www.moleg.go.kr/english/korLawEng>

¹¹¹ <http://www.law.go.kr>

¹¹² www.law.go.kr

¹¹³ Хууль сахиулахуй сэтгүүл. УБ. 2017 оны дугаар №1., 23 дахь тал

¹¹⁴ Хууль сахиулахуй сэтгүүл. УБ. 2017 оны дугаар №1., 27 дахь



Ийм учраас цагдаагийн байгууллага гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаандаа судалгаа шинжилгээний ажил явуулах, үйл ажиллагаагаа төлөвлөх, хэрэгжүүлэх, зохион байгуулах зэрэг үйл ажиллагаандаа шинжлэх ухаанчаар хандах, хууль сахиулах салбарт “Цахим хянагч-Электрон гав”, “Полиграф”, “GPS”, “Comp.stat”, “Crime mapping”, “CCTV” зэрэг орчин үеийн техник технологи, ухаалаг системүүдийг нэвтрүүлэх боломжийг судлах шаардлагатай.¹¹⁵

Мөн БНСУ-ын Цагдаагийн үйл ажиллагааны тухай хууль 2017 оны 07-р сарын 26-ны өдөр батлагдсан бөгөөд уг хуулийн 2 дугаар зүйлд цагдаагийн алба хаагчид дараах үүргийг гүйцэтгэнэ гэж заажээ. Үүнд:

1. Хүмүүсийн амь нас, бие, эд хөрөнгийг хамгаалах;
2. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, мөрдөн байцаах;
3. Харуулын үүргийг гүйцэтгэх, чухал хүмүүсийг хамгаалах, терроризмтай тэмцэх;
4. Нийтийн аюулгүй байдлыг хангах талаарх мэдээллийг цуглуулах, бэлтгэх, түгээх;
5. Хууль сахиулах үйл ажиллагаанд цагдаагийн мэдээллийн сан ашиглах;
6. Зам тээврийн осол, ослоос урьдчилан сэргийлэх;
7. Гадаадын засгийн газар, олон улсын байгууллагатай олон улсын хамтын ажиллагаа;

8. Нийтийн хэв журам, аюулгүй байдлыг хангах гэх мэт чиг үүргийг гүйцэтгэхээр заажээ.¹¹⁶

Дээр дурьдсан хуулийн заалтад Цагдаагийн байгууллагаас объект субъектын бүртгэл, судалгаа хийх талаар дэлгэрэнгүй тусгаагүй боловч БНСУ-ын Хууль сахиулах үйл ажиллагааны тухай хуулийн дээр зүйлд “Нийтийн аюулгүй байдлыг хангахад ач холбогдолтой мэдээлэл цуглуулах”, “Цагдаагийн мэдээллийн сан ашиглах” гэсэн хоёр заалт нь үйл ажиллагаандаа судлах шаардлагатай хүн, объектын шинж чанар, түүний онцлог зэргийг судалсан тусгайлсан мэдээллийн сан үүсгэж, түүнийг тогтмол ашигладаг болох нь илэрхий байна.

“Нийтийн аюулгүй байдлыг хангахад ач холбогдолтой мэдээлэл цуглуулах”, “Цагдаагийн мэдээллийн сан ашиглах” эрхийг БНСУ-ын Цагдаагийн албаны тухай хуулийн 24-р зүйлд зааснаар цагдаагийн байцаагч, ахлах байцаагч, цагдаагийн туслах ажилтны албан тушаалд ажиллаж буй эрх бүхий ажилтанд олгожээ.

Судалсан улс орнуудын цагдаагийн байгууллага нь объектын судалгаа хийх ажлын эрх зүйн үндсийг ялаатай боловч бүгд хуульчлан тогтоосон нь Цагдаагийн байгууллага цаашид объект, субъектын судалгаа хийж, ашиглах, түүнийг боловсонгүй болгох шаардлагатай болохыг илэрхийлж байна.

Дүгнэлт

Судалгаа хийх эрх бүхий субъектын хувьд цагдаагийн хэсэг харицсан ахлах төлөөлөгч, хэсгийн төлөөлөгч, байцаагч, офицер, түрүүч, туслах ажилтан, олон нийтийн цагдаа нар хийж, ашиглахаар зааснаас харахад дурьдсан субъектүүд цагдаагийн бүтэцийн хамгийн жижиг нэгж болох цагдаагийн хэсэг дээр тодорхой нутаг дэвсгэр хариуцан үүрэг гүйцэдэг алба хаагчид байгаа нь цагдаагийн байгууллагаас хариуцсан объектоо судлах шаардлагатайг нотлож байна.

Цагдаагийн байгууллагаас хийх объектын судалгааг Оросын холбооны улсаас бусад улс орны цагдаагийн байгууллага цахим хэлбэрээр, Япон улс цахим болон биетээр хослуулах хэлбэрээр хийж байгаа цаашид объект, субъектын судалгааг хөгжүүлж гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангахад мэдээллийн нэгдсэн тогтолцоог нэвтрүүлж, төрийн байгууллагуудын мэдээллийн сангийн бүрдүүлэлт, түүний ашиглалтыг сайжруулах, харилцан мэдээлэл шуурхай солилцох тогтолцоог бүрдүүлж цагдаагийн байгууллагын объектын судалгааг цахимжуулах шаардлага байгаа нь ажиглагдаж байна.

Мөн гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах салбарын эрдэм шинжилгээ, судалгааны ажлын санхүүжилтийг нэмэгдүүлэх, салбарын инноваци, эрдэм шинжилгээ, судалгааны ажлын тэргүүлэх

¹¹⁵ Гэмт явдалтай тэмцэх асуудал сэтгүүлийн 2013 оны дугаар №4 45. дахь тал

¹¹⁶ www.law.go.kr



чиглэлээр тодорхойлж, судалгааны ажлын үр дүнг практикт өргөнөөр нэвтрүүлж Бүгд найрамдах солонгос улсын Цагдаагийн албаны тухай хуулийн 26-р зүйлийн 1 дэхь хэсэгт заасан Үндэсний цагдаагийн газар нь судалгаа шинжилгээ, туршилт, шинжилгээ зэрэг нийгмийн аюулгүй байдлыг хангах салбарт шинжлэх ухаан, технологийг нэвтрүүлэх бодлого боловсруулж хэрэгжүүлэх туршлагыг нэвтрүүлж ашиглах замаар объектын судалгааны мэдээллийн цахим сан бий болгох, цахим сангийн аюулгүй байдлыг хангах талаар үндэсний дата төв болон бусад харилцаа холбооны байгууллагатай хамтран ажиллах нь зүйтэй.

Монгол Улсад үйлдэгдэж байгаа шинэ төрлийн гэмт хэргийг судлах түүний шалгаан нөхцлийн тогтоох, үйлдлийн арга, гэмт хэрэг үйлдэж буй цаг хугацаа, түүнийг үйлдсэн этгээдийн онцлог содон шинж тэмдэг, үйлдэж болзошгүй этгээдүүд болон шинэ төрлийн гэмт хэрэг үйлдэж ял шийтгэл эдлээд суллагдсан захиргааны хяналтанд байгаа этгээдүүдийн судалгааг шинжлэх ухааны үндэслэлтэй явуулж хэвших нь гэмт хэрэгтэй тэмцэх үйл ажиллагаанд эерэг нөлөө үзүүлэх боломж бүрдэнэ.

Санал

- Гэмт хэрэг тэмцэх, нийгмийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах тогтолцоонд объектын судалгааны нэгдсэн сан бүрдүүлж ашиглах;
- ШГЕГ, ОБЕГ, ХХЕГ, ТЕГ, ГЕГ, ИБМҮТ зэрэг төрийн тусгай чиг үүрэг бүхий байгууллагын судалгаа бүртгэлийг нэгтгэж нэгдсэн мэдээллийн нэг сантай байж, тэдгээр байгууллагын дүн мэдээг эргэлтэд оруулах;
- Хэсгийн байцаагч, төлөөлөгч нарыг зарим ажил үүргээс чөлөөлж объектын судалгааг сайжруулах, баяжуулах нөхцөл бололцоогоор хангах, цагдаагийн төрөл мэргэжлийн албадын жигд оролцоог нэмэгдүүлэх;
- Объектын судалгааны нэг хэлбэр бүхий \хэвшмэл\ загварыг өөрчилж, хариуцсан нутаг дэвсгэрийн онцлогт тохирсон өргөн мэдээлэл агуулсан үр дүнтэй шинэ загвар бий болгох
- Цагдаагийн албаны тухай хуулийн гэмт хэрэгтэй тэмцэх чиг үүрэг буюу 9-р зүйлийн 9.2.6-д “Цагдаагийн байгууллага гэмт хэрэгтэй тэмцэх үйл ажиллагаандаа объектын судалгаа хийж ашиглах” гэж шинээр нэмэлт оруулах гэсэн саналуудыг дэвшүүлж байна.



ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН ТУЛГАМДСАН АСУУДАЛ

ЭМЭГТЭЙ ХОРИГДОЛД ҮЗҮҮЛЭХ НИЙГМИЙН АЖЛЫН ҮЙЛЧИЛГЭЭ, АНХААРАХ ЗАРИМ АСУУДАЛ

О.Баяржаргал

*Дотоод хэргийн их сургуулийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн сургуулийн
Нийгмийн ажлын тэнхимийн ахлах багш, ахмад*

Товч агуулга: Гэр бүлийн хүчирхийлэл нь зөвхөн хохирогчийн бие махбодын болон сэтгэцийн эрүүл мэнд, нийгэм, эдийн засгийн бие даасан, аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөөд зогсохгүй тухайн хүчирхийлэлтэй гэр бүлд өсөн торниж байгаа хүүхэд, залуучуудын бие махбод, эрүүл мэндийн хэвийн хөгжил, нийгэмших үйл явцад сөргөөр нөлөөлдөг болохыг үндэсний болон олон улсын судалгааны үр дүн харуулж байна.

Гэр бүлийн хүчирхийллийн улмаас 3211 хүн эрүүл мэндээрээ хохирч, 64 хүн амь насаа алджээ. Тэдгээр хохирогчдоос 2708 хүн хөнгөн, хүндэвтэр, хүнд гэмтэл авсан нь тогтоогдсон байна.¹¹⁷ Хэдийгээр хөнгөн гэмтэл нь хүний амь насанд аюулгүй гэж үздэг ч үүнд хамрын ясны хугарал, ясны цуурал, 5 хүртэлх шүдний хугарал, гээд хүний гоо сайхныг насан туршид нь алдагдуулах зэрэг гэмтлүүдийг багтаан тооцсоныг цаашид анхаарах хэрэгтэй.

Гэр бүлийн хүчирхийллийн улмаас гэмт хэрэг үйлдэн ял эдэлж буй эмэгтэйчүүдийн өөрийн үнэлэмж доогуур, өөртөө итгэх итгэл муу, тэднийг дэмжин туслах хүмүүстэй холбоо багатай, тусгаарлагдсан, сэтгэл зүйн болон бие махбодийн хувьд гэмтэл авсан зарим тохиодолд архи, мансууруулах бодисны хамааралтай¹¹⁸ байдаг байна.

Мөн тэдний ар гэр, төрөл төрөгсөд нь түр болон удаан хугацааны эргэлтээр ирэхгүй, утсаар ярихгүй, илгээмж захидлаар харилцах нь хомс, үр хүүхэд нь асрамжийн газар хүмүүждэг зэргээс шалтгаалан ар гэрийн харилцаа холбоо тасрах тохиолдол ч байдаг бөгөөд тэднийг суллагдан гарахад хүлээн авах орчин байхгүй нь зарим талаасаа дахин гэмт хэрэг үйлдэх нөхцлийг бүрдүүлж байна. Иймээс гэмт хэрэг үйлдсэн эмэгтэйчүүд өмнөх хүчирхийлэлтэй харилцааны улмаас сэтгэл зүйн, бие махбодид үүссэн гэмтлийг нөхөн сэргээх болон тухайн орчноос шалтгаалсан бэрхшээлийг даван туулахад дэмжлэг туслалцаа үзүүлэх, нийгэмд бие даан ажиллаж, амьдрахад чиглүүлэх, гэр бүлийн харилцаа холбоог тасралтгүй байдлаар үргэлжлүүлэх зайлшгүй шаардлага байна. Иймээс дээрх зорилтот бүлэгт нийгмийн ажлын үйлчилгээг үзүүлэхэд анхаарах асуудлыг судалсан судалгааны үр дүнг танилцуулж байна.

Түлхүүр үг: Гэр бүл, хүндрэл бэрхшээл, сэтгэл зүйн дарамт, айдас түгшүүр.

Үндсэн хэсэг

Хүний жам ёсны эрхийг зөрчиж байгаа хамгийн түгээмэл хэлбэр нь аливаа хэлбэрийн хүчирхийлэл бөгөөд түүний дотор ураг төрлийн холбоотой хүмүүсийн хооронд үйлдэгддэг гэр бүлийн хүчирхийлэл нь гэмт хэрэг мөн болохыг өнөөдөр дэлхий нийтээрээ хүлээн зөвшөөрч түүнтэй тэмцэх аргыг эрэлхийлэх болсон. “Сүүлийн 5 жилийн байдлаар гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой үйлдэгдсэн гэмт хэргийн улмаас нийт 3211 иргэн хохирсны 2870 буюу 89,3 хувь нь эмэгтэйчүүд өртсөн байна”. (Ганбаатар, 2015, х.3)

Гэр бүлийн аль нэг гишүүн нь гэр бүлийн харилцаанд давамгайл байдал тогтоох, бусад гишүүдийг эрхшээлдээ байлгах зорилгоор хүчирхийлэл үйлддэг байна.

Мөн Улсын дээд шүүхийн судалгааны төвөөс шүүхээр шийдвэрлэгдсэн эрүүгийн хэргийн таслан шийдвэрлэх тогтоолд хийсэн судалгаанд тухайн онд улсын хэмжээнд гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой үйлдэгдсэн хэргийн улмаас 36 хүний амь нас хохирч, 44

¹¹⁷Г.Ганбаатар “Гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой гэмт хэргийг мөрдөн шалгах арга зүйн зөвлөмж” УБ 2015 он

¹¹⁸Хүний эрхийн үндэсний комисс “Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн бүх хэлбэрийн талаарх гүнзгийрүүлсэн судалгаа” 2007 он



хүн хүнд, 80 хүн хүндэвтэр, 270 хүн хөнгөн гэмтэл авч 37 сая төгрөгний хохирол учирсан гэж тогтоогджээ.

Гэр бүлийн хүчирхийллийн улмаас хохирогчийн эрүүл мэнд ямар их хохирдог болохыг дээрх судалгаануудын дүн харуулж байна. Гэвч эмнэлэгт хандсан хохирогчдын тоо нь гэр бүлийн хүчирхийлэлд өртөөд эмнэлэгт хандаагүй хохирогчдын тооноос мэдэгдэхүйц бага тоо болохыг ХЭҮТ-ийн Хамгаалах байраар үйлчлүүлсэн үйлчлүүлэгчдийн бүртгэлд хийсэн судалгааны үр дүн баталж байна. Азийн сангийн санхүүгийн дэмжлэгтэйгээр ХЭҮТ-өөс хийсэн судалгаагаар тус төвийн Хамгаалах байраар үйлчлүүлсэн гэр бүлийн хүчирхийллийн хохирогчид гэр бүлийн хүчирхийлэлд өртөж эхэлсэнээс хойш дунджаар 5-7 жилийн дараа л албан ёсны дэмжлэг тусалцаа авахыг хүсэн хууль цагдаагийн байгууллагад ханддаг болохыг тогтоожээ. Мөн хамгаалах байраар үйлчлүүлсэн гэр бүлийн хүчирхийллийн хохирогчдын дөнгөж 5 хүртэлх хувь нь эмнэлэгийн тусалцаа авдаг гэж мэдээлжээ. Энэ бүгдээс үзэхэд гэр бүлийн хүчирхийлэлд өртөж эрүүл мэндээрээ хохирсон нийт хохирогчдын тоо хэмжээ, эмнэлгийн үйлчилгээ авсан хохирогчдын тооноос хамаагүй их байх хандлага өндөр байна.

Гэр бүлийн хүчирхийлэл биеийн эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлээд зогсохгүй сэтгэцийн эрүүл мэндэд бас давхар нөлөөлнө. Хүчирхийлэл үйлдэгчийн байнгын дарамт, хүчирхийлэл заналхийлэл, улмаар гэр бүлийн хүчирхийлэгч хохирогч эмэгтэйчүүдийг буруушаах нийгмийн сөрөг хандлагад автсан хохирогч бурууг өөрөөсөө хайх ба өөрийгөө буруутгах тохиолдолд түгээмэл. Гэр бүлийн хүчирхийллийн хохирогч эмэгтэйчүүд эмнэлэгт хандахдаа ихэвчлэн тодорхой биш өвчний зовиуртай эсвэл сэтгэл санааны гүн хямралтай гэсэн зовиуртай эмнэлэгт ханддаг байна. /Garza, 2002/

Кампбелл ба Левандовский Жеффе нарын тусдаа бие даан хийсэн судалгаагаар гэр бүлийн хүчирхийллийн хохирогч эмэгтэйчүүдийн дунд сэтгэл санааны гүн хямрал, юмнаас айж байнга санаа зовох, бүх биеэр нь өвдөх, гэмтлийн дараах сэтгэл сананы хямралын шинжүүд илрэх нь хяналтын бүлэгтэй харьцуулахад илүү өндөр байв.

Мөн Роз, Хамптон ба Гэллис, Мичэль ба Ходсон нарын судалгаагаар гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийг харьцуулахад хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийг гэр бүлийн хүчирхийлэлд өртөөгүй эмэгтэйчүүдтэй харьцуулахад, хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийн өөрийн үнэлэмж доогуур, өөртөө итгэх итгэл муу, тэднийг дэмжин туслах хүмүүстэй холбоо багатай, бусдаас илүү их тусгаарлагдсан байсан нь илэрчээ. Өөрийгөө хүчирхийллийн шалтгаан гэж үзэх явдал, өөрийн үнэлэмж муутай байх хувийн шинж, хүчирхийлэл үйлдэгч рүү буцаж очих шийдвэр гаргасан зэрэг нь хоорондоо хүчтэй холбоотой гэж илэрсэн байна.

Хэдийгээр гэр бүлийн хүчирхийлэл нь сэтгэцийн эрүүл мэндэд сөргөөр хэрхэн нөлөөлж буйг нарийвчлан судалсан дээрх судалгаануудтай адил төрлийн судалгааг Монголд хийсэн судалгаа хангалтгүй боловч гэр бүлийн хүчирхийллийн хохирогч эмэгтэйчүүдтэй ажиллаж, тэдний нөхцөл байдлыг мэдэх Монгол судлаач, мэргэжилтнүүдийн дүгнэлт, судалгааны дүнгүүд нь гэр бүлийн хүчирхийллийн хор нөлөөний тухай их мэдээлсэн байдаг. Тэд гэр бүлийн хүчирхийллийн хохирогч эмэгтэйчүүд нь сэтгэл санааны хямрал гутралд орсон, өөрийн үнэлэмж доогуур, өөртөө итгэх итгэл муу байдаг нь олон жилийн хүчирхийлэлд өртөж хүчирхийллийн гүн гүнзгий айдаст автсан, тэднийг дэмжин туслах хүмүүстэй холбоо багатай, бусдаас илүү их тусгаарлагдсан байсан нь илэрчээ.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой хэргүүд нь нэг талаас гэр бүлийн гишүүд хоорондын үл ойлголцол, үл хүндлэл, үл итгэлцэл, хардалт, өс хонзон, таарамжгүй харьцаа, бусдын өдөөн хатгалт, танхай балмад зан зэрэг гэр бүлийн харилцаанаас үүдэлтэйгээр үйлдэгддэг бол нөгөө талаас хүчээр дарлагдсан буюу хүндээр доромжлогдсон санаа сэтгэл нь гэнэт хүчтэй цочирсон үед хүчирхийллээс үүдэлтэйгээр үйлдэгддэг байна.

Хорих дугаар ангид 2018 оны 10 дугаар сарын байдлаар хүнийг санаатай алах гэмт хэрэг үйлдсэн хорих ял шийтгүүлсэн 97 хоригдол буюу 38 хувь нь гэмт хэрэг үйлдэхээс өмнө сэтгэл санаа, бие махбодь, эдийн засаг, бэлгийн, үл хайхрах хүчирхийлэлд удаа дараа өртөж байжээ. (ШШГЕГ, 2018, х.3)

Гэр бүлийн хүчирхийлэл нь гэр бүлийн орчинд, далд хэлбэрээр үйлдэгддэг тул гэр бүлийн хүчирхийллийн улмаас гэмт хэрэг үйлдсэн эмэгтэй хоригдол нь гэмт хэргийн гэрч, хохирогч нь тэдний гэр бүлийн гишүүн, төрөл садан, ойр дотны хүн байдаг.




Хүснэгт 1. Хорих ялаар шийтгүүлсэн хугацаа

№	Хорих ялаар шийтгүүлсэн хугацаа (жилээр)	Хувь
1.	23	3
2.	15	10
3.	11	14
4.	10	57
5.	4-7	11

Та хэдэн жилийн хорих ялаар шийтгүүлсэн бэ? гэсэн асуултанд нийт судлуулагчдын 57 хувь нь 10 жил, 14 хувь нь 11 жил, 10 хувь нь 15 жил, 3 хувь нь 23 жил, 11 хувь нь 4-7 жил гэсэн хариулт өгсөн байна. Үүнээс харахад гэр бүлийн хүчирхийллийн улмаас гэмт хэрэг үйлдэн ял эдэлж байгаа эмэгтэйчүүдийн талаас дээш хувь нь 10-15 жилийн хорих ялаар шийтгүүлсэн байна.

Зураг 1. Боловсролын түвшин



Гэр бүлийн хүчирхийллийн улмаас гэмт хэрэг үйлдэж ял эдэлж буй хоригдлын талаас илүү хувь нь бүрэн бус дунд болон бүрэн дунд боловсролтой байгаа нь боловсролын түвшингээс хамааран гэр бүлийн хүчирхийлэлтэй нөхцөл байдлаа таслан зогсох, шийдвэрлэх зөв гарцыг олж чадаагүйтэй холбон тайлбарлаж болох юм.

Зураг 2. Гэмт хэрэг үйлдсэн шалтгаан нөхцөл



Та гэмт хэрэг үйлдсэн шалтгаанаа юутай холбон тайлбарлах вэ? гэсэн асуултанд нийт судлуулагчдын 86 хувь нь архидалтаас үүдэлтэй дарамт, шахалт, 7 хувь нь гомдол цөхрөл, итгэмтгий зан, 7 хувь нь гэр бүлийн таагүй харилцаа, миний өөрийн зан араншин гэж хариулсан байна.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй харилцааг таслан зогсоохын тулд ямар зүйлүүдийг хийсэн талаар хоригдлын хариулсан хариултыг нэгтгэн үзэхэд дараах хариултыг өгсөн байна. Үүнд:

- Цагдаад хандаж байсан, мөн эрүүлжүүлэхэд өгч байсан



- Нөхрөөсөө салж тусдаа амьдарсан боловч гуйгаад ирэхээр нь гайгүй болчих болуу гэж итгэсэн
- Аргадаж учирлаж их хэлж, ойлгуулахыг боддог байсан
- Сальъяа гэж хэлээд 2 гараа хугалуулж байсан
- Үргэлж уучилдаг байсан
- Үгээр нь байдаг байсан
- Хүүхэд гаргуул архи уухаа болж магадгүй гэж бодоод хүүхэдтэй болсон
- Ямар нэг зүйл хийж байгаагүй
- Хаана хандахаа мэдэхгүй байсан

... цагдаад хандаж, эрүүлжүүлэхэд хонүүлж тухайн үеийн нөхцөл байдлыг шийдсэн боловч маргааш нь гаргаж авах гэж өөрөө мөнгө төлдөг, бас чи яасан их хүн бариулдаг юм гээд бүр их зоддог болохоор ахиж цагдаад мэдэгдэхээ больсон.

Гэр бүлийн хүчирхийллийн улмаас гэмт хэрэг үйлдэж

Зөвхөн цагдаагийн байгууллагад л ханддаг байсан боловч энэ арга хэмжээ нь буцаад өөрт нь илүү дарамт үүсгэдэг нь харагдаж байна. Мөн энэ тохиолдолд үр дүнтэй үйлчилгээ авах эрх зүйн зохицуулалт төдийлөн хангалттай бүрдээгүйг харж болохоор байна.

Хүснэгт 2. Бие махбод болон сэтгэл санаанд илрэх шинж тэмдэг

№	Шинж тэмдэг	Байнга	Заримдаа	Огт үгүй
1.	Нойр хулжих	79%	21%	-
2.	Толгой өвдөх	70%	30%	-
3.	Зүрх савлах	70%	27%	3%
4.	Чичирч салганах	45%	55%	-
5.	Тодорхойгүй шалтгаанаар айж түших	62%	38%	-
6.	Сэтгэл санаагаар унах, хямрах	59%	41%	-
7.	Маш их ганцаардах	48%	52%	-
8.	Ичих	21%	79%	-

Дээрх шинж тэмдгүүд хэр удаан хугацаанд илэрснийг тодруулж асуухад 55 хувь нь хүчирхийлэлд өртөж эхэлснээс хойш одоог хүртэл, 38 хувь нь хорих ангид ирээд 1-2 жилийн дараа, 7 хувь нь хорих ангид ирээд 6 сар хүртэл хугацаанд гэж хариулжээ.

Судалгаанаас харахад нийт судлуулагчдын талаас илүү хувь нь хүчирхийлэлд өртөж эхэлснээс хойш одоог хүртэл дээрх шинж тэмдэг илэрч байна гэж хариулсан нь олон жилийн хүчирхийллийн улмаас гүн гүнзгий айдас, түгшүүр нь өөрөө эдгээр шинж тэмдгийг үүсгэж байдаг. Мөн судалгаанд мэргэжилтнүүд эдгээр бэрхшээлүүд байгаа гэж үздэгч тасралтгүй үргэлжлэх мэргэжлийн үйлчилгээ үгүйлэгдэж байгаа нь харагдаж байна.

Хүснэгт 3. Гэр бүлийн хүчирхийлэлд өртсний улмаас гэмт хэрэг үйлдэн ял эдэлж буй эмэгтэйчүүдийн хүүхдүүдийнх нь насны байдал

№	Өгөгдөл	Хувь
---	---------	------



1.	0-18 насны хүүхэдтэй	52
2.	19-25 насны хүүхэдтэй	23
3.	25-аас дээш насны хүүхэдтэй	25


Ял эдэлж буй эмэгтэйчүүдийн хүүхдүүдийн насны байдлыг нь судалж үзвэл нийт судалгаанд оролцогчдын 52 хувь нь 0-18 насны хүүхэдтэй, 23 хувь нь 19-25 насны хүүхэдтэй, 25 хувь нь 25-аас дээш насны хүүхэдтэй гэж хариулсан байна.

Хүснэгт 4. Гэр бүлийн хүчирхийлэлд өртсний улмаас гэмт хэрэг үйлдэн ял эдэлж буй эмэгтэйчүүдийн хүүхдүүдийг нь халамжилж буй хүмүүс

№	Өгөгдөл	Хувь
1.	Ах дүү нарын асаргаанд	34
2.	Ээж буюу эмээгийн асаргаанд	31
3.	Тусдаа гарсан	14
4.	Төрсөн эцгийнхээ асаргаанд /дахин гэрлэлт болон дагавар/	7
5.	Асрамжийн газар (өнөр бүл, энэрэл)	7
6.	Ах эгч нарынхаа асаргаанд	4
7.	Хохирогчийн талд	3

Ял эдэлж буй эмэгтэйчүүдийн хүүхдүүд хэний асаргаанд байдгийг судалж үзвэл нийт судалгаанд оролцогчдын 34 хувь нь ах дүү нарын асаргаанд, 31 хувь нь ээж буюу эмээгийн асаргаанд, 14 хувь нь тусдаа гарсан, 7 хувь нь төрсөн эцгийнхээ асаргаанд /дахин гэрлэлт болон дагавар/, 7 хувь нь асрамжийн газар (өнөр бүл, энэрэл), 4 хувь нь ах, эгчийн асаргаанд, 3 хувь нь хохирогчийн талд гэж хариулсан байна. Эндээс харахад дээрх нь судлуулагчдын хамгийн их санаа зовж, сэтгэл зүйн бэрхшээл үүсгэдэг асуудлын нэг бөгөөд энэ нь ярилцлагын явцад ч гэсэн илэрч байсан.

Зураг 3. Хүнд хэцүү байдаг асуудал



Өөрт тань хамгийн хүнд хэцүү байдаг 3 асуудлыг нэрлэн үү? гэсэн асуултанд нийт судлуулагчдын 59 хувь нь гэр бүл, үр хүүхдүүдээ маш их санаж, тэдэндээ санаа зовдог, 28 хувь нь айж түгшиж, сэтгэл санаа үргэлж хямардаг, нийгэм хэрхэн хүлээж авах бол гэсэн айдастай байдаг, 13 хувь нь өөрийн эрүүл мэнддээ санаа зовдог гэсэн хариулт өгсөн байна.


Харин Гэр бүлийн хүчирхийлэлийн улмаас гэмт хэрэг үйлдэж ял эдэлж байгаа эмэгтэйчүүдийн зүгээс нийгмийн ажлын үйлчилгээ үзүүлэхэд гардаг хүндрэл бэрхшээлийг судалгаанд оролцсон мэргэжилтнүүд /нийгмийн ажилтан, сэтгэл зүйч/ дараах байдлаар хариулсан байна.

- Гэр бүлийн хүчирхийлэлд байсан хүн ихэнхдээ бүх зүйлээ ярихаас эмээдэг, дотроо хадгалдаг тэр бүр асуудлаа ярьдаггүй, айдастай, тогтворгүй байдаг;
- Хууль зүйн туслалцаа үзүүлэхэд зохих мэдлэг дутмаг байх;
- Ял эдэлж байгаа эмэгтэйчүүдийн сэтгэл зүй маш эмзэг байдаг учир орчиндоо дасан зохицох нь удаан байдаг;



Дээрх судалгаанаас харахад үйлчлүүлэгчдийн хувьд хамгийн их санаа зовдог зүйл нь гэр бүл, үр хүүхдүүдээ маш их санаж, тэдэндээ санаа зовдог гэж үзсэн байхад, мэргэжилтнүүдийн өгсөн хариултаас эдгээр зүйлүүдийг чухал гэж үзээгүй байна.

Зураг 4. Хүнд хэцүү асуудлаа даван туулж буй байдал



Эдгээр хүнд хэцүү зүйлсийг та хэрхэн даван туулж байна вэ? гэсэн асуултанд нийт судлуулагчдын 37 хувь нь одоог хүртэл даван туулж чадаагүй, 31 хувь нь өөрийн сэтгэлийн тэнхээгээрээ даван туулж байна, 14 хувь нь хорих ангид ирснээс хойш ажил хийж эхэлснээрээ аажмаар мартагдана (энд орсноос хойш ажил төрөл хийвэл хэнд ч гологдохгүй ажиллаж чадна гэдгээ ухаарч өөртөө итгэлтэй болсонцаашид ч зорьсондоо хүрэхийн тулд гараад сайн ажиллана), 14 хувь нь хамгийн их итгэдэг хүнтэйгээ ярьдаг, 7 хувь нь эмчилгээ хийлгүүлж байна гэсэн хариулт өгсөн байна.

Судалгаанаас харахад судлуулагчдын 68 хувь нь одоог хүртэл даван туулж чадаагүй буюу өөрийн сэтгэлийн тэнхээгээрээ даван туулж байнагэсэн хариултыг харахад (зураг 3) - дээр гарсан гэр бүл, үр хүүхдүүдээ маш их санаж, тэдэндээ санаа зовдог асуудлууд давхцаж байгаа нь үүний гол шалтгаан болж байна.

Гэр бүлийн хүчирхийллийн улмаас гэмт хэрэг үйлдсэн эмэгтэйчүүдэд үйлчилгээ хүргэхэд хэнтэй хамгийн их хамтран ажиллах шаардлагатай болдог вэ? гэсэн асуултанд мэргэжилтнүүд /нийгмийн ажилтан, сэтгэл зүйч/ дараах хариултыг өгсөн байна.

- Мэргэжлийн сэтгэл зүйч, эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах төв
- Гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой манай оронд мэргэжлийн байгууллага ховор байдаг, түүнийг өргөжүүлэх, эмэгтэйчүүдийн байгууллагатай хамтрах
- Төрийн болон төрийн бус байгууллага
- Бясалгалын төв
- Төлөөлөгч
- Шашны байгууллага

Эдгээрээс харахад хорих ял эдэлж буй эмэгтэйчүүдэд тулгамдаж байгаа асуудлыг шийдвэрлэхэд гэр бүлтэй нь хамтран ажиллах шаардлага нэн чухал гэдгийг илтгэж байгаа ч мэргэжилтнүүдийн хувьд гэр бүлд нь эргэн нэгтгэх үйлчилгээг тасралтгүй хангах байдлаар үйлчилгээг үзүүлдэггүй байдал илэрч байна.

Зураг 5. Харилцааны хувьд тулгардаг хүндрэл бэрхшээл

Харилцааны хувьд гардаг бэрхшээлийг судалж үзэхэд 49 хувь нь ямар нэг хүндрэл гардаггүй, 27 хувь нь бусад хоригдолтой ойлголцоход хэцүү байсан, 17 хувь нь сэтгэлээр их унадаг, 7 хувь нь албан хаагчдын ялгаварлан гадуурхалт гэж хариулсан байна.

Харин ямар нэг хүндрэл гардаггүй гэсэн хариултыг судлаж үзэхэд тэд дараах асуудлаас үүдэн бусадтай төдийлөн харилцдаггүй болох илэрсэн.

- Гэр бүлийн байнгын хэрүүл, зодуур дунд байсан учир аливаа зүйлээс их айж түгших зүйл их байнга байдаг
- Бусадтай харилцахдаа хүртэл өөрийн мэдэлгүй айсан байдалтай байдаг



- Бусадтай ярилцаж, өөрийн тухай ярьж чаддаггүй
- Өөрийгөө ойлгуулах чадвар муу учраас, олон хүнтэй юм ярьдаггүй
- Дуу цөөтэй болохоор хэн нэгэнтэй харилцахад хэцүү байдаг

Хүснэгт 5. Амьдралд чухал хэрэгцээтэй чадварууд

№	Өгөгдөл	Маш чухал	Чухал	Чухал биш
1.	Харилцааны чадвар	65%	35%	-
2.	Тунгаан бодох чадвар	59%	41%	-
3.	Шийдвэр гаргах чадвар	55%	45%	-
4.	Хорт зуршлаас татгалзах чадвар	45%	52%	3%
5.	Сэтгэлийн хөдөлгөөнөө хянах чадвар	62%	38%	-
6.	Бусдыг мэдэрч ойлгох чадвар	41%	59%	-
7.	Төлөвлөх чадвар	34%	66%	-
8.	Бусадтай холбоо тогтоох чадвар	41%	59%	-
9.	Өөртөө итгэх итгэлийг нэмэгдүүлэх чадвар	48%	52%	-
10.	Зөрчлийг хүчирхийллийн бус аргаар шийдвэрлэх чадвар	65%	35%	-

Эдгээр асуудлын аль нь танд хамгийн чухал гэж үзэж байна вэ? гэсэн асуултанд судалгаанд оролцогчид харилцааны чадвар маш чухал гэж 65 хувь, чухал гэж 35 хувь, тунгаан бодох чадвар маш чухал гэж 59 хувь, чухал гэж 41 хувь, шийдвэр гаргах чадвар маш чухал гэж 55 хувь, чухал гэж 45 хувь, хорт зуршлаас татгалзах чадвар маш чухал гэж 45 хувь, чухал гэж 45 хувь, чухал биш гэж 3 хувь, сэтгэлийн хөдөлгөөнөө хянах чадвар маш чухал гэж 62 хувь, чухал гэж 38 хувь, бусдыг мэдэрч ойлгох чадвар маш чухал гэж 41 хувь, чухал гэж 59 хувь, төлөвлөх чадвар маш чухал гэж 34 хувь, чухал гэж 66 хувь, бусадтай холбоо тогтоох чадвар маш чухал гэж 41 хувь, чухал гэж 59 хувь, өөртөө итгэх итгэлийг нэмэгдүүлэх чадвар маш чухал гэж 48 хувь, чухал гэж 52 хувь, зөрчлийг хүчирхийллийн бус аргаар шийдвэрлэх чадвар маш чухал гэж 65 хувь, чухал гэж 35 хувь гэж хариулсан байна.

Зураг 6. Мэргэжлийн шинэ мэдээллийг авдаг эх сурвалж



Та хорих ангийн нийгмийн ажилтнуудын нэгдсэн сургалтнаас гадна мэргэжлийн шинэ мэдээллийг хаанаас авдаг вэ? нэсэн асуултанд судалгаанд оролцогчдын 60 хувь нь интернэт цахим мэдээллийн хэрэгслэс, 20 хувь нь шинээр гарсан ном, сэтгүүл, 20 хувь нь нийгмийн ажилтнуудын нэгдсэн сургалтанд одоохондоо хамрагдаагүй байна гэж хариулсан байна.

Дүгнэлт

Гэр бүлийн хүчирхийллийн улмаас гэмт хэрэг үйлдэн хорих ял эдэлж байгаа эмэгтэй хоригдлыг нийгэмшүүлэх асуудлыг судалж байгаа анхны тохиолдол байсан нь сэдвийн



судлагдсан байдлаас харагдаж байлаа. Хэдийгээр хорих байгууллагад мэргэжлийн нийгмийн ажлын үйлчилгээ сүүлийн 10 гаруй жил хөгжиж байгаа ч хорих анги бүр нийгмийн ажилтантай өөрийн гэсэн тустай тогтолцоо бүхий биеэ даасан салбар болжээ. Энэхүү судалгааны ажлын хүрээнд гэр бүлийн хүчирхийллийн улмаас гэмт хэрэг үйлдэж хорих ял эдэлж байгаа эмэгтэй хоригдлыг нийгэмшүүлэх ажлын тулгамдсан асуудлыг тодорхойлж, дүн шинжилгээ хийн санал зөвлөмжийг боловсрууллаа.

Гэр бүлийн хүчирхийллийн улмаас гэмт хэрэг үйлдэн хорих ял эдэлж байгаа эмэгтэйчүүдийн хувьд гэр бүл, үр хүүхдүүдээ маш их санаж, айж түгшиж, сэтгэл санаа үргэлж хямардаг, нийгэм хэрхэн хүлээж авах бол гэсэн айдас зэрэг нилээдгүй асуудлууд тулгардаг байна.

Эдгээр асуудлыг хэрхэн даван туулж байгааг харахад хорих ангид ирснээс хойш ажил хийж эхэлснээрээ аажмаар мартагдаж байгаа (энд орсноос хойш ажил төрөл хийвэл хэнд ч гологдохгүй ажиллаж чадна гэдгээ ухаарч өөртөө итгэлтэй болсонцаашид ч зорьсондоо хүрэхийн тулд гараад сайн ажиллана), хамгийн их итгэдэг хүнтэйгээ ярьдаг, эмчилгээ хийлгүүлж байна асуудлаа шийддэг байхад одоог хүртэл даван туулж чадаагүй хүмүүсийн асуудал нь (зураг 2)-дээр гарсан гэр бүл, үр хүүхдүүдээ маш их санаж, тэдэндээ санаа зовсон сэтгэл зүй нь тэдэнд бэрхшээлийг үүсгэдэг байна. Энэ хэрэгээр ял эдэлж буй эмэгтэйчүүдийн хувьд хүүхдүүд нь тэдний хамаатан садан болон асрамжийн газар, хохирогчийн талд байгаа энэ нөхцлийг бий болгоход хүргэж байна.

Мөн мэргэжилтнүүдийн зүгээс эдгээр хүмүүст үйлчилгээ үзүүлэхдээ гэр бүл болон бусад ойр дотны хүмүүстэй төдийлөн хамтарч ажилладаггүй болох нь судалгаанаас харагдсан.

Иймээс тухайн зорилтот бүлгийн үйлчлүүлэгчдэд хорих ангийн нийгмийн ажилтан гэр бүлтэй нь хамтран ажиллах шаардлага нэн чухал гэдгийг илтгэж байна.

Нийт судлуулагчдын талаас илүү хувь нь хүчирхийлэлд өртөж эхэлснээс хойш одоог хүртэл бие махбодь болон сэтгэл санаанд¹¹⁹ нь сөрөг шинж тэмдэг илэрч байгааг судалгаанаас харахад олон жилийн хүчирхийллийн улмаас гүн гүнзгий айдас, түгшүүр тогтсон нь өөрөө эдгээр шинж тэмдгийг үүсгэж байдаг. Иймээс нийгмийн ажилтан, сэтгэл зүйчийн тасралтгүй үргэлжлэх мэргэжлийн үйлчилгээ үгүйлэгдэж байгаа нь харагдаж байна.

Харин нийгмийн ажилтан, сэтгэл зүйчдийн хувьд үйлчлүүлэгчийн тодорхойлсон дэмжлэгтэй адил хэрэгцээг тэдэнд шаардлагатай гэж мэргэжилтний хувьд тодорхойлж байгаа ч үйлчилгээг хүргэхдээ төдийлөн анхаардаггүй байдал ажиглагдаж байна. Мөн мэргэжилтнүүдээс авсан судалгааны үр дүнгээс харахад тэд дийлэнхдээ интернэт, цахим хэрэгслээс мэдээллийг авдаг нь тэдэнд мэргэжлийн арга зүйн туслалцаа, дэмжлэг тогтмол тасралтгүй байдлаар хүргэх нь чухал байна.

Судалгаанаас харахад ял эдэлж буй эмэгтэйчүүдийн хувьд дараах чадварууд тэдэнд хамгийн чухал /Харилцааны чадвар, Тунгаан бодох чадвар, Сэтгэлийн хөдөлгөөнөө хянах чадвар, Зөрчлийг хүчирхийллийн бус аргаар шийдвэрлэх чадвар, Бусадтай холбоо тогтоох чадвар, Өөртөө итгэх итгэлийг нэмээгдүүлэх чадвар, Хорт зуршлаас татгалзах чадвар, Шийдвэр гаргах чадвар/ гэж үзсэн байхад мэргэжилтнүүд ч гэсэн эдгээрийг чухал гэж үздэгч энэ чиглэлээр тодорхой, үр дүнтэй сургалт, хөтөлбөр хэрэгжүүлдэггүй болох нь харагдсан.

Эдгээрээс харахад нийт ял эдэлж буй эмэгтэйчүүд болон зорилтот бүлэгт чиглэсэн урьдчилан сэргийлэх болон зан үйлд нөлөөлөх хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлэх, тэдний ар гэрийнхэн болон зарим тохиодолд хохирогчийн талтай хамтран ажиллах, эдгээр үйлчилгээг хүргэх мэргэжилтнүүдийг мэргэжил арга зүйгээр тасралтгүй хангаж, мэргэшүүлэх хэрэгцээ шаардлага байгаа нь харагдаж байна.

Санал

Хорих байгууллага дахь нийгмийн ажлын салбарт гэр бүлийн хүчирхийллийн улмаас гэмт хэрг үйлдсэн хоригдлуудад үйлчилгээ хүргэхэд дараах асуудлыг шийдвэрлэх шаардлагатай байна. Үүнд:

- Нийт ял эдэлж буй эмэгтэйчүүд болон зорилтот бүлэгт чиглэсэн урьдчилан сэргийлэх болон зан үйлд нөлөөлөх хөтөлбөрийг боловсруулж/Харилцааны

¹¹⁹Хүснэгт 2



чадвар, Тунгаан бодох чадвар, Сэтгэлийн хөдөлгөөнөө хянах чадвар, Зөрчлийг хүчирхийллийн бус аргаар шийдвэрлэх чадвар, Бусадтай холбоо тогтоох чадвар, Өөртөө итгэх итгэлийг нэмэгдүүлэх чадвар, Хорт зуршлаас татгалзах чадвар, Шийдвэр гаргах чадвар /, тогтмол хэрэгжүүлэх

- Хорих байгууллагын нийгмийн ажилтан, сэтгэл зүйчдийг тогтмол мэргэжлийн арга зүйгээр хангах, мэргэшүүлэх
- Мэргэжлийн мэдээлэл дамжуулах /арга зүйгээр хангах/ цахим хаягтай болох-энэ чиглэлийн судлаачидтай хамтран туршлага солилцох

Ном зүй

1. Батхуяг, С., Төртогтох, Б., Цогзолмаа, Н. (2015). Боловсрол судлалын судалгааны ажлын арга техник. Улаанбаатар хот. Хүслийн өнгө хэвлэх үйлдвэр.
2. Даваа-Очир, Д. (2001). Хорих ял эдлүүлэх үйл ажиллагаанд холбогдолтой эрх зүйн баримт бичгийн эмхтгэл. Улаанбаатар хот. Тоонотпринт хэвлэлийн компани.
3. Жадамбаа, Б., Чимэдлхам, Ц., (2011). Судалгааны арга зүй. Улаанбаатар хот. Гэрэлт судар хэвлэлийн компани.
4. Лхагва, А. (2008). Монгол улсын шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын түүхэн замнал. Улаанбаатар хот. Тоонотпринт хэвлэлийн компани.
5. Лузгин, С., А., Кузнецов, М., И., Казанцев, Б., Н., (2009). Хорих байгууллагын нийгмийн ажил. Улаанбаатар хот. Хууль зүйн үндэсний хүрээлэн хэвлэх үйлдвэр.
6. Мягмар, О. (2000). Хувийн дасан зохицохуй. Улаанбаатар хот.
7. Өлзийтунгалаг, Х., Батхишиг, А., (2008). Гэр бүлийн хүчирхийлэлийг судлаж, нийгмийн ажлын үйлчилгээ үзүүлэх нь. Улаанбаатар хот.
8. Ичинхорлоо, Ш. (2007). Судалгааны ажлын үндэс. Улаанбаатар хот.
9. Curt T. Griffiths, Ph.D, Yvon Dandurand, Danielle Murdoch. The social reintegration of offenders and crime prevention. Research report: 2007
10. Gwen Robinson, Lain D Grow. Offender rehabilitation. Theory and Practice.
11. Brewster.M (2002). Domestic violence theories, research and practical implication
12. Davies.J., Lyon, E (1998). Safety planning with battered women: Complex lives and difficult choices.
13. Garza.M.A. (2002). Evaluation of battered women is shelter: Outcomes to measure effectiveness.
14. Hunter Geboy, C. (1995). Life planning education: A youth development program. Washington, DC: Advocates for Youth.



ЭРДЭМТЭН, СУДЛААЧДЫН БАЙР СУУРЬ

МОНГОЛ УЛС ДАХЬ ЭРХ ЗҮЙН ШИНЭЧЛЭЛИЙН БОДЛОГО, ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН, АНХААРАХ АСУУДАЛ

Б.Болдбаатар

*Дотоод хэргийн их сургуулийн Цагдаагийн сургуулийн захирал,
доктор (Ph.D), профессор, цагдаагийн хурандаа*

Товч агуулга: Монгол Улс дахь эрх зүйн шинэчлэлийн бодлого, түүний хэрэгжилт, эрх зүйн хөгжлийн үе шат, үр дүн, эрх зүйн шинэчлэлийн талаарх бодлогын баримт бичгийн хэрэгжилт, сургамж, цаашид анхаарах асуудлын талаар дурдсан.

Түлхүүр үг: Эрх зүй, төр, эрх зүйн шинэтгэл, эрх зүйн шинэчлэл, төрийн бодлого, хууль тогтоомж, хууль тогтоох эрх бүхий байгууллага, хэрэгжилт.

1921 онд Ардын хувьсгал ялсны дараа хуучин төрийн хууль цаазыг хүчингүй болгох, хувьсгалт хууль цаазыг шинээр тогтоох ажлыг Ардын Засгийн газар эхлүүлж, улмаар 1926 онд Монголын нийгэм дэх эрүүгийн эрх зүйн харилцааг бие даасан Эрүүгийн хуулийн хэм хэмжээгээр анхлан зохицуулсан “Шүүх цаазын бичиг”, 1926 онд Монгол Улсын шүүн таслах газруудад аливаа хэргийг байцаан шийтгэх хууль, Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Иргэний хууль тус тус баталж, мөрдүүлсэн.

Улмаар нийгмийн харилцааг зохицуулах, гэмт явдалтай тэмцэх төрийн бодлогыг тодорхойлох, хууль тогтоомжийг боловсронгуй болгох ажил үргэлжлэн хийгдэж, 1929, 1934 оны Шүүх цаазын бичгүүд, 1942, 1961, 1986 оны Эрүүгийн хуулиуд, 1935 оны БНМАУ-ын Аливаа хэргийг байцаан шийтгэх хууль, 1949, 1963 оны Эрүүгийн байцаан шийтгэх хуулиуд, 1952, 1963, 1994 оны Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Иргэний хууль батлагдсан. Эдгээр хуулиуд түүхэн үүргээ гүйцэтгэсэн болохыг түүх бэлхэнээ илтгэдэг.

1980-1990 онд дэлхийн социалист системийн дийлэнх улсад өрнөсөн өөрчлөлт, шинэчлэлт, ил тод байдлын үзэл санааны нөлөө Монгол оронд нэвтэрч, 1990 оны эхээр манай улс улс төр, эдийн засгийн цоо шинэ тогтолцоонд шилжсэн.

1990 оноос хойшхи Монгол Улсын эрх зүйн шинэчлэлийн хөгжлийн асуудлыг шинэ Монгол Улсын Үндсэн хууль батлагдах хүртэлх үе /1990-1992/, эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөр батлагдах хүртэлх үе /1992-1998/, өнөө үе /1998 оноос хойш/ хэмээн үечлэн авч үзэж болно. Эдгээр зурвас үеүдэд Монгол Улсын эрх зүйн хөгжилд шийдвэрлэх нөлөө үзүүлсэн дараах үйл явц өрнөсөн.

Нэг.Монгол Улсын Үндсэн хууль батлагдах хүртэлх үе /1990-1992/

1990-1992 онд Монгол Улсад эрх зүйн сэтгэлгээ шинэ үзэл хандлага, үнэт зүйлээр баяжигдан нийгэмд зарчмын өөрчлөлтүүдийг бий болгосон. 1990 оны 3 дугаар сард 1960 оны БНМАУ-ын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр парламентат ёс, олон намын тогтолцооны үндсийг хүлээн зөвшөөрч, төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн тогтолцооноос зах зээлийн эдийн засагт шилжих чиг баримжааг баталгаажуулснаар эрх зүйн сэтгэлгээний өөрчлөлт бодит зохицуулалт болох эхний алхам хийсэн байна.¹²⁰

1992 онд “Ардчилсан” Үндсэн хуулиа баталж, эх орондоо хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэхийг эрхэм зорилгоо болгон, хүний эрх, эрх чөлөөг баталгаажуулсан билээ. Шинэ Үндсэн хуулийн агуулга, үзэл баримтлалд нийцүүлэн хууль тогтоомжийг шинэчлэх зайлшгүй шаардлагаар 1993 онд Эрүүгийн хууль, 1994 онд Эрүүгийн байцаан шийтгэх хууль, Иргэний хууль, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай зэрэг-суурь нийгмийн харилцааг зохицуулсан хуулиудыг шинэчлэн баталсан.

Хоёр.Эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөр батлагдах хүртэлх үе /1992-1998/

1992-1998 онд төрийн эрх мэдлийг зөвхөн хуваарилан зааглах төдий биш зарчмын хувьд хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийн байгууллагуудын бүтэц, чиг үүрэг, эрх

¹²⁰ “Монгол Улсын эрх зүйн хөгжлийн асуудлууд” эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл. УБ., 2011. 20 дахь тал



хэмжээгээр дамжуулж нэг нь нөгөөдөө хяналт тавих замаар эрх мэдлийн тэнцвэржилтийг хангах үзэл онолыг хуульчилсан. Түүнчлэн, хүний эрхийг дээдлэх зарчмыг иш үндэс болгон олон улсын стандартад нийцүүлэх замаар Монгол Улсын иргэний эдлэх эрх, үүргийг хуульчлан баталгаажуулсан төдийгүй эрх зүйн сэтгэлгээний цар хүрээг тодорхойлох “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцах” зарчмыг Монгол Улсын Үндсэн хуулийн Арванесдүгээр зүйлд хуульчилсан билээ. Мөн төрийн эрх мэдлийн хуваарилалтаар төрийн байгууллагууд үүрэг хүлээж байгаа нь хүний эрх, эрх чөлөөг баталгаатай эдлүүлэхийн тулд төрийн эрх мэдлийн хуваарилалт хийдэг ардчилсан зарчмын баталгаа болсон юм.

1998 он хүртэл төрийн байгуулал, батлан хамгаалах, гадаад харилцаа, төсөв, татвар, гааль, эрүүл мэнд, нийгмийн даатгал, нийгмийн хамгаалал, газар, байгаль орчин, аж ахуйн үйл ажиллагаа, дэд бүтэц зэрэг нийгмийн гол харилцааг зохицуулсан 180 гаруй хуулийг УИХ-аас батлан гаргасан байна.¹²¹ Хууль тогтоомжийн энэхүү шинэтгэл нь Монгол Улсын Үндсэн хуулийн үндсэн зарчимд тулгуурлан яаралтай хийж, хэрэгжүүлэх шаардлагатай ажлын эхлэл байсан юм. Эдгээр арга хэмжээний үр дүнд Монгол Улсын Үндсэн хуульд нэр заасан Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулиас бусад олон хуулийг баталж, өмнө нь батлагдсан хууль, байгуулагдсан олон улсын гэрээг Монгол Улсын Үндсэн хуульд нийцүүлэн өөрчлөх ажлыг эхлүүлсэн.

1992-1997 онд Монгол Улсын эдийн засгийн харилцааг зохицуулахад шаардлагатай хууль тогтоомжийн шинэтгэл эрчимтэй хийгдсэн ба үүнийг эрдэмтэн, судлаачид хууль тогтоомжийн шинэчлэлийн өрнөлтийн үе гэж тодорхойлсон байдаг.

Гурав. Эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөр батлагдснаас хойш буюу өнөө үе /1998 оноос одоог хүртэл/

1992 оны Монгол Улсын Үндсэн хууль, түүний үзэл баримтлалд нийцсэн ардчилсан нийгэм, зах зээлийн эдийн засгийн эрх зүйн үндэс бүрдэж эхэлсэн боловч эрх зүйн шинэтгэлийг үргэлжлүүлэх, хууль тогтоомжийг боловсронгуй болгох, нийгэмд шинээр үүсч буй харилцааг хуульчлан зохицуулах, тэдгээрийг олон улсын жишиг, загварт нийцүүлэх, хуулийг дээдлэх, хүндэтгэн хэрэгжүүлэх нийгмийн ухамсарыг төлөвшүүлэх шаардлага байсаар байсан. Иймд эрх зүйн шинэтгэлийн зорилго, зарчим, арга зүйн үндсийг нарийвчлан тодорхойлж, хэрэгжүүлэх арга хэмжээний чиглэл, төлөвлөгөө тогтоох зорилгоор УИХ-ын 1998 оны 18 дугаар тогтоолоор “Эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөр”, “Монгол Улсын хууль тогтоомжийг 2000 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”, “Монгол Улсын эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-г тус тус баталсан.

1998 оны Эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөрт эрх зүйн шинэчлэлийн зорилго, зарчим, арга зүйн үндсийг тодорхойлж, түүнийг хэрэгжүүлэх 7 үндсэн чиглэл¹²²-ийн нийт 56 зорилготой арга хэмжээг төлөвлөсөн.

Уг хөтөлбөрт “Эрх зүйн шинэтгэлийн зорилго нь тус улсад хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэх зорилгыг биелүүлэх үүднээс Үндсэн хуульд тунхагласан зарчим, үзэл санааны дагуу төрийн бүх шатны байгууллага, албан ташаалтнаас хэрэгжүүлэх үйл ажиллагааны үндсэн чиглэлийг тодорхойлж, улс төр, нийгэм, эдийн засгийн хөгжил дэвшлийг хангах эрх зүйн үндэс, таатай орчинг бүрдүүлэхэд оршино” гэж заасан.

УИХ-аас хууль тогтоомжийг боловсронгуй болгох ажлыг тодорхой хугацаатайгаар төлөвлөн зохион байгуулах үүднээс “Монгол Улсын хууль тогтоомжийг 2000 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-д нийцүүлэн “Үндсэн чиглэл батлах тухай” УИХ-ын 2001 оны 44, 2005 оны 26, 2009 оны 38 дугаар тогтоолыг тус тус баталж, хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байв. Харин 2013 онд “Хууль тогтоомжийг 2016 он хүртэл

¹²¹ “Монголын эрх зүйн шинэтгэл-8 жил” илтгэл болон зөвлөмжүүдийн эмхэтгэл. УБ., 2003. 86 дахь тал

¹²² Монгол Улсын бүрэн эрхт байдлыг хангах эрх зүйн үндсийг төгөлдөржүүлэх, Эдийн засгийн харилцааны эрх зүйн үндсийг боловсронгуй болгох; Төрийн байгууллын эрх зүйн үндсийг боловсронгуй болгох; Эрх зүйн шинэтгэлийн орчин бүрдүүлэх; Хууль зүйн мэргэжлийн боловсон хүчний сургалтын тогтолцоог боловсронгуй болгох; Олон Улсын эрх зүйн зохицуулалтад Монгол Улсын оролцоог өргөтгөх.



боловсронгүй болгох үндсэн чиглэл"-ийн төслийг Засгийн газраас боловсруулж, УИХ-д өргөн барьсан боловч улс төрийн нөхцөл байдлаас шалтгаалан батлах шаардлагагүй гэж үзсэн бөгөөд энэ хугацаанд эрх зүйн шинэчлэлийн үзэл баримтлалгүйгээр хууль тогтоомжийг шинэчлэх, өөрчлөх ажил хийгдсэн гэж хэлж болно.

Энэхүү байдлыг дахин үүсгэхгүй байх үүднээс Хууль тогтоомжийг боловсронгуй болгох үндсэн чиглэл боловсруулах асуудлыг 2017 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэн Хууль тогтоомжийн тухай хуульд улам өргөжүүлэн томъёолж, хууль тогтоомж боловсруулах ажлын төлөвлөгөөг Үндсэн чиглэлд тусгах, Үндсэн чиглэлийг боловсруулах, батлах, хэрэгжүүлэх суурь зарчмыг тодорхойлсон.

Монгол Улсын хууль тогтоомжийг боловсронгуй болгох үндсэн чиглэлүүдээс гадна "Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан үндэсний хөгжлийн цогц бодлого"¹²³, "Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөр"¹²⁴, "Монгол Улсын шүүх эрх мэдлийн стратеги төлөвлөгөө"¹²⁵, "Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030"¹²⁶ зэрэг бодлогын баримт бичиг, түүнчлэн Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлснээр "Эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөр"¹²⁷-г дэвшүүлсэн зорилтот арга хэмжээнүүд тодорхой хэмжээгээр хэрэгжиж ирсэн.

"Эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөр"-ийн хэрэгжилтэд дүн шинжилгээ тусгайлан хийх шаардлагыг харгалзан Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2007 оны 36 дугаар тушаалаар "Эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөрт хяналт шинжилгээ, үнэлгээ хийх ажлын удирдамж", "Хяналт шинжилгээ, үнэлгээ хийх ажлын ерөнхий график"-ийг баталж, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2007 оны 3 дугаар сарын 12-ны өдрийн 42 дугаар тушаалаар Хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх ажлын хэсэг, 8 дэд хэсгийг байгуулан ажиллуулж¹²⁸ "Эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөрийн 2008 он хүртэлх хэрэгжилтийн хяналт, шинжилгээ, үнэлгээний тайлан"-г гаргасан.

Энэхүү тайланд эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөрийн 7 үндсэн чиглэл, заалт бүрийн хэрэгжилтийг судалсны үндсэн дээр үнэлгээ өгч, дараах дүгнэлт хийжээ. Үүнд:

1. "Монгол Улсын бүрэн эрхт байдлыг хангах эрх зүйн үндсийг төгөлдөржүүлэх" үндсэн чиглэлийн хүрээнд хууль тогтоомжийн сангийн ихэнх хэсэг бүрджээ. Хууль тогтоомжийг тодорхой хэмжээнд хэрэгжүүлж байгаа бөгөөд нийгэмд зарим зэрэг нөлөө үзүүлж байна. Гэхдээ хөтөлбөрийн 9 дүгээр заалтад хууль ёс, нийгмийн дэг журмыг хангах эрх зүйн цогцолбор зохицуулалтыг боловсронгуй болгох зорилт хангалтгүй биелэгджээ.
2. "Эдийн засгийн харилцааны эрх зүйн үндсийг боловсронгуй болгох" үндсэн чиглэлийн хүрээнд зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжих, эдийн засгийн хөгжил, дэвшлийг хангах эрх зүйн орчинг бүрдүүлж, холбогдох хууль тогтоомжийг шинээр болон шинэчлэн батлах ажлыг үндсэндээ хэрэгжүүлж чадсан ба түүний нийгэмд үзүүлж буй үр нөлөө мэдэгдэхүйц болжээ. Гэхдээ шударга өрсөлдөөнийг дэмжих, гадаад, дотоод хөрөнгө оруулалтад ижил нөхцөл бүрдүүлэх, эдийн засаг дахь төрийн оролцоог зохистой түвшинд хязгаарлах зорилт хууль тогтоомжийн түвшинд хангалттай хэрэгжээгүй байна.
3. "Хүний эрх, эрх чөлөө, түүний хууль зүйн баталгааг хангах" үндсэн чиглэлийн хүрээнд хүний үндсэн эрх, эрх чөлөө Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон хууль тогтоомжоор зохих түвшинд баталгаажиг, зохих зэрэг нөлөөлөл ажиглагдаж байгаа боловч өнөөг хүртэл төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагааны улмаас хүний эрх зөрчигдөх явдал хэвээр байна. Ялангуяа хүний эрүүл, аюулгүй орчинд амьдрах, халдашгүй байх эрх, эрх

¹²³ Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030 батлах тухай УИХ-ын 2016 оны 2 дугаар сарын 5-ны өдрийн 19 дүгээр тогтоолоор Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого батлах тухай УИХ-ын 2008 оны 12 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсон.

¹²⁴ УИХ-ын 2003 оны 41 дүгээр тогтоолоор баталсан.

¹²⁵ УИХ-ын 2000 оны 39 дүгээр тогтоолоор баталсан.

¹²⁶ УИХ-ын 2016 оны 19 дүгээр тогтоолоор баталсан.

¹²⁷ УИХ-ын 1998 оны 18 дугаар тогтоолоор баталсан.

¹²⁸ Монгол Улсын эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөрийн хяналт, шинжилгээ, үнэлгээний тайлан. Хууль зүйн үндэсний хүрээлэн. УБ., 2008. 6 дахь тал



чөлөөг хангах боломж, нөхцлийг төрөөс бүрдүүлэх талаар хангалтгүй анхаарч иржээ.

4. “Төрийн байгууллагын эрх зүйн үндсийг боловсронгуй болгох” үндсэн чиглэлийн хүрээнд хуулийг шинэчлэх, шинээр батлах ажил үндсэндээ хэрэгжиж, хууль тогтоомжийн зохих сан бүрдсэн байна. Хууль хэрэгжүүлэх арга ажиллагаа, хэрэгжүүлэх этгээдийн эрх, үүрэг, хөрөнгө нөөцийн хуваарилалтыг хуулийн түвшинд хангалттай сайн зохицуулаагүй учраас энэ чиглэлийн хууль тогтоомжийн хэрэгжилт хангалтгүй, төрийн албаны үйлчилгээний чанар, төрийн албан хаагчдын чадавх сул, энэ талаарх иргэд, олон нийтийн үнэлэмж тааруу байна.
5. “Эрх зүйн шинэтгэлийн орчин бүрдүүлэх” үндсэн чиглэлийн хүрээнд хууль тогтоомжийн санг тодорхой хэмжээнд бүрдүүлж, зарим зохион байгуулалтын арга хэмжээ авч байсан боловч хууль дээдлэх нийгмийн эрх зүйн ухамсарт нааштай өөрчлөлт гарсангүй. Хуулийг сахин биелүүлэх, хууль зөрчсөн этгээдэд хариуцлага тооцох, хуулийн хэрэгжилтэд байнгын хяналт тавих зохистой тогтолцоо бүрэлдэж чадаагүй байна. Иймд тус чиглэлийн хүрээнд хэрэгжсэн арга хэмжээний нийгэм дэх эерэг нөлөө төдийлөн харагдахгүй байна.
6. “Хууль зүйн мэргэжлийн боловсон хүчний сургалтын тогтолцоог боловсронгуй болгох” үндсэн чиглэлийн хүрээнд төлөвлөсөн арга хэмжээ үндсэндээ хэрэгжсэн ба зохих эерэг үр нөлөө ажиглагдаж байна.
7. “Олон Улсын эрх зүйн зохицуулалтад Монгол Улсын оролцоог өргөтгөх” үндсэн чиглэлийн хүрээнд хуулийн зохицуулалт бүрэлдсэн хэдий ч хуулийг хэрэгжүүлэх бүтэц, зохион байгуулалт, нөөц хуваарилалтын зарим бэрхшээл нь уг зохицуулалтын үр нөлөөг зарим байдлаар сулруулж байна.

Дээрх 7 үндсэн чиглэл бүрийн дүгнэлтэд тулгуурлан “Эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөр” үндсэндээ хэрэгжиж, эрх зүйн шинэтгэлийн зорилт хууль тогтоомжийн түвшинд биелэгдсэн байна. Үүний үр дүнд өнөөдрийн байдлаар Монгол Улсын Үндсэн хууль, түүний үзэл баримтлалд нийцсэн ардчилсан нийгэм, зах зээлийн эдийн засгийн эрх зүйн үндэс бүрэлджээ. Харин хууль дээдлэх зарчмыг төрийн үйл ажиллагаанд хэвшүүлэх, хуулийг хүндэтгэн сахин биелүүлэх талаарх нийгмийн эрх зүйн ухамсарыг бүрдүүлэх зорилт зохих хэмжээнд хангагдсангүй гэсэн дүгнэлт хийсэн байна.

“Эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөр”-ийн эхний 10 жилийн хэрэгжилтэд 2008 онд дүн шинжилгээ хийснээс хойш хөтөлбөр, хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан ажлын хэрэгжилт, үр дүнгийн талаар тусгайлсан судалгаа хийж, үнэлэлт, дүгнэлт өгөх ажил зохион байгуулаагүй. Зөвхөн хөтөлбөрт тусгагдсан хуулиуд батлагдсан эсэхийг хянаж, эдгээр хуулийн жагсаалтыг шинэчлэх асуудлыг голлон анхаарч ирсэн. Харин 2017 онд Хууль зүйн үндэсний хүрээлэнгээс “Эрх зүйн шинэтгэлийн бодлогын баримт бичиг боловсруулахад дэмжлэг үзүүлэх нь” судалгааг хийж, “Эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөрийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийсэн. Энэхүү судалгааны тайлан:

- “...Эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөрийн хэрэгжилтэд 2008 онд хийсэн үнэлгээний тайлангийн Эрх зүйн шинэтгэлийн дараагийн шатны хөтөлбөр боловсруулж мөрдөх ерөнхий санал, зөвлөмжийг өнөөг хүртэл хэрэгжүүлээгүй;
- Эрх зүйн шинэтгэлийн дараагийн шатны хөтөлбөр батлагдаагүй ч шинэ хөтөлбөрт тусгаж, хэрэгжүүлэхийг санал болгож зөвлөсөн 5 зорилт Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт зэрэг бодлогын баримт бичгүүдэд тусгалаа олж зохих хэмжээнд хэрэгжиж ирсэн байна;
- Шинээр батлах хөтөлбөрт тусгахыг зөвлөсөн зорилтуудын хэрэгжилтэд дүгнэлт хийхэд зарим зорилт харьцангуй сайн хэрэгжиж байгаа /тухайлбал, “Хууль нийтээр дагаж мөрдөх журам агуулсан эрх зүйн хэм хэмжээний актын төслийг боловсруулах, хянах, батлах үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг сайжруулж, хуулийн төсөл боловсруулахад тавигдах шаардлага, төсөл боловсруулах арга ажиллагааг шинэчлэх, санхүүжилтийн эх үүсвэрийг улсын төсөвт тусгадаг болох” тухай зөвлөмж/, зарим зорилтод дэвшүүлсэн арга хэмжээний хэрэгжилтийг үргэлжлүүлж эцсийн үр дүнг үзэлгүй орхисон /тухайлбал, “Өнөөдөр хүчин төгөлдөр үйлчилж буй бүх хуулийн агуулга, эх бичвэр, хууль зүйн нэр томъёог дахин хянан нягталж, сайжруулах арга хэмжээг тодорхой үе шат төлөвлөгөөтэйгээр ойрын 3 жилд авч хэрэгжүүлэх” тухай зөвлөмж/, зарим зорилтын хүрээнд хэрэгжүүлсэн арга хэмжээ, богино хугацаанд өөрчлөгдөх



/тухайлбал, ...хууль сахиулах байгууллагын бүтэц, зохион байгуулалтын тогтолцоог дахин хянаж өөрчлөх” тухай зөвлөмж/, зарим зорилтыг тухайлсан хөтөлбөрийн дагуу цогц байдлаар хэрэгжүүлсэн боловч асуудалд судалгаа, тооцоотой хандах байдал бүрэн хангагдаагүйгээс хэрэгжилтэд хүндрэл, бэрхшээл үүсэх /тухайлбал, “Шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэх байгууллагын чадавх, үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх цогц арга хэмжээг хэрэгжүүлэх” тухай зөвлөмж/ зэрэг байдал ажиглагдаж байна. Энэ нь эрх зүйн шинэчлэлийн асуудалд системтэй, нэгдсэн бодлого, залгамж чанар, хариуцлагатай хандах хандлага хэрэгцээ, шаардлагатай байгааг илэрхийлнэ” гэж дүгнэсэн байна.

Ийнхүү эрх зүйн шинэчлэлийн нэг хэсэг болох хууль тогтоомжийн шинэчлэл нь 1990-1992 онд буюу Монгол Улсын Үндсэн хууль батлах хүртэл шилжилтийн үеийн нэн шаардлагатай хууль тогтоомжийг батлах, 1992-1998 онд Үндсэн хуулийн хавсралт хуульд заасны дагуу, 1998 оноос “Эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөр”, “Хууль тогтоомжийг боловсронгуй болгох үндсэн чиглэл”-ийн дагуу хэрэгжиж иржээ.¹²⁹

Одоо зарим хүрээний эрх зүйн шинэчлэл, түүний үр дүн, цаашид анхаарах асуудлын талаар товч дурдъя.

Захиргааны эрх зүйн шинэчлэл, үр дүн, анхаарах асуудал:

Төвлөрсөн эдийн засгийн харилцаанд оролцогч захиргаа өөрийн үйл ажиллагаа, түүний арга, хэлбэрийг зах зээлийн эдийн харилцаанд оролцоходоо өөрчлөх зайлшгүй шаардлага гарсан. Мөн Монгол Улсын Үндсэн хуулийн үзэл санааны дагуу захиргаа нь үйл ажиллагаандаа хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх, хууль дээдлэх зарчмыг ягштал баримтлан ажиллах шаардлага одоо ч ач холбогдолтой байсаар байна. Эдгээр шаардлага захиргааны эрх зүйн шинэтгэлийн суурь үндэс болсон.¹³⁰

2000 оны эхэн үеэс эхэлсэн захиргааны эрх зүйн шинжлэх ухааны хөгжлийн тэсрэлтийн үндсэн дээр батлагдсан Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль захиргааны эрх зүйн шинэтгэлийн бааз суурь болж байна. Энэ хуулиар “Захиргааны байгууллага”, “Захиргааны акт” хэмээх суурь ойлголтуудыг шинэчлэн зохицуулж, нийгмийн амьдралд хэвшүүлсээр ирлээ. Өөрөөр хэлбэл, эрх зүйн болон оюун санааны хүрээнд эдгээрийн талаар нэгдмэл ойлголт бий болсон нь нэгэн зэрэг үр дүн мөн.

2008 оноос хойшхи шинэтгэлийн гол баримт бичиг нь Захиргааны ерөнхий хууль мөн боловч анхаарал татсан асуудал байсаар байна.

Захиргааны байгууллагын тогтолцоог тодорхойлох хууль тогтоомжийн шинэтгэл удаашралтай явагдаж байна. Үүнд: Засгийн газрын тухай /1993 он/, Яамны эрх зүйн байдлын тухай /1996 он/, Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай /1996 он/, Монгол Улсын засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль /2006 он/ зэрэг хуульд зарчмын шинэтгэл, өөрчлөлт ороогүйгээс гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагын тогтолцоо ямар зарчим, үзэл санаанд тулгуурлан хөгжиж байгаа нь тодорхойгүй болж байна.¹³¹ Энэ байдал нь тодорхой салбар, хүрээнд үйл ажиллагаагаа явуулдаг тодорхой байгууллагын эрх зүйн зохицуулалтад сөргөөр нөлөөлж байна. Захиргааны байгууллагын тогтолцооны эрх зүйн зохицуулалтын асуудал нь эрдэмтэн, судлаачдын анхаарлыг төдийлөн татахгүй байгаа нь практикт эрх зүйн зохицуулалт сул байхад зохих ёсоор нөлөөлж байна.

Гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагад ажиллагсад төрийн чиг үүргийг хэрэгжүүлж, бусдыг засаглан захирах үйл ажиллагаа явуулдаг ч төрийн жинхэнэ алба хаагчид билээ. Төрийн жинхэнэ албан хаагч захиргааны шийдвэр гаргахад оролцогчийнхоо хувьд захиргааны эрх зүйн харилцааны голлогч субъект юм. Түүний эрх зүйн байдал, үйлдлийг тодорхойлогч хууль-Төрийн албаны тухай хуулийг 2002 онд баталж, 2008 онд нэмэлт, өөрчлөлт оруулж, 2017 онд шинэчилсэн найруулсан гэж байгаа боловч дараах асуудал нааштай шийдэгдэхгүйгээр өнөөг хүрлээ. Үүнд: 1/Төрийн албан хаагчийн эрх зүй, эдийн

¹²⁹ “Монгол Улсын эрх зүйн хөгжлийн асуудлууд” эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл. УБ., 2011. 7 дахь тал

¹³⁰ Хууль зүй үндэсний хүрээлэн. “Эрх зүйн шинэтгэлийн бодлогын баримт бичиг боловсруулахад дэмжлэг үзүүлэх нь” судалгааны тайлан. УБ., 2017. 90 дахь тал

¹³¹ “Монгол Улсын эрх зүйн хөгжлийн асуудлууд” эрдэм шинжилгээний бага хурлын эмхтгэл, УБ., 2011, 316 дахь тал



засгийн баталгаа, 2/Төрийн албан хаагчид хүлээлгэх хууль зүйн болон эдийн засгийн хариуцлагын асуудлыг дурдаж болно.

2008 оноос хойш захиргааны эрх зүйн шинжлэх ухаанд гарсан том дэвшил бол Захиргааны ерөнхий хууль батлагдсан явдал юм. Цаашид уг хуулийг суурь үндэс болгон эрх зүйн системчлэл, эрх зүйн ухамсар төлөвшүүлэх алхмыг хийх шаардлагатай байна.

Эрүүгийн эрх зүйн шинэчлэлийн бодлого, хэрэгжилт, үр дүн, анхаарах асуудал:

2008-2012, 2012-2016 онд хийгдсэн эрх зүйн шинэтгэл, хөтөлбөрүүдийн хэрэгжилт, түүний дотор эрүүгийн эрх зүйн шинэчлэлийн хүрээнд хэрэгжсэн ажилд үнэлэлт, дүгнэлт өгч, чиг хандлагын талаар товч авч үзье.

Эрүүгийн эрх зүйн шинэчлэлийн хүрээнд боловсруулагдсан Эрүүгийн хууль /2015/, Зөрчлийн тухай хууль /2017/, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль /2017/, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль /2017/, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль /2017/, Прокурорын тухай /2017/, Цагдаагийн албаны тухай /2017/ хуулийг эцэслэн баталж чадсан нь сүүлийн 15 жилд хийгдээгүй томоохон шинэчлэл болж чадсан.¹³²

УИХ-аас шинээр болон шинэчлэн баталсан хуулиуд эрх зүйт төрийн бодлогыг хэрэгжүүлэх, Монгол Улсын Үндсэн хуулиар баталгаажуулсан хүний эрх, эрх чөлөө хангах, шударга ёсны тогтолцоо бүрдүүлэх, олон улсын нийтийн эрх зүйн хөгжлийн чиг хандлагад нийцүүлэх дэвшилттэй зохицуулалт цөөнгүй тусгагдсан хэдий ч хэрэгжүүлж эхэлсэн 11 сарын хугацаанд хуулийн зарим зүйл, заалтыг хэрэглэхэд ойлгомжгүй, хийдэлтэй, давхардсан зохицуулалт цөөнгүй байгаа болох эрүүгийн хууль тогтоомжийн хэрэгжилтэд хийсэн судалгааны үр дүнгээс харагдаж байна.

Дээрх нөхцөл байдлаас дүгнэхэд, эрүүгийн эрх зүйн шинэчлэл бодлогын судалгаанд үндэслээгүй хийгдсэн төдийгүй, төрөөс баримтлах эрүүгийн эрх зүйн нэгдсэн бодлого байхгүй байгааг харуулж байна. Тухайлбал, 2012 онд Хууль зүйн сайдын тушаалаар Эрүүгийн хуулийг шинэчлэн боловсруулах ажлын хэсэг байгуулагдаж байсан бол уг Эрүүгийн хуулийн төсөл 2 Улсын Их Хурал, 3 Засгийн газар дамжиж, УИХ-д 3 удаа өргөн баригдаж, 2 удаа буцаагдсаны эцэст УИХ-аас 2015 оны 12 дугаар сарын 3-ны өдөр шинэчлэн найруулж, 2017 оны 5 дугаар сарын 11-ний өдөр нэмэлт, өөрчлөлт оруулж, 2017 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс хүчин төгөлдөр үйлчилж эхлээд байна. Эрүүгийн хуулийн төслийг боловсруулан хэлэлцүүлж, батлуулах явцад төрийн эрх барих улс төрийн хүчнээс өөрсдийн эрх ашгийг хамгаалсан шинжтэй зохицуулалтыг ихээр тусгасан нь эрх зүйн шинэтгэлийн нэгдсэн бодлого байхгүй байгааг харуулахын зэрэгцээ цаашид гэмт хэрэгтэй тэмцэх төрийн эрүүгийн бодлогыг боловсруулж, тогтвортой баримтлах, эрх зүйн уламжлал, шинэчлэлийг хослуулах нь шаардлагатай болохыг илтгэж байна.

Шүүхийн шинэтгэлийн хэрэгжилт, үр дүн, анхаарах асуудал:

Шүүх эрх мэдлийн бие даасан байдлыг хангах нь хүний эрх, эрх чөлөө, шударга ёсыг тогтоох үндэс суурь билээ. Шүүх бие даасан, шүүгч хараат бус байх нь иргэний эрх, эрх чөлөө, ашиг сонирхлыг бодитой хамгаалах хүчирхэг механизм, шүүх эрх мэдлийн эрх зүйн баталгаа мөн. Тийм учраас бие даасан хараат бус шүүхийг тогтоох нь эрх зүйт төрийн нэг гол зорилт, шалгуур болдог.¹³³

1992 онд Монгол Улсын Үндсэн хууль батлагдснаас хойш шүүхийг шинэ Үндсэн хуулийн зарчим, агуулгад нийцүүлэн байгуулах, шүүх эрх мэдлийг эрх зүйт төрийн үзэл баримтлалд нийцүүлж, төлөвшүүлэх талаар хэд хэдэн шинэтгэл хийсэн.

Уг шинэтгэлээр хийгдсэн ажлуудыг он дарааллаар нь судлан дүгнэлт хийвэл дараах үечлэлд хуваан авч үзэж болно. Үүнд:

- 1993-2002 он шилжилтийн үеийн шүүхийн шинэтгэл;
- 2002-2012 он шилжилтийн дараах үеийн шүүхийн шинэтгэл;
- 2012 онд Шүүхийн багц хуулиуд хэрэгжиж эхэлснээс хойших үе.

¹³² “Монгол Улс дахь гэмт хэргийн цагаан ном-2016”. Монголын криминологичдын холбоо. УБ., 2017. 33 дахь тал

¹³³ Кристофер Осаевь. “Харьцуулсан эрх зүй судлал: ерөнхий ба тусгай анги”. Орч.Ж.Нямдорж, Л.Намхай, Л.Ундрах. УБ, 2005. 54 дэх тал



2012 онд Шүүхийн тухай багц хуулиуд батлагдан хэрэгжиж эхэлснээс хойш хийгдсэн шинэтгэлийг дараах зургаан үндсэн дэд хэсгүүдэд хуваан авч үзэж үзэж болно. 1/Шүүхийн тогтолцоо 2/Шүүхийн бие даасан байдал, 3/Шүүгчийн хараат бус байдал, 4/Шүүхийн хүний нөөц, сонгон шалгаруулалт, 5/Шүүхийн ил тод, нээлттэй байдал, 6/Шүүх эрх мэдлийн хүрээний бусад байгууллага.

Дээрх дэд хэсгүүдийн шалгуур үзүүлэлтийг Монгол Улсын Ерөнхийлөгчийн зүгээс санаачлан боловсруулж, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 2010 оны 4 дүгээр сарын 15-ны өдрийн хуралдаанаар зөвлөмж болгосон “Шүүх эрх мэдлийн хүрээнд шинэтгэлийг гүнзгийрүүлэх хөтөлбөр” болон Шүүхийн ерөнхий зөвлөлөөс баталсан 2014-2020 онд Шүүхийн хөгжлийн стратегийг 5 дэд хөтөлбөрт заагдсан үзүүлэлтэд тулгуурласан.¹³⁴

Шүүхийн шинэтгэлийн хүрээнд хийгдсэн томоохон өөрчлөлтийн нэг болох шүүхийн тогтолцооны өөрчлөлтүүдэд дүн шинжилгээ хийхэд шүүхийн тогтолцоо өөрчлөгдсөнөөр буюу шүүхийг дагнан байгуулснаар шүүгч илүү мэргэших, энэ нь шүүхийн шийдвэрийн чанарт нөлөөлж, улмаар ажлын ачаалал буурах эерэг үзүүлэлттэй судалгааны дүн гарсан боловч хууль санаачлагчийн зүгээс шүүхийн тогтолцоог өөрчлөх бодлогын шийдлийг гаргахдаа хууль, тогтоомжийн онолын буюу суурь судалгаа хангалттай хийгээгүй, түүнчлэн хууль тогтоомжийн үр нөлөөний судалгааг хийгээгүйгээс шалтгаалан шүүхийн шинэтгэлийн томоохон ажлуудын нэг болох шүүхийн дагнасан тогтолцооны хэрэгжилтэд хүндрэл учирсан. Иймд аливаа шинэтгэл, хууль тогтоомжийг батлахдаа хууль тогтоомжийн үр нөлөөний судалгааг сайтар хийх нэгдмэл ойлголттой байх шаардлага шүүхийн салбарт мөн тулгарч байна.

Эрх зүйн шинэтгэлийн хүрээнд тогтмол шүүмж дагуулж байдаг асуудал нь шүүхийн ил тод, нээлттэй байдлын тухай асуудал байсаар байна. “Шүүх эрх мэдлийн хүрээнд шинэтгэлийг гүнзгийрүүлэх хөтөлбөр” хэрэгжүүлэх хүрээнд шүүхийн ил тод нээлттэй байдлыг хангах хөтөлбөр батлан хэрэгжүүлж байгаа нь дэвшилттэй алхам болжээ. Иймд шүүхийн ил тод, нээлттэй байдлыг хангах талаар авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээг цаашид гүнзгийрүүлэх, шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийх, судалгааны эргэлтэнд оруулах нь эрх зүйн шинэтгэлийн цаашдын хөгжилд чухал ач холбогдолтой.

Шүүхийн шинэтгэлтэй холбоотойгоор бусад байгууллагууд ч шинэтгэл хийгдэж байна.

Дүгнэлт

“Эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөр”, “Монгол Улсын эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”, “Хууль тогтоомжийг боловсронгуй болгох үндсэн чиглэл”, “Хүний эрхийг хангах хөтөлбөр”-ийн хэрэгжилт, эрх зүйн шинэчлэлийн байдлаас үзэхэд, эрх зүйн шинэчлэлийн нэгдсэн бодлогогүй, 4 жил тутам сонгуулийн үр дүнгээр олонх болсон улс төрийн нам, эвслийн үзэмжээр эрх зүйн шинэчлэл хийгдэж, эрх зүйн хөгжилд сөргөөр нөлөөлж байна.

1990 оноос хойш эрх зүйн шинэтгэлийн хүрээнд “Хууль тогтоомжийг боловсронгуй болгох үндсэн чиглэл”-ийг боловсруулан УИХ-аар батлуулан мөрдөж ирсэн уламжлал 2012-2016 онд улс төрийн нөхцөл байдлаас шалтгаалан тасарсан нь эрх зүйн шинэтгэлийн нэгдсэн бодлого алдагдахад хүргэсэн гэж үзэж болохоор байна.

1998 оны Эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөрийн хэрэгжилтэд 2008 онд дүн шинжилгээ хийснээс хойш шинээр эрх зүйн шинэтгэлийн бодлогын баримт бичиг боловсруулан баталж, хэрэгжүүлэлгүй өдийг хүртэл явж ирсэн нь учир дутагдалтай байна.

Монгол Улс 2200 гаруй жилийн төрт ёс, хууль цаазын баялаг уламжлалтай улс хэдий ч уламжлалаа огт харгалзахгүй, судлахгүй, залгамжлуулан авч явалгүй, түүнийг үгүйсгэх хандлага газар авч, гадаадын улсуудын эрх зүйн зохицуулалт, туршлагыг нэвтрүүлэх нэрээр үндэсний онцлог, ахуй, амьдралын хэв маяг, ёс заншил, зан суртахуунд нийцээгүй гадаадын улсуудын хууль тогтоомжийг орчуулан баталж, хэрэгжүүлэхээр оролдож байгаагаас хуулийн хэрэгжилтэд сөргөөр нөлөөлж байна.

Нийтийн ашиг сонирхлыг бус, хэсэг бүлгийн ашиг сонирхлыг илэрхийлсэн хууль тогтоомжийг хууль тогтоох дээд байгууллагаас баталж байгаа нь иргэдийн төрд итгэх итгэл, хууль дээдлэх ёс, шударга ёсны тогтолцоог гажуудуулахад хүргэж байна.

¹³⁴ Хууль зүй үндэсний хүрээлэн. “Эрх зүйн шинэтгэлийн бодлогын баримт бичиг боловсруулахад дэмжлэг үзүүлэх нь” судалгааны тайлан. УБ., 2017. 101 дэх тал



Тухайлбал, Өршөөлийн тухай хуулийг баталж, авлига, албан тушаал, эдийн засгийн гэмт хэрэг үйлдсэн этгээдүүдийг эрүүгийн хариуцлага, ялаас чөлөөлөх, Эдийн засгийн ил тод байдлын тухай хууль батлах замаар их хэмжээний татвар, хөрөнгөө нуусан аж ахуйн нэгж, иргэдийг өршөөх, стратегийн зарим ордыг ашиглах, хөрөнгө оруулах асуудалд нийтийн ашиг сонирхлыг харгалзалгүй, хэсэг бүлэг, хөрөнгө оруулагчийн ашиг сонирхолд нийцүүлэн шийдвэр гаргасан зэргийг дурдаж болно.

Эрх зүйн шинэчлэлийн нэгдсэн бодлогогүйн улмаас хууль тогтоомжийн болон хуулийн байгууллагын шинэчлэлийг судалгаанд үндэслэлгүй “таамгаар”, УИХ, Засгийн газрын гишүүний хувийн бодол, үзэмжээр хийж, түүнийг дагаад шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах байгууллагууд бүтэц, тогтолцоо, чиг үүрэг өөрчлөгдөж, улмаар үйл ажиллагаанд саад учруулж байна. Тухайлбал, Дотоодын цэргийг татан буулгаж, буцаан байгуулсан, Тахарын албыг шинээр байгуулж, татан буулгасан, Шилжилт хөдөлгөөний ерөнхий газрыг байгуулж, хил хамгаалах байгуулагад буцаан нэгтгэсэн г.м

Монгол төрийн залгамж чанар байхгүй, өмнөх УИХ, Засгийн газрын ажил, эхлүүлсэн, хэрэгжүүлсэн эрх зүйн шинэчлэлийг улс төрийн өршөө авах, эсрэг намыг “харлуулах” зорилгоор дараагийн УИХ, Засгийн газар үгүйсгэж, гацааж, үгүй хийх байдал түгээмэл болсон.

Захиргааны эрх зүй, эрүүгийн эрх зүй, шүүх эрх мэдлийн хүрээнд хийгдсэн шинэтгэл нь ардчиллын үнэт зүйлийг бэхжүүлэх, хүний эрх, эрх чөлөөг хангах, шударга ёсыг тогтооход чиглэгдсэн чухал алхам болсон хэдий ч цаашид улам боловсронгуй болгох олон асуудал байсаар байна. Эрх зүйн шинэтгэлийн үр дүн нь хамгийн багадаа 12 жилийн тогтвортой бодлогын үр нөлөөгөөр илэрдэг болох нь эрдэмтэн, судлаачдын бүтээл, өндөр хөгжилтэй улсуудын туршлагаас харагддаг.

Санал

1. Монгол Улсын Их Хурлаас “Эрх зүйн шинэчлэлийн нэгдсэн хөтөлбөр 2020-2032” бодлогын баримт бичиг баталж, хэрэгжүүлэх;
2. Хууль тогтоомжийн давхардал, хийдлийг арилгах нэгдсэн судалгааг гүйцэтгэж, хууль санаачлах эрх бүхий субъектүүдэд хүргүүлэх, хамтран ажиллах эрх зүйн үндсийг бүрдүүлэх;
3. Хуулийн төсөл боловсруулах мэргэшсэн чиг үүрэг бүхий Хууль зүйн хороо байгуулах;
4. Эрх зүйн шинэчлэл хийхдээ хууль цаазын уламжлалдаа тулгуурлан өндөр хөгжилтэй гадаадын зарим улсын эрх зүйн зохицуулалт, туршлагыг судалж, өөрийн улсын онцлогт тохируулан нэвтрүүлэх;
5. Нийтийн ашиг сонирхлыг бус, хэсэг бүлгийн ашиг сонирхлыг илэрхийлсэн хууль тогтоомжийг хууль тогтоох болон гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагаас батлах явдлыг таслан зогсоох, төрийн шийдвэр гаргах үйл ажиллагаанд иргэдийн оролцоо, хяналтыг нэмэгдүүлэх;
6. Шүүхийн ил тод, нээлттэй, бие даасан хараат бус байдлыг бэхжүүлэх, шүүгч сонгон шалгаруулах үйл ажиллагааг шударга, ил тод болгох, улс төрийн нөлөөллөөс ангид байлгах;
7. Эрх зүйн шинэчлэлийн бодлогыг тогтвортой хэрэгжүүлэх, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх төрийн албан хаагчдын сэтгэлгээ, хандлагын шинэчлэлийг хууль тогтоомжийн шинэчлэлтэй хамтад нь хийх.

Ном зүй

Нэг. Монгол Улсын хууль

- Монгол Улсын Үндсэн хууль. //Төрийн мэдээлэл. УБ., 1992. №1
- Монгол Улсын Эрүүгийн хууль. УБ., 2002. //Төрийн мэдээлэл. УБ., 2002. №5
- Эрүүгийн хууль (шинэчилсэн найруулга) //Төрийн мэдээлэл. УБ., 2016. №7
- Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль //Төрийн мэдээлэл. УБ., 2017. №23
- Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хууль // Төрийн мэдээлэл. УБ., 2012. №11
- Прокурорын тухай хууль // Төрийн мэдээлэл. УБ., 2017. №24
- Цагдаагийн албаны тухай // Төрийн мэдээлэл. УБ., 2017. №8
- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль // Төрийн мэдээлэл. УБ., 2017. №24



- Шүүхийн шинжилгээний тухай хууль // Төрийн мэдээлэл. УБ., 2010. №2
- Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль // Төрийн мэдээлэл. УБ., 2012. №11

Хоёр.Ном, сурах бичиг, гарын авлага, эмхэтгэл

- “Монгол Улс дахь гэмт хэргийн цагаан ном-2016”. Монголын криминологичдын холбоо. УБ., 2017
- Кристофер Осаевь. “Харьцуулсан эрх зүй судлал: ерөнхий ба тусгай анги”. Орч.Ж.Нямдорж, Л.Намхай, Л.Ундрах. УБ, 2005
- “Монголын эрх зүйн шинэтгэл-8 жил” илтгэл болон зөвлөмжүүдийн эмхэтгэл. УБ., 2003
- “Монгол Улсын эрх зүйн хөгжлийн асуудлууд” эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл. УБ., 2011
- Монгол Улсын эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөрийн хяналт, шинжилгээ, үнэлгээний тайлан. Хууль зүйн үндэсний хүрээлэн. УБ., 2008
- “Эрх зүйн шинэтгэлийн бодлогын баримт бичиг боловсруулахад дэмжлэг үзүүлэх нь” судалгааны тайлан. Хууль зүй үндэсний хүрээлэн. УБ., 2017

ХОТ ДАХИН ТӨЛӨВЛӨЛТ ДЭХ ИРГЭДИЙН ОРОЛЦОО, АНХААРАХ АСУУДАЛ

О.Хишигмөнх

*Отгонтэнгэр их сургуулийн Хууль зүйн сургуулийн
Нийтийн эрх зүйн тэнхимийн багш, докторант***Удиртгал**

Төрөөс хүний эрхийг хамгаалах, нийтийн ашиг сонирхлыг хангахын тулд хот төлөвлөлтийн бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлдэг. Монгол Улс 1954 оноос эхлэн өнөөг хүртэл хугацаанд нийслэл Улаанбаатар хотын ерөнхий төлөвлөгөөг 6 удаа баталсан бөгөөд хамгийн сүүлд Улсын Их Хурлын 2013 оны 2 дугаар сарын 8-ны өдрийн 23 дугаар тогтоолоор “Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлагын баримт бичиг”-ийг баталсан. Хот төлөвлөлтийг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор газар өмчлөгч, эзэмшигч иргэдтэй эд хөрөнгийнх хувьд хэрхэн харилцах талаарх зохицуулалтыг Хот байгуулалтын тухай, Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хууль, Газрын тухай, тухай, Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулиар голлон зохицуулж, тэдгээрийг дагаж гарсан журам болон Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоолоор баталсан журмаар зохицуулж байна.

Хот дахин төлөвлөлт нь иргэдийн санаачилгад тулгуурлан хийгдэж байгаа ажил хэмээдэг боловч эрх зүйн зохицуулалт болон төслийн хэрэгжүүлэх явцад иргэдийн оролцоо хангалтгүйгээс, оролцуулаагүйгээс олон сөрөг үр дагавар илэрч цаг хугацаа алдах, иргэдийн нийтлэг эрх ашиг хөндөгдөх, орон байргүй болох, эд хөрөнгийн болон сэтгэл санааны хохирол учирсан тохиолдол байгаа нь цаашид хот дахин төлөвлөлтийн төсөлд иргэдийг эхнээс нь оролцуулах, төслийг иргэдтэй хамтарч хэрэгжүүлэх шаардлага тулгарч буйн илрэл юм.

Цаг үе өөрчлөгдөж иргэдийн эрх зүйн мэдлэг сайжирч байхад түүнийг дагаад хувийн хэвшил, төр ч үйл ажиллагаандаа иргэдийн оролцоог сайжруулах шаардлага байна. Иргэдийг чадавхжуулах, оролцоог нэмэгдүүлэх асуудал богино хугацаанд шийдвэрлэгдэх асуудал биш гэдгийг бусад улсуудын туршлага харуулж байгаа бөгөөд богино хугацаанд бэлэгдлийн чанартай, эсэргүүцлийг намдаах түр зуурын хэрэгсэл болгох, хууран мэхлэх замаар төслийг хэрэгжүүлэх оролдлого нь дараагийн төслийг хэрэгжүүлэхэд саад болдог. Нийслэлийн хэмжээнд хэрэгжүүлж байгаа хот дахин төлөвлөх ажлын хүрээнд иргэдэд 200 гаруй тэрбум төгрөгийн хохирол учирсныг тогтоосон байгаа нь цаашид анхаарах шаардлагатайг илтгэнэ. Иймд иргэдийн оролцоог үр нөлөөтэй болгохын тулд хот дахин төлөвлөлтийг амжилттай хэрэгжүүлэхийн тулд эрх зүйн зохицуулалтын болон хэрэгжилтийг хэрхэн хангаж ажиллах нь оновчтой талаар онол практикийн түвшинд тодорхой хэмжээнд судлахыг зорилоо.

Үндсэн асуудал, эрх зүйн зохицуулалт

Монгол Улсын нийт хүн ам 3,238,479 үүнээс нийслэлд 387453 өрх буюу 1444699 хүн амьдарч байгаа нийт хүн амын 46 хувь нийслэлд оршин суудаг бөгөөд энэ тоо цаашид нэмэгдэх нь тодорхой байгаа юм. Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүний эрхийн Дээд Комиссарын газраас 2030 он гэхэд дэлхийн хүн амын 60 хувь хот, суурин газарт суурьшин амьдрах болно гэсэн тооцооллыг гаргасан¹³⁵ байгаа нь улс бүрийн хувьд хотжилтын асуудал тулгарч байгааг илтгэнэ.

Хот дахин төлөвлөлт гэж тухайн хот, тосгоны ирээдүйн хөгжил, эдийн засаг, нийгэм, дэд бүтцийн зөв зохистой үйлчилгээг бий болгохын тулд газар ашиглалт, хотын барилгажилт болон хот байгуулалтын үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд чиглэсэн үе шат бүхий төлөвлөлтийн мэргэжлийн үйл ажиллагааг¹³⁶ ойлгодог. Хот дахин төлөвлөж буй зорилго нь иргэдийн эрүүл, аюулгүй, таатай орчинд амьдрах эрхийг хангах юм. Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх үйл ажиллагааны хүрээнд хот, суурин газрын барилгажсан хэсэг, нийтийн эдэлбэрийн газрыг дахин төлөвлөн байгуулах, ашиглалтын шаардлага хангахгүй барилга байгууламжийг буулган шинээр барих, гэр хорооллын газрыг дахин

¹³⁵ Urbanization and Human Rights <http://www.ohchr.org>

¹³⁶ Хот байгуулалтын тухай хууль (2008) 3.1.2.



зохион байгуулах, дахин төлөвлөн барилгажуулах цогц үйл ажиллагаа юм. Нийслэл хотод тулгамдсан асуудлыг шийдвэрлэх зорилгоор хот дахин төлөвлөлтийн ажлыг 2013 оноос эрчимжүүлж төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж байна. Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх үйл ажиллагаа дараах төрөлтэй. Үүнд¹³⁷:

- Төлөвлөлтийн шаардлага хангахгүй барилгажсан хэсгийг дахин төлөвлөн барилгажуулах
- Ашиглалтын шаардлага хангахгүй барилга байгууламжийг буулган шинээр барих¹³⁸;
- Гэр хорооллын газрыг дахин зохион байгуулах;
- Гэр хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулах;
- Нийтийн эдэлбэрийн газрыг дахин төлөвлөн байгуулах.

Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас гэр хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулах төсөл хэрэгжүүлэх 24 байршлыг баталсан¹³⁹ бөгөөд эдгээр байршлыг газрын хэмжээ, хүн амын нягтаршил зэргийг харгалзан үзэж 75 хэсэгчилсэн талбайд хувааж, төсөл хэрэгжүүлэгчийг сонгон шалгаруулах үйл ажиллагааг эхлүүлсэн. Эдгээр хэсэгчилсэн талбайд 2013-2015 онд сонгон шалгаруулалт явуулснаас 49 хэсэгчилсэн талбайд сонгон шалгаруулалт хийгдэж нийт 36 аж ахуйн нэгж гэр хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулах төслийн үйл ажиллагаа хэрэгжүүлж байна. Энэ нь 14,242 нэгж талбар буюу 1,381.5 га талбай хамарч байгаа нь нийслэлийн гэр хорооллын нутаг дэвсгэрийн 15 хувь, гэр хорооллын хүн амын 10 хувийг тус тус хамарч байна. Гэр хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулах төслийн хүрээнд орон сууцны барилга, нийгмийн болон инженерийн дэд бүтэц, авто замын барилга угсралтын ажилд зориулан нийт 14,242 нэгж талбарын 1,545 нэгж талбар буюу 90 га газрыг чөлөөлж, 10,278 айлын орон сууцны барилга угсралтын ажлыг эхлүүлсэн байна. Төсөл хэрэгжиж эхэлснээс хойш 2014 онд 960 айлын орон сууц, 2015 онд 1,656 айлын орон сууц, 2016 онд 2,213 айлын орон сууц, 2017 онд 368 айлын орон сууц, нийт 5,309 айлын орон сууц ашиглалтад оруулсан байна. Эдгээр 36 төсөл хэрэгжүүлэгчээс 6 нь үйл ажиллагаагаа эхлүүлээгүй буюу газар чөлөөлөлт хийгээгүй бол бусад 30 нь хэсэгчилсэн байдлаар газар чөлөөлөлт хийсэн байна. Харин үлдсэн 23 төсөл хэрэгжүүлэгч 790 өрхийн газрыг чөлөөлснөөс 7 төсөл хэрэгжүүлэгч 755 өрхийн газар чөлөөлж, үүнээс 6 айлын газрыг шууд худалдан авсан бол, 749 өрхийг орон сууцаар бүрэн хангаж гэрээний үүргээ бүрэн гүйцэтгэсэн байна. Харин үлдсэн 23 төсөл хэрэгжүүлэгч 790 өрхийн газрыг чөлөөлснөөс 25 өрхийн газрыг худалдан авч, хэсэгчилсэн байдлаар 319 өрхийг орон сууцаар хангасан байна. Одоогоор орон сууцандаа орж чадаагүй үлдсэн 446 өрхийн 370 нь түрээсийн орон сууцанд, 7633 нь түр орон сууцанд амьдарч байна гэсэн мэдээллийг Нийслэлийн Гэр хорооллын дэд бүтцийн газраас мэдээлсэн. Гэтэл зарим төсөл хэрэгжүүлэгч нь санхүүгийн чадавч, бизнес төлөвлөгөө, эрсдэл зэргийг нарийн тооцоололгүйгээр төсөлд оролцож байгаагаас нэгж талбарт газраа чөлөөлсөн өрхийг орон сууцаар хангах үүргээ биелүүлж чадахгүй, түрээсийн зардал олгохгүй байх зэргээр чирэгдүүлж, хохироох явдал гарч байна¹⁴⁰ гэсэн дүгнэлтийг хүний эрхийн комиссоос гаргаж холбогдох арга хэмжээ авахыг анхааруулсан. Хүний эрхийн үндэсний комисс анхаарлаа хандуулах түвшинд байна гэдэг нь хот дахин төлөвлөлтийн төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд хүний эрхийн зөрчил анхаарал хандуулах түвшинд байгааг илтгэнэ.

Монгол Улс дахь хот дахин төлөвлөлтийн эрх зүйн орчны хувьд Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай, Газрын тухай, Хот байгуулалтын тухай, Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуулиар зохицуулж, тэдгээрийг даган гарсан журам болон

¹³⁷ Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хууль (2015) 12.1

¹³⁸ Нийслэлийн мэргэжлийн хяналтын газрын ахлах байцаагчийн 2014 оны 01-01/05, 2016 оны 01-01/08, 2017 оны 02-01/03, 02-01/04 дүгээр шийдвэрээр ашиглалтын шаардлага хангахгүй, газар хөдлөлтөнд тэсвэргүй нь тогтоогдсон нийтийн зориулалтай орон сууцны 6321 өрхийн 234 барилгын ашиглалтыг хориглосон бөгөөд нийслэлийн засаг даргын 10 удаагийн захирамжаар Баянгол дүүрэг, Баянзүрх дүүрэг, Чингэлтэй дүүрэг, Хан-уул дүүрэг, Сонгинохайрхан дүүрэг, Налайх дүүрэгт нийт 131 барилгыг буулгах, дахин төлөвлөх барилгажуулах тухай шийдвэр гарсан.

¹³⁹ Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2013 оны 07/29, 2013 оны 12/43, 2014 оны 19/23 дугаар тус тус тогтоолоор гэр хорооллын дахин төлөвлөлтийн байршлыг тогтоосон.

¹⁴⁰ Хүний эрхийн үндэсний комисс “Монгол улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын 17 дахь илтгэл УБ., 2018 х.93-94



Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоолоор баталсан журмаар зохицуулж байна. Тухайлбал, “Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх төсөл хэрэгжүүлэх талбайг сонгох үлгэрчилсэн журам¹⁴¹”, “Гэр хорооллын газрыг дахин зохион байгуулах төсөлд оролцогчдын хооронд байгуулах гурван талт гэрээний үлгэрчилсэн загвар¹⁴²”, “Гэр хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулах төсөлд оролцогчдын хооронд байгуулах гурван талт гэрээний үлгэрчилсэн загвар”, “Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгыг буулган шинээр барих төсөлд оролцогчдын хооронд байгуулах гурван талт гэрээний үлгэрчилсэн загвар”, “Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгыг буулган шинээр барих үйл ажиллагааны журам¹⁴³”-ыг тус тус баталсан. Мөн “Гэр хорооллын дахин төлөвлөлтийн үйл ажиллагааны журам¹⁴⁴” тус журамд нэмэлт өөрчлөлт оруулсан Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2014 оны 2 дугаар сарын 20-ны өдрийн 23 дугаар тогтоол мөрдөгдөж байна.

Монгол Улсын Үндсэн хуульд төр, түүний байгуулага нь нийгмийн зайлшгүй хэрэгцээг үндэслэн хувийн өмчийн эд хөрөнгийг дайчлан авбал нөхөх олговор, үнийг төлнө¹⁴⁵ хэмээн заасныг Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулиар нарийвчлан зохицуулж улсын батлан хамгаалах болон аюулгүй байдлыг хангах, шинжлэх ухаан, технологийн сорилт, туршилт болон байгаль орчин, цаг агаарын төлөв байдлын байнгын ажиглалтын талбай байгуулах, улсын чанартай зам, шугам сүлжээ, барилга байгууламж барих¹⁴⁶ гэсэн 3 төрлийн зориулалтаар тусгай хэрэгцээг үндэслэн иргэний өмчийн газрыг бүхэлд нь буюу түүний зарим хэсгийг нөхөх олговортойгоор солих буюу эргүүлэн авахаар заасан. Мөн уг хуулинд иргэний өмчийн газрыг улсын тусгай хэрэгцээг үндэслэн нөхөх олговортойгоор солих буюу эргүүлэн авах тухай шийдвэрийг Засгийн газар гаргах¹⁴⁷ бөгөөд шийдвэр гарахаас нэгээс доошгүй жилийн өмнө газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага газар өмчлөгчтэй урьдчилан тохиролцохоор зохицуулсан¹⁴⁸ байна.

Олон улсын хэмжээнд хот дахин төлөвлөлтийн хүрээнд хөндөгдөж буй иргэний орон байр, газар, өмчтэй байх эрхийг цөөнгүй олон улсын гэрээ, конвенцид тусгаж хамгаалсан байдаг. Тухайлбал, Хүний эрхийн түгээмэл тунхаглалд “Хүн бүр бусадтай хамтарч болон ганцаараа өмчлөх эрхтэй. Хэний ч өмч хөрөнгийг дураар хураан авч болохгүй¹⁴⁹”, “хүн бүр хоол хүнс, хувцас хүнар, орон байр, эмчилгээ сувилгаа, нийгэм ахуйн зайлшгүй шаардлагатай үйлчилгээг оролцуулаад өөрийн болон ам бүлийнхээ эрүүл мэнд, аж амьдралыг тэтгэхэд хүрэлцэхүйц амьжиргаатай байх эрхтэй¹⁵⁰” хэмээн тус тус баталгаажуулсан. Эдийн засаг, нийгэм соёлын эрхийн тухай олон улсын пактад “Хүн бүрийн болон түүний өрх гэрийн хүрэлцээтэй хоол хүнс, хувцас, орон сууц оролцуулан, амьдралын хүрэлцээтэй түвшинд аж төрөх, амьдралынхаа нөхцлөө байнга сайжруулах эрхийг хүлээн зөвшөөрнө¹⁵¹”, оролцогч улсууд энэ талаар чөлөөтэй зөвшилцөлд үндэслэсэн олон улсын хамтын ажиллагаа чухал ач холбогдолтойг хүлээн зөвшөөрч, энэ эрхийн хэрэгжилтийг хангах зохистой арга хэмжээ авна”, Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактад “хэний ч хувийн болон гэр бүлийн амьдралд хөндлөнгөөс дур мэдэн буюу хууль бусаар оролцох, орон байранд нь буюу захидал харилцааных нь нууцад дур мэдэн буюу хууль бусаар халдах, эсхүл нэр төр, алдар хүндэд нь хууль бусаар халдахыг хориглоно¹⁵²”, “Оролцогч улсууд энэхүү эрхийг хэрэгжүүлэхэд үндэсний нөхцөл, хөрөнгө бололцоондоо нийцүүлэн эцэг эх, хүүхдийн төлөө хариуцлага хүлээж буй бусад хүнд туслалцаа үзүүлэх арга хэмжээ авч, шаардлагатай тохиолдолд материаллаг тусламж,

¹⁴¹ Барилга, хот байгуулалтын сайдын 2016 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн 84 дүгээр тушаал.

¹⁴² 2016 оны 7 дугаар сарын 5-ны өдрийн 125 дугаар тушаал

¹⁴³ 2016 оны 7 дугаар сарын 5-ны өдрийн 126 дугаар тушаал

¹⁴⁴ Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2013 оны 2 дугаар сарын 25-ны өдрийн 03/31 дүгээр тогтоолоор баталсан.

¹⁴⁵ Монгол Улсын Үндсэн хууль (1992) 6.4

¹⁴⁶ Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль (2002) 32.1

¹⁴⁷ Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль (2002) 32.2

¹⁴⁸ Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль (2002) 32.4

¹⁴⁹ Хүний эрхийн Түгээмэл Тунхаглал (1946) 17

¹⁵⁰ Хүний эрхийн Түгээмэл Тунхаглал (1946) 25.1

¹⁵¹ Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пактын 11.1

¹⁵² Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 17.1



ялангуяа хувцас, орон сууцаар хангах хөтөлбөр хэрэгжүүлнэ¹⁵³”, Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай конвенцид “Амьдралын зохих нөхцөлөөр, ялангуяа орон сууц, ариун цэвэр, чадилгаан болон усан хангамж, тээвэр харилцаа холбооны тухайд хангагдах¹⁵⁴” талаар тус тус заасан.

Мөн Нэгдсэн Үндэстний Байгууллагын Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн хорооноос гаргасан Ерөнхий зөвлөмжид хүн бүрийн орон байраар хангагдах эрхийг хэрэгжүүлэх төрийн үүргийг тайлбарласан. Тухайлбал, Засгийн газар нь хүн бүрийн орон байраар хангагдах эрхийг хүндэтгэх ёстой бөгөөд албадан нүүлгэхээс зайлсхийх, газрын эзэн, хувийн өмчит барилгын компани зэрэг гуравдагч этгээд хүний эрхийг зөрчихөөс хамгаалах, хүн бүрийн орон байраар хангагдах эрхийг бүрэн хэрэгжүүлэхэд чиглэсэн хууль эрх зүйн, захиргааны, төсвийн, шүүхийн, соён гэгээрүүлэх гэх мэт олон төрлийн арга хэмжээг авч хэрэгжүүлэх ёстой гэж заасан. Ингэхдээ Засгийн газар хүн бүрийг наад захын тав тух хангасан орон байраар хангах асуудлыг тэргүүлэх зорилгоо болгох бөгөөд төсөв хөрөнгийг хуваарилахдаа эмзэг бүлгийн хүн амыг эн тэргүүнд орон байраар хангах хөтөлбөрийг санхүүжүүлдэг.

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейн тогтоолоор 2015 онд баталсан 2030 он хүртэлх Тогтвортой хөгжлийн Хөтөлбөр¹⁵⁵-т **эрх нь зөрчигдөж болзошгүй хүмүүсийг эн тэргүүнд хамгаалж, хэнийг ч үл орхигдуулах** үзэл санааг тунхаглан баталгаажуулж, хөтөлбөрийг **Ээлтэй хот, иргэдийн оролцоо**¹⁵⁵ ны харилцаанд баримтлах зорилтуудыг тодорхойлж, хөгжлийн бодлогоо бүх түвшинд хэрэгжүүлэх чадвартай, авлигаас ангид, иргэдийн оролцоог хангасан, мэргэшсэн тогтвортой засаглал төлөвшсөн байна хэмээн тогтвортой хөгжлийн үзэл баримтлалаа тодорхойлсон. Хот дахин төлөвлөлтийн хүрээнд төрөөс хүний эрхийг хамгаалах, нийтийн ашиг сонирхлыг хангахын тулд хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ иргэний орон байраар хангагдах, газартай холбоотой болон өмчлөх эрхэд хохирол учруулах ёсгүй хэмээн олон улсын түвшинд үздэг. Хот төлөвлөлтийн бодлого, зохицуулалт, үйл ажиллагааг хүний эрхэд суурилсан хандлагад нийцүүлэхийн тулд дараах зарчим, хэм хэмжээг баримтлахыг олон улсын эрх зүйн түвшинд баталгаажуулсан. Үүнд:

- Хот төлөвлөлтийн үйл ажиллагааг хуулийн дагуу хэрэгжүүлэх;
- Бодлого, эрх зүйн зохицуулалт нь олон улсын хэм хэмжээнд нийцсэн байх;
- Зөвхөн нийтлэг сайн сайхны төлөө хот төлөвлөлтийг хэрэгжүүлэх;
- Эрх, ашиг сонирхол нь хөндөгдөж болзошгүй хүмүүсийг бодитоор зөвлөлдөх, санал бодлоо илэрхийлэх боломжоор хангах, тэдний чөлөөт, идэвхтэй оролцоог бүрдүүлэх;
- Иргэдийн эрх тэгш байдлыг хангах, үл ялгаварлан гадуурхах;
- Хот төлөвлөлт болон нүүлгэн шилжүүлэлт хийхээс өмнө хуульд заасан буюу хангалттай хугацааны өмнө эрх, ашиг сонирхол нь хөндөгдөж буй хүмүүст урьдчилан мэдээлэх, шаардлагатай мэдээлэл өгөх;
- Шударга нөхөх олговор олгох гэх зэрэг юм.

Дээрх хүний эрхэд суурилсан хандлагад одоогийн хэрэгжүүлж байгаа төсөл хөтөлбөрүүд бүрэн нийцэхгүй байгаа бөгөөд хамгийн асуудал дагуулж байгаа нь хүмүүсийг бодитоор зөвлөлдөх, санал бодлоо илэрхийлэх боломжоор хангах, тэдний чөлөөт, идэвхтэй оролцоог бүрдүүлэх, иргэдийн тэгш байдлыг хангах, үл ялгаварлах, эрх ашиг сонирхол нь хөндөгдөж буй хүмүүст урьдчилан мэдээлэл өгөх, шудрага нөхөн олговрыг өгөх зэрэг асуудлууд хангалттай хэмжээнд хэрэгжихгүй байна. Мэдээлэл авах гэсэн, шудрагаар өмчөө үнэлүүлэх гэсэн иргэдийг нухчин дарах гэсэн оролдлого төсөл хэрэгжүүлж байгаа компаниудад байгаа юм. Хүчээр асуудлыг шийдвэрлэсэн тохиолдолд эрхээ цуцлуулж, мэдээлэл авч оршин суугчдаа тараасны төлөө хариуцлага хүлээж шүүхээр орж эрхээ сэргээлгэсэн тохиолдол гарч байгаа нь цаашид төсөл хэрэгжүүлэгч иргэдтэй зөвшилцөх асуудал нэн тулгамдсан асуудал гэдгийг нотолно. Үүнийг ч төсөлд оролцогч компаниуд дуу нэгтэй зөвшөөрч байгаа юм.

¹⁵³ Хүүхдийн эрхийн тухай конвенци (1989) 27. 3

¹⁵⁴ Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай конвенци 14. 2 (h)-

¹⁵⁵ Тогтвортой хөгжил 2030 хөтөлбөр 11 дэх зорилго.



Хот дахин төлөвлөлтөнд иргэдийн оролцоог хангах талаарх холбогдох хуулиар зохицуулсан байдлыг авч үзвэл Захиргааны ерөнхий хуульд Захиргааны үйл ажиллагаанд бусдын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндсөн захиргааны шийдвэр гаргах тохиолдолд тэдгээрт урьдчилан мэдэгдэх, оролцоог нь хангах¹⁵⁶ гэж заасан бол Хот суурин газрын дахин хөгжүүлэх тухай хууль нь иргэдийн эрүүл, аюулгүй, таатай орчинд амьдрах эрхийг хангах зорилгоор хот, суурин газрыг дахин хөгжүүлэх үйл ажиллагааны хүрээнд хот, суурин газрын барилгажсан хэсэг, нийтийн эдэлбэрийн газрыг дахин төлөвлөн байгуулах, ашиглалтын шаардлага хангахгүй барилга байгууламжийг буулган шинээр барих, гэр хорооллын газрыг дахин зохион байгуулах, дахин төлөвлөн барилгажуулахтай холбогдон үүсэх харилцааг зохицуулахад оршино¹⁵⁷, хот, суурин газрыг дахин хөгжүүлэх үйл ажиллагаанд нийтийн эрх ашгийг эрхэмлэх, олон нийтийн оролцоог хангах¹⁵⁸ зарчмыг баримтална, Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга хот, суурин газрыг дахин хөгжүүлэх талаар дараах бүрэн эрхийн нэг нь төсөл, хөтөлбөр, төлөвлөгөөг нийтэд сурталчлах, мэдээлэх, санал, гомдол хүлээн авах замаар олон нийтийн оролцоог хангах ажлыг зохион байгуулах¹⁵⁹, хот байгуулалтын тухай хуульд хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө нь тухайн хот, тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд үндэслэсэн дүүрэг, хороолол, бичил хороолол, талбайн өндөржилт, зай хэмжээ, инженерийн шугам сүлжээний шийдэл, ногоон байгууламж, орчны тохижилтын төлөвлөлтийн норм ба дүрмийн шаардлагыг хангасан, иргэдийн оролцоотой төлөвлөгдсөн байна¹⁶⁰, Хот төлөвлөлтийн үйл ажиллагаанд иргэдийн оролцоотой төлөвлөлтийн зарчмыг тусгаж ажиллана, хот, тосгоны захирагч нь хот төлөвлөлтийг хэрэгжүүлэхдээ иргэд болон холбогдох мэргэжлийн хүмүүсийн оновчтой саналыг авч хот төлөвлөлтөд тусгана¹⁶¹ хэмээн тус тус зохицуулсан.

Өнөөгийн байдал, тулгамдсан асуудал

Монгол Улсын хүн амын 46 хувь буюу 1444699 хүн нийслэлдээ амьдарч үүний 60 орчим хувь буюу 800 зуу мянга гаруй нь гэр хороололд уламжлалт гэр болон байшинд амьдарч байна. Анхнаасаа хот төлөвлөлт нь одоогийн хүн амын өсөлтийг тооцоогүй хийгдсэнээс болж олон асуудал тулгарч байна. Нийслэлийн иргэн бүрт өдөр тутам замын түгжрэл, улирлын шинжтэй утаа, тоосонцор, хөрсний бохирдол гээд асуудал нэмэгдсээр байгаа нь хотын дахин төлөвлөх, өнөөгийн асуудалд шийдэл олох шаардлагатайг бүх түвшинд ойлгож, зөв арга замаар ээлтэй хотыг иргэдийн оролцоотой төлөвлөгөөг хэрэгжүүлэх хэрэгтэйг харуулж байна. Одоогийн байдлаар Нийслэлийн хэмжээнд 24 байршилд дахин төлөвлөлт хийгдэхээр болж эхнээсээ төсөл, хөтөлбөрүүд хэрэгжиж эхэлсэн бөгөөд төслийг хэрэгжүүлэх явцад иргэд, төрийн байгууллага, төслийг хэрэгжүүлэгч компаниудад аль алинд шийдвэрлэх шаардлагатай тулгамдсан асуудлууд байна. Тухайлбал:

- Нийтлэг байдлаар хот төлөвлөлтөнд саад болж байгаа нэн тэргүүний асуудал нь газар өмчлөлийн асуудал гэж үздэг. Газар олголтыг анхнаас нь замбараагүй олгосноос наад зах нь эмнэлэг, сургууль барих, зам тавих, өргөсгөх, дэд бүтэц бий болгох ажлуудыг хийхэд төвөгтэй болсон.
- Бодлогын уялдаа, холбоо сул төдийгүй холбогдох эрх зүйн зохицуулалт дутмаг байдал: Эрт үеэс монголчууд саалиа бэлтгэхээр саваа бэлд гэж бэлтгэл ажил нь уг ажлыг үр дүнтэй хийж дуусгахад үр нөлөөтэй байдгийн хойч үедээ сургамжилсаар ирсэн. Үүний нэгэн адилаар хот төлөвлөлтийн ажлыг эхлүүлэхээсээ урьтаж хууль эрх зүйн орчинг бүрдүүлэх, холбогдох дүрэм журмыг боловсруулах ажил хийгдэж ёстой атал хот суурийн газрыг дахин хөгжүүлэх тухай хууль 2015 онд батлагдсан зарим шаардлагатай журмуудыг батлахгүй уддаг нь иргэд хохирох үндэслэл болсон.
- Хөрөнгө оруулалтын асуудал: Хот төлөвлөлтөнд санхүүжилтийн асуудал чухал үүрэгтэй. Хөрөнгө оруулалтын хувьд төсөл хэрэгжүүлэгчийн хөрөнгөөр, улсын

¹⁵⁶ Захиргааны ерөнхий хууль (2015) 4.2.6

¹⁵⁷ Хот, суурин газрын дахин хөгжүүлэх тухай хууль (2015) 1.1

¹⁵⁸ Хот, суурин газрын дахин хөгжүүлэх тухай хууль (2015) 5.1

¹⁵⁹ Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хууль (2015) 11.1.5

¹⁶⁰ Хот байгуулалтын тухай хууль (2008) 12.5

¹⁶¹ Хот байгуулалтын тухай хууль (2008) 17.1, 17.2



болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр, концессын гэрээний дагуу төр, хувийн хэвшлийн түншлэлийн үр дүнд бий болсон хөрөнгөөр, ашигт малтмалын ордоос уул уурхайн бүтээгдэхүүн нийлүүлэх замаар төлбөрийн баталгаа гарган бүрдүүлсэн хөрөнгөөр, хот, суурин газрын үндсэн хөрөнгийг барьцаалах замаар бүрдүүлсэн хөрөнгөөр, гадаад улс, олон улсын байгууллагын хандив тусламж, төсөл, хөтөлбөрийн санхүүжилтээр, дараа эргэн төлөгдөх нөхцөлөөр байгуулсан гэрээний үндсэн дээр бизнес, хувийн хэвшлийн байгууллагаас гаргах хөрөнгөөр, Засгийн газрын тусгай сангийн хөрөнгөөр, ипотекийн хоёрдогч зах зээлээс үнэт цаас гаргасан эх үүсвэрээр, банкны зээлээр, газар, үл хөдлөх эд хөрөнгө өмчлөгч, эзэмшигчийн хөрөнгөөр, хувь нийлүүлсэн талбайгаас ашиглаагүй үлдсэн хэсгийг (нөөц талбайг) худалдсан, түрээслэсний орлогоор¹⁶² тус тус санхүүжүүлж болохоор заасан. Нийтлэг байдлаар ихэнх төслүүд олон улсын байгууллагын санхүүжилтээр, хөрөнгөө барьцаалж банкнаас авах гэсэн эх үүсвэрээр төслийг хэрэгжүүлж байна. Нийслэлийн төрийн захиргааны байгууллага болон иргэд төсөл хэрэгжүүлэгчийг сонгохдоо санхүүгийн чадавхыг харгалзан сонгох хууль эрх зүйн зохицуулалт байгаа боловч иргэд санхүүгийн чадавхтай эсэх үнэн зөв мэдээллийг авахад бэрхшээлтэй, мэдээд төсөлд хамрагдаж байгаа бусаддаа мэдээлсэн ч байгууллагын нэр хүндэд халдсан гэж цагдаад өгч хуулиар торгуульсан тохиолдол гарсан. Нийслэлээс төсөл хэрэгжүүлэх эрхээ авч төслөө хэрэгжүүлээгүй 5 жил болж иргэд нь орон гэргүй болсон тохиолдол байгаа нь цаашид иргэд хот дахин төлөвлөлтийн хүрээнд хэрэгжиж байгаа төслүүдэд итгэх итгэл буурч газартайгаа, хуучин ч гэсэн байртайгаа үлдсэн дээр гэж үзэх болсон нь хот төлөвлөлтийг хийхэд тулгарч буй том бэрхшээл юм. Барилгын салбарт зээл олгох нь багасч эрсдэлтэй салбарт тооцож харин хөрөнгийн зах зээлийн хөгжил сулаас хөрөнгө босгож чаддаггүй тул барилгын компаниудад санхүүжилтийн эх үүсвэр тун цөөхөн байгаа юм.

- Муу боловсруулсан төсөл сайн хэрэгжих үндэсгүй бөгөөд сайн боловсруулсан ч зорилтот хэрэглэгчийнхээ бодит хэрэгцээг хөтөлбөрийг ягштал хэрэгжүүлээд ч үр дүнд төдийлэн хүрдэггүй¹⁶³ гэдэг нь хот төлөвлөлтийн төслийн явцад харагдаж байна. Иргэд мэдээллийг нэгнээсээ авч байгаа байдал нь үнэнээс гажих, холбогдох байгууллага, албан тушаалтнууд нэг бүрчлэн хүрч ажиллаж чаддаггүй байдал, мэдээллийн урьдчилан мэдэгдэх, иргэдийн оролцоог хангах ажил дутмагаас хот төлөвлөлтийн төсөл удааширч цаг хугацаа алдаж улмаар нийслэлчүүдийн нийтлэг эрх ашиг хөндөгдөж улирал бүрийн тулгамдсан асуудалтай нүүр тулж байна. Уг төслийг хэрэгжүүлэхээсээ өмнө иргэд урьдчилан холбогдох мэдээлэл, зөвлөгөөг иргэдэд хүрэх боломжтой мэдээллийн хэрэгслүүдийг ашиглан заавал өгч байх шаардлагатай байна.
- Төрийн хүлээх үүрэг, хариуцлага тодорхойгүй байдал: Хот дахин төлөвлөлтийн төслийн улмаас хохирсон иргэд хохирлоо барагдуулахаар орон байртай болохын тулд хандаагүй газар, уулзаагүй албан тушаалтан бараг үгүй¹⁶⁴, асуудлыг шийдвэрлэхгүй удаж байгаа, шийдвэрлэхгүй байгаа хамгийн гол шалтгаан төр гэрээний нэг тал оролцогчоор оролцож байгаагийн хувьд ямар үүргийг хүлээх, төслөө хэрэгжүүлээгүй, хууль бус аргаар төсөлд шалгарсан бол төрийн зүгээс авах арга хэмжээ, иргэдээ хамгаалах механизм бүрэн хуульд байхгүйгээс иргэд хамгаалалтгүй байна. Төрийн эрх бүхий албан тушаалтан өөрт олгогдсон бүрэн эрхийг иргэдийн эрхийг хамгаалах, хангахын тулд олгогдсон гэдгийг үл хайхрах өмнөх албан тушаалтанд бурууг өгч суух тохиолдол байгаа нь төрийн алба

¹⁶² Хот, суурин газрын дахин хөгжүүлэх тухай хууль (2015) 21.1

¹⁶³ Салватор Шиаво-Кампо, Пачампет Сундарам “ иргэддээ үйлчилж, төрт ёсны үнэт зүйлсээ хадгалах: Өрсөлдөөнт ертөнцөд төрийн захиргааг сайжруулах нь УБ.,2013 х.219

¹⁶⁴ Эмнести интернэшнл ТББ-ын хүний эрхийн сургагч багшаар ажиллаж байх үед дахин төлөвлөлтийн улмаас хохирсон иргэдтэй олон удаа уулзаж байхад тэдний туулсан амьдрал бусдад битгий дохиолдоосой гэж бодох, иргэд хохирсныхоо дараа асуудалд ул суурьтай хандаж эвлэлдэн нэгдэж хуульчийн зөвлөгөө авч байгаа нь харамсмаар. Дахин төлөвлөлтөнд байр нь газар нь орж байгаа иргэдэд зөвлөгөө өгөх гээд очиход бараг ирдэггүй, ирсэн нь болох үйл явцын талаар ямар ч ойлголтгүй, хурдан л сайхан халуун дулаан байртай болчихно гэсэн ойлголттой байдаг.



иргэдэд тасралтгүй, шуурхай үйлчлэх зарчим болон Үндсэн хуулийн үндсэн зарчмуудыг зөрчиж байгаа явдал юм.

- Хот төлөвлөлтийн төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ тухайн байршил дахь газар, үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөгч, эзэмшигчдийн 80-аас доошгүй хувийн зөвшөөрөл авах гэрээ байгуулахаар хуульчилсан байх хэдий ч тухайн төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэхийг хүлээн зөвшөөрөхгүй байгаа иргэдийн эрх, ашиг сонирхлыг хэрхэн хамгаалах асуудал зохицуулалтгүй. Хэдийгээр олонхын саналаар төслийг хэрэгжүүлэгчийг сонгож байгаа боловч 20 хувьд хамаарах иргэдийн эрх зөрчигдөх магадлал өндөр зохицуулалт юм. Төсөл хэрэгжүүлэх сонирхолтой компани 80 хувь¹⁶⁵ д хүргэхийн тулд нэг айлын эхнэр, нөхөртэй тус тусад гэрээ байгуулсан, танайх л үлдлээ гэж шахалтанд оруулж зөвшөөрүүлдэг асуудал байгаа нь ихэнх тохиолдолд иргэд мэдээлэлгүй, оршин суугчид нэгэндээ нааз зах нь гэрээ байгуулсан эсэхээ хэлдэггүй, компаниуд хэлэхгүй байвал өөрт чинь сайн гэж үнэн бодит мэдээллийг өгөхийн эсрэг ажилладаг нь барилгын компаниудын ёс зүйгүй, хуулийг биелүүлдэггүй байдлыг илтгэнэ.

Хот дахин төлөвлөлтийн төслийн ажил хэрэгжээд багагүй хугацааг өнгөрөөж зарим төсөл хэрэгжих газар иргэд эвлэлдэн нэгдэж өөрсдийн эрх ашигаа хамгаалах, төсөл хэрэгжүүлэгчтэй анхнаасаа хуулийн дагуу тохиролцож орчноо сайжруулах, аюулгүй баталгаатай эд хөрөнгөтэй болох зорилгын дор нэгдэн ажиллаж байгаа тохиолдол байна. Тухайлбал Баянзүрх газрын эзэн нөхөрлөл нь өөрсдөө төсөлд эхнээс оролцож хамтран хэрэгжүүлэх саналаа холбогдох газруудад тавьж өөрсдийн газар дээрээ захиалагч болж хөрөнгө босгон барилгын компаниар ажлаа гүйцэтгүүлэх гэж сүүлийн хэдэн жил ажиллаж байгаа боловч хуулийн зохицуулалт дутмаг, холбогдох байгууллагууд нь бүрэн ойлгохгүй багагүй цаг хугацааг зарцуулж байна. Энэ бол иргэдийн төсөл, хөтөлбөрт оролцох оролцооны бодит хэлбэр төдийгүй, төсөл богино хугацаанд үр дүнтэй хэрэгжих үндэс болохыг бусад улсын туршлага ч харуулдаг.

Энэтхэг, Филиппин болон ази, африкийн цөөнгүй орнуудад хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөрүүдэд иргэдийг оролцох боломжийг бүрдүүлж өгсөн төсөл нь амжилттай хэрэгжиж үр дүнгээ өгсөн байна. Иргэдийн оролцоог хангахын тулд цаг хугацаа болон хөрөнгө нилээдгүй шаарддаг гэдгийг төслийг хэрэгжүүлэгч засгийн газрууд болон төсөл хэрэгжүүлэгч дурьджээ. Иргэдийн оролцооны сүүлийн үеийн хандлага нь төслийг хэрэгжүүлэх явцад үр ашгийг нэмэгдүүлэх, хариуцлагыг сайжруулахад туслах зорилтоос төслийг тодорхойлох, боловсруулах шатанд иргэдийн оролцоог хангахад шилжсэн байна¹⁶⁶. Иргэдийн оролцоог хангаснаар хэд хэдэн давуу талууд бий болдог байна. Үүнд:

- Иргэдийн бие биеэ хүлээн зөвшөөрөх чадвар дээшилж багаар хамтарч ажиллах чадвар нэмэгддэг байна.
- Төсөлд хамрагдаж буй иргэдийн нийгмийн идэвх нэмэгдэж амьдрах чадвар дээшилж ядуурлын түвшинд эерэг нөлөө үзүүлдэг байна.
- Иргэдээс төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэгчид тавих хяналт сайжирч төсөл, хөтөлбөр амжилттай хэрэгждэг байна.
- Үл ойлголцол багасч тогтвортой үргэжилэх харилцааны үндэс суурь бий болдог байна.
- Цаг хугацаа алдагдаггүй, хугацаандаа хэрэгждэг.
- Төсөл, хөтөлбөрийг үр дүнд оролцогч бүх тал үр шимийг хүртэгч байдаг.

Иргэдийн оролцоог хуульчлах нь хангалтгүй бөгөөд иргэдийг оролцуулахын тулд улс төрийн хүчин чармайлт, дэмжлэг хэрэгтэй төдийгүй улмаар оролцоог хууль ёсны дагуу явуулах улс төр, бизнесийн соёл хэвших чухал байна.

¹⁶⁵ Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хууль (2015) 18.2 Төсөл хэрэгжүүлэгч нь гэр хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулах төслийн сонгосон талбай дахь газар, үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөгч, эзэмшигчдийн 80-аас доошгүй хувьтай гэрээ байгуулснаар төсөл хэрэгжих урьдчилсан нөхцөл бүрдэнэ.

¹⁶⁶ Салватор Шиаво-Кампо, Пачампет Сундарам "иргэдээ үйлчилж, төрт ёсны үнэт зүйлсээ хадгалах: Өрсөлдөөнт ертөнцөд төрийн захиргааг сайжруулах нь УБ., 2013 х.206-214



Дүгнэлт

Хот дахин төлөвлөлтийн төслийн үр нөлөөтэй байдал нь өнөөгийн байдлаас харахад иргэдийн оролцоонд тулгуурлаж явагдахаас өөр зам үгүй. Төрийн зүгээс иргэдийн оролцоог хэт хожуу оролцох, эсхүл хэлбэрийн төдий оролцох боломжоор хангаж байгаа байдал нь олон асуудал үүсгэж байна. Ихэнх оролцооны байдлыг хот дахин төлөвлөлтөнд төсөл эхэлсний дараа иргэдийн оролцуулж байгаа нь үл ойлголцох, төсөл удаашрах улмаар нийтлэг эрх ашиг сонирхол хөндөгдөхөд хүргэж байна. Иргэдийн оролцоог бий болгоход цаг хугацаа болон зардал багагүй шаардагддаг нь олон улсын туршлагаас харагдаж байна. Төрийн албан хаагчдын шагнал урамшууллын тогтолцоо болон иргэдийн оролцоог дэмжсний төлөө урамшуулах хөшүүрэг дутагдалтай байна. Иргэдийн оролцоог ганц хот дахин төлөвлөлтийн хүрээнд бус улс төрийн соёл болгон төлөвшүүлэх шаардлагатай байна. Учир нь иргэдэд итгэл төрүүлэхүйц байх буюу төрийн байгууллага, албан тушаалтан мэдээлэл өгөх, сонсох, яриа хэлцэл хийхэд бэлэн гэдэгт итгэж байгаа нөхцөлд иргэдийн оролцуулах нь хялбар үр дүнтэй. Мөн иргэдийн оролцоог хангахдаа эмзэг бүлэг, цөөнхийн бүлгүүдэд дуу хоолойгоо илэрхийлэх боломж олгох асуудал анхаарал татаж байна. Холбогдох эрх зүйн зохицуулалт нь хожимдож гарснаас, дутуу, ерөнхий зохицуулалтайгаас болж өнгөрсөн хугацаанд орон байргүй болсон, амь нас нь хохирсон, хэн хохирлыг нь барагдуулах эсэх тодорхойгүй нөхцөлд орсон иргэд байна. Эрх бүхий байгууллагын судалгаа, дүгнэлт гарч хохирлыг барагдуулах, орон байраар хангах шаардлагыг хүргүүлсэн боловч хэрэгжилт хангалтгүй, цаашид алдаа дахин давтагдахгүй байх талын ямар арга эмжээг авч хэрэгжүүлвэл зохистой талаар мэдээлэл оролцогч талуудад дутмаг байна.

Хот төлөвлөлтийн үед нийслэлийн зарим иргэд өөрсдийн оролцоог ухамсарлаж төсөлд оролцох сонирхол байр сууриа илэрхийлсэн тохиолдол байгаа боловч хүлээн авч хамтарч ажиллаж төслийг хэрэгжүүлэхгүй байгаа нь төрийн байгууллагуудын иргэдийн оролцоог хангах талаарх мэдлэг, туршлага дутмаг байгааг харуулж байна. Мөн төрийн алба төслийг хэрэгжүүлж байгаа газар нь тогтвортой бус сонгууль дагаж өөрчлөгддөг явдал нь хот дахин төлөвлөлтийн ажилд улмаар иргэдтэй тогтвортой харилцах харилцаанд сөргөөр нөлөөлж хугацаа алдах, зөрчилдөөн үүсэх, үл ойлголцолд хүрэх, төсөл хэрэгжүүлэх шатанд туршлага дутах зэрэг сөрөг үр дагавруудыг үүсгэж байна. Тогтвортой харилцаа иргэдийн итгэлийг төрүүлдэг учир иргэдтэй харилцаж байгаа төсөл хэрэгжүүлэгч төрийн байгууллагын ажилтан тогтвортой байх нь үр нөлөөтэй.

Хот дахин төлөвлөлтөнд иргэдийн оролцоог хангаж ажилласнаар оролцогч тал бүрийн эрх ашгийн тэнцэл хангагдах боломжтой. Тиймээс иргэдийн оролцоог хууль эрх зүйн зохицуулалтын хүрээнд тодорхой болгох, хэрэгжүүлэх төрийн байгууллага, албан тушаалтан, бизнесийн байгууллагыг чадавхжуулах, тогтвортой ажиллах нөхцлийг бүрдүүлснээр иргэдийн итгэл нэмэгдэж иргэдийн оролцоо бодитоор бий болж хот дахин төлөвлөлт төлөвлөөгийн дагуу үр дүнтэй явагдах боломж бүрдэхээр байна.

Ном зүй

- Монгол Улсын Үндсэн хууль 1992
- Захиргааны ерөнхий хууль 2015
- Хот байгуулалтын тухай хууль 2008
- Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хууль 2015
- Хүний эрхийн түгээмэл тунхаглал 1946
- Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт 1966
- Эдийн засаг, нийгэм соёлын эрхийн тухай олон улсын пакт 1966
- Хүүхдийн эрхийн тухай конвенци 1989
- Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай конвенци 14. 2 (h)
- Нэгдсэн Үндэстний байгууллагын Тогтвортой хөгжил 2030 хөтөлбөр
- НҮБ-ын эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн хороо, ерөнхий зөвлөмж
- Эмнести Интернэшнл, Хангалтгүй хэрэгжүүлж байгаа нь (судалгааны тайлан), 2016 он
- Хүний эрхийн үндэсний комиссын МОНГОЛ УЛС ДАХЬ ХҮНИЙ ЭРХ, ЭРХ ЧӨЛӨӨНИЙ БАЙДЛЫН ТАЛААРХ 17 ДАХЬ ИЛТГЭЛ 2018
- Салватор Шиаво-Кампо, Пачампет Сундарам “Өрсөлдөөнт ертөнцөд төрийн захиргааг сайжруулах нь” II дэвтэр 2013



ХИЛИЙН БООМТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА, АЮУЛГҮЙ БАЙДАЛД ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДЛУУД

Я.Цэлмэн

Дотоод Хэргийн Их сургуулийн Цагдаагийн сургуулийн Эрүүгийн процессын тэнхимийн ахлах багш, докторант, цагдаагийн хошууч

Товч агуулга: Монгол Улс дэлхийн улс гүрнүүдээс хоёрхон улстай хиллэдэг бөгөөд энэ утгаараа хилийн шалган нэвтрүүлэх асуудлыг хялбар зохион байгуулж, шийдэж болхоор өнгөц харагдаж болхоор.

Монгол Улсын хилийн тухай Монгол улсын хуулийн¹⁶⁷ 5.1.Монгол Улсын хилийн аюулгүй байдал нь /цаашид “хилийн аюулгүй байдал” гэх/ Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын салшгүй хэсэг мөн гэж заасан. Орчин цагт Монгол улсын хилд зэвсэглэн халдах оролдлого хөрш зэргэлдээ улсаас ирэхгүй ч хууль бус бараа оруулах, гаргах асуудал улам нэмэгдсээр байна.

Сүүлийн томоохон үйл баримтаас дурдвал Улсын Их Хурлын /цаашид УИХ гэх/ Н.Энхболдын 2018 оны 8 дугаар сарын 30-ны өдөр нийтэд олон нийтийн мэдээллийн хэрэгслүүдээр дамжуулан хийсэн “Эрдэнэс таван толгой компанийн лицензтэй талбайгаас 340 мянган тонн нүүрс алдагдсан нь тогтоогдлоо” гэх факт юм.

Түлхүүр үг: Хил, боомт, аюулгүй байдал, хууль тогтоомж, хяналт, шалгалт

Монгол улс дэлхийн улс гүрнүүдээс хоёрхон улстай хиллэдэг бөгөөд энэ утгаараа хилийн шалган нэвтрүүлэх асуудлыг хялбар зохион байгуулж болох мэт. Түүхийн хуудас сөхвөөс Их Монгол улсын тэртээгээс олон улстай хиллэж, худалдаа арилжаа эрхэлж, хил хязгаарын асуудлаа эвийг эрхэмлэн шийдэхийг эрмэлзэж ирсэн байдаг.

Түүх судалвал орчин цагийн Хилийн цэрэг нь Монгол улсад бие даан 1934 онд зохион байгуулагдаж байжээ. Түүнээс хойш 1990 он хүртэл хилийн хяналт, шалгалтын асуудал өнөөдрийнхөөс магадгүй илүү найдвартай байсан нь тоо баримт, хилийн хяналт шалгалтын үр дүнгээс харагдана. Гэхдээ мөн л нэг талын тоо баримтанд үндэслэж гаргасан дүгнэлт. Хилийн ббомтын үйл ажиллагааны талаар судлагаа хийхэд хоёр улсын тоо баримтыг харьцуулах шаардлагатай. Гэвч судалгаа хийх тоон баримтууд дутмаг байна.

Хил судлал нь улсын ба хилийн орон зайд улс орон, нийгэм, бие хүний аюулгүй байдлыг хангах, тэдний эрх ашгийг хамгаалах нийгэм, улс төрийн нарийн түвэгтэй үзэгдлийн шинж байдал, хууль, зүй тогтлын талаарх мэдлэгийн тогтолцоо, геополиткийн бие даасан салбар юм.¹⁶⁸

Монгол улсын хилийн тухай Монгол улсын хуулийн¹⁶⁹ 5.1 дүгээр зүйлд: “Монгол Улсын хилийн аюулгүй байдал нь /цаашид “хилийн аюулгүй байдал” гэх/ Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын салшгүй хэсэг мөн” гэж заасан. Орчин цагт Монгол улсын хилд зэвсэглэн халдах оролдлого хөрш зэргэлдээ улсаас ирэхгүй ч хууль бус бараа оруулах, гаргах асуудал улам нэмэгдсээр байна. Тухайлбал:

Монгол Улсын их хурлын гишүүн Н.Энхболдын 2018 оны 8 дугаар сарын 30-ны өдөр нийтэд олон нийтийн мэдээллийн хэрэгслүүдээр дамжуулан хийсэн “Эрдэнэс таван толгой компанийн лицензтэй талбайгаас 340 мянган тонн нүүрс алдагдсан нь тогтоогдлоо” гэх факт юм. Тэрээр мэдээлэхдээ: “Гаалийн ерөнхий газар шалгалтын дүгнэлтдээ эх үүсвэргүйгээр 390 мянган тонн нүүрсийг Тавантолгой транс компани хил гаргасан байна гэсэн. Эх үүсвэргүй гэдэг нь хаанаас авсан нь тогтоогдоогүй гэсэн үг. Гэтэл нүүрс алдагдсан газар бас бий болсон. “Эрдэнэс тавантолгой” лицензтэй талбайгаас 268 мянган тонн алдагдсан байна гэдгийг би өмнө нь зарласан. Тэр нь “Эрдэнэс тавантолгой” болон орон нутгийн Таван толгой компанийн инженерүүд хамтарч маркшейдерийн хэмжилт хийж гаргасан хэмжээ. Харин өнөөдөр мэргэжлийн хяналтын байгууллагын хөндлөнгийн

¹⁶⁷ Монгол Улсын хилийн тухай/шинэчилсэн найруулга/ Монгол улсын хууль. Төрийн мэдээлэл, №6

¹⁶⁸ Д.В.Александрович. Улсын хилийн аюулгүй байдлыг хангахад хил судлалын ухааны үүрэг, байр суурь. Улсын хилийн аюулгүй байдал ба хамтын ажиллагаа ОУЭШБХ-ын эмхэтгэл. УБ.,2012. т164

¹⁶⁹ Монгол Улсын хилийн тухай/шинэчилсэн найруулга/ Монгол улсын хууль. Төрийн мэдээлэл, №6



маркшейдеруудын хэмжилтээр 340 мянган тонн нүүрс “Эрдэнэс тавантолгойн” лицензтэй талбайгаас алга болжээ. Би Монголын ард түмний өмчийг эргүүлж олох, гэм буруутай этгээдүүдийг хууль хяналтын байгууллага эцэслэн тогтоохыг л хүсч байна. Буруутай эзэд нь хохирлыг төлөх ёстой. 340 мянган тонн нүүрс гэдэг бол 25 сая ам.доллар буюу 60 тэрбум төгрөг. Ийм хэмжээний өмч ард түмний халааснаас алга болжээ. “Эрдэнэс тавантолгой”-н талбайгаас гарсан 340, орон нутгийн өмчит Тавантолгой компанийн талбайгаас гарсан 50 мянган тонн нүүрс. Орон нутгийн Тавантолгой компаниас 206 компани гэрээтэйгээр нүүрс дамжуулан борлуулдаг юм байна. Ийнхүү “Эрдэнэс Тавантолгойн” талбайгаас 340 мянган тонн нүүрс хулгайлагдсан нь нотлогдлоо.

Хил хамгаалах ерөнхий газар Монгол Улсын гаалиар 2013-2017 оны хооронд нийтдээ 849 мянга 121 машин 90 тонн гэж бодоход гурван сая тонн нүүрсний асуудал босохыг үгүйсгэхгүй гарсан гэсэн мэдээлэл өгсөн. Тэгвэл Гаалийн ерөнхий газраас 820 мянган машин гарчээ гэсэн мэдээлэл өгсөн. Энэ хооронд 35 мянган удаа автомашин хоосон гарчээ гэсэн мэдээлэл бий. Нүүрс тээврийн машинууд 80-125 тонн даацтай. Дунджаар. Ийм учраас хууль хяналтын байгууллага шалгах хэрэгтэй” гэв.

Хил хамгаалах ерөнхий газрын болон Гаалийн ерөнхий газрын мэдүүлсэн тоо баримт яагаад зөрөх болов? Асуудал нь аль талдаа байна?

Монгол Улсын хилийн тухай хуулийн :

17 дугаар зүйл. Улсын хилийн боомт дээр ажиллах хяналт шалгалтын байгууллага

17.1.Зорчигч, тээврийн хэрэгсэл, бараа, мал, амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнд хяналт шалгалт хийх зорилгоор хилийн боомтод улсын хил хамгаалах, гааль, мэргэжлийн хяналтын байгууллага, виз бүртгэлийн асуудлыг шийдвэрлэх зорилгоор гадаадын иргэн, харьяатын байгууллага ажиллана.

17.2.Зорчигч, тээврийн хэрэгсэл хилийн боомтод тогтоосон замаар нэвтрэх бөгөөд улсын хил хамгаалах, гааль, мэргэжлийн хяналтын байгууллагын албан хаагчид шалгуулах үүрэгтэй.

17.3.Хилийн хяналтын байгууллага улсын хилээр зорчигч, тээврийн хэрэгсэл, бараа, мал, амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг нэвтрүүлэхдээ доор дурдсан дарааллыг баримталж хяналт шалгалт явуулна:

17.3.1.улсын хилээр гарах хөдөлгөөний чиглэлд мэргэжлийн хяналтын, гаалийн, улсын хил хамгаалах байгууллага;

17.3.2.улсын хилээр орох хөдөлгөөний чиглэлд улсын хил хамгаалах, мэргэжлийн хяналтын, гаалийн байгууллага гэж хуульчилсан байна.

Энэ олон давхар шалгалтын хаагуур нь эдгээр олон машин нүүрс гарчихсан бэ гэдэгт олон нийттэй адилхан мэдээлэлтэй байгаа судлаачийн зүгээс асуудлыг хөндөж байна.

Одоогоор асуудал эцэслэн тогтоогдоогүй байгаа ч ийм маргаантай, улс орны эрх ашигт ноцтой хохирол учруулсан асуудал хөндөгдсөн байхад улсын хил тайван байна гэж иргэд тайван суух боломж хэр байна вэ?

Хилийн аюулгүй байдлын эмзэг цэг нь тэгвэл хилийн боомт яах аргагүй болсон гэдэгт судалгаагаа чиглүүлээ.

Хилийн боомтын тухай хуулийг 2013 оны 12 дугаар сарын 26-ны өдөр батлаад 3 жил гаруй хүчин төгөлдөр мөрдсөний эцэст Монгол Улсын хилийн тухай /Шинэчилсэн найруулга/ хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн хүчингүй болгосон байна.

Монгол Улс 26 хилийн боомттой. Эдгээр хилийн боомтын гол үүргийг хил хамгаалах байгууллага хилийн боомтын тухай хууль батлагдах хүртэл гүйцэтгэж байжээ. Тодруулбал, хилийн боомтоор зорчигч, тээврийн хэрэгслийг шалган нэвтрүүлэх онцгой хийгээд чухал үүрэг тэднийх байв. Харин 2014 онд УИХ-аас Хилийн боомтын тухай хууль батлагдан гарснаар хилийн цэргийнхний үүрэг Иргэний харьяалал, шилжилт хөдөлгөөний ерөнхий газарт шилжсэн байдаг.

Тухайн үед хууль санаачлагчид шинэ хуулийг оруулж ирэхдээ гадаад худалдааг хөнгөвчлөх, төрийн үйлчилгээг хүнд сурталгүй, шуурхай болгох зорилтын хүрээнд хилийн боомтын үйл ажиллагааг сайжруулах, хяналт шалгалтын үр нөлөөг дээшлүүлж, давхардлыг арилгах зорилготой гэдгийг онцолж байв.

Гэтэл тус хуулийн зохицуулалтын үед дараах хүндрэлүүд гарах болжээ. Тухайлбал: 1993 онд батлагдсан Хилийн тухай хуулийн гол заалтууд шинэ хуульд шингэж, Иргэний харьяалал, шилжилт хөдөлгөөний ерөнхий газрын ажилтнууд шалган нэвтрүүлэх, хилийн



цэргийнхэн аюулгүй байдлыг хангах үүргийг хүлээхээр болсон. Энэ хүрээнд боомтын шалган нэвтрүүлэх үүргийг гүйцэтгэж байсан хилийн цэргийн 200 гаруй офицер, ахлагчийг Иргэний харьяалал, шилжилт хөдөлгөөний ерөнхий газарт шилжүүлжээ. Боомтууд дээрх шалган нэвтрүүлэх ажилтнуудын 80 хувь нь эмэгтэйчүүд байжээ. Хил зөрчигчдийн арга өдрөөс өдөрт нарийсч, хориглосон эд зүйлсээ хүний санаанд оромгүй байдлаар нууж хилээр нэвтрэхийг зорьдог. Гэтэл тэдгээрийг шалгах үүрэг бүхий эмэгтэйчүүд илрүүлэх битгий хэл шалгалтгүйгээр хил нэвтрүүлдэг болсныг албаны эх сурвалж хэлж байна. Ер нь эмэгтэйчүүд олон арван тонны ачаатай авто-машиньг хэрхэн шалгах билээ. Өндөр, өндөр ачаатай том автомашинд авирахаас эхлээд ачаа, бараа задлах, шалгах нь тэдний барах ажил биш. Угтаа энэ ажил мэргэжлийн арга барил шаарддаг. Улсын хилийн аюулгүй байдлыг хангахын тулд өмнө нь хилийн цэргийн бэлтгэгдсэн залуус шалгалтыг явуулж, томоохон зөрчлийг газар дээр нь таслан зогсоодог байлаа. Гэвч одоо энэ ажил цалгардаж, шалгалтгүйгээр хил нэвтрүүлдэг болсныг захын тээвэрчин хэлж байна. Үүнээс болж ан амьтны эд эрхтэн, байгаль, түүх соёлын үнэт дурсгалуудыг хил давуулахыг мэдэх боломжгүй болжээ. Ашиг хонжоо хайгчид ч энэ байдлыг ашиглаж, хилийн боомт орчимд хууль бус бүлэглэлүүд үүсгэчихэж. Гашуунсухайт, Шивээхүрэнгийн боомтоор нүүрс тээвэрлэдэг зам энэ төрлийн хэргийн гол урсгал болоод байгаа аж. 40 тонны даацтай автомашиныг өргөтгөж 100-120 тонн болгон нүүрс ачихдаа дунд нь хөлдөөсөн чононоос эхлээд хэдэн тонн самар ачаад л хил нэвтрэдэг болсон байна. Ийм маягаар Монголын хэр хэмжээний баялаг гадагшаа урсаж байгааг хэн мэдлээ. Түүнээс гадна хилийн боомтууд дээрх ачаалал хэтэрч, Алтанбулагийн боомт дээр л гэхэд 700 гаруй автомашин дугаарлаж хонох болж. Хангийн боомт дээр 300 гаруй машин дугаараа хүлээсээр хэд хонож байгааг жолооч, тээвэрчид бухимдан ярьж байна¹⁷⁰.

Сэтгүүлч Ч.Болорчулууны 2016 оны 02 дугаар сарын 04-ний өдөр нийтлүүлсэн “Хяналтгүй хилийн боомтууд” сэдэвт дээрх нийтлэлд тухайн үеийн мөрдөгдөж байсан хуулийн үед үүссэн хүндрэлүүд гаргаж тавьжээ. Үүний дараа жил Монгол улсын хилийн тухай Монгол улсын хуулийн шинэчилсэн найруулга УИХ-аар батлагдсан.

Яг л энэ он жилүүдэд энэ олон тонн нүүрс алдагдсан хэрэг холбогдож байна. Ялангуяа Хил хамгаалах ерөнхий газар Монгол Улсын гаалиар 2013-2017 оны хооронд нийтдээ 849 мянга 121 машин гарсан гэсэн мэдээлэл өгсөн Гаалийн ерөнхий газраас 820 мянган машин гарчээ гэсэн мэдээлэлтэй 29.121 автомашинаар зөрж байна. Бага машин нэвтэрсэн гэж мэдээлэл өгсөн Гаалийн ерөнхий газарт асуудал байж болохыг энгийн математик мэддэг хүн л шууд ойлгохоор байна.

Хилийн аюулгүй байдал гэдэг нь “улсын хил, хязгаар нутаг(хилийн орон зай)-т үндэсний аюулгүй байдал найдвартай хангагдах гадаад, дотоод нөхцөл баталгаатай хангагдах явдал”¹⁷¹ юм гэжээ.

Тэгвэл үндэсний аюулгүй байдалд нөлөөлхүйц хэмжээний ашигт малтмал, нүүрс улсын хилээр ямар ч саадгүй нэвтэрсээр ирснийг юу гэж ойлгох вэ?

Улс, үндэстний аюулгүй байдал ямагт улс төр, улс төрчдийн бусармаг үйлдлээс ангид байх ёстой бөгөөд, ангид байлгах үүргийг хууль сахиулах байгууллагуудад хуулиараа хүлээлгэсэн байдаг.

Олон улсын туршлагаас судлахад хилийн хяналт, шалгалтаа энгийн байгууллагад хариуцуулсан улс орон бараг байдаггүйг судлаачид өгүүлсээр байна.

Оросын холбооны улсын хил судлалын эрдэмтэд улсын хилийг манах /охрана/ ажиллагааг “Хил хамгаалах байгууллага өөрийн хүч хэрэгслээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээг улсын хилийг манах” гэх бөгөөд, хилийг хамгаалах /защита/ ажиллагааг “төрийн хилийн бодлогоор үүрэг хүлээсэн субъектүүдийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулах замаар авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээг улсын хилийг хамгаалах”¹⁷² гэжээ.

¹⁷⁰ Ч.Болорчулуун. “Хяналтгүй хилийн боомтууд”. <https://news.mn/r/716332/>

¹⁷¹ Ш.Арвай. Улсын хилийн тухай дурсамж, үзэл бодол. УБ 2005. т.185

¹⁷² Д.Дашдаваа. Хилийн аюулгүй байдлын тогтолцоо бүрдүүлэх асуудалд. Хил судлал сэтгүүл. №3,4,УБ., 2009. т12



Санал, дүгнэлт

Хилийн аюулгүй байдал, хяналт шалгалтад шинжлэх ухаанчаар хандаж, эрх зүйн зохицуулалтыг нийгмийн өнөөгийн болон хэтийн төлөв байдалд нийцүүлэн сайжруулах нь өнөөгийн тулгамдсан асуудал болжээ.

Хилийн тухай төр, хил, гаалийн хяналт шалгалтын талаар тогтвортой, нэгдсэн зохицуулалт Монгол улсад хэрэгжиж байна уу гэдэг асуулт хариултгүй үлдэж байна. Хилийн асуудал хариуцаж байсан өндөр албан тушаалтнууд гадаад улсад зугтаж, тухайн улсынхаа хилтэй холбоотой өндөр албан тушаалтан болсон гээд харамсмаар муу жишээнүүд бидэнд байна¹⁷³. Хэн нэгэн болон хэсэг бүлэг нөхдийн эрх ашигт үйлчлэхийн тулд богино настай, цоорхойтой, хуудуутай хууль батлан гаргаж байгаа юм биш биз гэсэн хардлага ч судлаачийн хувьд төрж байна. Улс орноо тонон дээрэмдүүлэх аюулаас зайлшгүй урьдчилан сэргийлэх цаг хэдийн болсон гэдгийг дээрх илтгэлд авагдсан хэдийгээр эцэслэн шийдэгдээгүй байгаа ч олноо ил болсон олон мянган тонноор хэмжигдэж буй нүүрс хулгайлан хилээр нэвтрүүлсэн асуудалд суурьлан дүгнэв.

Ном зүй

1. Монгол Улсын хилийн тухай/шинэчилсэн найруулга/ Монгол улсын хууль. Төрийн мэдээлэл, №6,

2. Д.В.Александрович. “Улсын хилийн аюулгүй байдлыг хангахад хил судлалын ухааны үүрэг, байр суурь” илтгэл. Улсын хилийн аюулгүй байдал ба хамтын ажиллагаа ОУЭШБХ-ын эмхэтгэл. УБ., 2012.

3. Ш.Арвай. Улсын хилийн тухай дурсамж, үзэл бодол. УБ 2005.

4. Монгол Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоол. Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал

5. Д.Дашдаваа. Хилийн аюулгүй байдлын тогтолцоо бүрдүүлэх асуудалд. Хил судлал сэтгүүл. №3,4,УБ., 2009

6. Ч.Болорчулуун. “Хяналтгүй хилийн боомтууд”. <https://news.mn/r/716332/>

7. <http://www.legalinfo.mn/law/details/12418>

8. <http://www.medee.mn/main.php?eid=104941>

¹⁷³ Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2018 оны 3 дугаар сарын 27-ны өдрийн “Монгол Улсын харьяатаас гаргах тухай” 32 дугаар зарлигийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь, Монгол Улсын харьяатаас гарсан Халидалдагийн Жекейд олгосон дээд офицерын “Бригадын генерал” цолыг хураан авсугай” хэмээсэн юм.

Ерөнхийлөгчийн зарлиг гаргахдаа тулгуурласан гол заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн, Цэргийн албаны тухай хууль бөгөөд түүн дотроо 28 дугаар зүйл. Цэргийн цолыг бууруулах, хураан авах, сэргээх буюу тус хуулийн 28.2.Гэмт хэрэг үйлдэж, хорих ял шийтгүүлсэн болон Монгол Улсын харьяатаас гарсан цэргийн алба хаагчийн цэргийн цолыг цол олгосон албан тушаалтны шийдвэрээр хурааж авна хэмээн зааснаар үндэслэн Х.Жекейн Бригадын генерал цолыг хураан авчээ.

Болсон явдлыг сөхвөл, Х.Жекей нь 2000 болон 2008 оны УИХ-ын сонгуулиар Баян-Өлгий аймгаас сонгогдож байжээ. Өдгөөгөөс дөрвөн жилийн өмнө тэрбээр Монгол Улсын иргэншлээ сольж Казакстан улсын иргэн болсон байж болзошгүй гэх мэдээлэл түгж байв. Хил хамгаалах албанд олон жил зүтгэж, Хил хамгаалах ерөнхий газрын дэд даргаас Бригадын генерал цол хүртэж, Казах түмний хайр хүндлэлийг хүлээж байсан Х.Жекей гэнэтхэн л иргэншлээ сольсон гэх мэдээлэл гарч эхэлсэн нь оргүй биш байв. УИХ-ын гишүүнээсээ буусны дараа тэрбээр удалгүй Казакстан улсын иргэн болж, улмаар тус улсын Хилийн тагнуулын албанд нэлээд дээгүүр алба хашиж буй гэх асуудал яригдаж эхэлсэн юм./ <http://www.medee.mn/main.php?eid=104941> /